



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (274)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Төрийн шагнал хүртээх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Журам батлах тухай*
- *Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арванхоёрдугаар сарын 8 №37 (274)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

506. Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 63 1180

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

507. Гу Гоныг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 130 1180
508. Төрийн шагнал хүртээх тухай Дугаар 132 1180

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

509. Журам батлах тухай Дугаар 161 1180

510. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай Дугаар 162 1185

511. Идлэг шонхор шувууг хамгаалах, зохистой ашиглах тухай Дугаар 163 1187

512. Гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 164 1187

513. Урлагийн зарим байгууллагын нэр өөрчлөх тухай Дугаар 166 1188

514. Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай Дугаар 167 1189

515. Нэрэмжит болгох тухай Дугаар 169 1189

516. Сургалтын зардлын жишиг тогтоох тухай Дугаар 170 1189

517. Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай Дугаар 173 1190

518. Нэмэгдэл олгох тухай Дугаар 174 1190

519. Эрчим хүчний салбарт дэмжлэг үзүүлэх тухай Дугаар 175 1191

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

520. Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай Дугаар 264 1191

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 63 | Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 36 дугаар тойргоос 2002 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр явуулсан нөхөн сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сонгогдсон Сундуйн Батболдын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 130 | Улаанбаатар хот

Гу Гоныг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, БНСУ болон хоёр орны нийслэл хотуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Улаанбаатар хотын тохижилт, соёлжилтыг дэзшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Сөүл хотын дарга асан, олон улсын хэзл хахуууль, ялзралын эсрэг байгууллагын БНСУ дахь ерөнхийлөгч Гу Гоныг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 132 | Улаанбаатар хот

Төрийн шагнал хүртээх тухай

"Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм"-ийн нэгийн 7, дэрвийн 1 дүгээр заалтуудыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

туурвисан Цүлтэмийн Энхжинд Монгол Улсын Төрийн шагнал хүртээсүгэй.

"Газар тэнгэр" гурвал, "Нүүдэл-2", "Цонх-4", "Цонх-6", "Цонх-9" зэрэг уран зургийн шилдэг бүтээл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 13-ны өдөр | Дугаар 161 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Засгийн газрын агентлаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг батлуулж, мөрдүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг даргад нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1999 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2002 оны 161 дүгээр тогтоолын хавсралт

ЯАМ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зорилт

1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаарх мэдээлэлд боловсруулалт хийж, зорилтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг, нөлөөллийг шинжлэн дүгнэх, хөгжлийн дараагийн зорилтыг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, санал, дүгнэлт, зөвлөлгөөгөөр хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн зорилго нь: төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүн, өртөг, зардал, үр нөлөөллийг бодитойгоор тогтоох, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг баталгаажуулах, амжилтыг ахиулах, удирдлагыг цаг үеэ олсон, үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь:

1.3.1. Үйл ажиллагааны тодорхойгүй байдлыг багасгах, гүйцэтгэлийг сайжруулах боломж, нөөцийг илрүүлж ашиглах;

1.3.2. Бодлогын сонголтыг хэрэгжүүлэх нөөцийн /орцын/ удирдлага, зохицуулалтын үр нөлөө, өгөөж, гарцыг сайжруулах;

1.3.3. Шийдвэр гаргах үйл ажиллагаат бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ, тавигдах шаардлага, тайлагнах хугацаа:

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд төрийн захиргааны төв, нутгийн захиргааны бүх шатны байгууллага хамрагдана.

2.2. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь жилийн үйл ажиллагааны үр дүндээ хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

2.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жилд 6-гаас доошгүй яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд энэхүү журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна.

2.4. Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг болон сум, дүүргийн үйл ажиллагааны явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар тогтооно.

2.5. Үйл ажиллагааны тайлан нь дараахь бүтэцтэй байна:

2.5.1. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн;

2.5.2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн;

2.5.3. Төрийн захиргааны манлайлал, үйл ажиллагааны төлөвлөлт болон тэдгээрийн хэрэгжилт, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, зохицуулах талаар авсан арга хэмжээ, үр дүн;

2.5.4. Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн;

2.5.5. Хөндлөнгийн хяналт, шалгалтын дагуу авсан арга хэмжээ, үр дүн;

2.5.6. Байгууллагын нээлттэй байдлыг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн.

2.6.Үйл ажиллагааны тайлан нь дараахь хавсралтаас бүрдэнэ:

2.6.1. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлт /шууд холбогдох арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт /шууд холбогдох арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.3. Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт /заалт нэг бүрээр/;

2.6.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт /арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.5. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөөнөөс гадуур зохиосон ажил /арга хэмжээ нэг бүрээр/;

2.6.6. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ /энэ журмын 1 дүгээр хавсралтаар/;

2.6.7. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан.

2.7. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглаасан мэдээ, баримт нь үнэн зөв байна /ашигласан мэдээ баримт нь үнэн зөв эсэх талаар мэдээлэл өгсөн албан тушаалтан хариуцлага хүлээнэ/;

2.7.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх Үндэсэн чиглэл, Засгийн газрын хөтөлбөрүүд, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн тухайн онд хүрсэн түвшин нь тодорхой тоо, хувиар илэрхийлэгдсэн байна;

2.7.3. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтүүдийн гүйцэтгэл нь тайланд үнэн зөв бодитойгоор бичигдсэн байна.

2.8. Үр дүнгийн хяналт-шинжилгээ гүйцэтгэлийн бодит үр дүнг төлөвлөсөн зорилттой харьцуулж есөлт, бууралтыг тооцоолох аргаар хийж, зорилт, гүйцэтгэлийн зөрүүгийн шалтгааныг илруулэх, тасалдлыг нөхөх, илүү өндөр түвшний зорилго дэвшүүлэх боломж, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр үр дүнгийн үнэлгээг гаргана.

2.9. Байгууллагын төлөвлөгөөнд үйл ажиллагааны зорилтыг хариуцах албан тушаалтан, хэрэгжүүлэх хугацаог тогтоож, үйл ажиллагааны гарц буюу үлээж буй үр дүнг тодорхой тусгана.

2.10. Үйл ажиллагааны зорилтын хүрэх үр дүн буюу төлөвлөсөн гарц нь тодорхой, хэмжигдэхүйц, бодитой, цаг хугацааны хязгаартай байна.

2.11. Хяналт-шинжилгээний дүгнэлт, санал, зөвлөмж нь үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, тасалдал, доголдлын шалтгааныг илрүүлж засах, байгууллагын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, төсвийг оновчтой зарцуулах шийдвэр гаргах үндэслэл болно.

2.12. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэхэн ажиллаган тухай үнэлгээг сайд бүр өгнө. Үнэлгээг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдсэн байх шаардлагатай.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

3.1. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнг үнэлэхдээ тухайн зорилт, арга хэмжээний хүрэх түвшинг гүйцэтгэлтэй харьцуулж оноогоор илэрхийлнэ.

3.2. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа,түүний үр дүнгийн үнэлгээг оноогоор дүгнэнэ. Оноог энэ журмын 3.3-т заасан томъёогоор тодорхойлно.

3.3. Зорилтын биелэлтийг дор дурдсан томъёогоор дүгнэнэ:

ЗБ=Г/Т; Энэ үнэлгээг хувиар илэрхийлэх бол ЗБ=Г/Т*100 гэж тооцно.

Энд ЗБ- зорилтын биелэлт

Г - гүйцэтгэл

Т - төлөвлөгөө буюу өмнөх оны гүйцэтгэл

Зорилтын биелэлтийн оноог Б=(Г/Т*100)*0.05-томъёогоор тодорхойлно. Үг оноог үнэлгээний коэффициентоор үржүүлж үнэлгээний оноог тодорхойлно. Үнэлгээний оноо 5-аас илүү гарсан тохиолдолд 1 нэгж оноог 0.1-тэй тэнцүү байхаар тооцно.

3.4. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй бодлогын зорилт, арга хэмжээний үнэлгээний оноог тодорхойлохдоо тухайн зорилт, арга хэмжээний биелэлтийн хувийг 0.05-аар үржүүлж тодорхойлно. Биелэлтийн хувийг тодорхойлоход дараахь зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарсан бол 100 хувь;
- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, үр дүн нь зарим хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 87.5 хувь /75.0-100.0 хүртэл хувь/;
- Тухайн заалтаар тавьсан зорилгодоо хүрэхийн тулд үндсэн судалгаа, тооцоо,холбогдох бичиг баримт хийгдэж дууссан, шийдвэр гаргагч дээд

байгууллагад өргөн барьсан бүюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 62.5 хувь / 50.0-75.0 хувь/;

Бэлтгэл ажил бүрэн хийгдсэн, тодорхой хэмжээнд ажил эхэлсэн бол 37.5 хувь /25.0-50.0 хувь/;

Тухайн заалтад тусгагдсан асуудал боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 12.5 хувь /0-25.0 хувь/-ийн биелэлттэй байна гэж үзнэ.

3.5. Ерөнхий сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан батламжийн биелэлт нь зорилт нэг бүрийн биелэлтийн хувь /3.3-т заасан томьёогоор тодорхойлогдох/-ийг 0.05-аар өржүүлж гаргасан үнэлгээний онооны нийлбэрийн дундажаар илэрхийлэгдэнэ.

3.6. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээг энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ»-ний дагуу хийнэ.

3.7. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ нь «Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ» гэсэн журмын 1 дүгээр хавсралтын үнэлгээний онооны нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хуваж гаргасан оноогоор илэрхийлэгдэнэ.

Дөрөв. Шагнал, урамшуулал

4.1. Ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 3 яамны Төрийн нарийн бичгийн дарга, 5 аймаг, нийслэлийн Засаг даргыг нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн шагналаар, авсан онооны дарааллын дагуу 3 яам, 5 аймгийн Засаг даргын Тамгын газрыг дараахь шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

1 дүгээр байр: Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 3.0 сая төгрөгөөр;

2 дугаар байр: Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.5 сая төгрөгөөр;

3 дугаар байр: Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.0 сая төгрөгөөр;

4 дүгээр байр: Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.5 сая төгрөгөөр;

5 дугаар байр: Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.0 сая төгрөгөөр.

4.2. Шагналд зарцуулах хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт жил бүр тусгана.

Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Өмнөх он	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Оноо	Үнэлгээний коэффициент	Үнэлгээний оноо
I. Бодлогын зорилт,сайд /Засаг дарга/-д үзүүлсэн үйлчилгээний үнэлгээ									
1.	Боловсруулж, шийдвэрлүүлсэн бодлогын баримт хэмжээ	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	хувь					1.0	
		2.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	хувь					1.0	
		3. Хөтөлбөр, төслийн хэрэгжилт	хувь					1.0	
		4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	хувь					1.0	
		5. Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	хувь					1.0	
2.	Хууль тогтоомж, зарлигийн биелэлт		хувь					1.0	
3.	Засгийн газрын шийдвэрийн биелэлт	1. Засгийн газрын тогтоолын биелэлт	хувь					1.0	
		2. Ерөнхий сайдын захирамжийн биелэлт	хувь					1.0	
		3. Хуралдааны тэмдэглэлийн биелэлт	хувь					1.0	
II. Бодлогын зорилын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ									
1.	Засгийн газрын хуралдаанд дэг баримтлал	1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	хувь					0.9	
		2. Нийт асуудалд Засгийн газрын хуралдааны дэг зөрчих хэлэлцүүлэхэ, шийдвэрийн төсөл нь батлагдаагүй асуудлын эзлэх хувь	хувь					0.9	
2.	Төсвийн зардлын гүйцэтгэл		хувь					1.0	

3.	Хүний нөөцийн ашиглалт	1. Хүний нөөцийг хөгжүүлэх зорилгын биелэлт	хувь	0.8
		2. Төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээний дундаж	оноо	0.8
		Ш. Төрийн захиргааны мэдлэйлын үнэлгээ		
1.	Үйл ажиллагааны төлөвлөлт	1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	хувь	0.9
		2. Төлөвлөгөөнөөс гадуур гүйцэтгэсэн ажлын биелэлт	хувь	1.0
2.	Тушаал, шийдвэрийн биелэлт		хувь	0.9
		IУ. Үр дүнг хангасан байдлын үнэлгээ		
1.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөний биелэлт	хувь	0.8
		2. Үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт	хувь	0.8
2.	Хөндлөн-гийн хяналт шалгалт, хяналт-шинжилгээ	1.Хяналт шалгалтын үнэлгээ	оноо	0.8
		2.Хяналт-шинжилгээний үнэлгээ	оноо	0.8
		3. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал	хувь	0.8
		4.Хяналт-шинжилгээ,үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэрийн биелэлт	хувь	0.8
3	Байгууллагын нээлттэй байдал	1.Санал, өргөдөл, гомдлын барагдуулалт	хувь	0.8
		2. Хугацаанд нь шийдвэрлэсэн санал, өргөдөл, гомдлын хувийн жин	хувь	0.8
		3.ВЕБ-сайтад тавьсан хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн теслийн нийт төсөлд эзлэх хувь	хувь	0.8
		4.ВЕБ сайтад тавьсан мэдээлэлд иргэдээс ирсэн саналыг тусгасан байдал	хувь	0.8
4	ЗДТГ-ын үйл ажиллагаагаа сайдуудаас үнэлсэн үнэлгээний дундаж		оноо	0.8
	Ерөнхий үнэлгээ		оноо	

Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын 2 дугаар хавсралт

ЯАМ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1. Хөтөлбөрүүдийн биелэлтийн явцыг үнэлэхдээ Улсын Их Хурал, Засгийн газраас батална үндэсний хөтөлбөрийн сайд өөрийн эрхлэх ажлын хүрээний болон салбарын хөтөлбөрийн, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар Засгийн газрын тогтоол, шийдвэрээр аймаг, нийслэлийн Засаг дарга шууд хэрэгжүүлэх буюу дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр тогтоосон хөтөлбөр болон аймгийн хөтөлбөрийн зорилт нэг бүрийн биелэлтийг гарган тэдгээрийн дунджаар тооцно.

2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг үнэлэхдээ ямар сайдын эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээ бүрийн хүрэх түвшинг гүйцэтгэлтэй, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын баталсан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээ бүрийн хүрэх түвшинг гүйцэтгэлтэй харьцуулсан үнэлгээгээр тооцно.

3. Хууль, тогтоомжийн биелэлтийг үнэлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн заалт нэг бүрийн биелэлтийн явцыг хариуцах сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын нэрээр үнэлнэ. Биелэлтийн хувь, оноог гаргахдаа журмын 3,4-ийг баримтална.

4. Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг үнэлэхдээ энэхүү арга чилэлын 3 дугаар заалтыг жишиг болгоно.

5. Төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагааны мэргэшлийн түвшингийн

үнэлгээний жигнэсэн дүнджийг тооцохдоо Төрийн захиргааны албаны зөвлөлийн 1995 оны 4 дүгээр тогтоолоор батлсан журмын дагуу үйл ажиллагааг нь үнэлсэн албан хаагчдын А үнэлгээг 5, Б үнэлгээг 4, В үнэлгээг 3 гэж тооцно.

6. Хүний нөөцийг хөгжүүлэх зорилтыг үнэлэхдээ хүний нөөцийг хөгжүүлэх талаар яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас батлсан хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийн хувиар тооцно /энэ аргачлалын 3 дугаар заалтыг жишиг болгоно/.

7. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ тус бүрийн хүрэх түвшингийн гүйцэтгэлийн хувиар гаргаж ердийн дунджаар тооцно.

8. Тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрхэлсэн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын дарга нарын тушаал, захирамжийн биелэлтийн явцын хувиар тооцно /энэ аргачлалын 3 дугаар заалтыг жишиг болгоно/.

9. Хяналт, шалгалтын үнэлгээг яа болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгы газарт Төрийн хяналт шалгах хороо, Санхүүгий хяналт шалгалтын газар, хэлтэс, Татварын албанаа хийсэн шалгалтын үнэлгээ, илэрсэн зөрчлий арилгасан хувиар, хяналт-шинжилгээний үнэлгээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдаас хийсэ хяналт-шинжилгээ, үнэлгээ, өгсөн зөвлөмж, түүний хэрэгжүүлсэн хувиар тооцно.

10. Байгууллагын нээлттэй байдлы үнэлэхдээ яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт иргэд, байгууллага, Засгий газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал ергедел, гомдол түүний барагдуулалтын хувиа тооцно.

11. Мэдээ, тайлангийн гаргалт чанарыг үнэлэхдээ яам болон аймаг, нийслэлий Засаг даргын Тамгын газраас Засгийн газры тогтоол, шийдвэрийн дагуу Засгийн газрын Хэрэ эрхлэх газарт ирүүлэх мэдээ, тайлангийн хугацаандаа ирүүлсэн байдал, чанарыг харгалзан хувиар тооцно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 162 Улаанбаатар хот

Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас Төрийн захиргааны байгуулллагын тогтолцоо, бүтцийн өөрчлөлт бүдүүвчийг шинэчлэн тогтоосны дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын жагсаалтыг хавсралт ёсоор батлсугай.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын 2002 оны батлагдсан орон тоо, төсвийг хэмнэх чиглэлээр шинэчлэн хянаж, тэдгээрийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө, ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтыг энэ онд багтаан зохих журмын дагуу батлаж мөрдүүлэхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын "Агентлаг байгуулах тухай" 2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 139 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН ЖАГСААЛТ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын харьяанд	1. Тагнуулын ерөнхий газар 2. Төрийн өмчийн хороо 3. Улсын мэргэжлийн хяналтын газар	1. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газар 2. Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлаг 3. Газрын харилцаа,геодези, зураг зүйн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд		4. Удирдлагын академи 5. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		6. Үндэсний татварын ерөнхий газар 7. Улсын гаалийн ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4. Цагдаагийн ерөнхий газар 5. Хил хамгаалах ерөнхий газар	8. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 10.Үндэсний архивын газар 11.Гал түймэртэй тэмцэх газар 12.Оюуны өмчийн газар
Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13.Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар
Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		14.Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 15.Байгаль,ой, усны нөөцийн газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6.Зэвсэгт хүчний жанжин штаб 7.Иргэний хамгаалалтын газар	
Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		16.Иргэний нисэхийн ерөнхий газар 17.Түлш, эрчим хүчний ерөнхий газар 18.Авто замын газар 19.Барилга,хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар 20.Аялал жуулчлалын газар 21.Тээврийн газар 22.Төмөр замын Хэрэг эрхлэх газар 23.Шуудан,цахилгаан холбооны газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		24.Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар 25.Хөдөлмөр эрхлэлтийн газар 26.Улсын нийгмийн халамжийн газар 27.Хүүхдийн төлөө үндэсний газар
Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8.Стандартчилал,хэмжил зүйн төв	28.Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар 29.Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар 30.Газрын тосны Хэрэг эрхлэх газар
Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		31.Улсын мал эмнэлэг,үржлийн газар 32.Улсын нөөцийн газар
Эрүүл, мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		33.Эмнэлгийн тусламжийг удирдах газар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 163 | Улаанбаатар хот

Идлэг шонхор шувууг хамгаалах, зохистой ашиглах тухай

Идлэг шонхор шувууг хамгаалах, түүний нөөцийг зохистой ашиглах зорилгоор Байгаль орчны хамгаас боловсруулсан санал, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих эвэшээрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ан агнуурын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол орны идлэг шонхор шувууг хамгаалах, түүний өсөж үржих нөхцөл, амьдрах орчинг сайжруулах, нөөцийг нь зохистой ашиглахад чиглэгдсэн үндэсний хөтөлбөрийг 2002 онд багтаан боловсруулж Засгийн газраар батлуулахыг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

2. Идлэг шонхор шувууны тоо толгой, тархцад хийсэн анхан шатны судалгааны дүнг үндэслэн 2002-2005 онд гадаадад гаргах идлэг шонхор шувууны тоог жил бүр 300 хүртэл толгой, түүний жишиг үнийг 4600 ам.доллар, төлбөрийг 3815 ам.доллар, хураамжийг 365 ам.доллар байхаар тус тус тогтоосугай.

3. Идлэг шонхор шувууны тоо толгойн намрын судалгааны дүн, гадаадаас ирүүлсэн захиалга, шинжлэх ухааны байгууллагын саналыг харгалзан гадаадад гаргах идлэг шонхор шувууны тоог 20 хүртэл хувиар өөрчлөн зохицуулж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамжид өөрчлөлт оруулах, 2001 онд гадаадад гаргах тоог тогтоох тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 164 | Улаанбаатар хот

Гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Манай орны ой бүхий зэрлэг нутагт түймэр гарч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Завхан, Хөвсгөл, Архангай аймгийн нутаг дэвсгэрт гарсан ойн түймрийг унтраах арга хэмжээнд 37073600 (гучин долоон сая далан гурван мянга зургаан зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Улсын байнгын онцгой комисст шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрөв, уг хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж Санхүү, эдийн засгийн яаманд тайлагнахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

2. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт түймэр унтраахаар дайчлагдан ажиллаж байгаа хүмүүсийн хэрэгцээнд зориулан хавсралтад заасан ажлын хувцас, багажийг улсын нөөцөөс гаргаж Улсын байнгын онцгой комисст олгон энэ оны 8 сарын 20-ны дотор багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгаж, улсын нөөцөөс гаргасан ажлын хувцас, багажийг нөхөн бүрдүүлэхэд шаардагдах 15500000 (арван таван сая таван зуун мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, суртальчилгааг тогтмолжуулах, ой, тайгад эргүүл ажиллуулах, нэгэнт гарсан түймрийг цаг алдалгүй унтраах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласугай;

б/түймэр унтраахаар ажиллаж байгаа хүмүүсийг ажлын хувцас, багаж хэрэгсэл, хоол хүнсэнэр хангах арга хэмжээ авсугай.

4. Түймэр унтраах ажилд дайчлагдан

ажиллаж байгаа хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Ойн түймэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийг мэргэжлийн удирдлага, зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа нарт даалгасугай.

6. Жимс, самар зэрэг байгалийн баялгийг түүж ашиглах хүмүүсийг бүртгэн тэдэнд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраах сургалт явуулах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

САНХҮү, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 164 дүгээр тогтоолын хавсралт

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)
1	Ажлын хувцас	ком	300	8000.00	2400000.00
2	Ажлын гутал	хос	300	8500.00	2550000.00
3	Бээлий	хос	300	500.00	150000.00
4	Хүрз	шир	400	2500.00	1000000.00
5	Хөрөө	шир	400	7000.00	2800000.00
6	Сүх	шир	400	5000.00	2000000.00
7	"Дружба" хөрөө	шир	20	230000.00	4600000.00
Дүн					15500000.00

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Дугаар 166 Улаанбаатар хот

Урлагийн зарим байгууллагын нэр өөрчлөх тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сонгодог урлагийн академик театрыг Дуурь, бүжгийн эрдмийн театр, Үндэсний жүжгийн академик театрыг Драмын эрдмийн театр, Улсын ардын дуу, бүжгийн чуулгыг Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга гэж тус тус өөрчлөн нэрлэж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд ажиллуулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын "Мэргэжлийн зарим байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай" 1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 98 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 167 | Улаанбаатар хот

Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чойсүрэнгийн Баатарыг Нью-Йорк дахь НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчээр томилсугай.

2. Гадаадад ажиллах томилолтын хугацаа дуусч байгаатай холбогдуулан Жаргалсайханы Энхсайханыг Нью-Йорк дахь НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр | Дугаар 169 | Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам, холбогдох байгууллага, хамт олны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Сайхан сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын баатар Жамъянгийн Лхагвасүрэнгийн;

2. Архангай аймгийн Өлзийт сумын соёлын төвийг Монгол Улсын ардын жүжигчин Дэндэвийн Чимэд-Осорын;

3. Төв аймгийн Мөнгөнморьт сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Цэндийн (өвгөөдэй) Дамдинсүрэнгийн;

4. Дорнод аймгийн Дашбалбар сумын 10 жилийн дунд сургуулийг төр, нийгмийн зүтгэлтэн Санжаасүрэнгийн Зоригийн;

5. Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар Базарын Ширэндэвийн;

6. Улсын багшийн их сургуулийн Багшийн сургуулийг Монгол Улсын гавьяат багш Дондогийн Цэвэгмидийн;

7. Өмнөговь аймгийн Манлай сумын 8 жилийн дунд сургуулийг Ардын хувьсгалын партизан Дамирангийн Нанзадын нэрэмжит тус тус болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр | Дугаар 170 | Улаанбаатар хот

Сургалтын зардлын жишиг тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагцагчид ногдох жилийн сургалтын зардлын жишгийг хавсралт ёсоор батална.

2. Дээд боловсрол эзэмшихэд нэг сурагцагчид ногдох жилийн сургалтын зардлын жишгийг баримтлан сургуулийнхаа сургалтын төлбөрийн хэмжээг тогтоон мөрдөхийг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 170 дугаар тогтоолын хавсралт

ДЭЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ЖИЛИЙН СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ЖИШИГ

№	Сургуулийн нэр	Зардлын жишиг (мянган төгрөгөөр)
1.	Монгол Улсын Их сургууль	280.0
2.	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	282.0
3.	Анагаах ухааны их сургууль	300.0
4.	Улсын багшийн их сургууль	270.0
5.	Хөдөө аж ахуйн их сургууль	250.0
6.	Соёл, урлагийн их сургууль	290.0
7.	Хүмүүнлэгийн их сургууль	280.0
8.	Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль	230.0
9.	Дурслэх урлагийн дээд сургууль	240.0
10.	Ховд дахь МУИС-ийн салбар	260.0
11.	Улаанбаатар хот дахь Анагаах ухааны коллеж	190.0
12.	Говь-Алтай дахь Анагаах ухааны коллеж	190.0
13.	Дархан-Уул дахь Анагаах ухааны коллеж	190.0
14.	Дорноговь дахь Анагаах ухааны коллеж	240.0
15.	Баян-Өлгий дахь Багш, соёлын сургууль	190.0
16.	Архангай дахь Багшийн коллеж	190.0
17.	Дорнод дахь Багшийн коллеж	190.0
18.	Дизайн урлагийн коллеж	240.0
19.	Соёлын коллеж	250.0
20.	Завхан дахь Эдийн засгийн коллеж	225.0
21.	Шаталсан сургалттай мэргэжлийн сургуулийн дипломын сургалт	160.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 173 Улаанбаатар хот

Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 35 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал болон одоо мөрдөгдөж байгаа бусад хөтөлбөр, үзэл баримтлалыг шинэчлэн баяжуулж, тодотгох үндэсэн дээр 2021 он хүртэлх Монгол Улсын үндэсний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж Засгийн газарт 2003 оны I улиралд багтаан танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Б.Чадраа нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 174 Улаанбаатар хот

Нэмэгдэл олгох тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төсвийн байгууллагын ажилтны цалинг нэмэгдүүлэх зорилттой уялдуулан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Аудитын тухай хуулийн дагуу шалгалт өгч мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан бөгөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан нарт уг эрх нь хүчин төгөлдөр байх хугацаанд олгох мэргэжлийн зэргийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 15 хувьтай тэнцэх хэмжээтэй байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4–ний өдөр | Дугаар 175 | Улаанбаатар хот

Эрчим хүчний салбарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшин, эрчим хүчний салбарын хүндрэлтэй байдлыг харгалзан Баруун болон Дорнод бүсийн эрчим хүчний систем, Даланзадгадын дулааны цахилгаан станц, Налайхын дулааны станцын ахуйн хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний үнэд улсын төсвийн 2002 оны тодотголын дагуу улсын төсвөөс 2002 оны сүүлийн хагас жилд 994.9 (есөн зуун ерэн дөрвөн сая, есөн зуун мянган) сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 24–ний өдөр | Дугаар 264 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинээр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийг /цаашид Эрүүгийн шинэ хууль гэнэ/ 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон билээ.

Энэхүү шинэ хуулиар урьд нь гэмт хэрэгт тооцож байсан зарим хэргийг гэмт хэрэгт тооцохгүй байх, зарим үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох болон зарим төрлийн ялыг хүчингүй болгох буюу хугацаа, хэмжээг нь өөрчлөх, зарим ялыг шинээр буй болгож ялын төрөлд үндсэн өөрчлөлт оруулсны дээр зарим зүйлд заасан хорих ялын доод хэмжээг өсгөх буюу дээд хэмжээг багасгах зэрэг үндсэн өөрчлөлтүүдийг оруулав.

Иймд Эрүүгийн шинэ хуулийн Ерөнхий ангийн 12 дугаар зүйлд зааснаар оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод, дээд хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх доод хэмжээнд нийцүүлэх, хасах зэргээр хуульд нийцүүлэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн шинэ хуульд зааснаар 1987 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 74[1] дүгээр зүйл /Хүний цус, эд эрхтэнг хууль бусаар хил нэвтрүүлэх/, 89 дүгээр зүйл /Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж бусдыг алах/, 91 дүгээр зүйл /Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 93 дугаар зүйл / Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулах/, 95 дугаар зүйл /Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах/, 96 дугаар зүйл /Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл болгоомжгүй учруулах/, 99 дүгээр зүйл /Зодох/, 101 дүгээр зүйл /Алах, хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх/, 114 дүгээр зүйл /Эмэгтэй хүнийг тулган хавьчиж хурьцал үйлдэх/, 119 дүгээр зүйл /Эмэгтэй хүнийг гэрлүүлэхээр албадах буюу гэрлэхэд нь саад хийх/, 127[1] дүгээр зүйл / Банкнаас авсан зээлийг төлөхөөс санаатайгаар зайлсхийж их хэмжээний хохирол учруулах/, 132 дугаар зүйл /Тээврийн хэрэгсэл, машин буюу механизмыг шунахай зорилгоор дур мэдэн ашиглах/, 133 дугаар зүйл /Эрчим хүч ашиглах журам зөрчих/, 135 дугаар зүйл /Бусдын эд хөрөнгийг болгоомжгүй устгах, гэмтээх/, 136 дугаар зүйл /Машин, механизмыг хайр гамгүй ашиглах, хадгалах/, 142 дугаар зүйл / Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг зөрчих/, 143 дугаар зүйл /Шүүмжилсэн иргэнийг мөрдөн хавчих/, 149 дүгээр зүйл /Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй эх буюу ганц бие эцгийг ажлаас халах/, 163 дугаар зүйл /Стандартын болон хэрэглээний шаардлага хангаагүй, чанар муутай,иж бүрдэл дутуу,чанарын баталгаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх /, 164 дүгээр зүйл / Улсын тайлан мэдээг санаатай худал гаргаж мэдээлэх/, 166 дугаар зүйл /Малтай хатуу ширүүн харьцах/, 167 дугаар зүйл /мал эмнэлгийн журам зөрчих/, 168 дугаар зүйл / Хадлан, тариалан, суулгац, тарьцыг санаатай устгах/, 174 дүгээр зүйл /Бензин болон шатах тослох материалыг хууль бусаар олгох/, 175[2] дугаар зүйл /Хориглосон зар сурталчилгаа эрхлэх/, 176[2] дугаар зүйл /Валютын гүйлгээний журам зөрчих/, 176[3] дугаар зүйл /Банкны зээл, санхүүгийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх борлуулах, ашиглах/, 177[2] дугаар зүйл /Гэрээний тухай хууль тогтоомж зөрчих/, 177[3] дугаар зүйл /Нотариатын тухай хууль тогтоомж зөрчих/, 179 дүгээр зүйл /Шуудангийн төлбөрийн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх/, 180 дугаар зүйл / Зорчигчийн билетийг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 181 дүгээр зүйл /Недрийг ашиглах, алт бусад үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчих/, 182 дугаар зүйл /Газар эдэлбэрийн хууль тогтоомж зөрчих/, 193[2] дугаар зүйл /Дархлаажуулалтыг зохион байгуулах үүргээ хангалтгүй биелүүлэх/, 213 дугаар зүйл / Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны шаардлагад зориуд захирагдахгүй байх/, 228 дугаар зүйл /Цэргийн үүрэгтэн цэргийн тоо бүртгэлээс зайлсхийх/, 231 дүгээр зүйл /Захиргааны хяналтын журам ноцтой зөрчих/ , 232 дугаар зүйл /Гэрлэлтээ бүртгүүлэхдээ гэрлэхэд харшлах шалтгааныг нуух буюу худал мэдэгдэх/, 233 дугаар зүйл /Одон, медаль хулгайлах, худалдах, худалдан авах, арилжих, хуурамчаар үйлдэх/, 236 дугаар зүйл /Сүсэг бишрэлийг далимдуулан мэхлэх/, 258 дугаар зүйл /Түүх, соёлын дурсгалт зүйлсийг санаатай устгах, эвдэх, гэмтээх/, 261 дүгээр зүйл /Согтуу үедээ тээврийн хэрэгсэл жолоодох/, 264 дүгээр

зүйл /Тээврийн талаар дагаж мөрдөж байгаа журам зөрчих/, 270 дугаар зүйл /Даргадаа захирагдахгүй байх/, 277 дугаар зүйл /Дур мэдэн чөлөөгүй явах/, 278 дугаар зүйл /Анги буюу албаа хааж байгаа газраа дур мэдэн орхих/, 280 дугаар зүйл /Байлдааны байдалд ангиа дур мэдэн орхих/, 297 дугаар зүйл /Цэргийн олзлогдсон албан хаагч гэмт үйлдэл хийх/, 299 дүгээр зүйл /Цэргийн ажиллагаа явагдаж байгаа нутгийн хүн амд хүч хэрэглэх/, 300 дугаар зүйл /Олзлогдогчидтой хатуу ширүүн харьцах/, 301 дүгээр зүйл /Улаан загалмай тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах/ зэрэг нь гэмт хэрэгт тооцогдохгүй бөгөөд эдгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлөх бөгөөд хэрэв хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд байгаа бол тус тусын шатанд 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгоно.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт шийтгүүлж ял эдэлсэн буюу энэ тогтоолын дагуу ялаас чөлөөлөгдсөн хүмүүсийг ял шийтгэлгүйд тооцно.

3. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт урьд нь ял шийтгүүлж, уг зүйл, хэсгээр оногдуулсан ял нь Эрүүгийн шинэ хуулиар гэмт хэрэгт тооцогдох зүйл, хэсгээр оногдуулсан ялд багтсан бол эдэлсэн ялыг хувь тэнцүүлэн тооцож, гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялаас чөлөөлж, гэмт хэрэгт тооцсон нь хэвээр байгаа зүйл, хэсгээр оногдуулсан ялын эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлнэ.

Харин гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялд Эрүүгийн шинэ хуулиар гэмт хэрэгт тооцсон хэвээр байгаа зүйл, хэсгээр оногдуулсан ялыг багтаасан байвал эдэлсэн ялыг хувь тэнцүүлэн тооцож, багтаасан хүнд ялаас хугацааг харгалзахгүй чөлөөлж, уг багтсан ялаас эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлнэ. Хэрэв уг багтсан ялыг эдэлсэн байвал ялаас бүрэн чөлөөлнө.

Түүнчлэн гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялыг өөр зүйл, хэсгээр оногдуулсан ялтай нэмж нэгтгэсэн байвал гэмт хэрэгт тооцогдохгүй болсон зүйл, хэсгээр оногдуулсан ялыг шууд хасч тооцно.

4. 2002 оны 09 дүгээр сарын 01-нээс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Эрүүгийн шинэ хуулийн зохих зүйл, хэсэгт зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын дээд хэмжээнээс дээгүүр байвал уг ялыг шинэ хуульд заасан дээд хэмжээнд нийцүүлэн хасна.

5. 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Эрүүгийн шинэ хуульд гэмт хэрэгт шинээр тооцохоор заасан зүйл, хэсгүүдийг 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 00 цагаас хойш үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд хэрэглэнэ.

6. 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Эрүүгийн шинэ хуулийн зүйл, хэсгийн заалтаас урьд дагаж мөрдөж байсан 1987 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн нь хасагдсан байвал чухамхүү тэр бүрэлдэхүүнээр

шийтгүүлсэн хүмүүсийг эдлээгүй үлдсэн ялаас чөлөөлж, ял шийтгэлгүйд тооцно. Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь хасагдсан боловч өөр төрлийн гэмт хэрэгт хүндэрч зүйлчлэгдсэн бол ялаас чөлөөлөхгүй, ял шийтгэлгүйд тооцохгүй.

7. Тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр шийтгүүлж, одоо ял эдэлж байгаа этгээдийн үйлдэл нь Эрүүгийн шинэ хуулиар тухайн гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэх болсон буюу хорихоос өөр хөнгөн ял оногдуулж болох зүйл, хэсгээр зүйлчлэгдэх болсон бол уг хэргийг хянаж байгаа шүүх буюу уг ялыг эдлүүлж байгаа газрыг харъяалах шүүх болон харьяалал тогтоосон шүүхийн шүүгч захирамж, шүүх тогтоол гарган хуульд нийцүүлж шийдвэрлэнэ.

8. Эрүүгийн шинэ хуулиар тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээ урьдах хуульд зааснаас дээшилж тогтоогдсон бол гэмт этгээдэд оногдуулсан буюу оногдуулах ялыг хүндрүүлэхгүй бөгөөд энэ нь 2002 оны 09 дүгээр сарын 01-нээс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт хамаарна. Харин одоо дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгт ял эдэлж байгаа буюу шийтгүүлж байгаа этгээдийн хорих ялын доод хэмжээ багассан тохиолдолд 1987 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсгийн доод хэмжээгээр оногдуулсан ялыг Эрүүгийн шинэ хуульд заасан доод хэмжээнд нийцүүлэн хасч тогтооно.

9. Нэг төрлийн гэмт хэргийг давтан болон үргэлжилсэн үйлдлээр хийсний сүүлчийн үйлдэл нь 2002 оны 09 дүгээр сарын 01-нээс хойш гарсан байвал Эрүүгийн шинэ хуулиар зүйлчилж шийдвэрлэнэ.

10. Энэхүү тогтоолын 1-д заасан ажиллагааг 2002 оны 10 дугаар сарын 01-ний дотор, 7-8-д заасан ажиллагааг 2002 оны 12 дугаар сарын 01-ний дотор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад байгаагаас бусад хэргийн тухайд шүүгч захирамж, шүүх тогтоолоор гүйцэтгэнэ.

11. Монгол Улсын Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай Монгол Улсын 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хууль, энэ тогтоолыг биелүүлэх ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран зохион байгуулж, дүнг энэ тогтоолын зүйл нэг бүрээр гарган 2002 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Дээд шүүхэд ирүүлэхийг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарт, хяналт тавьж ажиллахыг Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим /Д. Батсайхан/-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч. ГАНБАТ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ Д. БАТСАЙХАН

ШҮҮГЧ Б. ДАНГААСҮРЭН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (275)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Орон нутгийн замын сан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай*

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ИЛТГЭЛ:

- *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2002 он*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны аравдугаар сарын 16 №38 (275)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

521. Байнгын хорооны гишүүнээр батлах тухай Дугаар 64 1195

522. "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүцаах тухай Дугаар 65 1196

523. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай Дугаар 66 1196

524. Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 67 1196

525. Дэд хорооны гишүүнээр батлах тухай Дугаар 69 1196

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

526. Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай Дугаар 133 1197

527. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 144 1197

528. Дүрэм, журам батлах тухай Дугаар 148 1197

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

529. Орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай Дугаар 176 1204

530. Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай Дугаар 177 1209

531. Журам батлах тухай Дугаар 178 1210

Дөрөв. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ИЛТГЭЛ

532. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2002 он 1212

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн С.Батболдыг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 4–ний өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын түүхийн хөгжлийн үе шат, өнөөгийн байдлыг тодорхойлоход эрдэмтэд, судлаачдын санал, дүгнэлтийг авах, холбогдох хуулиар нэгэнт зохицуулагдсан харилцааг давхардуулахгүй байх, зарим нэр томъёог тодруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн болон бусад тооцоо, авах арга хэмжээний жагсаалтыг гаргах нь зүйтэй байгаа зэрэг үндэслэлүүдээр дахин боловсруулахаар хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 10–ны өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2, 61.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэнхүүгийн Шаравдоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2002 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 10–ны өдөр | Дугаар 67 | Улаанбаатар хот

Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдийн авч байгаа нөхөн олговрын доод хэмжээг сард 22600 төгрөгөөр тогтоож, 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 11–ний өдөр | Дугаар 69 | Улаанбаатар хот

Дэд хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Батболдыг Нутгийн өөрөө удирдах ёсны дэд хорооны гишүүнээр батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 133 | Улаанбаатар хот

Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай

Найман зуу гаруй жилийн тэртээд 335 алд газар харван байг онож дээд амжилт тогтоосон Есөнхэя мэргэний аварга амжилтыг бахархан тэмдэглэж, хөшөө чулуунд сийлүүлсэн нь Чингисийн чулууны бичиг гэж алдаршиж, сурын спортод зориулсан дэлхийн анхны хөшөө болсон билээ. Иймэндэр уламжлалтай монгол үндэсний сурын харваа нь эрийн гурван наадмын бүрэлдхүүн хэсэг, монгол хүний ёс суртахуун, гоо зүй, зан үйлийн олон сайхан өв уламжлалыг шингээсэн, хурц хараа, хүч чармайлт, эв дуй шаарддаг спортын чухал нэгэн төрөл билээ.

Төрийн ёслол, наадам, баяр цэнгэлд сурын харвааны эзлэх байр суурийг өндөрт өргөж хөгжүүлэхэд төрийн бүх шатны байгууллагын туслалцаа, дэмжлэг, санаачилга оролцоо эн тэргүүнээ нэн чухал байна.

Үндэсний сурын харваг орон даяар бүх нийтийг хамруулан жигд хөгжүүлж, залуу үедээ өвлүүлэх зорилгоор Монгол Улсын Үндэсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой 2006 онд тохиож түүнийг монголын төр ёсны их баяр болгон тэмдэглэхтэй холбогдуулан манай орны төв, хөдөөд үндэсний сурын харваг хөгжүүлэх, эрийн гурван наадмаа эн тэгш байдлаар хийдэг түүхэн уламжлалаа өндөрт өргөн дээдлэх талаар Монголын үндэсний сурын холбоо, сурчдаас гаргасан санаачилгыг дэмжихийг нийт ард иргэд, аймаг, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, спортыг ивээн тэтгэгчдэд уриалсугай.

2. Үндэсний уламжилалт сурын харваг улам хөгжүүлж, дэлгэрүүлэхийн тулд залуу үед сурын харвааны арга барилыг өвлүүлэх, зааж сургах, харваачдыг олноор бэлтгэх, нум сумны үйлдвэрлэлийг дэмжих, төв, орон нутагт болох баяр наадмаараа үндэсний сурын уралдаан, тэмцээн зохиодог заншил тогтоох зэрэг цогцолбор асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 144 | Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Нямдоржийн Пүрэвийг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Тойдонгийн Даваасүрэнг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Төмөрийн Өнөрийг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 148 | Улаанбаатар хот

Дүрэм, журам батлах тухай

"Прокурорын байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 2, 41 дүгээр зүйлийн 5, 44 дүгээр зүйлийн 4 дэх заалтуудыг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1."Прокурорын ёс зүйн дүрэм" –ийг 1 дүгээр хавсралтын, "Прокурорын сахилгын дүрэм"- ийг 2 дугаар хавсралтын, "Прокурорын зэрэг дэв олгох дүрэм"- ийг 3 дугаар хавсралтын, "Прокурорын байгууллагын бэлгэдэл, прокурорын энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журам"-ыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

2.Энэ зарлиг батлагдсантай холбогдуулан "Прокурорын сахилгын дүрэм батлах тухай"Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 73, "Журам батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 212, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 89 дүгээр зарлигуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн нэгдүгээр хавсралт

ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж хамгаалах зарчим, хэм хэмжээ, хуульд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгаж чиг үүргээ чин шударгаар хэрэгжүүлэх гол нөхцөл мөн.

Прокурор ёс зүйн зөрчил гаргах нь нийгмээс прокурорт итгэх итгэлийг алдагдуулах, прокурорын байгууллагын нэр хүндийг бууруулах сөрөг үр дагавартай тул прокурор бүр ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдөвөл зохино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт

1.1 Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт нь прокурорын үйл ажиллагааг дагаж мөрдөх ёс зүй, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, прокурорын нэр төрийг хамгаалахад оршино.

2 дугаар зүйл.Прокурорын ёс зүйн хэм хэмжээ

2.1 Прокурор нь төрийн тусгай албан хаагч, өвөрмөц чиг үүрэг бүхий албан тушаалтан болохын хувьд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдөвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг прокурорын ёс зүйн хэм хэмжээ гэнэ.

2.2 Прокурорын ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэхдэ дараахь зарчмыг баримтлана.

2.2.1 Хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах;

2.2.2 Хуулийг хүндэтгэн дээдэлж, чанд сахин биелүүлэх;

2.2.3 Прокурорын байгууллага нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;

2.2.4 Прокурор гадны нөлөөнд үл автах;

2.2.5 Хуулийг нэг мөр хэрэглэх;

2.2.6 Прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгах

Хоёр. Прокурорын ёс зүйн тусгайлсан хэм хэмжээ

3 дугаар зүйл. Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад баримтлах ёс зүйн хэм хэмжээ

3.1. Прокурор нь хяналтын чиг үүргээ мэргэшлийн өндөр түвшинд,хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.2. Прокурор нь хэргийн оролцогч, өмгөөлөгчидтэй харицахдаа ямарваа ялгаварлал байдал гаргахгүйгээр тэдэнд хүндэтгэлтэй хандаж, түхайн хэргийг шударга, зөв шийдвэрлүүлэх итгэл үнэмшлийг төрүүлж чадахуйц мэдлэг, харьцааны соёлтой байна.

3.3. Прокурор нь хэргийн оролцогч болон бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа аашилж зандрах, айлган сүрдүүлэх, доошин хэрцгий харьцах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргахгүй байна.

3.4. Прокурор нь хувийн сонирхлын үүдэнээс харьяаллын бус,бүсдын хяналтад байгаа хэрэг материалтай танилцах, зөвлөгөө өгөх,хэрэг буртгэгч,мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавихыг цээрлэх, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлэхгүй байна.

3.5. Прокурор нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг, материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах, саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөс бусад тохиолдолд хэрэг, материалын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нөлөөлүүлэхгүй байна.

3.6. Прокурорт хандаж гаргасан байгууллага, иргэдийн хүсэлт, гомдол, мэдээлэлд анхааралтай хандаж шуурхай шийдвэрлэж байна.

3.7. Ойр дотно харилцаатай хүмүүс, өмнө нь ажилласан байсан, эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэний хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй.

4 дүгээр зүйл. Хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ

4.1. Прокурор дараахь үйл ажиллагааг явуулахыг хориглоно.

4.1.1. Прокурорын хяналтын чиг үүрэгтэй холбогдолгүй асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох;

4.1.2. Багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхдээ тэдгээр байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох;

4.1.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр прокурорын байгууллагын нэр хүндэд харш суртагчилгаа хийх;

4.2. Прокурор нийгэм, соёлын арга хэмжээнд оролцохдоо уг үйл ажиллагаа, арга хэмжээ нь прокурорын байгууллагын нэр хүндэд харшлахаар бол түүнээс татгалзана.

4.3. Албан үүргээ хэрэгжүүлэхэд харшлах, эсхүл сергеэр нөлөөлөх, прокурорын албан тушаалыг ямар нэг байдлаар ашиглахыг санаархсан аливаа хэлцэл, үйл ажиллагаанаас зайлсхийнэ.

4.4. Прокурорын албан тушаалд харшлах үндэслэл бухий хөрөнгө оруулалт, бизнесийн бусад ашиг сонирхлоос татгалзана.

4.5. Албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан аливаа мэдээллийг өөрийн санхүүгийн эх үүсвэр болгон ашиглахгүй.

5 дугаар зүйл. Прокурорын улс төрийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт

5.1. Прокурор улс төрийн дараах үйл ажиллагаанд оролцохыг хоригломо:

5.1.1. Бүх шатны улс төрийн сонгуулийг зохион байгуулах байгууллагын бүрэлдэхүүнд орох;

5.1.2. Улс төрийн аливаа байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаал эрхлэх.

5.1.3. Улс төрийн сонгуульд нэр дэвшигчид хөрөнгө менгө олж өгөхөөр амлах, зуучлах, хандив өргөх, бусад туслалцаа үзүүлэх;

6 дугаар зүйл. Прокурор биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ

6.1. Прокурор нь өөрийн бүхий л үйл ажиллагаа, биеэ авч явах байдлаараа прокурорын байгууллагын нэр хүндийг хамгаалж, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж байна.

6.2. Албан үүргээ хэрэгжүүлэх болон эрх бүхий байгууллагаас шаардсанаас өөр тохиолдолд бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар тодорхойлохгүй.

6.3. Хувийн журмаар эрдэм шинжилгээний ажил эрхлэх, багшлах, зохиол бүтээл туурвих, хэвлэн нийтлэх, гэрээ хэлцэл байгуулахад прокурорын албан тушаал, прокурорын байгууллагын нэр хүндийг ашиглахаас зайлсхийнэ.

6.4. Дүрэмт хувцастай яваа үедээ, түүнчлэн албан үүрэг гүйцэтгэж явах үедээ бүюу ажлын байранд, эсхүл байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчтэй учуу согтуурахыг хоригломо.

6.5. Прокурор учуу согтууран эрүүлжигдэх, захиргааны арга хэмжээ авагдах, бусадтай зүй бусаар харьцах, бусдыг дорломхолхыг цээрлэнэ.

Гурав. Прокурорын ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх

7 дугаар зүйл. Прокурорын ёс зүйн зөрчил

7.1. Прокурорын ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон прокурорын ёс зүйн хэм хэмжээг сanаатай буюу санамсаргүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

8 дугаар зүйл. Ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх

8.1. Прокурор ёс зүйн зөрчил гаргасан тухай дараахь хүсэлт, гомдлыг үндэслэн шалгалт явуулна:

8.1.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, шүүгч хүсэлт гаргасан;

8.1.2. Иргэн, албан тушаалтан, байгуллага гомдол, мэдээлэл ирүүлсэн;

8.1.3. Эрүүгийн болон иргэний хэргийн оролцогчид, тэдгээрийнх хууль ёсны төлөөлөгчийн гомдол, хүсэлт;

8.2. Прокурор ёс зүйн зөрчил гаргасан байж болзошгүй гэж үзэх үндэслэл байвал дээд шатны прокурор өөрийн санаачлагаар шалгалт явуулж болно.

9 дүгээр зүйл. Ёс зүйн дүрмийг биелүүлээгүйгээс гарах үр дагавар

9.1. Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь прокурорт Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

9.2. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулахдаа энэ дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг урьдчилан шалгаж тогтоосон байна.

10 дугаар зүйл. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа

10.1. Ёс зүйн зөрчлийг "Прокурорын сахилгын дүрэм"-д заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн хөрдүгаар хавсралт

ПРОКУРОРЫН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Прокурорт сахилгын шийтгэл оногдуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, энэ дүрмийг баримтлана.

1.2 Прокурор хуулиар тогтоосон чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автан, гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгох, хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг өөрийн чиг үүрэгийн хүрээнд ханган, дээд шатны прокурорын шийдвэрийг заавал биелүүлэх, албан үүрэгт ажилдаа үнэнч шударга, санаачилгатай хандах, мэдлэг, мэргэшлээ байнга дээшлүүлэх, прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй.Прокурор нь байгууллагынхаа дотоод журмыг чанд сахина.

1.3 Прокурорт дараахь үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулна:

1.3.1 Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн;

1.3.2 Улсын ерөнхий прокуророос хуулийг хэрэгжүүлэх талаар гаргасан аргачилсан заавар, журмыг хэрэгжүүлээгүй;

1.3.3 Прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн;

1.3.4 Байгууллагын дотоод журмыг зөрчсөн;

1.3.5 Хуульд заасан албаны чиг үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

1.3.6 Тухайн прокурорын гаргасан шийдвэр хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн нь түүний ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалсан нь тогтоогдсон;

1.4 Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоосон байна.

Хоёр. Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг шалгах

2.1 "Прокурорын байгууллагын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан дээд шатны прокурор нь доод шатны прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл байгаа эсэх талаар шалгалт явуулна.

2.2 Аймаг, нийслэл, тээвэрийн прокурорт сахилгын шийтгэл оногдуулах эсэх үндэслэлийг Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газраас шалгана.

2.3 Шаардлагатай гэж үзвэл Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокуророос тусгайлан томилсон прокурор сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийн талаар шалгалт явуулж болно.

2.4 Энэ дүрмийн 1.3.6-д заасан үндэслэлийг мэргэжлийн зөвлөл шалгаж тогтооно.

2.5 Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг шалгах хугацаа 14 хоног байна. Зайлшгүй нэмэлт шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл шалгах хугацааг тухайн шалгалт явуулж байгаа прокурорын саналаар дээд шатны прокурор 14 хоног хүртэл сунгаж болно.

Гурав. Шалгалт явуулж дууссаны дараа явуулах үйл ажилагаа

3.1. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл тогтоогдсон гэж үзвэл шалгалтын материалтай танилцах эрхтэй болохыг тухайн прокурорт тайлбарлаж өгнө. Прокурор шалгалтын материалтай танилцсан тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулна.

3.2. Тухайн прокурор шалгалтын материалтай танилцаад тайлбар гаргах, нэмэлт шалгалт хийлгэх тухай бичгээр хүсэлт гаргах эрхтэй. Дээд шатны прокурор хүсэлтийг хянаж үзээд үндэслэлгүй гэж үзсэн бол тэр тухай хүсэлт гаргасан прокурорт хариу өгөх, эсхүл үндэслэлтэй гэж үзвэл нэмэлт шалгалт явуулна.

3.3. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл тогтоогдоогүй бол дээд шатны прокурорт танилцуулж, шалгалтын материалыг архивын нэгж болгон хадгална.

3.4. Шалгалтыг иргэн, байгууллага, албан тушаалтны гомдол, мэдээллийн дагуу явуулсан боловч прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлгүй байна гэж үзсэн бол энэ тухай тэдэнд албан ёсоор хариу өгнө.

Дөрөв. Сахилгын шийтгэл оногдуулах

4.1. Тухайн прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд уг асуудлыг Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

4.2. Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын эвдрэлийн хуралдаанд тухайн прокурорыг өөрийн биеэр байлцуулж, сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийн талаар шалгасан албан тушаалтан танилцуулна. Харин прокурор өөрөө хүсэлт гаргаагүй бол Улсын ерөнхий прокурорын дэргэдэх эвдрэлийн хуралдааны түүнийг оролцуулахгүй байж болно.

4.3. Тухайн прокурорыг албан үүргээ хэрэгжүүлэхдээ мэргэжлийн алдаа гаргасан гэж мэргэжлийн эвдрэлийн дүгнэлт гаргасан бол уг асуудлыг эвдрэлийн хуралдаанаар хэлэлцүүлэхгүй бөгөөд Улсын ерөнхий прокурор мэргэжлийн эвдрэлийн дүгнэлтийг үндэслэн сахилгын шийтгэл оногдуулна.

4.4. Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын дэргэдэх эвдрэлийн хуралдаанаар прокурорт сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлыг хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана.

4.4.1. Прокурорын байгууллагын тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулахыг Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорт эвдлөх;

4.4.2. Шалгалт дутуу хийгдсэн гэж үзвэл дахин шалгалт хийлгэх, нэмэлт баримт шаардан авах;

4.4.3. Тухайн прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлгүй гэж үзвэл шалгасан прокурорын болон доод шатны прокурорын саналыг хэрэгсэхгүй болгож, энэ тухай санал ирүүлсэн прокурор болон гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэн, байгууллага, албан тушаалтанд хариу өгөх;

4.4.4. Тухайн прокурорын үйлдэл, үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлэх.

4.5. Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын дэргэдэх эвдрэлийн хуралдаан Прокурорын байгууллагын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4-т заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулах үндэслэлтэй гэж үзвэл Улсын ерөнхий прокурорт энэ талаар санал тавих бөгөөд шалгалтын материалыг эвдрэлийн хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын ерөнхий прокурорын газарт нэн даруй хүргүүлнэ.

4.6. Сум, сум дундын ахлах прокурор харьяа прокурортоо сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлтэй гэж үзвэл шалгасан материалыг саналын хамт дээд шатны прокурорт уламжилна.

4.7. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулахдаа гаргасан зөрчлийн шинж байдал, шалтгаан, нөхцөл, зөрчил гаргагчийн хувийн байдал зэргийг харгалзана.

4.8. Прокурорт сахилгын шийтгэлийг Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын тушаалаар оногдуулна.

4.9. Сахилгын шийтгэлийн төрлийг нэг зөрчилд давхардуулан оногдуулж болохгүй.

4.10. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулахдаа Прокурорын байгууллагын тухай хууль, Прокурорын сахилгын дүрмийн аль заалтыг баримталж байгаагаа тушаалдаа заавал дурдсан байна. Харин прокурорын гаргасан зөрчил нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой, эсхүл байгууллагын дотоод журмыг зөрчсөн бол Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол Прокурорын ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг тус тус давхар баримталж, сахилгын шийтгэл оногдуулна.

4.11. Сахилгын шийтгэл хүлээсэн прокурор шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл нэг сарын дотор дээд шатны прокурорт болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.

4.12. Сахилгын шийтгэл оногдуулсан тушаалыг тухайн прокурорт танилцуулж, түүний хувийн хэрэгт шалгасан материалын хамт хадгалах бөгөөд шаардлагатай гэж үзвэл сахилгын шийтгэл оногдуулсан тухай хамт олонд нь мэдээлнэ.

Тав. Сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа

5.1.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор, сахилгын зөрчил гаргасныг хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл оногдуулж болно.

5.2. Энэ дүрмийн 5.1-д заасан хугацааг тухайн прокурорын хувьд дараахь хугацаагаар хамааруулахгүй.

5.2.1. Өвчтэй байсан хугацаа /энэ нь эмнэлгийн байгууллагын магадлагаа, дүгнэлтээр нотлогдсон бол/;

5.2.2. Ээжлийн амралт эдэлж байсан хугацаа;

5.2.3 Жирэмсний амралттай байсан хугацаа;

5.2.4. Захиргааны чөлөөтэй байсан

хугацаа;

5.2.5. Гадаад улсад албан томилолтоор ажилласан хугацаа;

5.2.6. Ажлаасаа түр чөлөөлөгдөн гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан хугацаа;

Зургаа. Сахилгын шийтгэлийг арилгах

6.1. Сахилгын шийтгэл оногдуулснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.

6.2. Сахилгын шийтгэл хүлээсэн прокурор нь гаргасан зөрчлөө бүрэн засч, үүрэгт ажлаа үлгэр жишээчээр биелүүлж, засарч хүмүүжсэнээ харуулсан бөгөөд шийтгэл оногдуулсанаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол дээд шатны прокурор уг шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусахаас өмнө арилгаж болно.

6.3. Сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө арилгахдаа дараахь үндэслэлийг харгалзана:

6.3.1. Сахилгын шийтгэл хүлээсэн прокурорын хүсэлт;

6.3.2. Сахилгын шийтгэлийг хугацааны өмнө арилгуулах тухай доод шатны прокурорын санал;

6.4. Сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө арилгахдаа Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурор тушаал гаргана.

6.5. Албан тушаал бууруулах шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцсон, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаанаас өмнө арилгасан нь тухайн прокурорыг өмнөх албан тушаалд эгүүлэн томилох үндэслэл болохгүй.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн гуравдугаар хавсралт

ПРОКУРОРЫН ЗӨРЭГ ДЭВ ОЛГОХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1."Прокурорын зөрэг дэв олгох дүрэм" нь прокурорт зөрэг дэв олгох, хүчингүй болсонд тооцох журмыг тогтооно.

1.2. "Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар прокурор нь төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх,хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөхийн зөрэг дэвтэй байна.

1.3. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зөрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар, бусад прокурорын зөрэг дэвийг Монгол Улсын ерөнхий прокурорын тушаалаар олгоно.

1.4. Прокурорын зөрэг дэвийн нэмэгдлийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр зөрэг дэв олгосон шийдвэр гарсан өдрөөс эхлэн сар бүр олгоно.

Хоёр. Прокурорт зөрэг дэв олгох, хүчингүй болсонд тооцох

2.1. Прокурорт зөрэг дэв олгохдоо албан тушаалын ангиллыг дараахь байдлаар харгалзана:

Зөрэг дэв	Албан тушаал
Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурор
Төрийн хууль цаазын шадар зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч
Хууль цаазын итгэмжит зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, аймаг, нийслэл,тээвэр, дүүргийн прокурор
Хууль цаазын ахлах зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын орлогч, туслах прокурор, сум, сум дундын ахлах прокурор,
Хууль цаазын зөвлөх	Аймаг, нийслэл, тээвэр, сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор

2.2. Прокурорт зөрэг дэв олгохдоо түвшин, ажил хэргийн чадвар, прокурорын ёс зүйн Прокуророор ажилласан хугацаа, мэргэшлийн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзана:

Зэрэг дэв	Зэрэг дэв олгоход харгалзах үзүүлэлтүүд		
	Прокуророор ажилласан хугацаа	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар	Ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдал
Хууль цаазын итгэмжит зөвлөх	5 жилээс доошгүй	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр хангалттай үнэлгээ авсан	Сахилгын шийтгэл хүлээгээгүй буюу хүлээсэн боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан
Хууль цаазын ахлах зөвлөх	3 жилээс доошгүй		
Хууль цаазын зөвлөх	1 жилээс доошгүй		

2.3. Хууль хамгаалах байгууллагад урьд нь хуульч мэргэжлээр ажиллаж байсан хүн прокуророор томилогдвол түүний ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг харгалзан тухайн албан тушаалын ангилалд тохирох прокурорын зэрэг дэвийг шууд олгож болно.

2.4. Прокурорын албан тушаалын ангиллыг дээшлүүлэх, эсхүл бууруулах тохиолдолд урьд нь олгосон зэрэг дэвийг өөрчилж, шинэ албан тушаалын ангилалд тохирох прокурорын зэрэг дэвийг олгоно.

2.5. Эрхэлсэн ажилдаа онцгой үр бүтээл гарган ажиллаж байгаа прокурорт албан тушаалд нь тохирох зэрэг дэвийг зохих хугацаанаас өмнө, эсхүл нэг шат дээгүүр зэрэг дэвийг олгож болно.

2.6. Прокурорын албан тушаалд ажиллаж байгаад тэрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон үндэслэлээр чөлөөлөгдсөн хүн прокуророор дахин томилогдсон тохиолдолд прокурорын тухайн албан тушаалын ангилалд тохирох зэрэг дэвийг олгоно.

2.7. Прокурор хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын албан тушаалаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн прокурорын зэрэг дэв хүчингүй болсонд тооцогдоно.

2.8. Прокурорын зэрэг дэв олгох хугацаа болсон боловч мэргэшлийн түвшин хангалттүй, прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд тухайн албан тушаалын ангилалд тохирох зэрэг дэвийг олгохгүй.

2.9. Хуульд зааснаар ажлаас халахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарч, албан тушаал бууруулсан тохиолдолд уг прокурорын зэрэг дэвийг буурууллж болно.

2.10. Энэ дүрэмд зааснаас бусад тохиолдолд прокурорт олгосон зэрэг дэвийг буурулах буюу хүчингүй болгохыг хориглоно.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн дөрөвдүгээр хавсралт

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭДЭЛ, ПРОКУРОРЫН ЭНГЭРИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР, ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын прокурорын байгууллага, прокурор нь хууль ёс, төрөө дээдлэн хүндлэгч, шударга үнэнийг эрхэмлэгч улс, нийгэм, иргэнийг аливаа гэмт явдлаас хамгаалан тэмцэгч гэсэн агуулгыг илэрхийлсэн бэлгэдэл, энгэрийн тэмдэгтэй байна.

Хоёр. Прокурорын байгууллагын бэлгэдэлийн загвар

2.1. Прокурорын байгууллагын бэлгэдэл нь дугуй хүрээтэй, бамайн дээд хэсэгт сэлэмний бариулыг, доод хэсэгт сэлэмний үзүүрийг цухуйлган байрлуулж, төв хэсэгт тэрийн соёмбыг товойлгож, дээд хүрээг нь тойруулан "Монгол Улсын прокурор" гэсэн үгсийг товойлгосон бичээстэй байна. Бэлгэдлийг алтан шаргал өнгөтэй металлаар хийнэ.

Гурав. Прокурорын энгэрийн тэмдгийн загвар

3.1. Прокурорын энгэрийн тэмдэг нь Монгол Улсын прокурорын байгууллагын бэлгэдлийн агуулгыг тусгасан байна.

3.2. Энгэрийн тэмдэг дээр хөх өнгөтэй сэлмийг бамбайн дээд хэсэгт бариулыг нь, доод хэсэгт үзүүрийг нь цухуйлган байрлуулна. Бамбай нь давхар хүрээтэй, дугуй хэлбэртэй төвгөр байна. Бамбайн хүрээний доод хэсгийн гуравны хоёрын алтан шаргал өнгөн дээр 5 товруутай, бамбайн доод хэсгийн гуравын нэгийн цагаан өнгөн дээр шар өнгөөр "Прокурор" гэсэн бичээс байна. Бамбайн төв хэсгийн хөх өнгөн дээр алтан өнгөтэй соёмбыг товойлгон байрлуулж, бамбайн доод хэсгийг алдрын навчаар хагас хүрээлсэн байна.

3.3 Энгэрийн тэмдэг нь хувийн дугаартай байна.

Дөрөв. Прокурорын байгууллагын бэлгэдлийг хэрэглэх журам

4.1. Прокурорын байгууллагын бэлгэдлийг эх

эгаврыг гоёмсог, үзэмжтэй үйлдэж, Улсын ерөнхий прокурорын албан тасалгаанд байнга байрлуулна.

4.2. Прокурорын байгууллагын бэлгэдлийн хуулбар хувийг бүх шатны ахлах прокурорын ажлын өрөө, прокурорын зөвлөлийн хурлын танхимд байрлуулах бөгөөд прокурорын шуурхай ажлын автомашин, прокурорын гүйцэтгэх болон техникийн ажилтны үнэмлэх дээр дүрслэн хэрэглэнэ.

Тав. Прокурорын энгэрийн тэмдгийг хэрэглэх журам

5.1. Бүх шатны прокурор албан үүргээ гүйцэтгэж байх үедээ прокурорын энгэрийн тэмдгийг зүүнэ.

5.2. Прокурорын энгэрийн тэмдгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.3. Прокурорын энгэрийн тэмдгийг үрэгдүүлсэн тохиолдолд Улсын ерөнхий прокурорт нэн даруй мэдэгдэнэ. Энэ тухай Улсын ерөнхий прокурор шийдвэр гаргаж уг тэмдгийг хүчингүйд тооцно.

5.4. "Прокурорын байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 43, 44 дүгээр зүйлүүдэд заасан үндэслэлээр прокурорыг ажлаас чөлөөлсөн, халсан тохиолдолд түүний энгэрийн тэмдгийг хураажавна.

5.5. Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газар нь прокурорын энгэрийн тэмдгийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, прокурорын энгэрийн тэмдэг олгосон тухай хувийн хэрэгт нь тэмдэглэнэ.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр | Дугаар 176 | Улаанбаатар хот

Орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай

Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 1 дүгээр хавсралт ёсоор тогтоож, уг хөрөнгөөр 2003 онд хийх зам засварын ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор батална.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРААС 2003 ОНД ОРОН НУТГИЙН АВТО ЗАМЫН САНД ТӨВЛӨРӨХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг, хотын нэр	Төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/
1	Архангай	66.7
2	Баян-Өлгий	121.5
3	Баянхонгор	83.7
4	Булган	66.6
5	Говь-Алтай	67.1
6	Дорноговь	67.0
7	Дорнод	70.9
8	Дундговь	61.6
9	Завхан	80.4
10	Өвөрхангай	72.6
11	Өмнөговь	70.6
12	Сүхбаатар	53.9
13	Сэлэнгэ	112.6
14	Төв	80.0
15	Увс	63.8
16	Хөвсгөл	83.7
17	Хэнтий	70.0
18	Дархан-Уул	128.9
19	Орхон	117.9
20	Говьсүмбэр	14.3
21	Ховд	75.6
22	Улаанбаатар	2000.0
	Нийт дүн	3629.4

Засгийн газрын 2002 оны 176 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРААС ОРОН НУТАГТ ТӨВЛӨРСӨН ХӨРӨНГӨӨР 2003 ОНД ХИЙХ ЗАМ ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Аймаг,хотын нэр	Зам, засварын ажлын жагсаалт	Төсөвт ертөг /сая.төг/
1.	Архангай	- Эрдэнэмандал, Хануйн голын 66 м, Хайрхан хойд Тамирын, Батцэнгэлийн модон гүүрүүдэд засвар хийх	26.6
		- Аймгийн төв доторхи зам, гүүрийн засвар	32.5
		- Замуудад тэмдэгжүүлэлтийн ажил хийх	5.0
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	66.7
2.	Баян-Өлгий	- Буянт, Улаанхус, Харчулуутын гүүрүүдийн мес цөнгийн хамгаалалт	7.9
		- Нисэх онгоцны буудал хүртэлх 2 км хатуу хучилттай авто зам	61.2
		- Булган, Дэлүүн, Улаагчины зам гүүрүүдийн засвар	48.8
		- Замын улсын хяналтын зардал	3.6
		ДҮН	121.5
3.	Баянхонгор	- Цагаанхад, Тонгорогийн дабааны замуудыг засах	15.4
		- Галуут сумын чиглэлд Сүмбэр, Харганы голд модон гүүр барих	18.6
		- Шаргалжуутын рашааны чиглэлийн зам, гүүрүүдийн засварт	20.8
		- Аймгийн төвийн замын засвар, тэмдэгжүүлэлт хийх	26.3
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	83.7
4.	Булган	- Дашинчилэн чиглэлд Сүүжийн ба Хар бухын модон гүүрүүдийн засвар	11.2
		- Ургац тээврийн зарим зам, гүүрийн засвар	20.6
		- Баяннуур, Хульж, Хишиг-Өндерийн Могойн модон гүүрүүдийн засвар	18.0
		- Булганы төвийн хар замын засвар	8.9
		- Замуудад тэмдэгжүүлэлт хийх	5.3
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	66.6
5.	Говь-Алтай	- Буганы Шүүтийн замын засвар	11.7
		- Дөтийн 2 дабааны хайрган замын засвар	12.6
		- Алтай, Зостын амны хар замын засвар	29.7
		- Аймгийн замуудад тэмдэгжилт хийх ажил	10.5
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	67.1
6.	Дорноговь	- Сайншандын хөнгөвчилсөн хар замын их засвар	50.0
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	14.4

		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	67.0
7.	Дорнод	- Бумбат, Хархираа, Хайлантын модон гүүрүүдийн засвар	15.0
		- Унагай,Тээг, Сэвсүүл, Чулуунхороотын /Эрээнцавын/ модон гүүрүүдийн засвар	18.0
		- Хамардавааа, Зөгийн амны замуудыг засах	8.2
		- Чойбалсангийн төвийн бетон замын болон Хэрлэнгийн доод бетон гүүрийн засвар	27.1
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	70.9
8.	Дундговь	- Мандалговийн төв, нефть баазын замын засвар	35.0
		- Мандалговь-Эрдэнэдалай, Говь-Угтаал, Баянжаргалан чиглэлийн замуудын бартаатай хэсгийг засах	14.0
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	10.0
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	61.6
9.	Завхан	- Буянтын модон гүүрийн мөс цэнгийн хамгаалалт, засвар	14.7
		- Ургамлын Хүнгүйн гүүрүүдийн засвар	10.6
		- Их-Уулын модон гүүрийн засвар	13.8
		- Отгоны рашааны чиглэлийн замыг хэсэгчлэн засах	5.2
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	10.0
		- Улиастайн төвийн замын засвар	23.5
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	80.4
10.	Өвөрхангай	- Баянтээгийн нүүрсний уурхайн чиглэлийн зам, гүүрийн засвар	14.7
		- Хужирт, Улаанцутгалангийн зам гүүрүүдийн засвар	10.1
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	8.1
		- Арвайхээрийн төвийн замын засвар	12.8
		- Уянга сумын Онги, Уянгын модон гүүрүүдийн засвар, Найманнуур чиглэлийн хангайн нүрууны дабааны замын засвар	10.0
		- Товхон голын модон гүүрийн засвар	7.0
		- Орхон голын модон гүүрийн засвар	5.0
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	72.6
11.	Өмнөговь	- Ёлын амны чиглэлийн замын засвар	14.8
		- Даланзадгадын төвийн бетон замын засвар	28.4
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	12.5
		- Даланзадгадын нефть баазын замын засвар	12.4
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	70.6

12.	Сүхбаатар	- Баянголын модон гүүрийн засвар	15.2
		- Баруун-Уртын төвийн замын засвар	17.7
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	18.4
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	53.9
13.	Сэлэнгэ	- Сэлэнгийн Орхоны Шаамар, Сэлэнгийн салаа, Хандгайт, Шанд, Бумбатын модон гүүр, замын засвар	14.8
		- Найрамдал чиглэлийн замын засвар	36.9
		- Зүүнбүрэнгийн төмөр бетон гүүр барих	28.9
		- Ерөө, Худэр чиглэлийн хайрган зам, модон гүүрүүдийн засвар	20.0
		- Аймгийн төвийн замын засвар	9.4
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	112.6
14.	Төв	- Зуунмод хотын замын тэмдэгжүүлэлт	17.8
		- Сүмбэр чиглэлийн замын засвар	15.3
		- Жаргалант чиглэлийн асфальтбетон замын засвар	15.0
		- Борнуур чиглэлийн зам, төвийн гүүрийн засвар	10.0
		- Батсүмбэр, Сөгнөгөр чиглэлийн зам гүүрийн засвар	10.0
		- Налайх-Зуунмодын замын засвар	9.3
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	80.0
15.	Увс	- Тэсийн голын модон гүүрийн засвар, мөс цөнгийн хамгаалалт	16.5
		- Нарийн, Хар-Усны голын гүүрүүдийн шинэчлэлт	13.0
		- Улаангомын төвийн замын засвар	28.8
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	2.9
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	63.8
16.	Хөвсгөл	- Их Жаргалангийн модон гүүрийн засвар, мөс цөнгийн хамгаалалт	7.9
		- Галт сумын Идэрийн голд гүүр шинээр барих	10.0
		- Бажийн давааны зам гүүрийг засах	4.5
		- Омпуугийн дөрөлж, Тэсийн шуудууны модон гүүрүүдийг засах	7.4
		- Хатгал-Мөрөнгийн замын эвдэрсэн, шатсан гүүр, замуудыг засаж шинэчлэх	15.7
		- Мөрөн хотын төвийн замын засвар, тэмдэгжүүлэлт хийх	35.6
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	83.7
17.	Хэнтий	- Хурхын дээд гүүр, Бархч, Эг, Баян, Хэрлэн голын гүүрүүдийн засвар	16.5
		- Аймгийн төвийн Хэрлэн голын төмөр бетон гүүрийн эргийн чулуун бэхэлгээ	14.5
		- Хэрлэнгийн Хөмүүлтэйн гүүрүүдийн засвар	

		- Өндөрхаааны төв замын засвар	15.0
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	17.5
		- Замын улсын хяналтын зардал	3.9
		ДҮН	2.6
			70.0
18.	Дархан	- Шарынголын чиглэлийн замын засвар	11.7
		- Ургац тээврийн нийт зам, гүүрүүдийн засвар	45.0
		- Дархан хотын доторхи гудамж, замуудын засвар	61.6
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	8.0
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	128.9
19.	Орхон	- Эрдэнэтийн төвийн зам, гудамжны засвар	42.8
		- Эрдэнэт-Хялганат, Ингэттолгойн хайрган зам, гүүрүүдийн засвар	30.5
		- Эрдэнэт-Булганы болон бусад ургац тээврийн замын засвар	35.0
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	7.0
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	117.9
20.	Говьсүмбэр	- Нийт замын тэмдэгжүүлэлт	4.1
		- Аймгийн төвийн замын засвар	10.2
		ДҮН	14.3
21.	Ховд	- Хомын хоолойн модон гүүрийн засвар	15.5
		- Чонохарайхын модон гүүрийн засвар	16.0
		- Их улаан даваа, Үенчийн хавцлын зам засах	10.0
		- Ховд хотын доторхи болон Мянгад чиглэлийн хар замын засвар	30.0
		- Нийт замын тэмдэгжүүлэлт	1.5
		- Замын улсын хяналтын зардал	2.6
		ДҮН	75.6
22.	Улаанбаатар	- Нийслэлийн зам, гүүрийн засвар, арчлалт, хотын замын ашиглалтын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, норм, нормативыг боловсруулах Японы буцалтгүй туслалцаар хийгдэх Авто зам сайжруулах төслийн Монголын талаас хийх ажлын зардал	1850
		- Замын улсын хяналтын зардал	150
		ДҮН	2000
		НИЙТ ДҮН	3629.4

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр | Дугаар 177 | Улаанбаатар хот

Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах зам ашигласны төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Орон нутгийн чанартай авто зам болон аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж, талбайгаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах цэгийн байрлал, төлбөрийн хэмжээг тогтоохдоо авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний дагуу баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймаг,нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Авто зам, замын байгууламж, талбайгаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах ажлыг одоогийн байгаа цэгийн тоог нэмэхгүй байхаар зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолоор батлагдсан журмаас гадуур авдаг төлбөр, хураамжийн талаар гарсан бүх шийдвэрийг хүчингүй болгохыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчдад даалгасугай.

5. "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 35 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн "...1999 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 159 дүгээр тогтоол" гэснийг "...1999 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 159 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН БОЛОН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ТӨЛБӨР АВАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Авто замын тухай хуулийн 5.1.3–т заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан олон улсын болон улсын чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс ямчийн хэлбэр, тэдгээрийн харьяаллыг үл харгалзан зам ашигласны төлбөр /цаашид "төлбөр" гэнэ/ авахад үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх төлбөртэй авто зам /замын чиглэл, урт/, замын байгууламжийн жагсаалтыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Хоёр. Төлбөр хураах зарчим

3. Төлбөртэй авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийг замын санд төвлөрүүлэх үйл ажиллагаар авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага замын засвар арчлалт хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулна.

4. Төлбөр хураах цэгийг төлбөртэй авто зам, замын байгууламжийн орох болон гарах хэсгүүдэд байрлуулна.

5. Төлбөртэй авто замын орох хэсгийн төлбөр хураах цэгт тээврийн хэрэгслээс төлбөрийг хураан авч тасалбар олгож, гарах хэсгийн цэгт тасалбарыг шалгана. Хэрэв тасалбарыг үрэгдүүлсэн эсхүл орох хэсгийн төлбөр хураах цэгээр дайраагүй тохиолдолд төлбөрийг гарах хэсгийн төлбөр хураах цэгт хураана.

6. Төлбөрийн хэмжээг тээврийн хэрэгслийн ангилал, даацыг харгалзан инфляцийн түвшинтэй

уялдуулан Засгийн газраас тогтоож байна.

7. Төлбөр хураах ажиллагаа нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар зохион байгуулагдсан байна.

Гурав. Бусад

8. Төлбөр хураах цэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

9. Төлбөртэй авто зам, замын байгууламжийг авто замын сүлжээний зураг тэмдэглэж, нийтэд мэдээлсэн байна.

10. Нэг чиглэлийн замд явах тээврийн хэрэгслээс төлбөрийг давхардуулан авахыг хориглоно.

11. Дуут болон гэрлэн дохио ажиллуулан албан үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламж, цагдаа, гал унтраах байгууллагын тээврийн хэрэгсэл болон бүх төрлийн цуваанаас төлбөр авахгүй.

12. Тогтоосон чиглэлд байнгын үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай аж ахуйн гэрээ байгуулан авто зам ашигласны төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд тэдгээрт 20 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлж болно.

Засгийн газрын 2002 оны 177 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН БОЛОН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС АВАХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

(төгрөг)

	Хөнгөн тэрэг	Ачааны авто машины даац, тонноор			Автобусны багтаамж (зорчигчдын тоо)			Механизм
		3.5 тн хүртэл	3.6-12.0 тн	13 тн-оос дээш	12 хүртэл	13-24	25-аас дээш	
Хураамжийн хэмжээ	500	800	1000	1500	800	1000	1500	1000

Тайлбар: -Бүх жин нь 3.5 тн хүртэлх тээврийн хэрэгслүүдийг хөнгөн тэрэгт хамааруулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 178 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2002 оны 178 дугаар тогтоолын хавсралт

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь төрийн бодлогын хүрээнд цахилгаан холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх үүргийг хэрэгжүүлэхээр төвлөрүүлсэн бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан /цаашид "сан" гэх/ -д хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Сангийн хөрөнгийг Харилцаа холбооны тухай хуулийн 11.1-д заасны дагуу цахилгаан холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх зорилгоор шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэхэд зарцуулна.

3. Тухайн жилд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, зардлын төлөвлөгөөний төслийг харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүс нутгийн судалгаа, холбогдох байгууллагын саналыг үндэслэн харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4. Сангийн хөрөнгийг энэ журмын 2-т зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

5. Сангийн хөрөнгийг Шуудан, цахилгаан холбооны газрын бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дансанд байршуулна.

Хоёр. Сангийн удирдлага

6. Сангийн үйл ажиллагааг Шуудан, цахилгаан холбооны газар удирдана. Сангийн захиргыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

7. Сангийн захирал сангийн үйл ажиллагааны талаар дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ энэ журмын 3-т заасан төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулах;

2/ энэ журамд заасны дагуу санд хөрөнгө бүрдүүлж, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх;

3/ сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

4/ сангийн хөрөнгийн төсвийн төслийг боловсруулах, гүйцэтгэлийн тайланг гаргах;

5/ сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын биелэлтийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

6/ сангаас санхүүжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг тооцох, шаардлагатай бол санхүүжилтийг зогсоох.

Гурав. Сангийн хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалт

8. Сан нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

1/ гадаад, дотоодын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хандив, зээл, тусламжийн хөрөнгө;

2/ бусад хөрөнгө.

9. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгохдоо дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

-үйлчилгээ хүрээгүй тухайн бүс нутгийн нийгмийн асуудалд чухал нөлөө үзүүлэхээр байх;

-Монгол Улсын мэдээлэл холбооны сүлжээг хөгжүүлэх төлөвлөгөөнд туссан байх;

-мэдээлэл холбооны салбарт Засгийн газраас дэвшүүлсэн зорилтод нийцсэн байх.

10. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр алслагдсан бүс нутагт сүлжээ барьж байгуулах болон өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг баримтална.

11. Энэ журмын 3-т заасны дагуу батлуулсан төлөвлөгөөний төслийг жил бүрийн 8 дугаар сарын

20-ны дотор сангийн захирал төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Дөрөв.Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих

12. Сангийн захирал нь сангийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, сангийн зарцуулалтыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

13. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих мэргэжлийн хяналтыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

14. Харилцаа холбооны зохицуулах хороо нь бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор үүрэг үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавина.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ИЛТГЭЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТУХАЙ ИЛТГЭЛ 2002 ОН

ӨМНӨХ ҮГ

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай Улсын Их Хуралд илтгэж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдан ажилласан нэг жил гаруйн хугацаанд явуулж ирсэн үйл ажиллагаа, дангаараа болон бусадтай хамтарч хийсэн судалгаа, төрийн болон төрийн бус байгууллагуудын сэдэвчилсэн, хэсэгчилсэн зарим судалгаа, тайлан, хяналт шалгалтын ажилдаа тулгуурлан энэхүү илтгэлийг гаргаж байна.

НҮБ-ын санхүүжилтээр хийгдсэн "Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах" төслийн хүрээнд 2001 оны таваас наймдугаар сарын хооронд зохион байгуулагдсан Хүний эрхийн төлөө байдлын судалгааны ажилтай тус Комиссын үйл ажиллагаа давхацсан нь энэ илтгэлийг гаргахад ихээхэн ач холбогдолтой болсон юм. Энэхүү судалгааны ажилд "Хүний эрхийн Үндэсний Комисс анх сургалт семинар зохион байгуулах үеэс эхлэн оролцож, Комиссын ажилтнууд төвийн судалгааны таван багт хуваагдан ажиллаж, хоёрыг нь Комиссын гишүүд ахалж ажилласан ба нэгдсэн тайланг гаргахад идэвхитэй оролцсон.

Уг судалгааны ажлыг нийслэл хот болон бүх аймаг, 127 сум, 8822 өрх, 579 аж ахуйн нэгж, байгуулага, 60 шахам мянган иргэдийг хамруулан хийжээ. Судалгааны ажлыг гардан зохион байгуулагчид хамтарч тайлангаа ном болгож / Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, УБ, 2001 он/ хэвлүүлж, ергөн олон нийтэд 2001 оны 12 дугаар сарын 10-нд Олон улсын Хүний эрхийн өдрөөр ергөн барьсан.

Дээрх тайлан нь энэхүү илтгэлийн үндэсн суурь дэвсгэр болсон ба гол гол дүгнэлт, томьёоллыг түүн дээр тулгуурласан болно.

Түүнээс гадна илтгэлийг боловсруулахдаа иргэдийн ергөдөл, гомдлын мөрөөр хийсэн хяналт шалгалтын ажлын үр дүн, тодорхой сэдвээр явуулсан судалгаа, семинар, сургалтын материал, Засгийн газрын Хүний эрхийн тайлан, мэдээлэл, гадаад зарим улс оронд хэвлэгдсэн тайлан, илтгэл, бие даасан судлаачдын бүтээл, туурвилыг зохих түвшинд ашигласан юм.

Илтгэлийг хувийн эрх, эрх чөлөө, улс төрийн эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх, эрх чөлөө, нийтийн эрх, эрх чөлөө гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг дөрвөн бүлэглэлээр нь ангилсан болно.

НЭГ. ХҮНИЙ ХУВИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүний хувийн эрх, эрх чөлөө нь ардчиллын чухал үнэт зүйл юм.

Энэхүү бүлэг эрх, эрх чөлөө тухайн улс оронд хэрхэн биеллээ олж, ямар хэмжээнд байгаагаар нь уг улсын ардчиллын түвшинг хэмждэг.

1.1. Амьд явах эрх

Үндсэн хуулийн хүрээнд амьд явах эрхийн баталгаажилт олон улсын эрхийн хэм хэмжээнд нийцэж байна.

Монгол улс бол цаазаар авах ялыг халаагүй

улсын тоонд ордог бөгөөд Эрүүгийн хуульдаа уг ялыг хэрэглэж болохгүй субъектуудыг нэлээд эртнээс тогтоож, мөрдөж ирсэн онцлогтой.

1961 онд батлагдсан Эрүүгийн хуульд эмэгтэйчүүд ба 60-аас дээш насны эрэгтэйчүүд, түүнчлэн уг гэмт хэргийг үйлдэх үед 18 насанд хүрээгүй байсан хүмүүст цаазаар авах ялыг оногдуулж болохгүй /хуулийн 18 дугаар зүйл/ гэж заасан байв. Энэ зарчим өнөөг хүртэл хэлбэрэлтгүй хэрэгжиж иржээ.

1993 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн таван зүйлд цаазаар авах ялыг оногдуулахаар заасан бол 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөх Эрүүгийн шинэ хуульд зургаан зүйлд цаазаар авах ялыг хэрэглэж болохоор байна. Цаазаар авах ялгүй байсан нэг зүйлд шинээр уг ялыг /"Зандалчлах" 177.2-р зүйл/ нэмж оруулжээ.

Түүнчлэн Эрүүгийн хуучин хуульд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар алахад гэмт хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх 14 төрлийн үйлдэл байсан бол шинэ хуулиар 3-ыг нэмж, 17 төрлийн үйлдэл болжээ. Өөрөөр хэлбэл, гурван үйлдэлд нэмж цаазаар авах ял оноож болох байна.

Шүүхийн практикийг судалж үзэхэд өдгөө зөвхөн хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар алах гэмт хэргэ болох ЭХ-ийн 86 дугаар зүйлийн 2-т заасан тохиолдолд л уг ялыг хэрэглэж байна. 1990 оноос хойш өөр үйлдэлд энэ ялыг хэрэглээгүй.

1990-2000 онд анхан шатны шүүх цаазаар авах ялыг 259 хүнд оногдуулсан байх бөгөөд тэдгээрийн 3.10/ эхлэн мөрдсөн нь Ирээдүй болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын" . . . Энэхүү шийтгэлийг гагцхүү эрх бүхий шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх эцсийн тогтоолыг биелүүлэх замаар хэрэгжүүлж болно" гэсэн заалттай нийцсэн байна.

Цаазаар авах ялыг үүчлэх, хөвээр үлдээх эсэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаардаг тул Улсын Дээд шүүхээр хянасны дараа цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд үүчлэл үзүүлэх үндэслэл байгаа эсэхийг Монгол Улсын Ерөнхийлөгч хянан үздэг.

Цаазаар авах ялыг хэрэглэхдээ хүнийг хилсдүүлэхгүй байх хуулийн баталгаа байгаа ч гэсэн цагдаа-мөрдөн байцаахын зарим ажилтан, сэжигтэн, яллагдагч нарт бие махбодь, сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэн, хилсээр хэрэг хүлээлгэх, улмаар шүүх түүнийг нь үндэслэн таслан шийдвэрлэж, цаазаар авах ялыг хилсээр оногдуулах ноцтой алдаа арилаагүй байна. Жишээ нь: Завхан, Говь-Алтай аймгийн шүүх хэргийн бүрдэл хангагдаагүй, шүүгдэгчийн гэм буруу хөдөлбөргүй тогтоогдоогүй байхад иргэн "Э"-д бусдыг санаатай алсан хэргээр цаазаар авах ялыг гурав дахин оногдуулсан байх бөгөөд тэдгээр таслан шийдвэрлэх тогтоолыг тухай бүрт нь дээд шатны шүүх хүчингүй болгож байжээ. : /609003 тоот эрүүгийн хэргээс/

Улсын Дээд шүүхийн давах шатны шүүх 2000 онд анхан шатны шүүхийн цаазаар авахаар шийдвэрлэсэн таслан шийдвэрлэх тогтоолуудаас 3-ыг өөрчилж, 2-ыг хүчингүй болгожээ.

1.2. Халдашгүй чөлөөтэй байх эрх

Үндсэн хуулиас үзэхэд иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхэд хувь хүний нэр төрийн, дүрийн хүнд, бие сэтгэл, эд хөрөнгө, хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй дархан байдлыг хамаран баталгаажуулжээ.

Иргэний "халдашгүй чөлөөтэй байх эрх"-ийн хамгийн чухал, гол баталгаа бол төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хуулийн үндэслэл, нотолгоогүйгээр баривчлахгүй, хорихгүй, эрх чөлөөг нь хязгаарлахгүй, нэгжихгүй байх явдал юм.

Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хууль /1963 он/, Захиргааны хариуцлагын тухай хууль /1992 он/, Цагдаагийн байгууллагын тухай хууль /1993 он/, Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль /1999 он/ болон зарим хуульд тодорхой гэмт үйлдэл, захиргааны зөрчилд сэжиглэгдсэн, холбогдсон иргэнийг албадан ирүүлэх, албадан саатуулах, баривчлах, цагдан хорих, орон байранд нь болон биед нь нэгжлэг, үзлэг хийх журам, үндэслэлийг хуульчилж өгсөн.

Энэхүү хурц, төвөгтэй асуудлыг авч үзэхийн тулд юуны өмнө Монгол улсад түр саатуулах, албадан саатуулах, цагдан хорих ямар журам, дэгтэй байгаа, тэдгээрийг хэн зөвшөөрдөг, ямар нөхцөлд, ямар хугацаагаар хориглодог зэргийг нэттэж, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд хууль тогтоомжид дүн шинжилгээ хийвэл дараах байдал харагдаж байна.

1.2.1. Түр саатуулах

- Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн этгээдийн нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно. /Цагдаагийн байгууллагын тухай хууль,1993 он, 24 дүгээр зүйл/,

- Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах захиргааны жүрмаар албадан саатуулж болно. Зөрчил гаргасан этгээдийг "захиргааны жүрмаар түр саатуулах хугацаа 6 цагаас илүү байж болохгүй. /Захиргааны хариуцлагын тухай хууль, 1992 он, 13 дугаар зүйл/,

- Хаваа эяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэлх насны, хаяг, эцэг эх, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 48 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно. /Хаваа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль, 1994 он, дүгээр зүйл/.

- Таниулын Ерөнхий газарт хариуцлуулсан гэмт хэргийн сэжиг бүхий этгээдийг түр албадан саатуулах" /хуулаа заагаагүй/ /Таниулын байгууллагын тухай хууль, 1999 он, 12.1.5/.

- Хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан нь улсын хилийн болон сил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэндээсээ үйлдэх зорилгоор 3 цаг хүртэл. . саатуулах /Улсын хилийн тухай хууль, 1993 он, 33 дугаар зүйл/.

Эдгээрээс үзэхэд олон байгууллагын янз бүрийн албан тушаалтан, өөр өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр иргэнийг саатуулах эрхтэй бөгөөд "түр саатуулах" гэдэг нь 3 цагаас 48 цаг хүртэл, Таниулын тухай хуулиар бол тодорхой хугацаагүйгээр үргэлжлэх болох байна.

1.2.1.1. Нөхтой асуудал бол аль ч байгууллагын хэвэд түр саатуулах байрны нөхцөл, журам, саатуулагдан этгээдийн эрхээйн байдлын талаар тогтоосон хэм хэмжээ байхгүй, иймээс хэнийг ч ямар ч үндэслэлээр хэмааГүй, аль тааралдсан ауулах өрөө тасагтаанд хорьж саатуулдаг байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн "түр саатуулах" /6 цагийн/ байрудад хийсэн шалгалт судалгаанаас үзэхэд зөвхөн 2001 оны нэгдүгээр улиралд тэдгээрт бүрэн бус мэдээгээр 7595 хүн саатуулагдсэн. Жишээлбэл: /2001 оны IV сард/ Шалгалт судалгаа зэрэг хийсэн нь өдөр гэхэд дээрх зуугаан дүүргийн цагдаагийн байрууда 45 хүн түр саатуулагдаж байсны 9-ийг нь зургаагаас илүү цагаар, заримыг нь 12 цагаас 22 цаг хүртэл хугацаагаар саатуулж хууль, хүний эрхийг нөхтой зөрчсөн байв. / Нийслэлийн цагдаа хорих төв, албадан саатуулах байруудад хийсэн шалгалтын материал., 2001 он, ХЭҮК/

1.2.1.2 Өөр нэг нөхтой зөрчилтэй бол түр саатуулах өрөөнүүдийн нөхцөл маш муу, цонх, агаажуулалт, гэрэлтүүлэг байгүй, бетонон шалтай, суух зандал ч /Сүхбаатар дүүргийнхээс бусад нь/ байхгүй, нэг хүнд оногдох талбай маш бага байв. Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн түр саатуулах байранд хийсэн шалгаталаар нэг хүнд 0.66 м2 1.8 м2 талбай ноогдож буй тооцоо гарсан. Цагдаагийн түр саатуулах хууль гарсаар арав шахам жил болж байхад түр саатуулах байрны талаар /2001 оны V сар хүртэл/ ямар нэг журам тогтоосоогүй, хяналтгүй ажиллаж ирсэн байна. Жишээлбэл: УБТЗ-ын цагдаагийн хэлтсийн түр саатуулах байр нь 2.8 х 2.7 м талбайтай, цонхгүй, агаар үлээх зоолой нь ажилладгүй, агаарын солилцоогүй, маш бүгчим, эхүүн үнэртэй бөгөөд прокурорын шалгалтын үед нэг өрөөнд 8 эрэгтэй, нэг эмэгтэй хүнийг 2-14 цаг хамт саатуулсан, шалгалтын өмнөх 8 өдрийн туршид 7-10 хүнийг тогтмол түр саатуулсан, нэг өдөр 20 хүнийг тэр өрөөнд саатуулсан зэрэг нь тогтоогдсон (нэг хүнд 0.3 м2 талбай ноогдож байсан байна). /Прокурорын илтгэх хуудас, 2000.4.10/

1.2.2. Албадан саатуулах

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар /137-р зүйл/: Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч, прокурор дараах үндэслэлээр сэжигтэнг 72 цагийн хугацаагаар албадан саатуулж болно.

1. Үг эттэгд оргон зугатахыг завдсан
2. Байнга оршин суух орон байргүй
3. Хэн болох нь тогтоогдохгүй байгаа бүюу онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл байвал.

Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар зөрчил гаргасан этгээдийг нөхтой хор уршиг бий болгохоД хүргүүлэхгүй байх зайлшгүй шаардлагатай тохиолдолд харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж, түүнийг 72 цаг хүртэл хугацаагаар захиргааны жүрмаар албадан саатуулж болно. Улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулж болохоор байна.

Эрүүгийн хэргийн сэжигтнийг прокурорт мэдэгдэж, захиргааны зөрчлийн сэжигтнийг нь болохоор шүүхэд мэдэгдэж, прокурор болохоор үг албадан саатуулах тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгодог, шүүх албадан саатуулах мэдэгдэл авсны дараа ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байгаа, зарим тохиолдолд 72 цагаар албадан саатуулах үед прокурорт ч, шүүхэд ч мэдэгдэх шаардлагагүй байгаа зэрэг нь хууль тогтоогчийн зүгээс хүний халдашгүй эрхтэй холбоотой эноо чухал асуудалд нэгдмэл шалгууураар хандадаггүйн илрэл юм.

Зүй нь, Монгол улсын нэгдэн орсон, хүлээн зөвшөөрсөн олон улсын эрхийн хэм хэмжээгээр бол, баривчлагдсан бүюу саатуулагдсан хүний асуудлыг зөвхөн шүүх таслах эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэх ёстой бөгөөд, ер нь аливаа хууль бус хорих, баривчлах үйл ажиллагааны талаар гаргасан гомдлыг зөвхөн

шүүх авч хэлэлцэн, тогтоол гаргах ёстой байна.

Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуульд / 2002 он/ албадан саатуулах /баривчлах/, цагдан хорих асуудлыг шүүхээр шийдвэрлэхээр тогтоосон нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцэж байна. Энэ хуульд албадан саатуулах гээсн ойлголтыг "баривчлах"-аар сольсон байгаа бөгөөд хэдийгээр хуульд баривчлах хугацаг шууд заагаагүй боловч хуулийн 59 дүгээр зүйлээс 72 цагийн /24 цаг+48 цаг/ хугацаатай гэдэг нь ойлгогдож байна.

Энэ хуулийн "Баривчлах" гээсн Наймдугаар бүлэг-ийг хүний халдашгүй байх эрхийн хүрээнд авч

үзвэл дараах дүгнэлтийг хийж болох байна.

1. Хууль тогтоогч Сэжигтнийг баривчлах асуудлыг онцлон авч үзэж тусгайлсан бүлгээр энэ асуудлыг зохицуулжээ.

Хэдийгээр өмнөх байцаан шийтгэх хуулийг хүний эрхийн талаас нь шүүмжилдэг боловч уг хуульд иймэрхүү тусгайлсан бүлэг байгаагүй.

2. Хуулийн 58.1-р зүйл "Сэжигтэн оргон зугатахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай үндэслэл байгаа бол түүнийг баривчилна" гэснээс үзэхэд сэжигтнээр тооцогдсон хүн бүрийг заавал баривчилж байхаар хуульчлагджээ.

"Оргон зугатахыг завдах" гэдэг нь ихэвчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын үзэмжийн асуудал байдаг. Хэнгэн гэмт хэрэгт сэжигтэгдсэн хүнийг ч энэ үндэслэлээр албадан саатуулж болох байна.

"Хүнд гэмт хэрэг"-т Эрүүгийн хуулийн /2002 он/ 17.4-д заасснаар "нэг сарын хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг" тооцдог. Хүнд хэрэгт олон төрлийн үйлдэл тооцогддог. Жишээ нь: Татвар төлөхөөс зайлсхийсэн сэрдэгдэхэд заавал /ЭХ-ийн 166.2-р зүйл/ баривчлагдах ёстой болж байна.

3. Энэхүү баривчлах тухай заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цагдан хорих нь нийтлэг журам байх ёсгүй гэсэн зарчимтай шууд зөрчилдөж байна.

4. Нэгэнт гэмт хэрэгт сэрдэгдэхэд заавал баривчлагдаж үүрааг дараачийн таслан сэргийлэх арга хэмжээг цагдан хорихоор авах магадлал өндөр байх болно.

1.2.2.2. Албадан саатуулах асуудлын гол цөм нь эрүүгийн хэргийн хувьд ч, захиргааны зөрчлийн хувьд ч саатуулагдсан хүн хожим гэм буруутай нь тогтоогдож, ял, захиргааны шийтгэл хүлээх ёстой хүн байж уу, үгүй юу гэдэгтэй шууд холбоотойд оршино. Шалгалт, судалгааны дүнгээс үзэхэд, харамсалтай нь цагдаагийн байгууллага, түүний холбогдох албан тушаалтнууд хүний халдашгүй дархан эрхэнд хуулийн үндэслэлгүйгээр халдаж, албадан саатуулах эрхээ хэтрүүлэх явдал хавтгайрч байгаа нь бодит үнэн болж байна.

Улсын Ерөнхий прокурорын газраас /2000 оны 1 улиралд/ нэгдсэн удирдамжаар бүх аймаг,хотод хийсэн шалгалтаар захиргааны хариуцлагын тухай хуулиар 2000 оны эхний хоёр сард нийтдээ 1081 хүнийг албадан саатуулсан байх ба, тэдгээрийн 57-г нь үндэслэлгүйгээр албадан саатуулсныг тогтоож, сулласан байна.

Түүгээр ч барахгүй 2000 онд ямар ч шийдвэрлүүгийн хоригдсон 36 хүн, хорих хугацаа нь хэтэрсэн 102 хүнийг прокурорын тогтоолоор суллажээ. /Прокурорын илтгэх хуудас, 2000.4.10/

Цагдаагийн ажилтнууд захиргааны зөрчлийг бүртгэхдээ бусдыг хуулийн үндэслэлгүйгээр албадан саатуулах, гаргасан гэх зөрчлийг нь шалгахгүй орхих, албадан саатуулах хугацаа /72 цаг/ хэтрүүлэх явдал тархмал байдаг.

Сэжигтнээр албадан саатулах нь нэлээд тохиолдолд хэрэг хүлээлгэх, залжаж дарамтлах арга хэрэгсэл болсны нэг тод баримт бол долоо хоногийн баасан гаригийн үдээс хойш иргэдийг албадан саатуулдаг явдал юм. Бямбүрэ дүүрэгт 51 хүний /2001.4.9-ний байдлаар/ 6-г нь 4 дүгээр сарын 6-ны баасан гаригт албадан саатуулсан байв. Нийслэлийн прокурорын газрын нэгжилтан сонинд өгсөн ярилцлагадаа: "Зарим цагаа сэжигтнийг албадан саатуулахдаа тав дахь өдрийн /Баасан гариг/ үдээс хойш ямар нэгэн шалтаг хайн 72-т суулгадаг" Албадан саатуулахыг /72 цаг/ ард иргэд, хуулийн ажилтнуудын дунд "Цагдаагийнхны хүнээр тоглодог гурван хоног" гэж нэрлэдэг болжээ гэсэн нь бодит үнэн юм. /"Зууны мэдээ" онин, 2001.8.2, №178/

1.2.3. Цагдан хорих

Цагдан хорих нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэглэдэг тапан сэргийлэх арга хэмжээний хамгийн хүнд нь бөгөө хоригдож буй этгээдийн эрх зүйн байдлаас нь хамааруулж а) сэжигтнээр цагдах хорих,

б) яллагдагчаар цагдан хорих гэж хоёр ангилж байна.

1.2.3.1. Сэжигтнээр цагдан хорих

ЭБШХ-ийн 88 дугаар зүйлд заасснаар онцгой тохиолдолд гэмт хэргэгдэгч сэрдэгдэж байгаа этгээдэд ял сонгохын өмнө таслан сэргийлэх арга хэмжээ авч болох ба уг арга хэмжээг авсаас хойш 14 хоногийн дотор ял сонгох, хэрэв ял сонгоогүй бол үүнд арга хэмжээгээ хүчингүй болгохёстой.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын практикаас үзэхэд цагдаагийн ажилтнууд болон прокурорууд нэгдүгээрт, энэхүү 88 дугаар зүйлийн "онцгой тохиолдол" гэдгийг онцлон анхаарч үздэггүй, хоёрдугаарт, таслан сэргийлэх өөрарга хэмжээг хэрэглэх боломжтой байхад зөвхөн цагдан хорихыг урьтал болгодог байна.

Тухайн хүнийг гэмт хэрэг үйдсэн эсэхийг шалгаагүй, ер нь хэрэг гарсан эсэх хэрэв гарсан бол уг хэрэгт нь хүн холбоотой эсх, ямар зүйл ангиар буруутгагдах эсэх нь тодорхойгүй байхад сэжигтнээр тооцож, улмаар цагдан хорих гэж улайран хөөцөлдөж, хорьж буй нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9-р зүйлийн: "Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй", Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-ийн "Хуульд заасан үндэслэл, хумааг гадуур хэнийг ч баривчлах, хорихыг хориглоно" гэсэн заалтуудтай шууд зөрчилдөж байна.

Сэжигтнээр цагдан хорьсон тохиолдолд цагдаагийн ажилтнууд заавал 14 хоногаас байж ял сонгох бүрэн даражийн асуудлыг шийдэг гэж хандлага олон жилээр үргэлжилж байна. Зүй нь

сэжигтнээр цагдан хорьсон буюу өөр арга хэмжээ авсан үед 14 хоногийн аль ч өдөр ял сонгох буюу суллах ёстой.

1.2.3.2. Яллагдагчаар цагдан хорих

ЭБШХ-ийн 95 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэгт холбогдсон хүнд ял сонгож, яллагдагчаар татсанаас хойш эхний удаад 2 сар /Үүнд өмнө нь ЭБШХ-ийн 88 ба 137 дугаар зүйлээр хоригдсон 17 хоног орохгүй/, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэх яллагдагчийн хувьд сум, сум дундын болон дүүргийн прокурор, нийслэлийн болон дагнасан прокурор, Улсын Ерөнхий прокурорын туслах, орлогчид нийтээд 8 сар, Улсын Ерөнхий прокурор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хорьж мөрдөх хугацаа 26 сар хүртэл хугацаагаар нэмж сунгадаг.

Үүнээс үзвэл хүнийг мөрдөн байцаалтын шатанд нийтдээ гурван жил 17 хоног 17 хоног +2 сар + 8 сар + 26 сар = 36 сар 17 хоног/ хорьж болох бөгөөд хэрэв тухайн хүний хэрэг шүүхээр очиж хэд хэдэн удаа буцсан бол /нигэж удаан хугацаагаар хоригдсон хүний хэрэг ихэвчлэн шүүхэд очиж нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан байдаг/ шүүх, шүүгчийн тогтоол, захирамжаар мөн л олон хоног сараар нэмж хоригдно. Шүүх дээр урьдчилан хоригдсон хугацаа нь ЭБШХ-ийн 95 дугаар зүйлд заасан хугацаанд /гурван жил/ оролгүй байна.

Үүнээс үзэхэд гэмт бүрүүтай нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хүнийг олон жилээр, шүүхийн тогтоолгүйгээр зөвхөн мөрдөн байцаагчийн үйлдсэн тогтоолоор нигэж удаан хугацаагаар хатуу, шийүүн нөхцөлд байлгана гэдэг бол туйлын хүнд залхаалт бөгөөд шүүхийн таслан шийтгэх тогтоолгүйгээр ял эдлүүлж байгаатай утга нэг юм.

Эрүүгийн шинэ байцаан шийтгэх хууль /2002 он/ хүнд/өвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн ялладагчийг/ хорьж мөрдөх хугацаа 24 сараар тогтоосон байх боловч зарим онц хүнд хэргэт шалгагдагдын хувьд 30 сарын хугацаа тогтоожээ. Энэ нь хэдийгээр одоогийн мөрдөж буй хуулиас зурган сараар бага байгаа боловч гэм бүрүү нь тогтоогдоогүй байгаа хүнийг 2 жил 6 сар хорих нь ихээхэн хүнлэг бус залхаан цээрлүүлэлт юм.

Өөр нэг анхаарал татаж буй асуудал бол энэ хууль хүндэвтэр гэмт хэргийн ялладагчийг 24 сараар хорьж болох тухай /ЭХ-ийн 69.3/ заалт юм. Одоогийн мөрдөж буй хуулиар зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэргийн ялладагчийн хугацаат сунгаж болох ёстой.

"Хүндэвтэр гэмт хэрэг" гэсэн ойлголтонд нь эрүүгийн шинэ хуулиар торгох, баривчлах ялаар шийтгүүлж болох хүмүүс хамрагдсан байхад тийм хэрэгт холбогдогдыг өмнөхөөсөө 12 дахин илүү хугацаагаар хорих болж байгаа нь хүний эрхийн нөхцөл асуудал юм.

1.2.4. Анхаарал татах өөр нэг нөхцөл асуудал бол цагдан хорих үндэслэл юм. Ер нь ЭБШХ, Захиргааны хариуцлагын хуулиас үзэхэд түр саатуулах, албадан саатуулах, цагдан хорих үндэслэл хэт өргөн, яаж ч тайлбарлаж болохоор, хэнийг ч, хэзээ ч хорьж цагдаж болохоор тусгагдсан, түүнийг нь ч хорьж, цагдах эрхтэй албан тушаалтнууд ашиглаж, хүний эрхийг хохироож, хуулийг завхруулдаг нь тод томруун харагдаж байна. ЭБШХ-ийн 94 дүгээр зүйлд: Онц хүнд, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл удаа дараа ял шийтгэгдэж байсан буюу онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн мөрдөн байцаалтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох үндэслэл байна гэж үзвэл цагдан хорьж болно. /ЭБШХ, 1963 он, 94 дүгээр зүйл/.

Хүчин төгөлдөр Эрүүгийн хууль /1993/ нь нийтдээ 301 зүйлтэй бөгөөд 446 үйлдэлд ял халдаж болохоор байгаагийн 34 нь онц хүнд, 124 нь хүнд гэмт хэрэгт, 153 нь хүндэвтэр, 135 нь хөнгөн гэмт хэрэгт хамрагдаж байна. /Улс төрийн болон хувийн эрх, эрх чөлөөний багийн тайлан 2001 он/. Үүнээс үзэхэд гэмт хэрэгт холбогдогчдын дийлэнхийг зөвхөн холбогдсон хэргийнх нь ангиллаар цагдан хорьж болохоор байна. Ер нь ч амьдрал дээр ингэж хорьдог. Онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах үйлдэл нь гэмт хэрэгт тооцогддог нийт үйлдлийн 70 орчим хувийг эзэлж байна. Түүгээр ч барахгүй хөнгөн гэмт хэрэгт холбогдогдийг ". . . дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох хангалттай үндэслэл байвал. . ." хүнд өвтэй , хөхүүл, жирэмсэн байсан ч хорьж болох байна.

Насанд хүрээгүй хүн, эмэгтэйчүүдийг хорьж мөрдөх хугацаа нь бусдынхтай адил байгаа нь энэ талаарх олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байна.

Эрүүгийн шинэ хуульд /2002 он/ насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндэслэл хугацаат нэг сар, хорьж мөрдөх өрөнхий хугацаат 18 сараар тогтоосон байна.

1.2.5. Хүний эрхийн Үндэсний Комиссоос нийслэлийн төвийн зургаан дүүргийн болон, Төмөр замын цагдаагийн хэлтэс, Мөрдөн байцаах газарт 2000 он, 2001 оны эхний гурван сард хэрэгсэхгүй болгогдсон 2287 хүнд холбогдох 1948 хэргийг судалж үзэхэд сэжигтэн, ялладагч гэх тооцогдож байсан 497 хүнийг 1-210 хоногоор албадан саатуулж, цагдан хорьсон байв.

Аймгуудын цагдаагийн байгууллага дээр хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргийг 2000 он, 2001 оны эхний хагасаар судлуулж үзэхэд бүрэн бус мэдээгээр /дөрвөн аймаг ороогүй/ энэ хугацаанд 2626 хэрэгт 2450 хүнийг холбогдуулж шалгаж, 483 хүнийг 5878 хоног хорьсон байна.

Эдгээрээс үзэхэд бүрэн бус тоогоор 2000 он болон 2001 оны эхний хагаст /497+486/ 980 хүнийг олон, цөөн хоногоор хилсээр хорьж, Үндэсн хуульд заасан "хүний халдашгүй, чөлөөтэй" байх эрхийг нь зөрчсөн байна.

1.2.6. Иргэдийн халдашгүй, чөлөөт байх эрхтэй салшгүй холбоотой, ялангуяа баривчлах, хорих ажиллагаанд тавих хязалт сул, дур зоргоороо баривчилж хорьж бүй одоо үед урьдчилан хорих, албадан саатуулах, түр саатуулах байрны нөхцөл, эрүүл ахуйн шаардлага нь хүний эрхийн түлгамдсан

асуудлын нэг болжээ.

Монгол Улсад 1999 онд анх удаагаа Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг батлан гаргасан. Энэ хууль нь олон улсын жишиг, стандартад хүрээгүй боловч сэжигтэн, яллагдагчийн эрхийг баталгаатай болгох, хоригдох нөхцөл жүрмыг сайжруулахад чухал түлхэц болсон гэж үзэх үндэстэй.

Харамсалтай нь уг хууль гарсаар гурван жил болж байхад түүнийг хэрэгжүүлэх, ялангуяа хоригдогчдын эдлэх эрхийг хангах, хамгаалах талаар дорвитой өөрчлөлт гаргасангүй. Уг хуульд: Хоригдсон эгтээдийн байрлах өрөөний цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, модон шалтай, эсхүл модон наартай байх бөгөөд хорих өрөөний чийглэг 55-60 хувь, өвлийн улиралд 18 хэмээс багагүй дулаантай байх, хорих байгны өрөө нь нэг хүнд 2.5 ба түүнээс дээш хавтгай дэрвэлжин метр талбай ногдож байх, хоригдсон эгтээд бүр хүчлага, дэвсгэрээр хангагдана гэж заасан.

Улаанбаатарын "Ганц худаг" дахь цагдан хорих төв байр болон нийслэлийн албадан саатуулах байруудад 2001 оны IV сард хийсэн шалгалт судалгааны дүнгээс үзэхэд урьдчилан хорих байгны нөхцөл, боломж туйлын хангалттүй байна.

Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн албадан саатуулах байр нь подвалд байрлаж, 7 өрөөтэй, түүний 1 нь /6 цаг/ түр саатуулах, 1 нь эмэгтэйчүүдийг хорих, 1 нь насанд хүрээгүй хүмүүсийг хорих, 4 нь насанд хүрээгүйдийг хорих зориулалттай аж. Өрөө тус бүр нэг адил 2.5 х 3.4 = 8.5 м2 талбайтай, цементэн шалтай, бөгөөд 6 м2 талбай бүхий банзаар хийсэн өндөрлөгтэй.

Бүх өрөөнд нь гэрэл гэзээ ордоггүй, дотроо чийдэнгүй зөвхөн хаалганы тотгоноос ташуу тусгах нэг чийдэнтэй, нэгэнт цонхгүй учир цахилгаан тасарвал бүх өрөө таг харанхуй болдог. Эл учраас ном, сонин унших, бичих боломж бараг байхгүй. Бүх өрөөнд цэвэр агаар оруулах ямар ч боломжгүй учраас бүгчим эхүүн,

эвгүй үнэртэй. Бүх өрөөний дунд ганц жорлонтой, хоригдогсдыг өдөрт хоёрхон удаа бие засуулдаг. Хоёр өрөөнд насанд хүрээгүй хүнийг томчуудтай хорьсон байлаа. /Улс төрийн болон хувийн эрх, эрх чөлөөний багийн тайлан. 2001 он/

Нэг хүнд хуульд заасан хэмжээнээс 1.5 м2-ээр бага талбай ноогдож байна.

Хоригдсон хүмүүсийг шар будаа, цувдайгаар хийсэн амтлагчгүй, бага хэмжээтэй хоолоор хооллодог, ямар ч хүчлага дэвсгэргүй, хувцаа дэвсэж унтдаг.

Цагдаагийн өрөнсий газрын харьяа Цагдан хорих төв /Ганц худаг/-ийн нөхцөл байдал өмнө дурдсанаас дээрдэх юмгүй, гол гол үзүүлэлтэрээ хүний эрүүл мэндийн эсрэг, залхаах төв болсоор ирсэн нь тодорхой байна.

Лабораторийн шинжилгээгээр тус төвийн өрөөний 1 м3 агаарт байх нянгийн тоо эрүүл ахуйн нормоос хоёроос дөрөв дахин их, цус задлагч стафилюкокк нян

эрүүл ахуйн нормоос 7.2 дахин их ба шинжилгээ авсан өрөөнүүдийн агаарт хөгц илэрсэн байна. /Эрүүл ахуй, халдвар судлалын байцаагчийн 2001-4-30-ны өдрийн 60 тоот акт/

Бусад аймгийн Урьдчилан хорих байруудад нөхцөл байдал нэг адил түвшинд байна.

- Хоригдогсдод дан ганц цувдайн бантан, шар будаа өгдөг, нэг хүнд ноогдох

хоолны илчлэг нь 1800 килокалори болж байна. Хүмүүсийг хүчлага, дэвсгэрээр хангадаггүйгээс хоригдогсод өөрсдийн дээл хувцсыг хэрэглэдэг, тэдний үсанд оруулдаггүй, тэд бөөстөж, ариун цэврийн наад захын шаардлага хангахгүй нөхцөлд байна. /Өөврхангай аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/.

- Аймгийн цагдаагийн газрын баривчлах байр нь анх зоорины зориулалтаар

баригдсан, гэрэлтүүлэггүй, чийглэг ихтэй, аймгийн прокурорын газраас цаашид ашиглаж болохгүй тухай шаардлага тавьсан ч өнөөдийг хүртэл ажилласаар байна. /Дорноговь аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

- Нэг хоригдогчид 1.6 м2 талбай оногдож, өрөөний чийглэг 14.4 хувь, хоолны илчлэг нь 619 килокалори, ... Хоригдогсдын 50 хувь нь хүчлагагүй. /Хэнтий аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Урьдчилан хорих байны өрөөнүүд 100 хувь гэрэлтүүлэггүй, агааржуулах техөөрөмж ажилладаггүй, нар салхинд гаргадаггүй, өглөө, өдөр, оройд зөвхөн бантан өгдөг. Хорих өрөөнд маш бөгчим, 35-38 хэмийн халуунтай.

Бүх хоригдогсод хөнжил, гудас байхгүй, ар гэрээсээ авчруулдаг. Хоригдогсдыг өглөөний бослогоос өөр үед гаргаж салхилуулдагүй (15 минут л гаргадаг). Хоолны чанар муу, өвөлдөө хүйтэн, зундаа их бөгчим. /Дундговь аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Урьдчилан хорих байр нь цонх байхгүй, агааржуулах техөөрөмжгүй, маш бүгчим, үгаалтуур, хучлага байхгүй. /Баянхонгор аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

1.2.7. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй гэдгийг олон улсын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, Монгол улсын Үндсэн хуульд тодорхой заасан. Энэ бол хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн чухал баталгаа.

Монгол Улс 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцид /1984 он/ нэгдэн орсон.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцид: *Эрүүдэн шүүх* гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө, эсвэл түүний өдөөн

хатгасналаар буюу ил, далд зөвшөөрлөөр хэн нэгэн эгэздийг мэдэгдэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлан сүрдүүлэх, албадах, аливаа үндэслэлээр ягаварлан гадуурхах шалтгаанаар бие махбодь, эрэлт сонсголь хувьд сонаатайгаар хүчтэй өвтгэх, цаналгах аливаа үйлдлийг хэлнэ гэж тодорхойлсон.

Дээрх тодорхойлтоор авч үзвэл манай улсад байгаа нэгэн урьдчилан хорих, баривчлах байрнууд нь эрүүгийн хүний эрхийг халхлах, албадах, сэтгэл санаа, бие махбодийн шаналгалд оруулах нэг арга хэрэгсэл болж хувирсан бөгөөд шалгах шатанд дараа шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх замаар хилсээр хэрэг хүлээлгэн шүүхэд шилжүүлэх явдал ч гардаг байна.

- 96 хүний дунд явуулсан анкетын судалгаагаар "Хэргийг тулган хүлээлгэж шийдвэрлэх явдал байна уу?"- гэсэн асуултад судалгаанд оролцогдын 45 хувь нь "байгаа", 40 хувь нь "заримдаа тохиолдолд" гэж хариулжээ. /Хэнтий аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Цагдаа нарын албадан саатуулах байранд хоригдож байсан 29 хүний дунд явуулсан судалгаагаар мэрдэн байцаагч сүрдүүлдэг гэж 9, тулган шаардаг гэж 18, биед халддаг гэж 8 хүн хариулжээ. Хөвд аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

- Судалгаанд оролцогдын 71.4 хувь нь урьдчилан хорих байранд хоригдогсдыг зориуд сэтгэлзүйн шахалт үзүүлдэг, хүчний байгууллагын зүгээс эрүү шүүлт тулгах, эсвэл бие махбодийг тарчлаан зовоож, сэтгэл санааны дарамтанд оруулах тохиолдол гардаг гэж 50 хувь нь хариулжээ. /Булган аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Урьдчилан хорих төвд хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийг хүчнээ заасан үндэслэлгүй прокурорын байгууллагын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, өөрөө олж давтан гэмт хэрэг үйлдсэн, удаан хугацаагаар хоригдсон хүмүүсийн өрөөнд оруулж, тэдгээр золгүй зэрэгээр дарамт шахалт үзүүлдэг байдал нь эрүүгийн зарим төлөөлөгчийн хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болсныг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2002.01.08-ны өдрийн 02 тоот тогтоолд тодорсон дурьдсан байна.

1.2.1. Хэнд боловч хүнлэг бус хэрцгий хандаж болохгүй гэдэг Үндсэн хуулийн зарчим шүүхээр ял шийтгүүлж, шоронд ял эдлэгдэж нэг адил хамаарна.

НҮБын баталсан Хоригдлуудтай харьцах наад захын зүйлс дүрмүүд, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудад хорих байгууллагуудад тавигдах стандарт шаардлага, хоригдогсдын эрхийг хамгаалах арга механизм, зүгээр эрхийн талаар тодорхой тусгасан байдаг.

Манай Улсад Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль хорих байгууллагатай холбогдолтой олон тооны зүйлээ, журам байна. Гэвч биелэлт огт өөр байдалтайг судалгаа харуулж байна. Хууль зүйн сайдын 1994 оны 25 дугаар тушаалаар нэг хоригдолд ноног тутамд 3500 ккал илчлэг бухий, одоогийн ханшаар ноног 480 төгрөгийн хоол өгөхээр тогтоосон боловч 310 төгрөгөөр тооцож олгодог байна.

Хоригдлыг ажлын байраар ханган нь түүний эрхийг хангах чухал нөхцөл мөн. 2000 оны байдлаар улсын хэмжээнд дулаанаа улиралд 41,1 хувь буюу 2642 хоригдол, хүйтний улиралд 29.8 хувь буюу 1914 хоригдол тогтмол ажил эрхэлж байна.

1999-2000 онд 279 хоригдол нас барсан мэдээтэй бөгөөд 2000 онд нас барсан 97 хоригдлын 81 хувь өвчний үчир, тэдний 90 орчим хувь нь сүрьеэгээр нас баржээ.

2000-2002 оны эхний улирлын байдлаар зөвхөн хорихын нэгдсэн эмнэлэгт жин алдаж туралд орсон 35 хүн иржэмүүлсэн байна. Төрийн шоронд ял эдэлж байгаа хүн яагаад туралд ордог байна вэ гэсэн зүй ёсны асуулт гарах нь гарцаагүй.

Орон нутаг дахь шорон, хорих ангиудад нөхцөл байдал туйлын хангалтгүйгээс, хоригдогсдын эрх ноцтойгоор зөрчигдөх нь ердийн үзэгдэл болжээ.

Жишээ:

- Хорих нь аж ахуйн аргаар барьсан, шалтай л болохоос малын хороотой нэг адил. 50 хүний багтаамжтай гэх мөртлөө 70 хоригдол байна. Хоригдлуудад нормын хувцас өгдөггүй, хөнжил, гудас гэрээсээ авч хэрэглэдэг. Өдөрт 240-250 төгрөгний хоол өгдөг болов. Илчлэг нь нормд хүрдэггүй, өвлийн улиралд нэг удаа усанд оруулдаг. /Увс аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/,

- Зүүнхараа дахь чанга дэглэмтэй хорих ангид үзэг хийхэд нэг хөнжил, гудас, ажлын хувцыг хоёр хүний дунд өгдөг.... Хоригдлуудыг халуун нар, бороо, цасанд удаан суулгаж гар, хөл хөлдөөх, наршуулах гэх мэтээр эрүүл мэндэзэр нь хохироож байна... /Сэлэнгэ аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/,

- Чанга дэглэмтэй Маанытын хорих ангид хоригдлууд цагаан шохойны үйлдвэрт хүнд, хортой нөхцөлд ажилладаг боловч хордлого тайлах сүү болон хүнсний зүйлийг өгдөггүйгээс эрүүл мэндээрээ хохирч байна. Хоригдогсдод бантан бага шар будаа, хоёрхон зүйл хоол өгдөг. Олонхи нь хөнжил гудасгүй.

Хоригдлуудыг орой 24 цагаас хойш бие засахыг хориглодог, хуучин хоригдол нь шинэзэрэг өтгөн шингэнээ зөөлдөг. /Төв аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Энэ бүхэн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хэрэгжилт маяг улсын хувьд хувийн өөрямаг чэрхтэй харьцуулшгүй доод түвшинд байгааг тод харуулж байна.

1.3. Шүүхээд гомдол гаргах эрх

Үндсэн хуульд: Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол

гаргана. ИХШХШТХ-д: "Хууль, Монгол улсын олон улсын гэрээнд заасан, эрх чөлөө, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа сонирхогч этгээд уул эрхээ хамгаалуулахаар. . . шүүхэд мэдүүлэх эрхтэй" гэж тус тус заасан. Эдгээр заалтаас үзвэл шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй, хууль зүйн баталгаатай байна.

1.3.1. Шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй байгаа боловч, иргэдийн хувьд шүүхээд харьяалагдвал зохих маргааны нэлээд хэсэг нь шүүхэд "хамаарлгүй" мэт зөвхөн захиргааны байгууллагын хүрээнд хязгаарлагдан чирэгдэж, хохирох явдал байна.

Хэрэг маргааныг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаж байна уу гэсэн асуултад Шүүхэд гомдол мэдүүлэх эрхийн тухай судалгаанд оролцогчдын 35.4 хувь нь "бүрэн чадсан", 11.4 хувь нь "шийдвэрлэж өгөөгүй"; "шүүх таны тавьсан хүсэлтэд яаж хандсан бэ" гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 53.3 хувь нь зарим үед үндэслэлгүй буцаадаг гэж хариулсан байна. Үг судалгаанд 96 хүн хамрагдсан бө тэдний 80 гаруй хувь урьд өмнө нь хуулийн байгууллагад хэрэг маргаанаа шийдвэрлүүлсэн хүмүүс байна. /Хэнтий аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Өөр нэг асуудал бол төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын хууль бус шийдвэр, үйлдэлтэй холбогдолтой гомдлыг шийдвэрлэх дагнасан шүүх өнөөг хүртэл байгууллагаагүй явдал юм. Үүний улмаас богино хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэгдэж байх ёстой гомдол шүүхийн "их тогоо"-нд орж, хүнд суртлын урт замыг туулж буй нь хүний шүүхэд гомдол гаргах эрхэд мууграр нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд эрчигдсэн эрхийнхээ талаар шүүхэд гаргагдаг гомдол, нэхэмжлэл их өсч, шүүхийн ачаалал, нэг шүүгчид ноогдох иргэний хэрэг маргаан ч эрс нэмэгдсэн байна.

1998-2001 оны шүүхийн статистикаас үзэхэд шүүх иргэний 101115 маргаан шийдвэрлэжээ.

Гэвч шүүх өргөдөл гомдлыг "түдгэлзүүлэх", бусад байгууллагад шилжүүлэх, хугацаа хэтрүүлэх, буруу шийдвэрлэх зэргээр иргэдийг хохирөох явдал гаргасаар байна. 2001 онд улсын хэмжээгээр 3127 хэргийн үлдэгдэлтэй гарсны 675-ын хугацаат хэтрүүлсэн байв.

Давах, хяналтын шатанд хянагдсан хэргүүдээс үзэхэд иргэний хэргийн шүүн таслах ажлын чанар хангалтгүй байна.

Түүний гол шалтгаан бол шүүгчдийн нэлээд нь эрх зүйн шинэ хүчирхэгтэй холбоотой хууль маргаан хоёрыг зөв авцалдуулан ойлгож, хэрэглэх мэдлэг, дадлага дутмаг, шүүгчийн ачаалал их зэрэг баримт нөхцөлтэй холбоотой юм. Ялангуяа хөдөө шүүхийн санхүүжилт илт дутмаг байна. 2000 онд анхан шатны нэг шүүгчид улсын дунджаар эрүү, иргэний 237 хэрэг ноогдож байв.

Дархан-Уул аймгийн зэрэг найман шүүх өнөө ч түрээсийн байранд байна. Шүүхийн бодит зардлыг их хэмжээгээр танаж баталдаг, үнэ хансны өөрчлөлтийг төсөвт тусгах өгдөгүй зэргээс болж нэлээд шүүх ертөн болжээ. 2000 онд Нийслэлийн шүүх 50.2 сая, Төв аймгийн шүүх 16.2 сая, Сэлэнгэ аймгийн шүүх 15.1 сая, Увс аймгийн шүүх 10.2 сая нийт шүүх 163.5 сая төгрөгийн ертэй гарчээ.

ШЕЗ-ийн тооцооноор 2001 оны II улиралд шүүхүүд 167.9 сая төгрөгийн ертэй аж. /Улс төрийн болон хувийн эрх, эрх чөлөөний судалгааны багийн тайлан 2001 он/

1.3.2. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрх зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй болох тухай 1992 оны Үндсэн Хуулийн дагуу нэг ч иргэн шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргаагүй нь анхаарал татаж байна.

1.4. Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх

Үндсэн хуульд заасан энэ эрхээ иргэд бусдын учруулсан хохирол, эд хөрөнгийн бус гэм хорыг арилгуулахаар шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах замаар хамгаалуулдаг.

Эд хөрөнгийн хохирлоос гадна иргэн хүн өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл, иймхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг /хохирлыг/ арилгуулахаар шаардах эрхийг 1994 онд шинэчлэн найруулсан Иргэний хуулийн 7-р зүйлд заасан нь хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн дорвитой алхмын нэг мөн байв.

1.4.1. Иргэд өөртөө хэн нэгний түүний дотор засаг захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлийн улмаас хохирэх учирсан гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээлттэй байна.

Шүүхийн 2001 оны статистикаас үзвэл иргэний нийт маргааны 50 гаруй хувь нь хохирлоо төлүүлэх тухай нэхэмжлэл байна.

Иргэн өөрт учирсан хохирлынхоо талаар нэхэмжлэл гаргаж, шүүхийн нүсэр шат дамжлагыг даван туулж хүссэн шийдвэрээ гаргуулж эрхээ хамгаалуулах нь тийм ч амархан асуудал биш. Ялангуяа шүүхийн шийдвэр бодитойгоор биелэгдэхгүй байгаа нь энэ эрх хэзээ ч бүтэшгүй мөрөөдөл болон үлдэхэд хүргэж байна. Улсын хэмжээгээр 1999 оны 11 сарын байдлаар иргэний нэхэмжлэлтэй шүүхийн шийдвэр 36.9%, 2000 оны байдлаар 36.8%, 2001 оны байдлаар 35.8% нь биелдэг гэсэн байна. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нь хариуцагч этгээд нь төлбөрийн чадваргүйн улмаас нэхэмжлэгч нь хохирлоо авч чадахгүйд хүрч байна (Хууль зүй, Дотоод хэргийн яамны шалгаан зааварлах хэлтсийн мэдээнээс).

2001 оны эхний долоон сарын байдлаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албанд 28883 гүйцэтгэх хуудас бүхий 55.355.5 сая төгрөгний төлбөр гаргуулахаас 17806 гүйцэтгэх хуудас бүхий 31463.2 сая төгрөгний биелэгдээгүй төлбөр байжээ.

Шүүгдийн дунд явуулсан судалгаагаар шийдвэр үйцэтгэгч нарын мэргэжлийн бэлтгэл ханган гүйцэтгэгч, төлбөр төлөгчийн нөлөөнд автах нь ажиглагдаж, багц хэмжээний төлбөрийг барагдуулах талаар ханган гүйцэтгэгч, "гаргуулсан төлбөрийнхөө 5-10 хувийг авдаг гэсэн албан бус яриа байдаг гэж хариулсан нь иргэдээс шийдвэр гүйцэтгэгчийн талаар гаргадаг олонхи гомдол, өргөдлийн агуулгатай өдрийн бичиг гэж тус байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үзэлгээний баримт бичигт тэмдэглэжээ. /Шүүхийн шийдвэр биелүүлэх Ерөнхий Газрын 2000 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үзэлгээ өөр тухай- Илтгэх хуудас/

Сэдлгаанд хамрагдсан шүүгчид тайлбарлахдаа: нэг шийдвэр гүйцэтгэгчид ахлах гүйцэтгэгчээс эхлэн 7-10 дарга онооддог учир олон шатны дага нарын өөр өөр тушаал хэвийн ажиллагаа таагүй нөлөөлдөг гэсэн байна.

- Ийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба нь дотроо аккаараа сайн гэж тооцогддог Баянгол дүүргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хэсэг 8 гүйцэтгэгчтэй. 2001 оны эхний долоон сард 5686 гүйцэтгэхүндэсны 14191.3 сая төгрөгийн төлбөрөөс денгеж 1.7 хувийг биелүүлж, 3139 гүйцэтгэх хуудасны 9690.1 сая төгрөгний төлбөрийг биелүүлээгүй байна.

Энэ гүйцэтгэгчид дунджаар 446 төлбөрийн материал ноогдож буй нь ажлын чанар гүйцэтгэлд муугаар өлөөлж байна.

4.2. Манай хууль тогтоомжид огт тусгагдаагүй, судалж, санал болговсруулах, хууль тогтоогчийн анхаарлыг хандуулах ёстой, иргэдийн гайхал өрөлийг барж байдаг нэг тулгамдсан асуудалтэй хүний амь нас, бие эрхтний "үнэлгээ" юм.

Үнэ адуу дайраад алчихад шүүх дор нь үнийг нөгөгүулаад өгчихөж байхад, хүн дайраад эцэслүүлэхэд сохор эсс ч гаргуулахгүй байна" гэсэн цүмжлэл хохирогчдоос байнга гардаг боловч, чулийн заалт байхгүй" гэсээр өдий хүрчээ. Гэмт хэрэгт улмаас эвдэрэн 2001 онд 476 хүн амь хохирч, 320 хүн хүнд гэмтэл, 726 хүн хүндэвтэр, 2482 хүн хөнгөн гэмтсэн байна. /УДШ-ийн мэдээ/

Чулийн эгтээд, хүний нэр төр, алдар хүндийг нэлэх, доромжилж гутаасны төлөө хохирол гаргаж бүгод байхад түүнтэй зүйрлэшгүй амь нас, бие эрхэнийг үнэлэхгүй байгаас нүүгаар ч зөөтэх аргагүйзэт. Энэ асуудлаар Иргэний болон бусад хуульдгсдорхой заалт оруулах шаардлагатай байна.

4.3. Төрийн байгууллага, албан тушаалтны буруутгажиллагааны улмаас

иргэдэдучирсан гэм хор, хохирлыг нөхөн төлүүлэх арга механизм, хуулийн хөшүүрэг туйлын хангалтгүй байна. Төрийн захиргааны байгууллага, шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгуулагын хүүль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд чирсан хохирлыг арилгах журмын тухай хоёр хууль 990 онд гарсан боловч зөвхөн олгогдоогүй цалин хөлсийг л нөхөн гаргуулахаас хэтэрсэнгүй өдий хүрчээ.

Иймэ төрлийн нэхэмжлэл гаргах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхэд цагдаа, прокурорын ажилтнууд хөшүүн хойрго хандах, саад бэрхшээл учруулах нь ч байна. Олон нөхцөл шалтгааны улмаас хохирсон этгээд төр бүр шүүхэд хандаж нэхэмжлэл, гомдол гаргадаггүй.

Ялангуяа хилсээр мөрдөгдэж, хоригдож "амьдаараа тамлагдсан" хүмүүсээс дээрх хуулийн дагуу хохирлоо ягаад нэхэмжлэхүүгий байна вэ гэхэд: "цалингийн хэдэн төгрөгийн төлөө дахин хуулиар яваад яах юм, миний яаж зовж шаналсан, эрүүл мэндээрээ хохирснүг хэн хариуцах юм бэ гэдэг ба дараа нь цагдаагийнхан

өөр нэг асуудлаар дарамтална" гэж хариулдаг байна. /Нэг емгөөлөгчийн ярианаас/.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах талаар тусгайлсан бүглийг шинэ ЭБШХ-д оруулсан нь хүний эрхийг хангах, баталгаатай болгоход чухал ач холбогдолтой болжээ.

Гэхдээ энэ бүлэгт хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тийм ч туушгай тусгаж чадсангүй гэх эргэлээ төрөхөөр байна.

Төрийг төлөөлж буй байгууллага, ажилтнуудын бүрутгай ажиллаганы улмаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд бүсдаас ялган үзэж, хөнгөлөтгэй хандах ямар ч үндэслэл байх ёсгүй. Гэтэл "шүүд бус хохирлыг төр хариуцахгүй" гэсэн нь Үндсэн хуулийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхэд нийцэхгүй байна. Ялагаад шүүд бус хохирлыг төр хариуцахгүй байх давуу эрхтэй байх болж байна вэ? Энэ бол тэгш эрхийн зарчимд үл нийцэх, улмаар иргэний эрхийг хохироосон заалт юм.

1.5. Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх.

Үндсэн хуулийн дээрх заалтыг яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, өөрийн гэм бүрүүгийг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй. Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн гэмт хэрэгт холбогдолгүйг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй. Гэрч нь гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхээс татгалзах эрхтэй гэж Үндсэн хуулийн заалтыг ЭБШХ-д нилээд тодотгосон боловч Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд их зөрчилтэйгөөр тусгагдсан гэж үзэж болохоор байна. Тухайлбал, уг хуульд зохигчдын эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдийг зөвхөн өөрсдийнх нь зөвшөөрснөөр гэрчээр байцааж болно. Энэ тохиолдолд тэд гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

"Гэр бүлийн гишүүд" гэсэн нэг ойлголтыг хууль бүрт өөр өөрээр тодорхойлж байгаа нь хууль боловсруулах, батлах үйл ажиллагааны нэг

дутагдал гэж хэлж болох юм.

ЭБШХ-д /34-р зүйл/:

- "Гэр бүлийн гишүүд" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй нэг гэрт амьдарч байгаа эхнэр, нөхөр, төрсөн болон үрчилж авсан хүүхэд, төрөл садны хүмүүс"-ийг "төрөл садан"- гэж төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, төрсөн буюу үрчилж авсан эцэг, эх, төрсөн буюу үрчилж авсан хүүхэд, ах, эгч, өвөг эцэг, эмэг эх, хадам эцэг, эх, ач, зээ болно;

Гэр бүлийн тухай хуульд /3-р зүйл/:

- "Гэр бүлийн гишүүн"-гэж гэрлэсэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүнийг ойлгоно. "Төрлийн хүн"-гэдэгт гэрлэсэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин тэдгээрийн хүүхдийг, "садангийн хүн" гэж гэрлэсэгчийн төрсөн эх, эгч, дүү, авга, нагац тэдгээрийн хүүхдийг хэлнэ – гэж тус заажээ.

Үүнээс үзвэл, ИХШХШТХ-д заасанчлан зөвхөн эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдийг тодийгий, хэрэв хамт амьдарч байгаа бол өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин тэдгээрийн хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг "Гэр бүлийн гишүүн"-гэж үзэх учир Үндсэн хуульд заасны дагуу тэдний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэх ёстой.

Өөр нэг анхаарал татаж буй асуудал бол ИХШХШТХ-д заасан "зөвшөөрснөөр гэрчээр байцааж болно" – гэсэн заалт юм.

"Зөвшөөрүүлэх" –гэдэг бол сэтгэл зүйн даралт, хууль мэдэхгүйн гачлантай салшгүй холбоотой ойлголт.

Үндсэн хуулийн үзэл санаа бол эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ иргэн хүн цаг үргэлж, чөлөөтэй эдлэх ёстой гэсэн үг. Гэтэл энэ эрхийг чөлөөтэй эдлүүлэхгүйгээр "зөвшөөрүүлнэ"-гэдэг нь хууль бус ажиллагаа юм.

1.6. Өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх

ЭБШХ, ИХШХШТХ, Өмгөөллийн тухай хуулиудад өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах жүрмыг тусгасан.

1.6.1. Өмгөөлөгчийг ёс тедий үзэж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хэдхэн тооны хэргээс бусдад нь өмгөөлөгчийг оролцуулдаггүй байсан, өмгөөлөгчдийн өөрсдийнх нь идэвхигүй үйл ажиллагаа зэргээс нь энэ эрхийн бодит хэрэгжилтэд одоо ч сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрх хомс, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагчдын өмгөөлүүлэх эрх нөцтой зөрчигдөг нь судалгаа, шалгалтаас тод харагдаж байна. **Жишээ:**

2001 оны 4 дүгээр сард Цагдан хорих төв "Ганц худаг"-т хийсэн судалгаагаар мөрдөн байцаалтын шатанд цагдан хоригдсон 619 хүний 80 орчим хувь нь өмгөөлөгч огт авагчийбайв. Шалтгааныг лавлахад олонхи нь өмгөөлөгч авагчийх мэдэхгүй, өөрөө хоригдсон болохоор ар гэрийнхэн нь хөөцөлдөж мэдээгүй, өмгөөлөгч авах алаар мөрдөн байцаагч яригагүй гэх буюу өмгөөлөгчийн хэлс төлөө мөнгөгүй гэж хариулцгаажээ. 201 оны 4 дүгээр сарын 9-нд Баянзүрх дүүргийн Цагдагийн хэлтсийн албадан саатуулах байранд байсан хоригдогсоос ганц нь ч өмгөөлөгч авагчийгүй сард мөн тэнд хоригдсон 1967 хүний 27 хувь нь буюу 524 хүнд өмгөөлөгчгүйгээр байцаан шийтгэх ажиллагаа явуулжээ.

1.6.2. Анхаарал татсан асуудлын нэг нь төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хэрэн хангах тухай юм.

Өмгөөллийн тухай хуульд

- Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөс санхүүжүүлнэ. Энэхүү зардлыг санхүүжүүлэх тайлан, тооцоо гаргах журмыг ШЕЗ, МЁХ-нь сналыг үндэслэн хууль зүйн, хүн амын бодлого, хөдөлмөрийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтоно.

Шүүхийн тухай хуульд:

- Өмгөөллийн хөлс төлөх чадваргүй шүүгдэгчид төрөөс туслалцаа үзүүлэх эх үүсвэр тус заасан.

Хууль биелүүлэхийн тулд Хууль зүйн сайд, Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайдын хамтарсан "Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсөөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо өргөх журмын тухай" тушаал 1995 онд гарчээ. Тушаалын ёсоор ШЕЗ холбогдох зардлыг шүхийн байгууллагуудад хуваарилан хүргүүлэх ёстой бөгөөд эхний жилүүдэд эрхбиш биелүүлж байжээ. Энэ зардалд улсын төсөөс 1997 онд 4.0 сая 1998 онд 2.0 сая, 1999 онд 7.0 сая төгрөг буюу нэг шүхэд 30.0-200.0 мянган төгрөг батлаж өгсөн байна. Гэтэл өмгөөлүүлэгч төлбөрийн чадваргүй гэдэг Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Санхий сайдын 1993 онд батална "Амьдрал ядуу, багаа эрлэгтой өрх, иргэдэд туслах санхийн хөрөнгийг бүрдүлэх, зарцуулах журам"-ын дагуу сум, дүүрэг баг, хорооны Засаг даргаар тодорхойлуулах зөгийн олон чирэгдлээс шалтгаалан тэр мөнгийг ёс авч чаддаггүй байна.

"Орлого багатай ядуу иргэд өмгөөлөх авч чаддаггүйгээс болоод ихээхэн хохирч байна. Үүнээс бүгийн ядуу иргэдийг өмгөөлөх санхүүжилт ганай аймагт хуваарилагддаггүй гэж өмгөөлөгчийн зөвлөлийн дарга нь эрьж байна" /Дарга-Уул аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/.

Өмгөөлөх байгууллагын зохион байгуулалт, бүрэлдэхүүнийг сайжруулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх асуудал анхаарал татаж байна. Одоо улсын хэмжээнд өмгөөлөгчдийн 42 төвөө, 21 зөвлөл 400 гаруй өмгөөлөгч ажиллаж эсэн мэдээ байна. Сүүлийн дөрвөн жилд өмгөөлөгчийн мэргэжлийн шалгарууллалт болоогий байна. Тэний дотор чадвар сул, ёс зүйн дүрэм жүрмаа зөрчигчид

байдаг нь үйлүүлэгдийнхээ эрхийг зөрчихөд хүрдэг байна. Ууны өмнө өмгөөлөгдийн эрх үүрэг, ёс зүйн асуудыгтоо шинээр авч үзэх цаг болжээ.

Өмгөөлөх нарын мэргэшлийн түвшин өмгөөллийн үг чадварыг эрс дээшлүүлэх шаардлагатай байгаа нь орон нутагт хийсэн судалгаанаас ажгдах байна.

- Өмөөлөгч нар нь шүүхийн шийдвэр гарсны дараа өмгөөлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах талаар үчир дутагдалтай байдаг. Тус аймагт өмгөөлөгч (бүлвон үүхий нэн шаардлагатай байна. Өмгөөллийн эвлэл нь 40-60 насны хоёр өмгөөлөгч, хоёр дадлагажигтай, нэг нь эрхээ хасуулаад дахин сэргээгдсэн нэгэн байна. /Булган аймгийн судалгааны багийн тайлан/2001 он/

- Өмгөллийн байгууллага хөдөлмөрийн насны болон рэд мэргэжилийн өмгөөлөгчөөр дутмаг байна. /Дундговьаймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

- Өмөөлөгч эхлээд миний өмгөөлөгч болохыг зөвшөөрч, бүхий л байдлыг ярилуснаас хойш хэдэн хоорон дараа би чиний өмгөөлөгч болоосоо болиоо, энэ хэрэг негээ талд чинь шийдвэрлэгдэх юм шиг байна. Би негээ талын өмгөөлөгчөөгөөс болиоо, аль ашигтай талд нь орвол дээрх үүдэс намайг үүчлаарай- гэсэн. /Хэнтий аймгинсудалгааны багийн тайлан 2001 он/

Энэ бүхэн иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрх үүнээгий зөрчигдөж буйг харуулж байна. Эрүүгийн байцан шийтгэх шинэ хуульд эрүүгийн хэрэг дэх өмгөөлөгчийн эрхийг өргөтгөж, сэжигтний баривчлахаас өдгөн хорих, таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс хянан хэлэлцэхэд байлцаж, санал гаргаж болохоо тогтосон нь ихээхэн шинэлэг зүйл юм.

1..7. Ѳстох баримтыг шалгуулах эрх

ЭЁБШС-д: Яллагдагч нь . . . баримт сэлт гаргаж өгөх нөлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах эрхтэй/ өмгөөлөгч нь . . . хэрэгт ач холбогдол бүхий . . . баимт сэлт гаргаж өгөх, сэжигтэн нь . . . баримт сэлт гаргаж өгөх, нөлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах эрхтэй. хохирогч нь. . . баримт сэлтгаган өгөх, нөлох баримт шалгуулах хүсэлт гаарга эрхтэй гэж заасан.

"Нөлох ббармыг шалгуулах эрхтэй" гэсэн Үндсэн хуулийн заалтыг "нөлох баримт шалгуулах хүсэлт гаргах эрхтэй гэсэн ЭБШХ-ийн дээрх заалт нь зүгуулгын хүдвэрчидэж байна. Тухайлбал ЭБШХ-ийн 204-р зүлд "сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгч нь зөвхөн хүсэт аргах эрхтэй бөгөөд . . . Хүсэлтийг мөрдөн бйайдаг хянах үзэзд түүнийг хангасан буюу хэрэгсэхгүй гүйцэтгэх тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж, үүнтоолыг яллагдагч буюу түүний өмгөөлөгчид зүлд "сэжигдэнэ" гэж заасан нь Үндсэн хуулийн энэхийн зөрэг бөгөөд үзэмжийн хэрэг болжээ.

Практик дээр мөрдөн байцаалт дууссны дараа хяавзт хэрэгтэй танилцаад яллагдагч, өмгөөлөгчөөс гаргасан тодорхой хүсэлтүүдийг ихэнх тохиолдолд мөрдөн байцаагч нар ЭБШХ-ийн энэхүү 204-р зүйлээр хэрэгсэхүй болгож хаадаг байна. Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчингүй болсон, өөрлөгдсөн, хэрэг нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан зохилоох шалтгаан нь нөтлох баримт шалгуулах эрхийг хангаагүйтэй холбоотой байна.

УДШ-ийн Судалгааны төвийн танилцуулгад "давж заалдах шатны магадлал хүчингүй болж байгаа гол шалтгаан нь. . . нөтлох баримтын зөрүүг шалгаагүй, хуулийн шаардлага хангаагүй нөтлох баримтыг үндэслэх, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг шалгаж тогтоогоогүй. . ." явдал мөн гэж дүгнэжээ.

Улсын Дээд шүүхийн зөрүүгийн давж заалдах шатны 2000-5-12-ны өдрийн 99-р магадлалаас үзэхэд анхан шатны шүүхийн шүүгч иргэн К-д холбогдох хэргийг хянаад "Би Г-р алаагүй, энэ хэрэг гарах үед Төв аймгийн Архуст суманд амьдарч байсан" гэсэн шүүгдэгч К-ийн хүсэлтийг шалгуулах тухай хүсэлтийг "биелүүлээгүй" гэсэн үндэслэлээр хэргийг буцаасан байна.

Шалгуулах эрхийн негээ талд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын "шалгах үүрэг" байх ёстой бөгөөд тэд иргэдийн хүсэлтийг "хянах" биш, заавал шалгах үүрэг хүлээж байх нь Үндсэн хуулийн үзэл санаа юм.

1.8. Шударга шүүхээр шүүлгэх эрх

Шударга, хараат бус, зөвхөн хууль захирагддаг шүүхийн тухай асуудал бол Монголын өнөөгийн нийгэм дэх шүүмжлэл, маргаантай эмзэг асуудлын нэг юм.

Шүүх, шүүгчтэй холбоотой олон янзын шүүмжлэл, бүр нөцтой гэж хэлж болох баримт яригдаж, бичигдэж, зарим нь нотлогдсон явдал ч байна.

Шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхгүй удаж, иргэдийг чирэгдүүлдэг хууль зөрчиж, буруу шийдвэрлэдэг танил тал хардаг байхад шударга шүүхээр шүүлгэх эрх баталгаатай хэрэгжиж байна гэх итгэл бага байна.

Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтарч хийлгэсэн "Монгол дахь авилгалын талаарх олон нийтийн санаа бодол, байр суурь" гэсэн судалгаагаар хамгийн их авилгалд автсан байгууллагууд, эдний дотор судалгаанд хамрагдагчдын үнэлгээгээр гааль /73.5%/, банк /63.8%/, харин шүүх 48.8 хувиар гуравт орсон нь хэдийгээр давхар нотолгоогүй ч олон түмэнд итгэл алдаж буйн илрэл юм.

2000 оны 5 шүүгч ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн үчир отцорсон, 2001 оны эхний хагаст 24 шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэсэн /Шүүх эрх мэдэл-сэтгүүл, 2000 он, №4, 2001 он №2/ байна.

Гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн, шүүн таслах ажилд ноцтой дутагдал гаргасны үчир 2001 он гарсаар 8 шүүгчийг огцруулах саналыг Шүүхийн

Ерөнхий зөвлөлөөс оруулсан байна.

Дорноговь аймгийн сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр ажилlaж байсан "Б" гэгч нь эд мерийн баримтаар хураагдсан 211 кг үгаасан ноолуурыг тухайн үеийн ханшаар нэг кг-ыг нь 35000 төгрөгөөр, нийтдээ 7.385.000 төгрөгөөр үнэлсэн зохих газрын үнэлгээ байхад шүүхийн гүйцэтгэх хуудсанд нэг кг-ыг нь 15000 төгрөгөөр бодож, нийт 3.165.000 төгрөгийг улсад оруулахаар тогтоож, улсад 4.220.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн, Дархан-Уул аймгийн сум дундын шүүхийн шүүгч "Т" нь 1996 онд хүлээн авсан эрүүгийн хэргийг 2000 онд шийдвэрлэсэн байх бөгөөд шүүх хурлын протоколоос үзэхэд шүүгдэгч "Г"-г биш өөр хүнийг шүүх хуралдаанд оруулж хууль ноцтой зөрчсөн. /"Зууны мэдээ" сонин, 2001-4-23, №97/

Нийслэлийн нэг дүүргийн ерөнхий шүүгч: Шүүхийн нэр хүнд иргэдийн дунд унаж байгаа гэдэгтэй санал нэг байна. Энэ нь хувийн болон харилцааны соёл, ажил хэргийн чадвар муутай шүүгчдээс болж байгаа юм. Эдийн засгийн хувьд хараат бус байж чадахгүй байна. Цалингаа хугацаандаа авч чаддаггүй, гэрэл цахилгаан, харилцуур утсаа таслуулчихсан шүүх, шүүгчдийн хэвийн ажиллах

нөхцлийг төрөөс хангаж өгч чадахгүй байна шүү дээ.

Ер нь бол шүүх засагчлын Үндсэн хууль тунхагласан зарчим өнөөдөр хоосон нэр томъёо төдий байна /"Зууны мэдээ"-сонин, 2001-4- 23,№97/ гэж илэн далангүй ярьсан байна.

Нийслэлийн шүүхээр хэналтын журмаар хянагдсан иргэний хэргийн судалгаанаас үзэхэд, зарим шүүх ИХШХШ тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж, хууль бус бүрэлдэхүүнтэйгээр хэрэг шийдвэрлэх, шийдвэр тогтоолыг зөвлөлдөх тасалгаанд үйлдэлгүй ноцтой зөрчил гаргах, нэхэмжлэлийн шаардлагаас халих, аль эсвэл дутуу орхих, дээд шатны шүүхийн магадлалд дурдсан заалтыг биелүүлэхгүй байх, зохигчдын мэтгэлцэх эрхийг хангагчгүй гэх мэт

дутагдал ихээх хэмжээгээр гаргасан тойм мэдээ, 2000 он/.

1.9. Шүүх ажиллагаанд биеэр оролцох эрх

ЭБШХ-д: Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаар хэрэг хэлэлцэхэд шүүгдэгчийг заавал оролцуулна. Гагцхүү шүүгдэгч нь Монгол улсын хилийн гадна байгаа бөгөөд шүүхэд хүрэлцэн ирэхээс зайлсхийвэл шүүгдэгчгүйгээр хэрэг хэлэлцэж болно гэж заасан. Иймэ заалт шинэ хуульд ч тусгагдсан байна.

Энэ анхаарал татаж буй асуудал бол хилийн гадна байгаа хүний хэргийг яаж түүнгүйгээр хэлэлцэх вэ гэдэг асуудал юм. Шүүгдэгчгүйгээр, эчнээгээр хуралдаж хэрэг шийдвэрлэнэ гэдэг бол Үндсэн хуулийн агуулгад харшлах болно.

Хориглож буй шүүгдэгч дээж заалдах шатны шүүхээр хэрэг хэлэлцэхэд оролцож чаддаггүй, оролцуулж эрхийг нь эдлүүлэх талаар ямаар ч арга хэмжээ авдаггүй бруу практик хэвшиж тогтсон байна.

Үндсэн хуульд заасан "шүх акиллагаа" гэдэг бол анхан шат, давах шат, хэналтын шатыг багтаасан цогц ойлголт байтал ЭБШХ-д хяналтын шатны шүүхэд хэргийг хянан хэлцэхэд хэрэгт холбогдогч үг хуралд оролцохгүйн тухай заагаагүй байна /368-р зүйл/.

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд: "Хэргийн оролцогч нь шүүх хуралдаанд оролцох эрхтэй". /24-р зүйл/.

"Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна. Харин хүндэтгэн үзэх шалтгаангүйгээрирэхгүй бол нэхэмжлэлийг буцаана".

"Зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд . . . дээж заалдах хуралдаанд оролцохыг хүсвэл шүх тэдгээрийг хуралдаанд биеэр оролцох эрийг нь хангаж, хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэх үүрэгтэй" /169-р зүйл/ гэж мөн тус тус заасан байна.

Харин ЭБШХ-тай адилаар хэналтын шатны шүүх хуралд зохигчдын оролцох эрхийн тухай заагаагүй байна.

Шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхийг зөрчих явдал иргэний байцаан шийтгэх ажиллагааны явцад гардаг нь шүүхийн практикийн удаллагаанаас харагдаж байна.

Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 1999 оны 885 –р шийдвэрийг нийслэлийн шүүхийн 1999 оны 217дугаар тогтоолоор хүчингүй болгохдоо: ". . . хавтаст хэргийн материалаас үзэхэдхариуцагчид шүүх хуралдаан болох тухай албан ёсоор зарлан дуудах хуудас өгөөгүй, өгсөн гэх бэлэг "иржээгүй" гэсэн шалтгаанаар шүүх хуралдааныг 3–4 удаа хойшлуулсны эцэст хуулийн заалтыг зөрчин хуралд хийсэн" гэж заасан байна. /Улс төрийн олон хувийн эрх, эрх чөлөөний судалгааны багийгтайлан 2001 он/

1.10. Шүүхийн шийдвэрийг дээж заалдах эрх

Үндсэн хуульд заасан нэг эрхийг баталгаажуулахын тулд ЭБШХ-иад анхан шатны шүүхийн тогтоолыг тогтоол үншин сонсохгүй өдрөөс хойш, хэрэв шүүгдэгч цагдан хоригдсон байгаа бол уг тогтоолын хуулбарыг түүнд гардуулаг өгсөн өдрөөс хойш арав хоногийн дотор дээж заалдах гомдлоо гаргана, мөн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт гарсан өдрөөс нь хойш арв хоногийн дотор дээж заалдах гомдол гаргаж болно. / ИХШХШТ хуулъ/ гэж тус тус заажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх циэ хуульд:

Шүүхийн тогтоолд дээж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгэд, түүнийг гардаж авсан бүюу танилцуулснаасхойш дээж заалдах гомдол гаргах эрхтэй гэж тусаан нь давах

гомдол гаргачийн хэвэд ашигтай болсон байна.

Хууль тогтоомжид давж заалдах гомдлын агуулгад хязгаарлагдаагүй газьдаггүй болговч ИХШХШ тухай хуульд давж заалдах гомдол, эсэргүүцлийн үндэслэлд анхан шатны шүүхээр хянан хэлэлцээгүй шинэ нотлох баримт гаргаж өгсөн /166-р зүйлийн 3 дахь заалт/ - гэсэн нь практикт багагүй маргаан дэгдээдэг байна.

Анхан шатны шүүх дээр яригдаж боломжгүй байсан нотлох баримт өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгалахын тулд давж заалдах гомдолдоо заажаа хавсаргахыг иймхүү хуулиар хориглож байгаа нь хэрийг нотлох баримтын үндэсэн дээр шүдаргаа шийдвэрлэх зарчмыг илт гажуудуулсан заалт юм.

Анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэсэн таван хэрэг тутмын нэг нь давж заалдах гомдол гардаг бөгөөд 1998 2001 оны статистикаас үзэхэд давж заалдах шатнаа хянагдсан нийт эрүүгийн хэргийн таслан шийдвэрлэх тогтоолын 52.2-54.7 хувь нь хэвээр үлдэж 45.3-47.8 хувь нь хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн байна. Харин 2000, 2001 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн иргэний хэргийн арван хэрэг тутмын нэг нь давж заалдах гомдол гаргаснаас үзэхэд эрүүгийн хэрэгт давж заалдах гомдол иргэнийхээс 2 дахин их байна. Таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгосон, өөрчилсөн үндэслэлийн дотор "хэргийн зүйлчлэл буруу", "хэрэгтний сувийн байдал", "ялыг тохируулагаүй", хэзээрочийн гэм буруутай ажиллагаа хэрэг арилгад нөлөөлсөн", "аргагүй хамгаалалтын хэмжээг хэтрүүлсэн" гэсэн зүйлүүд зонхилж байна.

2000 оны Улсын Дээд шүүхийн давж заалдах шатны шүүхдаанаар аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэсэн бүгд 29 хэргийг хянан хэлэлцсэнээс 29.7 хувь буюу 7 хэргийн тогтоолд өөрчлөлт оруулж 46 хэрэг нь буюу 62.1 хувьд нь ял хөнгөрүүлсэн байна. Энэ нь давж заалдах шатны шүүхийн алдаа зөрчил анхан шатны шүүхэд тийм ч бага биш байгаа хэрүүж байна.

1.11. Училлхүсэх эрх

Училал бол зөвхөн төрийн төрүүн - Ерөнхийлөгчид үндэсн хуулиар олгогдсон эрх юм.

Цаазаар авах ялаар шийтгүүлсэн хүнээс ямь хэлтрүүлэх тухай хүсэлт гаргасан, гаргагүй аль ч тохиолдолд тухий хэргийг Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлэх бөгөөд түүнийг Ерөнхийлөгч хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор ялтанд училал үүгүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Шаардагатай бол уг хугацаа 30 хүртэл хоногоор сунгаж болдог байна. /Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 102 дугаар зүйл/

Энэ бол зөвхөн нэг өөрчлөл хүсэлт биш, хүний амь насыг хөгудал. Шалгахад тувэгтэй, эздрээтэй өөрчлөл гомдлыг шалгах хугацаанаа 6 сараар тогтоосон байхад хүний амь насны асуудлыг хоёрхон сараар шийдвэрлэхээр заасан нь хэт богино байна.

Иймд цаазаар авах ялын асуудлыг шийдвэрлэх хугацаар тусгайлан 6 сар буюу түүнээс дээш гэж хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч хорих газар ял эдлэж буй хүмүүсээс 1998 онд училалт хүссэн 142 хүсэлтийн 17-д, 1999 онд 135 хүсэлтийн 15-д, 2000 онд 140 хүсэлтийн 24-д нь тус тус училал үзүүлжээ. Харин цаазаар авах ялтай хэдэн хүний хэдэд нь училал үзүүлснийг авч чадаагүй болно. Энэ тоо нь төрийн нууцын зэрэглэлд орсон нь эргэлзээтэй байна.

1.12. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө

УИХ 1993 оны "Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 1994 оны "Шашин-сүм хийдийн талаархи төрийн бодлогын үзэл баримтлалын тухай" зөвлөмж тус тус гаргасан нь хүний шүтэн бишрэх эрх чөлөөг хангахад бодит нөлөө үзүүлжээ.

1.12.1. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар хувь хүн сүм, хийд байгуулах тухай өргөдлөө, дүрмийн хамт аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргаж, зөвшөөрөл авсны үндэсн дээр сүм хийд байгуулж хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлдэг журамтай.

1990-ээд оноос хойших нийгмийн ухамсарт гарсан их өөрчлөлт нь шашин шүтэх эрх чөлөөнд ч мөн их давалгаа үүсгэсэн.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад Будда, Христос, Ислам, Бахай, Бөө, Язу тарнийн 270-аад сүм хийд байгаагаас 186 нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс уламжлалт гэгдэх Буддын шашин 112 хийд дацан /нийслэлд 28/, Ислам шашны 2 /нийслэлд 1/, Бөөгийн 1 / нийслэлд/ , "уламжлалт бус" гэгдэгт Христос шашны 65 / нийслэлд 39/, Бахай шашны 5 / нийслэлд 1/, Язу тарнийн 1 сүм үйл ажиллагаа явуулж байна.

1.12.2. Сүм хийдийг бүртгэхэд үндэслэлгүйгээр татгалзах, хаах, боох хандлага байгаад шүүмжлэлтэй хандвал зохино.

Төв аймгийн Жаргалант суманд байгаа христийн сүмийг хөөх, Аргалант суманд байгаа христийн сүмийг цардаагаар тараалгах, 1999 онд Төв аймагт байгуулагдсан Ватиканий төлөөлөгчийн газрын санхүүжилттэй хүмүүнлэгийн хүүхдийн цэцэрлэгийг шашны үйл ажиллагаа явуулж байна гэсэн нэрээр зогсоох зэрэгээр нотолгоо үндэслэлгүйгээр хардан сэрдэх, хаан боох, гуйвуулах зэрэгээр зарим нэгэн зүй бус авир гаргажээ. /Шашин шүтэх, эс шүтэх эрхийн нөхцөл байдал, судалгааны урьдчилсан тайлан/

Төр, сүм хийдийн харилцааны тухай

хуулийн 7 дугаар зүйлийн "7"-д " аливаа шашны байгууллага, лам санваартан өөрийн шашныг эс шүтэгчдийг... эд мөнгөө татахыг хориглоно" гэснийг зарим албан тушаалтнууд хүмүүнлэгийн ажил хийж байгаа бол шашны ажил огт хийж болохгүй, шашны ажил хийж байгаа бол хүмүүнлэгийн ажил хийж болохгүй мэтээр тайлбарлаж, хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь зарим шашны гол үйл ажиллагаа байдгийг үгүйсгэхийг оролдох нь ч байна.

Орчин үед төр, сүм хийдийн харилцааны талаарх төрийн бодлого, үйл ажиллагаа нь уламжлалт ба уламжлалт бус шашнуудын дотоод болон тэдний өөр хоорондын харилцааны гарч байгаа шинэ үзэгдэл, үйл явцын хандлага, чиглэлийг шинжлэн судлах явдал ирэгдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангахад чухал ач холбогдолтой болж байна.

1996 оноос хойш айраг, нийслэлийн ИТХ шашны байгууллагад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохоос хугацаат нэг жилээр тогтоон улмаар уг хугацаа дуусах үед жил, жилээр сунгадаг журам тогтсон байна. Гэвч тухайн үед зөвшөөрөл олгосон ИТХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусснаы дараа шинээр сонгогдсон ИТХ шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хугацаа сунгахдаа хойрго хандаг, түүнээс зайлсхийдэг хандлага гардаг ажээ.

Шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохгүй, олгосон ч богино хугацаатай байх нь нэг талаас шүтэн бишрэх эрхээ чөлөөтэй эдлэх боломжийг хязгаарлах, мөн бусдын зүгээс гадуурхах шалтгаан болдог. Негее талаар бүртгэл зөвшөөрлийн журмыг зөрчих явдал байгааг зөвтгөж болохгүй.

1.13. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрх

Энэ заалтын дагуу Монгол Улсад засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд зорчиход "зам явах" авдаг байсныг бүрмөсөн халснаар зорчих эрх бодитой болжээ.

Статистикийн мэдээнээс харахад бүх төрлийн тээврийн хэрэгслээр 2000 онд давхардсан тоогоор 93.0 сая хүн, 10643.4 мян.тонн ачаа тээвэрлэж, зорчигч эргэлт/нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн км зайгаар үржүүлсэн үзүүлэлт/ 1946.0 сая хүн.км болжээ.

Зорчих эрхийг Онц байдлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хилийн тухай зэрэг салбар хуулиудаар хязгаарласан нь зүй ёсны гэж үзэхээр байна.

1.14. Төр буюу байгуулагын эрхийн суурь газраа сонгох эрх

Иргэний бүртгэл мэдээллийн тухай хуулиар эрх олгосноор "Монгол Улсын Засгийн газар 1996 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх нийтлэг журам"-ыг 47 тоот тогтоолоор батлан мөрдүүлжээ.

Энэхүү актаар эрүүгин ял тэнссэн, засан хүмүүжүүлэх ажил хийж байгаа бол ялын хугацаа дуустал, гэмт хэрэгт сэжиглэн, яллагдагчаар татагдсан бол уул хэрэг шийдэгдэх гэх зэрэг болон бусад үндэслэлээр шилжин суурьшихыг төр түдгэлзүүлэх журам тогтоосон нь иизвчлэн зүй ёсны буюу холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Харин Нийслэлийн/Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 69 тоот тогтоолоор /2000 оны 46, 2001 оны 08 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/ бүртгэгдсэн журмын өссөн хөдөөнөөс Улаанбаатар хотод суурьшихаар шилжин ирсэн насанд хүрэгчдээс үлчилгээний хөлс" нэрээр 50000 төгрөг, 18 хүртэх насны хүүхдээс 25000 төгрөгийн хураамж авч байхаар тогтоосон нь хүний үг эрхэнд харшилж байна. Энэ бол үнэхээр төсөвт нийгэмшлийн үйлчилгээнд зардал нэмэгдэж бол түүнийг төсвүдийн хоорнд зохицуулж иргэнд хохиролгүй шийдэх, хэрэг дээвиас төлбертэй үйлчилгээ хийх бол өөрдөө сайн дураар шийдэх маягаар зохицуулж болох ажуудал юм. Дээрх журмаар 5 ам бүлтэй / насанд хүрэгчэй 3 хүүхэд / өрх дунджаар 200000 төгрөг шилжин суурьшихад зарцуулна гэсэн тооцоо гарч байгаа бегөөд энэхүү хураамжийн орлого юунд зарцуулагдах талаар ямар ч мэдээлэлгүй ,хяналтгүй байна. Энэ бухнээс үүдээд эдийн засгийн албадлаар хүний шилжин суурьших эрхийг боомилж бүйхэгэ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Иймэ практик бусад аймагт тархаж байгаа даруй таслан зогсоох ёстой.

- Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 15 тоот тогтоолоор Чойбалсан хотод шилжин ирэгч насанд хүрсэн хүнд 10000 төгөг, хүүхдэд 5000 төгрөгний төлбөр тогтоосон байна.

- Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 4 сарын 14-ны 25 дугаар тогтоолоор тус аймагт шилжин ирж суурьшихдиргэдээс авах нэг удаагийн хураамжийг 19 болготүнээс дээш насны хүн тус бүрээс 25000 / хорин таван мянга/ төгрөг, түр оршин суухад насанд хүрэгчдээс сар тутамд 2000 төгрөг авч байлгүүс тус тогтоосон байна.

Түүнчлэн иргэд улсынхаа нутаг дэвсгэрт түр болон байнга оршин суухад илүү тэлэн бичиг баримт шаардаг зэрэг бэрхшээл байдаг.

1.15. Гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрх

Энэ харилцааг Монгол Улсын иргэн гадаадад хүвийн хэргээр зорчих цагаачлах тухай хуулиар бүхэлд нь, Харьяатын тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль болон бусад хуулиар зарим нэг талаас нь зохицуулж байна

Гагцхүү энэ эрхээ эдлэх явдал нь улсын

аөулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, бүсдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхолд нийцсэн байхыг шаарддаг.

Монгол Улсын иргэдэд гадаадад явах, тэнд оршин суухаар цагаачлахад тухайн иргэнийг хүлээн авах улсын дотоодын хуулиар тогтоосон журмаас өөр Монголын төр, засгийн зүгээс учруулах ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Гагцхүү очих орны хууль тогтоомжоор урьдчилан зөвшөөрөл авах, амьдрах баталгаатай холбоотой болзол шаардах тохиолдол зарим орны хувьд нэлээд хатуу, заримынх нь хувьд бага зэрэг хязгаарлалт байдаг бөгөөд төр нь тухайн орны дотоодын асуудал учраас Монголын иргэн уг хүрмыг хүссэнээр зөрчиж болохгүй билээ. Иймээс зарим иргэдийн бусад улс оронд зорчих, цагаачлах гэсэн хүсэл эрмэлзэл хангагдахгүй байгааг үүйсгэхгүй байна.

2000 онд 83 оронд 508821 иргэн гарсан бол мөн онд тэдгээр орноос 495285 монгол иргэд эх орондоо буцаж ирсэн ба нийтдээ 1 сая 41 мянган хүн Монгол Улсын хилийн боомтоор нэвтэрсэн байна. Монгол улсын хилээр гадагш гарсан 508821 хүний тооноос улсын хилээр буцаж орсон 495285 хүнийг хасахад хилийн цаана буюу бусад улс оронд 13536 хүн үлдсэн дүн гарч байна. Жил ирэх тутам Монгол Улсын иргэд гадаадад зорчих нь өсөж байгаа зэрэг нь энэ эрх хангагдаж буйн баримт мөнтолгоо юм.

ХОЁР. ХҮНИЙ УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төрийг удирдах хэрэгт оролцох эрх

Иргэд төрийг удирдах хэрэгт оролцох эрхээ: нэгд, төрийн байгууллагад сонгогдох, хоёрт, сонгох эрхээ эдэлж, Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох, гуравт, төрийн албан тушаал эрхлэн ажиллах гэсэн үндсэн хэлбэрээр эдэлж байна.

2.1.1. Иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох хамгийн шийдвэрлэгч эрх бол сонгох, сонгогдох эрх юм. Сонгууль бол ард түмний хүсэл зоригоо илэрхийлэх арга хэрэгсэл бөгөөд төр нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишиг шаардлагад нийцэж, жинхэнэ чөлөөтэй, шударга явагдсан цагт хүний улс төрийн эрхийг хангагдаг тул хүний эрхийн хэрэгжилтийн чухал баталгаа болдог.

Монгол Улсын шинэ (1992) Үндсэн Хуулиар сонгуулийн бүх нийтийн шууд, чөлөөт, саналаа нууцаар гаргаж сонгох зарчим тогтоосон бөгөөд түүний дагуу сонгуулийн хууль гаргаж 1992, 1996, 2000 онд парламентын, 1993, 1997, 2001 онд Ерөнхийлөгчийн сонгууль явуулжээ. 1992 оны сонгуулиар УИХ-ын 76 суудлын 69- ийг, 2001 оны сонгуулиар 72-ыг тус тус МАХН авсан байна.

1996 оны сонгуулиар "МҮАН-МСДН-ын ардчилсан холбоо" эвсэл 50, МАХН- 25, МҮНН-1 суудал тус тус ноогдож байжээ.

2000 оны УИХ-ын сонгуулиар "ИЗНН" эвслээс 1, МҮАН-МШАН-ын "Ардчилсан холбоо эвсэл"-ээс 1, "Эх орон-МАШСН"-аас 1, бие дааж нэг хүн тус тус суудал авсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох удаа дараагийн сонгуульд иргэд ардчилсан үндсэн дээр оролцож ирэв.

Иргэдийн сонгуульд оролцсон байдал:

Сонгууль	Он	Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын тоо	Хувь
Монгол Улсын Их Хурлын сонгууль	1992	1085129	1037392	95.60
	1996	1147260	1057189	92.15
	2000	1247033	1027985	82.43
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	1993	1106403	1025970	92.73
	1997	1155228	982640	85.06
	2001	1205885	1000110	82.94
Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль	1996	1028216	739946	71.96
	2000	1066147	647616	60.74

Энэ хүснэгтээс харахад сонгуулиас сонгуульд сонгогчдын оролцоо буурч байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь ойрхон сонгууль олон болсноос зарим нь залхаж идэвхи нь суларсан. Сонгуулийн компанийг зохион байгуулах ажлын арга барил дахь дутагдал зэрэг олон шалтгаантай холбоотой байж болох юм.

Сонгуультай холбоотой хүний эрх зөрчигдсөн тохиолдол цөөнгүй гарч байна.

1998 оноос хойш улсын хэмжээнд иргэний паспортын нөөц дуусан, иргэний паспортыг иргэний үнэмлэхээр солих ажил удааширч, зохих бичиг баримтгүйн улмаас 2000 оны УИХ-ын сонгууль, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд олон хүн оролцож чадаагүй байна.

Тухайлбал, сонгогчдын бичиг баримтгүйн улмаас 2000 оны УИХ-ын сонгуульд 2.1 хувь, 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 1.5 хувь нь оролцож чадаагүй байна гэсэн мэдээг аймгийн сонгуулийн хороо мэдээлж байжээ. /Ховд аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

2.1.2. УИХ 1994 онд "Төрийн албаны тухай хууль" гаргаж Монголын төр мэргэшсэн, чадварлаг албатай байх, төрийн алба хашиж байгаа хүмүүсийн эрхийг хамгаалах зарчим, баталгаа, хууль зүйн үндсийг шинээр тавьсан.

Хүний эрхийн талаас нь үзвэл энэ хуулиар иргэд төрийн албанд орох адил тэгш боломжтой байх эрхийг баталгаажуулж тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан хэнийг ч төрийн захиргааны албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болохыг зааж өгсөн нь чухал алхам болжээ.

2000 оны байдлаар нийт 135391 төрийн албан хаагч байна. Тэдний 1.9 хувь буюу 2615 нь төрийн улс төрийн албан тушаалд, 5.8 хувь буюу 7809 нь төрийн захиргааны албан тушаалд, 15.3 хувь буюу 20662 нь төрийн тусгай албан тушаалд, 77.0 хувь буюу 104305 нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байна. Орон нутгийн төсөөс цалинждаг 85625 төрийн албан хаагч байна.

/Монгол Улсын төрийн албаны тухай гарын авлага, статистикийн тойм, 2000 он/

Төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг төрийн албаны тэс байгуулага буюу гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бие даасан үйл ажиллагаа явуулж, ажлаа УИХ-д тайлагнадаг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг. Түс Зөвлөлийн чиг үүргийн нэг нь төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдөн тухай маргааныг хянан шийдвэрлэх явдал юм. Уг зөвлөлөөс энэ талаар гаргасан судалгаанаас үзэхэд 1995 оны 7 дугаар сарын 24-нөөс 2001 оны 6 дугаар сарыг хүртэл хугацаанд төрийн жинхэнэ албан хаагч байсан буюу зохих шалгалт өгч тэнцсэн иргэдээс үндэслэлгүйгээр халсан буюу ажилд авахгүй байгаа тухай Төрийн захиргааны албаны зөвлөлд 165 өргөдөл, гомдол ирүүлжээ. Тэдгээрийг хянан үзээд өргөдөл гомдол ирүүлэгчдийн 56.3 хувь буюу 93 хүнийг ажилд нь буцаан томилуулах буюу ажлаар хангуулж, 6.7 хувь буюу 16 хүнийг ажлаас үндэслэлгүй халагдсаныг шүүх тогтоон ажилд нь буцаан оруулсан байна.

2.2. Нам, олон нийтийн байгууллагын байгуулах, сайн дурарааа эвлэлдэн нэгдэх эрх

2.2.1. Улс төрийн нам. Улс төрийн намуудын тухай хуулиар (1990) иргэд улс төрийн нам байгуулах, бүртгэх, үйл ажиллагаагаа нь зогсоох, дуусгавар болгохтой холбогдсон зарчим, журмыг тогтоожээ.

Монгол Улсад улс төрийн намууд шинээр үүсэн олон намын тогтолцоо оршин тогтнох бүрэлдсэн нь улс төрийн ардчилсан шинэтгэлийн нэг үндэсэн үр дүн, иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх зэрэгжиж байгаагийн бодит илрэл юм. Монгол Улсад одоо 18 нам үйл ажиллагаа явуулж байна:

Эвлэлдэн нэгдэх эрхийн нэг чухал баталгаа бол Үндэсэн хуулийн "Аль нэг нам, бусад олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүнийх нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэсэн Үндэсэн хуулийн заалт билээ.

Гэтэл хүмүүсийг намын харьяалаар ялгаварлан гадуурхах, ажил албан тушаалаас нь халж өөрчлөх, эсвэл ажилд авахгүй байх явдал сүүлийн жилүүдэд олонтаа гарах болсон байна. УИХ болон орон нутгийн ИТХ-ын сонгууль явагдсан онуудад /1996, 2000 он/ төрийн албан хаагчдын халагдах, чөлөөлөгдөх хөдөлгөөн эрс өсч буй нь яах аргагүй анхаарал татах асуудал юм.

Энэ нь хэдийгээр ажлаас өөрчилсөн тушаалаас харагдахгүй боловч хүмүүсийн гомдол судалгаагаар нотлогдож байна.

УИХ-ын сүүлийн хоёр сонгуулийн /1996 он ба 2000 он/ дараа төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийн тоог сонгуулийн өмнөх онуудтай /1995 он ба 1999 он/ харьцуулахад 2-оос 5 дахин их байна. /Төрийн албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн төлөв байдлын судалгааны тайлан, 2001 он/

Ховд аймагт 1992 оноос хойш аль нэг намын харьяаллаар нь ялган гадуурхаж ажлаас өөрчилсөн хүний тоо 850 байна.

2.2.2. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага. Монголд одоо мэргэжил, үйлдвэрлэлийн чиглэлээр 105.3 мянган гишүүнтэй үйлдвэрчний эвлэлүүдийн 12 холбоо, харин нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулагдсан ҮЭ-ийн 22 холбоо, анхан шатны 2300 байгууллагад 220.0 мянга гаруй гишүүн хамрагдагийн 48.6 хувь нь төсөвт байгууллагад, 26.5 хувь нь хувийн хэвшилд, 25.0 хувь нь улсын үйлдвэрийн газарт тус тус ажиллаж байна. Эдгээр ҮЭ-ийн эрхийн статусыг 1991 онд батална Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулиар бэхжүүлсэн нь иргэдийн ҮЭ-д нэгдэх эрхийг хангах чухал баталгаа болсон юм.

2.2.3. Төрийн бус байгууллага /Олон нийтийн байгууллага/

"Төрийн бус байгууллагын тухай хууль" /1997 он/ бусад 0 гарүй хуулийн зохих заалтаар иргэд ТББ байгуулах замаар эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж байна. Энэгийн байдлаар улсын хэмжээнд 2200 гаруй төрийн бус байгууллага улсын бүртгэлд бүртгэгджээ.

Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийг хэлэлцэн хэрэгжүүлэн судалж үзэхэд дараахь зөрчилтэй байдал ажиглагдаж байна. Үүнд:

1 Төрийн бус байгууллагын (ТББ) тухай хуулийн 1 дүгаар зүйлд ТББ-ыг бүртгүүлэх тухай өргөдөлд:

а/ байгуллагын нэр, хаяг;

б/ удирдах зөвлөлийн гишүүд, дарга, гүйцэтгэх захирын нэр, хаяг;

в/ удирдах зөвлөлийн даргын гарын үсэг бүхийгтөрийн бус байгууллагын дүрэм;

г/ улсынгэмдэгтийн хураамж төлсөн тухай баримтыг хавсаргахыг заажээ.

Гэтэгхүүль зүй, Дотоод хэргийн сайдын 2000 оны 50 дугаар тушаалаар батална "Дотоодын төрийн бус бйгуллагыг бүртгэж гэрчилгээ олгох журам"-д бүртгэлийн хураамж төлсөн баримтыг оролцуулахгийгэн нэмж 3 бичиг баримт, 72 дугаар тушаалаар батлсан "Гадаадын болон олон улсын төрийн бус байгуллагын төлөөлөгчийн газрыг нээж ажиллуулах эвлэрэл олгох журам"-д нэмж 5 бичиг баримт хавсаргахаар заажээ, хүүльд заагдаагүй нэмэлт материал шаардах болжээ.

2. ТББ-ын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль /1997/-д ТББ-ын тухай хуульд хэлбэгдсэн бүдэг хуулийн заалтыг нийцүүлэх талаар заасангүй. Үүнээс гадна эрхийн тухай болон ТББ-ын тухай хуулийн заагин заалт хоорондоо зөрчилдөжээ. Тухайлбал, ТББ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь заасгүй хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захирганы төв байгууллага ТББ-ыг бүртгэх, бүртгэхээс татгалзах тухайгаа өргөдөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан байхд Эрийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт ҮЭ-ийг 14 хоногийн дотор үлсын бүртгэл бүртгэхээр заасан нь зөрчилтэй байна.

3. ТББ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т "Татан буулах төрийн бус байгууллагын зохих төлбөрийг хийнй дараа үлдсэн зөрөнгийг ижил төстэй зорилт бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлэ тийм төрийн бус байгууллага байхгүй бологоилгод нь нийцсэн үйл ажиллагааны зарцуулна" заасан нь Иргэний хууль болон бусад хуультай зөрчилдөж ємчлөгчийн ашиг сонирхолд харшлсан байна.

Үүсгэн байгулагчаасаа санхүүждэг ТББ / Өмчөөлгчийн товчоо, орон сууц өмчлөгчдийн холбоо гэх мэ-ын хувьд "Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь төлийсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалах хуулийн этгээдэд ... өмчлөгчөөс санхүүждэбйгуллага хамаарна" гэсэн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх заалт үйлчлэх ёстой. Түүнчлэн ТББ нь өөрийн хөрөнгөд түшиглэн тодорхой үйлчилгээ явуулдаг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх салбар /хэлтэй буудал, нийтийн хоолны газар, сургалтын төв, амралт, сувилал гэх мэт/-тай байхыг зөвшөөрч, түүний эрх зүйн статусыг тодорхойлон хуульчлах шаардлагатай байна.

4. Хүүхдийн эрхийн тухай хууль /1996 он/-ийн 8 дугаар зүйлийн 2, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зөвхөн хүүхдийн төрийн бус байгуллага байгуулах, түүнд эвлэлдэн нэгдэх эрхтэй гэж хязгаарласан нь үндэслэл муутай, холбогдох бусад хуулийн заалттай ч (ТББ-ын хууль 5-ын 1 зэрэг) зөрчилдсөн байна.

Улс орны эдийн засаг, нийгмийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 18 насанд хүрээгүй зарим хүн төрөл бүрийн хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн хуулийн 109 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхэлж болох насны доод хязгаарыг заасан байдаг. Иргэний хуулийн 12 дугаар зүйлийг эндэслэн хүүхдийг иргэний эрх эрхийн бүрэн чадамжтайг зарласан тохиолдолд тэд хүүхдийн болон бусад төрийн бус байгуулага байгуулах, түүнд эвлэлдэн нэгдэх эрхтэй байх ёстой. Нөгөө талаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн дээрх 2 заалт нь Хүүхдийн эрхийн тухай Конвенц /1989 он/, Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх болон байгуулага байгуулах эрхийг хамгаалах тухай Конвенц /1948 он/-ийн холбогдох заалттай зөрчилдөж байна. Иймд Хүүхдийн эрхийн тухай хуулийн дээрх заалтыг Монгол Улсын Үндэсн хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн заалттай нийцүүлэх шаардлагатай.

2.3. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх

Манай улсын өмнөх Үндсэн хуулиудад "эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн адил тэгш эрхтэй" гэж заажж ирсэн бол 1992 оны Үндсэн хуульд "эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй" хэмээн цоо шинэ утга агуулгаар баяжуулан хуульчилсан билээ.

Мөн түүнчлэн эмэгтэйчүүдийн асуудлаарэн олон улсын таван конвенцид нэгдэж орсон. Түүнээс гадна үндэсний бусад хууль тогтоомжуудад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн асуудлыг тусгаж өгсөн.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн практик хэрэгжилтийн асуудлыг авч үзье.

2.3.1. Манай улсын эдийн засгийн идэвхитэй хүн ам 2001 оны байдлаар 847.6 мянга байсан бөгөөд үүнээс 809.0 мянга нь ажил эрхэлж, 38.6 мянга нь ажил хөдөлмөр эрхлээгүй байна гэж УСГ-ын 2000 оны эмхтгэлд дурьдсэн. Эдийн засгийн идэвхитэй хүн амын 412.8 мянгыг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд үүнээс 392.1 мянга нь ажил хөдөлмөр эрхэлж байна.

Ажил эрхэлж буй салбарыг хүйсээр харьцуулан харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол боловсрол, эрүүл мэнд, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн ажлыг илүү эрхэлж байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад

боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 40.3 мянгаар, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн салбарт 5.6 мянгаар их байгаад зогсохгүй боловсруулах үйлдвэр, худалдааны салбарт эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү байна.

Мөн түүнчлэн хот хөдөөгийн аль алинд ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр буюу хот, хөдөөгийн дүнгээр10%-ийн ялгаатай байна. 55 хүртэлх насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт бараг адил байгаа боловч 55 түүнээс дээш насны ажил эрхлэгчдийн тоо ерөнхийдөө буурсан ч эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс бараг хоёр дахин илүү /3.8%:1.8%/ байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү эрт тэтгэвэрт гардагтай холбоотой.

Харин төрийн үйлчилгээний албанд тухайлбал, боловсрол, эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд нийт ажилласгдын 70-80 хувийг эзэлж байна Хувийн хэвшлийн хувьд үйлчилгээний бэлэгтүүр, зах зээл дээр худалдаа эрхлэгч нарын 64% нь эмэгтэйчүүд байна. Тухайлбал, зочид буудал, зоогийн газар ажилласгдын 71 % нь эмэгтэйчүүд байхад бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдийн 51% нь эмэгтэйчүүд байгаа юм. Түүнчлэн ажил эрхлэлтийн байдлын /хувираа эсвэл бусдад ажиллаж байгаа эсэх/ хувьд ажил эрхэлж буй 358.7 мянган эмэгтэйчүүдийн 156.3 мянга буюу 43% нь гэрээгээр ажиллаж байна.

Ажил эрхэлж буй нийт эмэгтэйчүүдийн 48% нь хотод байхад 51% орчим нь хөдөөд ажил эрхэлж байна. Харин энэ салбарт ажилладаг эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс 38 мянгаар илүү байна.

2.3.2. Монгол Улсын хувьд суүлийн жилүүдэд суралцаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцаа улам бүр алдагдсаар байна. Үүний тод жишээ бол сууль боловсрол эзэмшиж явцад сургууль завсардаж байгаа хүүхдүүдийн дийлэнх хувийг хөвгүүд эзэлж байгаа бөгөөд анги дэвших түсам охидын сургуульд хамрагдах түвшин ихэсч байна. 1999 оны байдлаар бага сургуульд суралцагчдын 50.2%, бүрэн бус дунд боловсрол олгох ангид суралцагчдын 53.8%, бүрэн дунд боловсрол олгох ангид суралцагчдын 60.2%-ийг охидууд эзэлж байгаа юм. 2000 оны эхний хагас жилийн байдлаар сургууль завсардсан 8-15 насны 68.2 мянган хүүхэд байгаагаас 61.7% буюу 42.1 мянга нь хөвгүүд байна.

Дээд боловсролын салбарт суралцагчдын хувьд хүйсийн харьцаа алдагдаж нийт суралцагчдын 53690 буюу 63.2%-ийг охидууд эзэлж байгаа юм. Ийнхүү эмэгтэйчүүдийн боловсрол эзэмшиж явдал өндөр байгаа нь сайшаалтай хэдий ч эрэгтэйчүүдийн боловсролд мөн давхар анхаарах асуудал тулгарч байна.

2.3.3. Улс төр, нийгэм, эдийн засгийн шийдэгр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин, байр суурь тодийлөн нэмэгдэхгүй, хангалттүй хэмжээнд байсаар байна.

Байнгын ажиллагаатай Парламентын гишүүдийн 10.5%, Засгийн газрт нот эмэгтэй дэд сайд байгаа нь хууль тогтоох, гүйцэтгэх засагглалын түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалттүй байгаагийн тод жишээ юм. Харин цүхийн шүүгчдийн 90 шахам хувь эмэгтэйчүүд байгаа нь шүүх засагглалын хувьд эмэгтэйчүүдийг эзлэх байр суурь сайн байгаат харуулж байгаа тоон үзүүлэлт юм.

Монголын ажил олгогч эдийн нэгдсэн холбооны мэдээгээр тус байгууллагад бүртгэлтэй 4900 гаруй аж ахуйн нэгжийн 2000 нь ууй буюу 40.8%-ийг эмэгтэйчүүд тэргүүлж байгаагээн дүн гарчээ. Энэ нь хувийн секторын удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо улам бүрдэшилж байгааг харуулж байна.

2.3.4. Монгол Улс 2000 оны байдлаар 554 мянган өрхтэй бөгөөд үүнээс 5641 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. 2000 оны байдлаар 1000 хүн тутамд 9 гэрлэлт, 0.6 цуцлалт ноогдож байна. Гэр бүл цуцлалт 1990 онтой харицуулахад 0.5 пунктээр буурсан дүн харагдаж байгаа хэдий ч гэрлэлт 7.9 пунктээр буурсантайгаа харьцуулах юм бол тедий л бүрааргүй болох нь харагдаж байна. Гэр бүлийн хүрээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш байдал уламжлалт зан заншлаас шалтгаалж ялгавартай байсаар байгаа юм. ЗЮ онд ҮСГ-аас хийсэн Цаг ашиглалтын судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс /Хөтөд2 цаг, хөдөөд 6 цаг 30 мин/ илүү олон цагийг гэрийн хөдөлмөрт зарцуулсаар байгаа дүн гарчаа. Ийнхүү эмэгтэйчүүдийн гэрийн хөдөлмөртэзцуулах цаг их байгаа нь тэдний өөрсдийгөө болоцсуулах, хөгжих боломжийг хязгаарлаж байна. Тиймээс гэрийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоог тэгш болгох, гэрийн хөдөлмөрийн үнэлгээг бий болгох нь хэт асуудлууд тулгарч ирж байна.

Гэр бүлийн хүрээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд тохиолдож байгаа хүрц асуудал бол гэр бүлийн хүчирхийлийн асуудал болоод байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэдээллээс харахад гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртөгчдийн 90 гаруй хувийг эмэгтэйчүүд, хүүхдүүд эзэлдэг эгээ. Мөн тус төвөөс 1995, 1998, 1999 онуудад 300-5000 хүнийг хамарсан судалгаа хийхэд судалгаанд хамрагдсан гурван хүн тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд ямар нэг байдлаар өртдэг хэмээн хариулжээ. Энэхүү байдал нь ч гэр бүл дүүлэлтад шууд нөлөөлж байгаа юм. Гэр бүлийн хүрээнд хүчирхийлсэн гэмт хэрэг, тэр дундаэмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлсэн хэргүүд суүлийн жилүүдэд ееэх хандлагатай болоод байгаа нь энэ асуудалд төреес авч хэрэгжүүлэх арга хэмжээг хүчтэй болгох шаардлагатайг харуулж байна.

2.4. Төрийн байгууллага алба тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэргүүлэх эрх

Иргэдээс эрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өрөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх журмыг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргаж өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" (1995 он) хуулийн тогтоон хэрэгжүүлж байна.

Иргэдээс ирс, нийгмийн болон хувийн аливаа асуудлаар эрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хандаж байгаас "өргөдөл", төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна гэж үзэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шаардахыг гомдол гэж үзнэ.

Иргэд өргөдөл, гомдлоо бичгээр буюу эсхүл амаар аль хэлбэрээр гаргах эрхтэй.

Дээрх хуулийг дагуу Монгол Улсын Засгийн газар 1995 онд "Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдон зарим арга хэмжээний тухай" 222 дугаар эгоол гаргасан байна.

Уг тогтоолоор иргэдээс яам, тусгай газар, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, тэдгээрийн харъяабайгуллагад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн ав, шийдвэрлэх журмыг тус тусын чиглэлээр боловсруулан батлаж мөрдүүлэх, өргөдөл гомдлын оймо, шийдвэрлэлтийн байдал, мөрөөр нь зохио ажил, тэдгээр асуудлуудаас өөрийн байгуулагын явуулах бодлого, авах арга хэмжээнд хэрэгжүүсгаж хэрэгжүүлсэн тухай мэдээллийг хаас бүтэн жилээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар ирүүлж нэгтгэн дүгнэж байхаар журамлажээ.

Иргэдээс төрийн захиргааны байгууллагууда 2000 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэлэлтийн байдлыг авч үзвэл, 11 яаманд нийт дүнгээр 8612 өргөдөл, гомдол ирүүлснээс 7736өргөдөл, гомдлыг хуулийн /30 хоногт буюу шаардагатай үед 30 хоногоор сунгах/ хугацаанд нь шийдэлэж хариу өгсөн, 233 өргөдөл, гомдлын хугацаехэтэрч хариу өгсөн дүн гарчээ. Хугацаа хэтрүүлэ хариу өгсөн өргөдөл, гомдлын 94.8 хувь буюу 221 өргөдөл , гомдол Батлан хамгаалах яамад 5.1 хувь буюу 12 өргөдөл , гомдол Байгаль эрчны яаманд оногдож байгаа дүнтэй байна.

2000 оид йаг, нийслэлийн дүнгээр 79069 өргөдөл, гомдл хүлээн авсны 24 хувь нь Нийслэлийн Засг даргын Тамгын газарт иржээ. Олонхи газар өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж хэрү өгсөн мэдээтэй байна. Харин Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засагдрын Тамгын газарт хариу хүссэн өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэх явдал гарчээ.

1996-2000 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-д 6400 шахэ өргөн /жилд дунджаар 1600 хүн/ өргөдөл, гомдл ирүүлсэн байх бөгөөд тэд захидалдаа цахэрдсан тоогоор 7500 шахам асуудлыг хөндөж.

Эдгээ өгөдөл, хүсэлтийг дотор нь ангилж үзэхэд:

- Ахуй амьдралын хүндрэл бэрхшээлээ шийдвэрлүүлэх үүдэнээс эээл,

мөнгөн болон эд материалын тусламж үзүүлэхийг хүссэн өргөдөл нийт хүсэлтийн 38.6 хувийг,

- Амьдралын анхдагч хэрэгцээ болсон байр, орон сууцны асуудлаа шийдүүлэх чиглэлийн хүсэлт 9.5 хувийг,

- Үйлдвэргэл, үйлчилгээ /жижиг, дунд үйлдвэр/ эрхлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэхийг хүссэн өргөдөл 16.2 хувийг,

- Үр хүүхдээ сургууль курст суралцуулах, тэдний сургалтын төлбөр, зардлыг шийдвэрлүүлэх тухай өргөдөл 15.2 хувийг,

- Ажлын байраар хангаж ажилд оруулахад туслахыг хүссэн өргөдөл 8.0 хувийг,

- Эрүүл мэндийн хувьд хохирсон, эмчилгээ сувилгаа хийлгэхэд туслалцаа үзүүлэхийг хүссэн өргөдөл 2.54 хувийг тус тус эзэлж байна.

Гэвч иргэдийн энэхүү эрхийн улс төрийн ач холбогдлыг үнэлж, шинэ арга барилаар хандах явдал мэдэгдэхүйц дээшлэхгүй байна.

УИХ-д ирүүлсэн гомдлын дийлэнх нь "иргэний зөрчигдсөн эрхийг төрийн байгууллага зохих ёсоор хамгаалж чадахгүй" байгаа тухай өгүүлжээ.

Иргэдээс ирүүлсэн гомдлын дотор шүүх, цагдаа, мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаанд хүнд суртал, чирэгдэл, шударга бус байдал их байгаа, иргэдийн эрх, ашиг сонирхлыг хохироодог талаар ихэвчлэн бичсэн байна.

Төрийн байгууллага, албан тушаалтнаас иргэдийн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн тухай албан ёсны мэдээ тайлан нь теслийн шугамаар хийсэн судалгааны дүнгээс зөрүүтэй байгаа нь иргэдийн өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийг зөрчих явдал нүүгдмал байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн мэдээгээр Говьсүмбэр, Дорнод, Орхон аймагт өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа хэтрүүлээгүй гэсэн байхад Тусгай багийн судалгаагаар 2-6 сар, түүнээс дээш хоногоор ч хэтрүүлсэн нь илэрсэн байна.

УИХ-ын "Иргэдийг хүлээн авах байр"-нд ирэгсдийн 40 орчим хувь нь "шүүхийн үйл ажиллагаа өнөөдөр шударга үнэний баталгаа болж чадахгүй байгаа тухай" гомдол гаргадаг байна. Ер нь засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс иргэдийг шүүхийн жүрмаар хамгаалах механизм одгөө бүрдээгүй байгаа нь иргэдийн энэхүү эрхийг хангах явдалд тохиолдож буй гол бэрхшээлийн нэг гэж үзэж болно.

Энэ эрхийн хэрэгжилтэд зайлшгүй анхаарах ёстой асуудал бол иргэний өргөдлөө шийдвэрүүлэх эрхийн нөгөө талд нь албан тушаалтны заавал шийдвэрлэх үүрэг байгаа явдал юм. Гэтэл албан тушаалтнууд өөрийнх нь бүрэн

эрхэд хамаарч буй асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, бусад байгууллагад шилжүүлэх зэргээр иргэний эрхийг хохироож чирэгдүүлэх нь их түгээмэл байна.

2.5. Иттэл үнэмшилтэй байх, мэдээлэл хайх, хүлээн авах, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх, эрх чөлөө

Үндэсэн хуульд заасан дээрх эрх, эрх чөлөө нь хоорондоо салшгүй нягт холбоо, хамааралтай, нэг нь нөгөөгүйгээр оршин хэрэгжих боломжгүй учраас эдгээрийг энэ хэсэгт авч үзэв.

Хүн үзэл бодлоо хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан дээр үг хэлэх, мэдээлэл хайх, хүлээн авах замаар илэрхийлдэг. Үг хэлэх, хэвлэн нийтлэхгүйгээр үзэл бодлоо өргөн олонд чөлөөтэй илэрхийлэх аргагүй, хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхгүй, мэдээлэл гаргаж дамжуулахгүйгээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө амьдрах боломжгүй юм.

2.5.1. Хүний иттэл үнэмшилтэй байх эрх нь хүний заяамал, салшгүй эрх боловч төрийн зохих албан тушаал хашиж буйтайгаар холбогдож өөрийн иттэл үнэмшлээ илэрхийлэхэд хуульд заасан зарим хязгаарлалтыг хүлээн эвшээрдэг. Тухайлбал, Намын гишүүнээс түдгэлзэвэл зохих албан тушаалын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Цэцийн тухай хууль, Прокурорын тухай хууль зэрэгт тодорхой зарим албан тушаалд томилогдсон, сонгогдсон хүн намын гишүүнээсээ түдгэлзэх, үзэл бодлоо илэрхийлэхэд эрхэлж буй албандаа хүндэтгэлтэй хандах гэсэн хязгаарлалтууд бий.

Харин хүний тодорхой иттэл үнэмшилтэй байснаар нь ялгаварлан гадуурхах, ажил хөдөлмөрөөс нь халж солих хууль, хүний эрхийг ноцтой зөрчсөн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд тогтмол гарсаар байна. Улсын Их Хурал болон орон нутгийн сонгуулийн дараа төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг олон тоогоор ажлаас халах "уламжлал" тогтоод бараг арваад жилийн нүүрийг үзсэн.

2.5.2. 2000 оны байдлаар 220 нэрийн сонин, сэтгүүл тогтмол хугацаанд нэг удаа 1.2 сая хувиар хэвлэгдэж, бие даасан сувагт 4 телевиз, кабельт сүлжээний 16, теле студи 50, өргөн долгионы АМ радио 8, богино долгионы FM радио 14, радиогийн 6 студи, 11 мэдээллийн агентлаг, 6 интернетийн мэдээллийн online сүлжээ үйл ажиллагаа явуулж байна.

1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гарсан нь дээрх багц эрхүүдийг баталгаажуулахад гарсан том ахиц болсон юм.

Энэ хуулиар төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад цагдан хяналт тогтоохыг, тийм хяналт явих байгууллага байгуулахыг, мөн тийм хяналтын үйл ажиллагаагаар санхүүжүүлэхийг, төрийн байгууллага өөрийн мэдээлэл хэвлэл мэдээллийн эзэмшлэгт байхыг тус тус хориглосон.

Түүнчлэн салбарын үйлдвэрлэл арван хуульд хэвлэл мэдээллийн хэрэгслийг тухай, энэ талын эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг нэмэлт, өөрчлөлт оруулсан нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хийгээд хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр өмчлөхийг хориглосон нь энэ эрхүүдийн бүтэлгүйтэн хэрэгжих давуу тал нь мөн боловч тэдгээрийн цаашдын хэрэгжилтэд саад, тоттог бөөс, хууль зөрчсөн зүйлүүд нь байсаар байна.

Хэвлэл мэдээллийн эх чөлөөний тухай хуулийн хэрэгжилт тарууу, хуулиудад үндэслэлгүй хязгаарлалт, хориглолт бас нэмэгдэл байгаагаас гадна үндэсний радио, телевиз дээр нь 52 сонин, сэтгүүл засаг төрийн байгууллагын өмчид буюу эрх мэдэлд байна.

Эдгээр бүлэг эрхийг зохицуулж буй хуулиудыг судалж үзэхэд дараах байдал ажиглагдаж байна.

а/ Хуульд урьдын эдлэл "үүрэгдэх", захиргаадах шинжтэй заалтууд тусгагдсаар байна. Хувийн болсон чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллагуудад өөрийн хараанаас шиг үүрэг нөгөдүүдэд тедийгүй, түүнийгээ биелүүлэхгүй бол хууль зүйн хариуцлага хүлээлгэх тухай заадаг зуршил хууль тогтоох хүрээнд аймаар байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2001 онд "Хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгууль болгохын явуулах явцын хэлэлцүүлэг, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй" гэсэн өөрчлөлт оруулсан нь дүр зургийг шинжтэй гажуудал мөн. /Б.Чимид Үзэгдэлтэй чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, УБ, 2000 он, 14 дэх талд/

б/ Хориглосон зарим заалтууд хүний эрхийн зарчмын талаасаа зөрчилтэй төрүүлж байна. Жишээлбэл: "...санал авах хүртэл 7 хоногийн хугацаанд олон нийтийн санаалгуулга явуулахыг хориглоно. Нам, эвслийн ажиланд байгаа хэвлэлээс бусад аль нэг нам, эвслийн нэр дэвшигчийн талаар дагнасн сурталчилгаа явуулахыг хориглоно. /УИХ-ын сонгуулийн хууль, 1992 он, 5, 21 дүгээр зүйл/

Монголын Үндэсний радио, телевизээр Сонгуулийн ерөнхий хорооны өгөлсөн хуваарьт заасанаас өөр төлбөртэй ба төлбөргүй нэвтрүүлэг явуулж болохгүй. /Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 1993 он, 28 -р зүйл/

в/ Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 267 тоот тогтоолоор батлагдсан "Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг буртгэх журам"-ын дагуу хэвлэл, мэдээллийн хэрэгслийг Улсын бүртгэгдэд буртгэх, үйл ажиллагаа эрхлэх эвшээрөл олгох, хяналт тавих эрх зүйн зохицуулалт журамлагдсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэж авах, хяналт тавих процессын ажиллагаа нь засгийн газрын дээрх тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Хууль зүйн сайдын 199 оны А/352 тоот тушаалаар батлагдсан "Хэвлэл мэдээллийн хэрэгслийг буртгэх, хяналт тавиагдавар"-ын дагуу зохицуулж байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн

сайдын 2000 оны 50 тоот тушаалаар улсын буртэлийн гэрчилгээний загварыг батална гэснээ уг тушаалаар улсын буртэлд буртэж, гэрчилгээ олгох асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Удирдлагын зөвлөгөөнөөр хэлэлцүж шийдвэрлэн, сайдын гарын үсгээр батилгаажсан гэрчилгээ олгодог байна. Эдгээр журам, заавраар тогтоосон эрх хэмжээний хүрээнд дун шинжилгээ хийж үзэхэд:

1. Тус журам, заавраар алгээ хэвлэл мэдээллийн хэрэглийг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах, гатан буулгах эсэхийг бие даан шийдвэрлэх эрхийг зөвхөн төрийн бүх шатны байгуууллага, нам эвсэл, олон нийтийн байгуууллага, аж ахуйн нэгжид олгосон байна. Энэ нь Үндэсэн хуулиар тунхагласан "Хүн бүр эрх зүйн эгтээд байна болон нийгэм өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ...байгуууллага байгуулах, сайн дураар эвлэрэлцэн нэгдэх эрхтэй" гэснийг илт зөрчиж байна.

2. Тус журмын 1-д өгүүлсэн хоригийн биелэлтэд хяналт тавих зорилгоор тогтмол хэвлэлийн нэг хувийг хэвлэгдсэн даруй Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар хоригдсон төрөөс мэдээллийн агуулгад цензур тогтоохуйц үзэнийг зөрчиж байна. Мөн тус журамд Улсын нэгдсэн буртгэлд буртгүүлж гэрчилгээ авсауй, түүнчлэн холбогдох хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн хэвлэл, мэдээллийн хэрэглийн үйл ажиллагааг Хууль зүйн яам дүрэмдээ заасны дагуу зогсоох хүртэл арга хэмжээ авна гэж заасан Хууль зүйн сайдын тушаалаар батилсан заавартаа хэвлэл мэдээллийн хэрэглийн зорилго чиглэл нийтлэлийн чиглэлийг үүсгэн байгуулагчаар батлуулж, түүнд нь тус яам хяналт тавина гэсэн нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгуууллага байгуулахуйг бегөөд иймхяналтын үйл ажиллагаа санхүүжүүлэхүйг гэснийг зөрчиж байгаа ба холбогдох хууль тогтоомж" гэж чухам ямар хууль тогтоомжийг заасан нь бүрхэг байна. Энэ тодорхой бус байдлаас шалтгаалан энэ үгийг хэн нэгэн өөрт ашиггайгаар тайлбарлан, эрхийг хязгаарлаж болзошгүй байна.

2.5.3. Үгсэн Их Хурал 1994 онд Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль батлан гаргасан. Энэ хууль хэдийгээр иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зорилгоор тайван жагсаал, цуглаан хийх эрхийг батилгаажуулсан гол чухал бариимт мөн боловч эргэн хинах, боловсронгуй болгож, сайжруулах шаардлага байна. Монгол улсын Үндсэн хуулийн Цэц 1996 оны 3 дугаар сарын 21-ний өдөр иргэн Д.Ламхавын "Жагсаал, цуглаан хийх журмын тухай" Монгол улсын хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд зөрчсөн эсэхийг тогтоохыг хүссэн өргөдлийг хүлээн авч хэлэлцсэн байна. Д.Ламжав Цэцэд хандаж гаргасан өргөдөл, түүнтэй холбогдуулан өгсөн тайлбартаа "Жагсаал, цуглаан хийх журмын тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д "Цуглааныг зохион байгуулагч багасны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ", мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "Цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байгаа "оролцогч улсууд тайван замаар хуран цуглах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө" гэсэн заалтыг зөрчиж байна гэжээ.

Үндэсэн хуулийн Цэц өргөдлийг хянан хэлэлцээд: жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн холбогдох заалтууд нь Монгол Улсын Үндэсэн хуулийн 10 дугаар зүйл, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалт, Үндэсэн хуулийн хавсралт хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна" гэсэн дүгнэлт гаргажээ.

Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Их Хурал 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоороо хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн боловч Үндэсэн хуулийн цэц 1996 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа УИХ-ын дээрх шийдвэрийг авч хэлэлцээд тууүчийн дүгнэлтээ хөвээр үлдээж шийдвэрлэсэнээр гомдолд дурдсан хуулийн заалтын хэсэг хүчингүйд тооцогдож дурдсан хязгаарлалт үгүй болжээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19 дэх хэсэгт: "Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад ёгч зөвшөөрөл авна" гээд мөн зүйлийн 3 дахь хэсэгт: "Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 өдрийн дотор түүнийг зөвшөөрсөн эсэхээ бичгээр мэдэгдэнэ" гэж заажээ.

Энэ заалтад жагсаал, цуглааныг зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэх хугацаа / ажлын 6 өдөр/ хэт удаан байхаар тусгасан байна.

2.5.4. Манай Үндэсэн хуульд зөвхөн мэдээлэл хайх, хүлээн авах эрх тусгагдсан бөгөөд олж авсан мэдээллээ түгээх эрх тусгагдаагүй байна. Мэдээлэл хайх эрхийг хэрэгжүүлэхэд нууцын холбогдолтой зүй ёсны хаалт, хязгаарлалт байна. Төрийн нууцын тухай, байгуууллагын нууцын тухай, хувь хүний нууцын тухай хууль болон Эрүүгийн байцаан шийтэх хуульд тодорхой хязгаарлалтууд бий.

Харин төрийн нууцын жагсаалт хэтэрхий өргөн байгаа, байгуууллагын дарга, эрх баригчид өөрсдийн үзэмжээр байгуууллагынхаа нууцыг тогтоодог, төрийн байгуууллагын үйл ажиллагааны мэдээллийг өргөн олон нийтэд түгээх нэгдсэн суүмж, уламжлал тогтоогүй зэрэг нь иргэд, ялангуяа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хүссэн мэдээллээ олж авч чадахгүйд хүрэх, улмаар зарим мэдээллийн төлөө ял зэмлэл хүлээх нь байна.

ГУРАВ. ХҮНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа

хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
Өмчлөгчийн эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.
Балчээр, нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.
Монгол Улсын иргэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, зээмшиж, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.
Хувийн өмчийг хууль бусаар дайчлан авахыг хориглоно. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө.
Иргэд хувийн аж ахуй эрхлэх, зохиол бүтээл туурвих түүнийхээ үр шимийг хүртэх эрхтэй гэж хуульчлан тогтоож, хүний эдийн засгийн эрхийг баталгаажуулж өгчээ.

3.1. Эд хөрөнгө шударгаар олж авах, зээмших, өмчлөх эрх

1991 онд Улсын Бага Хурал Өмч хувьчлах тухай хууль гаргаж, хувийн ба нийтийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрч, аж ахуйн нэгжийн хийгээд арилжааны банкуудын тухай зэрэг зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдсон суурь хуулиуд гаргаж мөрдүүлсэн нь хүний эдийн засгийн эрхийг тал бүрээр хангах анхны алхам болжээ.
Монгол улсын иргэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр ижил гараанаы зарчмаар хамрагдаж, хувийн өмчийн анхны хуримтлал бий болов. Үг бичгийг 1,9 сая хүнд олгож, өмч хувьчлалын эхний шатыг 1990 зөд оны дундуур дуусгаж, дараа нь хоёр дахь шат болох үнэт цаасны зах зээлийг нээжээ. Өдгөө 1,2 сая үнэ хөрөнгийн биржээр дамжуулан 470 гаруй компанийн хувьцаа зээмшигч болжээ. Хувийн аж ахуй эрхэлж, өөртөө хөдөлмөрлөн үр дүнг нь өмчлөх болов.
Сүүлийн 10 жилд бүгд 960 гаруй улсын мэдлийн жижиг, том үйлдвэр болон аж ахуйн байгууллагын мал, мөн орон сууц орохгүйгээр хөдлөх, үл хөдлөх хөрөнгө нийтдээ 49820,0 сая төгрөгийн хөрөнгийг хувьчлан Монгол Улсын болон гадаадын иргэн, хувийн, хамтарсан болоод дагнасан аж ахуйн нэгжид зохих үнэзр нь өгсөн байна.
Статистикийн мэдээгээр иргэд банкинд 1992 онд нийтдээ 2783,3 сая төгрөг хадгалуулж байсан бол 1995 онд 36818,0 сая хүрч 13,2 дахин, 1999 онд 45052,3 сая төгрөг, 2000 онд 86367,9 сая төгрөгт хүрч 1995 оныхоос 2,3 дахин өссөн байна.
Орон сууц хувьчлах тухай хуулийн заалтыг үндэслэн орон сууц хувьчлах ажлыг 1997-оос 2000 оны хооронд зрчимтэй зохион байгуулж, төрийн өмчийн 84,0 мянган орон сууцнаас 81,0 мянган орон сууцыг буюу нийт орон сууцны 96,4 хувийг иргэдэд үндсэнд нь үнэгүй хувьчилсан байна. Өөрөөр хэлбэл, 300,0 төрбум төгрөгийн орон сууцыг иргэдэд үнэгүй хувьчилсан гэсэн үг юм. Эдгээр хувьчлагдсан сууцнаас Үл хөдлөх эд хөрөнгийн газрын мэдээгээр төрөөс хувьчлагдсан нийт сууцны 89,3 орчим хувь нь Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдэж баталгаажсан байна.
Харин төмөр замын байгууллагад ажиллагсад орон сууцаа хувьчлж авч чадаагүй байгаа нь иргэд тэгш эрхтэй байх зарчимтай зөрчилдөж байна. /Эдийн засгийн эрхийн судалгааны тусгай багийн тайлан 2001 он/
Дээрх тоо баримтаас иргэд үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөтэй болох үйл явц богино хугацаанд их хэмжээн зрчимжсэнгүй үзэхээр байна.
3.1.2. Монгол Улсын иргэн үл хөдлөх хувийн аж ахуй эрхлэх эрхээ баталгаатай эдлэх нь газар өмчлөх, зээмших зэдлээс их хэмжээн хамааралтай байна.
Үндэсэн хуулийн зүргадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвөөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно" гэж заасан юм. Энэ нь иргэд хамгийн найдвартай, үнэ цэнэтэй үл хөдлөх хөрөнгөтэй болж, аж ахуй эрлэх үндэс болоож олгож байгаа хэрэг мөн боловч одоо хүртэл газар хувьчлах асуудлыг шийдвээлэж чадаагүй маргаантай асуудлын нэг болсоор байна. Хэдий тийм ч иргэд ашигтай байрлал бүхий газрыг зээмших эрх олж аваад өөрийн өмч мэтээр түлэйн газраа өндэр үнэ хүргэж, бусдад худалдах явдал нилээд газар авчээ. Сонин, хэвлэл, радиогоор зөвөөрөлтэй газар худалдах тухай зарлах нь жирийн үзэгдэл болсон байна. Энэ нь газрыг өмчлүүлэх хууль гарахаас өмнө иргэд байгуулага зээмшилд буй газраа өөрийн өмч мэтээр зэрэгцэн зарцуулж эхэлснийг нотолж байгаа бөгөөд иргэдэд газар өмчлүүлэх тухай эрх зүйн зохицуулалтыг бий болгох явдал хойшлуулшгүй болсныг харуулж байна.
Иргэд, аж ахуйн нэгжийн газар зээмших асуудал Нийслэлийн хэмжээнд иаш хүндрэлтэй байна.
Газрын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд зааснаар Нийслэлийн Засаг дарга нь дүүргийн Засаг даргын саналыг харгалзан Нийслэлийн хөгжилд "чухал ажил үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгуулагад" газар ашиглуулах талаар шийдвэр гаргах, мөн дүүргийн Засаг дарга нь аж ахуйн нэгж байгуулагад газар зээмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргах эрхтэй. Хуулийн заалт хоёрдмол утгатай байгаагаас гадна төрийн өмчийн газрын зээмшлийг улс, нийслэл, дүүрэг, аймаг, сумаар заагласн зохион байгуулагуйгээс газар зээмшүүлэх шийдвэр гаргах талаар "өрсөлдөөн" гарч, шат дамжлага зүүдсүртлын саад тотгор их болжээ.
Нийслэлийн хэмжээнд тогтоосон журмаар бол Улаанбаатарт газар зээмшихийг түлд 8 шат дамжлага дамжиж, наад зах нь 5 сараас доошгүй хугацаа зарцуулагддаг байна. Инээх газар зээмших эрх олсны дараа барилга барьх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах хүртэл бас цөөнгүй дамжлагаар орж, хянуулж, зөвшөөрөл авдаг.

Газрыг эзэмшилд олгох ажлын үе шат (даралаал)

ГАЗАР ЭЗЭМШИХ ХҮСЭЛТ ГАРГАХ /Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ХБГХ-ны газарт/

↓

АРХИТЕКТОР, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГЧ НАР СУДАЛГАА ХИЙХ

/Хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан судална./

↓

САНАЛ БОЛОВСРУУЛАХ

/Газар олголтын схем зураг бэлтгэж, хэлтсийн 7 мэргэжилтний зөвшөөрөл авч, техникийн зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгэх./

↓

ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ /Энэ хурлын үеэр ДШГС, ЦШСГ, УСАГ, РСГ, ОСНААГ, БОЭХГ, ЭМХА, ГТТГ-уудын ерөнхий инженерийн санал авна/

↓

МЭРГЭЖЛИЙН КОМИССЫН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

/Хот байгуулалт, газар зохион байгуулалтын Комиссын 17 гишүүний санал авч протоколд тэмдэглэнэ./

↓

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ МАТЕРИАЛЫГ ХҮРГҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ ГАРГУУЛАХ /Байршил тогтоож газар олгох эрх олгоно./

↓

ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН МЭДЭГДЭЛ, ДҮҮРЭГ ХАРИУЦСАН АРХИТЕКТОРААС АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР АВАХ

↓

ДҮҮРЭГ ХАРИУЦСАН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ТӨЛБӨРИЙН БАЙЦААГЧ НАРТАЙ ГАЗАР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ ХИЙЖ, ТӨЛБӨРӨӨ ТУШААЖ, ГЭРЧИЛГЭЭ АВАХ

ОБЪЕКТ БАРИХ /Зураг төслийг эскизийн шатанд батлуулах, техникийн нөхцөл авах, ажлын зураг боловсруулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцөх, экспертизийн дүгнэлт гаргуулах, барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, улаан шугам тавих, барилга барих, ашиглалтад хүлээн авах комисст үзүүлэх, зөвшөөрөл авах/

↓

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨӨ БҮРТГҮҮЛЭХ

Газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох ажиллагааны олон шат дамжлага аймаг, орон нутагт ч мөн адил байна. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалт, газрын харилцааны газар нь 1998-2000 онд иргэд, аж ахуйн нэгжээс газар эзэмшлийн холбогдолтой 11670 өргөдөл хүлээн авч 660 өргөдөл буюу 7 хувийг нь шийдвэрлэж, бусдыг хэрэсэн нь тодорхой бүртэлгүй байсан бө тэдгээр өргөдөл , хүсэлтийг 60-354 хоногийн хугацаанд шийдвэрлэж хуулийн хугацааг ихээр хэтрүүлж байжээ. Цаг тухайд нь шийдвэрлэгддэггүйгээс барилга байгууламж зөвшөөрөлгүйгээр барих явдал хавтгайрч, 123 барилга байгуулаж баригдсан гэсэн тоо байна. /Эдийн засгийн эрхийн судалгааны багийн тайлан 2001 он/

Газар олгох тухай дүүргийн Засаг даргын шийдвэрийг Нийслэлийн Засаг дарга хүчингүй болгох, дараагийн Засаг дарга нь өмнөхийнхөө олон жилээр олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох эрэгэр иргэдийг нөхтой хохироож байна. Энэ мэтээс шалтгаалан иргэд газар эзэмшлийн гэрээ байгуулахаас зайлсхийх болжээ. Иймд Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийсгаж, иргэдийн эрхийг хамгаалах шаардлага нэмэгдэж байна.

3.1.3. Сүүлийн үед нийслэлчүүдийн дунд ялангуяа ТҮЦ эрхэлж буй дунд бө түүнээс доош амьжиргаатай өрхүүдийн дунд сэтгэл түгшээсэн нэг явдал гарч байгаа нь дүүргүүдийн Засаг дарга нарын шийдвэрээр ТҮЦ-ийг албадан буулгах ажил компаничлан явуулах болсон явдал юм.

Төрийн захиргааны байгуллага олон шат дамжлагыг дамжуулан ТҮЦ ажиллуулах зөвшөөрлийг олгосон атлаа сүүлийн үед Дүүргийн Засаг дарга шийдвэр гаргаж, жижиг бизнес эрхлэгчдийн ТҮЦ-ийг албадан буулгах компани дэгдээсэн нь нэг талаас хувийн өмчийн эрхийг илт зөрчиж нөгөө талаас төр зайлшгүй шаардлагаар иргэний өмчийг шилжүүлэхэд хүрсэн бөл холбогдох зардлыг нөхөн олгох Үндсэн хуулийн заалтыг үл хайхарсан ажиллагаа болжээ гэж үзэх үндэстэй.

Хууль тогтоомжоор хувийн өмчийн эд хөрөнгийг хураан авч, улсын орлогод оруулах, шийдвэр гаргах эрхийг цөөнгүй байгуллага, албан тушаалтанд олгосон нь нөхтой зөрчлүүдэд хүргэж байна.

Хувийн өмчийн эд хөрөнгийг хурааж, улсын орлогод оруулж буй байдлыг судлахад дараахь зөрчил дутагдал илэрч байна. Гааль, албан татвар зэрэг захиргааны хэлтэстэй холбогдох ажиллагаа зөрчил ихрүүлж торгууль төлбөр тавьсан орлогынхоо зохих хувийг өөртөө үлдээх журам тогтоосон нь хууль биелүүлэх хөшүүрэг болохоосоо хүний эрхэд халдахад түлхсэн хөшүүрэг болж байна.

Эрүүгийн хуулийн 172-1 дугаар зүйлд их хэмжээний эд зүйл, валют, валютын үнэт зүйл, эрдсийг хууль бусаар хил нэвтрүүлсэн бол уг эд зүйлийг хурааж эрүүгийн харилцлага хүлээлгэхээр заажээ. Энэ зүйл анхаар ихэвчлэн спирт, нооluур, тарваганы арьс, машин зэрэг эд юмс гаргах буюу оруулах гэсэн бөгөөд татвар төлөх тусгай зөвшөөрөл авахаас зайлсхийсэн хүмүүс өртдег байна. Шүүхээс сүүлийн 5 жилд /1996-2000 онд/ ял шийтгүүлсэн 478 хүнд эд хөрөнгийг нь хураах нэмэгдэл ял хэрэгтлэсэн байна. Зарим иргэд олон арван сая төгрөгний түүхий эд бараа хураалгаж, их

хэмжээгээр хохирол хүлээж байна.

Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлд: Гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйл , түүнчлэн гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн эзвэсг хэрэгсэл, гэмт үйлдлийн улмаас олсон ашиг тэдгээртэй адилтган үзэх бүсэд эд зүйлийг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж улсын орлогод оруулахыг эд хөрөнгө хураах гэнэ гэж заасан.

Шүүх дээр дурьдсан зүйлийг хураахдаа энэ зүйлийг баримталдаг бөгөөд өөрсдийн хүч хөдөлмөрөөр шударгаар олж авсан эд зүйл нь Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлд хамаарах ёсгүй.

Иргэний хуулийн 134-р зүйлийн " эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг хураана" гэсэн заалт ч хэт өрөнхий, агуулгын хувьд дэндүү хавтгайруулсан шинжтэй байна.

Захиргааны жүрмаар эд хөрөнгө хураах явдал нэлээд байгаа нь иргэдийн эрх зөрчигдөх нэг шалтгаан болдог байна.

Эдгээр байдалд дүгнэлт хийж хувийн өмчийн эд юмсыг хураах хуулийн үндэслэл жүрмыг хууль тогтоомжид нарийвчлан авч үзэж үндэслэлийг нь зөрчлийнх нь шинж байдалд нь нийцүүлэн ялгавартайгаар тодорхойлох шаардлагатай байна.

3.1.4. Онц байдлын тухай /1995/, Дайны байдлын тухай /1998/, Дайчилгааны тухай /1998/ зэрэг хуульд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв жүрмыг хамгаалах зайлшгүй шаардлагаар хуульд заасан үндэслэлээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эд хөрөнгө, төөрөлийн хэрэгсэл, барилга байгууламж, техник болон хүнс тэжээлийн нөөцийг нөхөх олговортойгоор дайчилж болохыг заасан байна.

Засгийн газрын 1999 оны 200 дугаар тогтоолоор хувийн хэвшлийнхнээс дайчлан гаргуулах эд хөрөнгийн үнийг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн үнээр, төөрөлийн хэрэгслийн үнийг авто төээрийн хэрэгслийн даатгалд даатгуулсан үнээр, бусад эд хөрөнгийн үнийг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцож нөхөн төлүүлэхээр тус тус заажээ.

Энэ журам нь зөвхөн Дайчилгааны тухай хуульд заасан нөхцелд эд хөрөнгийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор олгохоо хамаарна.

Онц байдлын тухай хуульд үнэ, нөхөн олговор 2-ыг заагаад үнийг зохицуулаагүй орхижээ. Дээрх байдлаас үзэхэд хувийн эд хөрөнгийг дайчлахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулах Үндэсн хуулийн шаардлага тэр бүр хангагдаагүй байна.

3.1.5. Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх нь өмчийн эрхийг хамгаалах нэг үндэс мөн. Үл хөдлөх эд хөрөнгийн энэхүү бүртгэлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар эрхэлнэ. Бүртгэлийн байгууллагын эрх зүйн байдлыг хууль болон Засгийн газрын 2001 оны 11 ба 40 дүгээр тогтоолуудаар батална тус газрын дүрэм, "Улсын бүртгэгчийн ажиллах журам", "Үйлчилгээний хөлс, түүнийг захиран зарцуулах журам" зэрэг актаар тодорхойлж байна.

Үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгүүлэх, хувьчлагдсан орон сууцны эрхийн баталгаажуулалт хийлгэхэд тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 172 дугаар зүйлд зааснаар: үнийн дүнгийн 0,01 хувиар бодож хураамжийн дээр хөлс давхардуулан авч байгаа нь зохисгүй юм. Зарим үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээг бүртгэхэд олон янзын татвар хураамж авч байгаат залруулбал зохилтой.

Жишээ: Иргэн хүн 15,6 сая төгрөгийн үнэтэй барилгаа анх удаа бүртгүүлэхэд тэмдэгтийн хураамжинд 1560 төгрөг, үйлчилгээний хөлсөнд 10000 төгрөг, нотариатын үйлчилгээний хөлсөнд 2000 төгрөг бүгд 13560 төгрөг, худалдана гэвэл 341600 төгрөг буюу барилгынхаа үнийн 2,3 хувьтай тэнцэх төлбөр төлдөг байна.

Үүнээс гадна үл хөдлөх хөрөнгийн жилийн татварт 0,6 хувиар тооцож 93600 төгрөг төлнө. Түүнчлэн тэр хөрөнгөө заавал хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх ёстой бөгөөд тэрхүү үнэлгээний байгууллагад багагүй мөнгө төлдөг байна.

Татвар өндөр байгаагаас шалтгаалан иргэд үл хөдлөх хөрөнгөө худалдахдаа ихэвчлэн балэгглэлийн гэрээгээр халхавчилдаг байна. Сүүлийн 5 жилд бэлэглэх гэрээ 15689, худалдах гэрээ 13860 бүртгэгджээ. Үүнээс үндэслэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой татвар хураамж олон, хэмжээ нь ч багагүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. /Эдийн засгийн эрхийн тусгай багийн тайлан 2001 он/

3.2 Аж ахуй эрхлэх эрх

Улсын Бага хурлаар 1991 онд Аж ахуйн нэгжийн тухай хууль гаргаснаар хувь хүн аж ахуйн нэгж байгуулах замаар аж ахуй эрхлэх боломж нээгдсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал 1995 онд "Хоршооны тухай" хууль, "Нөхөрлөл компаний тухай" хууль, 1999 онд "Компаний тухай" хуулийг тус тус баталжээ.

3.2.1. Монгол улсын иргэн аж ахуйн нэгж байгуулах буюу байгуулахыг эрхэмийхээ хувьд хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.

Иргэн хүн хувиараа эрхлэх аж ахуйг ерөдөл гаргаж, түүндээ нэр, хаяг, регистрийн дугаар, эрхлэх ажил үйлчилгээнийхээ төрлийг заажбайгуулдаг, түүнчлэн хүн амын орлогын татвар төлдөг эзрэгэрээ иргэдэд хамгийн дөхөмтэй хэлбэр юм.

1995 оны шинэчлэн найруулсан Иргэний хуульд "Иргэн хуулийн эгтээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх нөхцел жүрмыг хуулиар тогтооно" гэж тодорхойлсон болоовч одоо хүртэл ийм хууль гараагүй. Татварын Ерөнхий газрын дэргэдэх Улсын Бүртгэлийн алба хувираа эрхлэх аж ахуйг шинээр бүртгэхээ больсон байна.

Иймээс хувираа эрхлэх аж ахуйн тоо жилээс жилд буурчээ.

3.2.2. Шинэчлэн найруулж 1998 оны 1 дүгээр сарын 8-нд батална Хоршооны тухай хууль хүчин төгөлдөр болсноос өмнө бүртэгдсэн хоршоог хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор шинэчлэн бүртүүлэхээр заасан. Гэвч хоршоод дахин бүртүүлэх сонирхолгүй бөгөөд зарим хоршоо гишүүдийн тоогоо 9 болгож бүртүүлсэн боловч тэдгээр нь ихэвчлэн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцодоггүй хэлбэрийн тедий хүмүүс байна. Шинээр байгуулагдсан хоршоо ч гэсэн 9 гишүүнтэй гэх боловч зарим нь хий нэрээр бүртүүлсэн тохиолдол ч байна.

2001 оны 3 дугаар сард Налайх дүүрэгт явуулсан судалгаагаар тус дүүргийн 44 хоршооны 14 нь бүюу 31,7 хувь нь 9-өөс доош гишүүнтэй, 24 нь бүюу 50 орчим хувь нь 9 гишүүнтэй байв. Орон нутагт хоршооны гишүүдийн тоо бүр ч цөөн байна. Дархан-Уул аймгийн 81 хоршооны 42 нь 9-өөс доош бүюу ихэвчлэн 3-5 гишүүнтэй. Энэ байдлыг анхаарч хоршоонуудыг гишүүнчлэлийн тооны босгыг багасгах нь зүйтэй гэсэн саналыг манай сайн дурын судлаачид гаргаж байв. /Эдийн засгийн эрхийн тусгай багийн тайлан 2001 он/

3.2.3. Хувьцаат (ХК) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-ийн эрх зүйн байдлыг 1999 онд батална Компанийн тухай хуулиар зохицуулж байна.

ХК нь ихэвчлэн 1990 оноос хойш хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр иргэд хувьцааг нь хуудалдан авсан, олон мянган гишүүнтэй үүссэн боловч хувьцаа нь аажмаар цөөн хүмүүсийн гарт бөөгнөрч ХХК болох үйл явц хурдассан байна. ХК-уудХХК болж өөрчлөн байгуулагдах явцад хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хяналтыг хүчтэй болгох шаардлага нэмэгдэж байна.

Монголын хөрөнгийн биржийн мэдээнээс үзэхэд нийт ХК-ийн 202 нь бүюу тал хувь нь 1993 оноос хойш ноогдол ашиг хуваарилсан байна. Үүнээс 1993 онд 111, 1994 онд 86, 1995 онд 69, 1996 онд 51, 1997 онд 54, 1998 онд 22, 1999 онд 16, 2000 онд 20 хувьцаат компани ашиг хуваарилж, ашиг хуваарилсан компанийн тоо жил тутам буурчээ. Нэгж хувьцаанд өгч байгаа ноогдол ашгийн хэмжээ нь ч өсөөгүй, ёс тедий байгаа нь хувьцаа эзэмшигчдээс компаний үйл ажиллагааг хянаж, өмчлөгчийн эрхээ хамгаалах дадлага байхгүй, мэдлэг дутмаг хомстой холбоотой.

3.2.4. Жилд олон арван аж ахуйн нэгж татан буугдаж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд ашиг хуваарилж чадахгүй байгаа нь аж ахуйн нэгж байгуулж, аж ахуй эрхлэх эрх зүйн болон эдийн засгийн таатай орчин төдийлөн бүрдээгүй байгааг харуулж байна.

Улаанбаатар хотод аж ахуйн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 60 гаруй хүнээс санал асуулга авч дүгнэхэд: 58 % нь монголд аж ахуй эрхлэх эрх зүйн тааламжтай орчин бүрдээгүй, хүнд суртал их, шат дамжлага олон, 78,4% нь татварын дарамт их байна, гаалийн, ашгийн, онцгой албан татварын, нэмэгдсэн өртгийн, үл хөдлөх хөрөнгийн, нийгмийн даатгалын гэх мэтээр олон зүйлийн татвар хураамж төлж байгаагаас аж ахуй хөл дээрээ зогсож, хуримтлал бий болгож чадахгүйд хүрч байна. 30 % нь хүү өндөр, бэрхшээл ихтэй учир банкнаас зээл авах гэж хөөцөлдөж байгаагүй , 45% нь зээл хөөцөлдөөд бүтээгүй, маш их бэрхшээлтэй гэж хариулсан байна. /Эдийн засгийн эрхийн тусгай багийн тайлан 2001 он/

3.2.5. Иргэд нөхөрлөл, хоршоо, компани байгуулахдаа ТЕГ-ын дэргэдэх Улсын бүртгэлийн газарт бүртүүлж байна. Тухайлсан хууль байхгүй боловч нөхөрлөл, хоршоо, компанийтухай хуулиудад тусгайлсан заалттай бөгөөд тэдгээр заалтад бүртүүлэх тухай өргөдлэд ямар баримт бичиг хавсаргахыг заасан байдаг. Нөхөрлөл, компанийтухай хуульд зааснаас өөр баримт бичиг шаардахыг хориглоно гэж заажээ.

Аж ахуйн нэгжийг ТЕГ-ын дэргэдэх байгуллага болох Улсын бүртгэлийн газар бүртгэдгээс энэ алба нь заавар журам боловсруулахдаа татвар төлүүлэх тал руу бүртгэлийн газрын одоогийн харьяаллыг өөрчлөж, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль гаргах шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

3.2.6. Иргэдийн хувийн аж ахуй эрхлэх үндсэн эрхийг төрийн зарим албан хаагчын тухайд хязгаарласан нь анхаарал татаж байна. Энэ талаарх хуулиудын заалтуудыг багцалж үзвэл нэгдүгээрт: аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа гардан эрхлэх, удирдах, удирдах зөвлөлийн болон Захиргааны зөвлөлийн гишүүн байхыг нь шууд хориглосон /Монгол Улсын Их Хурлын гишүүн, төрийн захиргааны албан хаагчид, гаалийн байцаагчид/, хоёрдугаарт: хуулиар тогтоосон үүрэгт хамаарахгүй ажил албан тушаал хавсарч болохгүй /Ерөнхийлөгч, шүүгч, прокурор, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүд, Татнуулын байгууллагын ажилтан, гуравдугаарт: ямар нэгэн тодорхой заалтгүй /Шүүхийн шийдвэр биелүүлэх байгуулагын ажилтан, цэргийн албан хаагчид, Засаг дарга нар/ байна. Харин Үндсэн хуулийн Цэцийн тухай хуульд Цэцийн гишүүн хүдалдааны үйл ажиллагаа эрхэлж болохгүй гэж онцлон заажээ. Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт "Засгийн газрын гишүүн өөрийн хувийн аж ахуй болон өмч эзэмшилтэй нь холбоотой орлогыг ЗГХЭГ-т жил бүр мэдэгдэнэ" гэж заасан байна. Дээрхээс үзэхэд төрийн албан хаагчдын аж ахуй эрхлэх эрхийг янз бүрийн шалгуураар хязгаарлаж, харилцан адилгүй хуульчилсныг тухайн албаны онцлог, хүний эрхийн талаас нь нийтэд хянан үзэж, эрх тэгш хязгаарлалт тогтоох шаардлагатай.

3.2.7. Нийтийн зориулалттай орон сууцны 1 дүгээр давхарт үйлдвэрлэл үйлчилгээ зэрэгцэн эзэмшүүлэх олгоход ДБХ-ийн сайдын 2000 оны 93 дугаар тушаалаар батална "Нийтийн зориулалттай

орон сууцны зориулалт, төлөвлөлтийг өөрчлөхөд тавих шаардлага, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам".

Нийслэлийн Засаг даргын 2000 оны 341 дүгээр захирамжаар батална "Барилгын зориулалтыг өөрчилж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах журам" зэргийг үндэслэдэг бөгөөд энэ зөвшөөрлийг 9 шат дамжлага дамжиж, маш удаан хугацаа зарцуулснь эцэст хотын ерөнхий инженер бөгөөд ИБХ-ийн даргатай гэрээ хийж, хотын захирагчийн ажлын албанд 150000 мянган төгрөг төлдөг байна.

Гэрээний заалт нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2.4-т заасныг үндэслэсэн боловч энэ заалт иргэдээс төлбөр хураамж авахтай ямар ч холбоогүй, Засаг даргын эрх хэмжээг тодорхойлсон заалт байна.

2000 оноос өмнө бол орон сууцны суурь үнийг төлж гэрээ байгуулдаг байсан ба энэ журам хүчингүй болсон байна. Зөвшөөрөл олгох ажил нь шат дамжлага ихтэй бөгөөд зураг хийлгэхэд 9 байгуллагаас зөвшөөрөл, барилгын засвар дууссаны дараа 12 хүний гарын үсэгтэй барилгыг хүлээн авсан акт зэргийг үйлддэг байна.

Иргэн хүн өөрийн хувийн өмчөө ашиглахдаа улсад 15000 төгрөг төлж, Төрийн Захиргааны албан тушаалтантай гэрээ хийж байгаа нь өмчөө чөлөөтэй хэмжээ ашиглах эрхийг шууд зөрчсөн байна. Уг гэрээг нэг жилийн хугацаатай байгуулдаг бөгөөд жил бүр сунгадаг байна.

3.2.8. Үйлдвэрлэл, үйлчилгээ худалдаа эрхлэхэд тавигдах шаардлага, хяналт тавих зөвшөөрөл олгох журмыг Худалдаа үйлдвэрийн, Байгаль орчны, Дэд бүтцийн хөгжлийн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нарын, Худалдаа, үйлдвэрийн улсын хяналтын албаны дарга, Нийслэлийн болон дүүргийн Засаг дарга нарын шийдвэрээр баталж, мөрддөг байна. Зарим үйлчилгээний талаар давхардсан журам зааврууд ч гардаг.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэхэд тавих шаардлага, зөвшөөрөл олгох хугацаа, авах хураамж нь дүүрэг бүрт ялгавартай байдаг. Улсын хэмжээнд нэгдсэн журам тогтоогүй байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гэхэд л хүнсний зах, барьцаалан зээлдүүлэх, соттуруулах ундаагаар болон соёлын төлбөрт үйлчилгээгээр үйлчлэх журмуудыг батлан гаргажээ.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг богино хугацаагаар олгож, олон бичиг баримт бүрдүүлдэг байсан журам Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хэрэгжих эхэлснээр хүчингүй болсон байна.

3.2.9. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Худалдаа Үйлдвэрлэлийн Улсын Хяналтын алба, Нийслэлийн болон дүүргүүдийн Засаг даргаараас үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ эрхлэх явдлыг зохицуулсан шинжтэй олон тооны журам, заавар гардаг өөр хоорондоо ижил төстэй, заримталаар иргэдийн хувийн аж ахуй эрхлэх эрхийг зөрчсөн, тэдний өөрсдийн шийдвэл зохих асуудлыг заасан шинжтэй баримт бичиг ч гардаг байна.

Дээрх журмуудад зааснаар ломбард, архи дарс үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх, бөөний худалдааны хүнсний, барааны зах, хоолны газар ажиллуулах зөвшөөрлийг өвөрөн аж ахуйн нэгжид олгох, харин иргэд энэ үйлчилгээг хувиараа эрхэлж болохгүйгээр журамласан байна.

Энэ нь Үндэсэн хуульд заасан иргэн хүний хувийн аж ахуй эрхлэх эрхийг шууд хязгаарласан шинжтэй байна.

Аж ахуй эрхлэх зөвшөөрөл олгох журам ямар ч хууль тогтоомжтүйгээр, дээр дурьдсан байгууллагуудын үзэмжээр явж ирсэн ба 2000 оны 2 дугаар сард "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль" гарч 2001 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж эхлэх ёстой боловч мөрдөж эхлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн бүртгэх байгууллагад бүртгүүлснээр чөлөөтэй эрхэлж болно", 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Бүх төрлийн хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоолны үйлчилгээг үйлдвэрлэлийн нөхцөл, технологийн ажиллагаа, бүтээгдэхүүнийхээ дээжийг зохих хяналтын байгууллагад шалгуулж зөвшөөрөл авсны үндэсэн дээр эрхэлнэ" гэж заасан боловч энэ хуулийг хэрэгжүүлэх ажил эхлээгүй байна.

3.2.10. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх явцад дор дурьдсан 20 орчим байгууллага хяналт шалгалт хийдэг байна.

- Эрүүл мэндийн хяналтын алба /ЭМХ-ын улсын алба, Нийслэлийн ЭМХА, Дүүргийн ЭМХА/
- Стандарт, хэмжил зүйн хяналт Үйлдвэр, худалдааны хяналт /худалдаа, үйлдвэр, үйлчилгээний, геологи, уул уурхайн/-ын алба
- Татварын хяналт
- Гаалийн хяналт
- Боловсрол,соёлын хяналт
- Дэд бүтэц /авто тээврийн, түлш эрчим хүчний, харилцаа холбооны, авто замын, барилга техникийн, аялал жуулчлалын/-ийн хяналтын алба
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын алба
- Хүнсний аюулгүй байдал, ХАА-н хяналт /мал эмнэлгийн, үржлийн, үргамал хорио цээрийн, үрийн, хүнсний/–ын алба
- Галын хяналт
- Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Мэргэжлийн хяналтын хэлтэс
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын алба
- Дүүргийн ЗДТГ-ын ТҮҮХХ-ийн хяналт
- Хэрэглээгүйдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, түүний аймаг, нийслэл дэх салбарууд

Дээрх хяналт шалгалтын байгууллагын зэрэгцээгээр нийслэл, аймаг, сум, дүүргийн ИТХ, Тэргүүлэгчид өөрсдийн гаргасан шийдвэрийн биелэлтийг шалгах, тодорхой арга хэмжээ зохион байгуулахад төрөл бүрийн хандив, туслалцаа авах

зэрэг үйлдэл хийгдэг байна.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй 60 орчим хүнээс санал асуулгаар судалгаа авч үзэхэд 20 гаруй хувь нь давхардсан олон шалгалт ирдэг, ижил үүрэгтэй олон хяналтын албад биелүүлэх боломжгүй шаардлага тавьдаг, гар хардаг гэж хариулсан байна.

Дээрх хяналтын албадын дүрэм, эрх хэмжээг судалж үзэхэд зарим хяналтын албадын чиг үүрэг, эрх хэмжээ хоорондоо адил давхардсан шинжтэй байна. Ялангуяа Эрүүл мэнд, Хүнс ХААН, Худалдаа үйлдвэрийн улсын хяналтын албадын чиг үүрэг их ойролцоо байна. Тухайлбал: Эрүүл мэндийн улсын байцаагч хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын байдалд хяналт тавих эрхтэй байхад Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч хүнсний үйлдвэрлэлийг технологи, стандарт шаардлагын дагуу эрхлэх, бүтээгдэхүүний чанар , аюулгүй байдлыг хангах үүрэгтэй, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, хамгаалалт, худалдаатай холбогдуулан гаргасан хууль, эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт, дүрэм жүрмыг худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, иргэд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүрэгтэй байна.

Түүнчлэн Нийслэлд Эрүүл мэндийн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын албад дүүргийн, Нийслэлийн, улсын гэсэн 3 шатлалтай байна.

Иймээс хяналтын албадын бүтэц, чиг үүргийг нарийн судалж, давхардлыг багасгах нь зүйтэй байна.

3.3. Зохиол бүтээл туурвих, түүнийхээ үр шимийг хүртэх эрх

Оюуны өмчийн эрхтэй холбоотой харилцааг Зохиогчийн эрхийн тухай хууль /1993/, Патентийн тухай хууль /1993 /, Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль /1996 /, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /2000 /, Технологи дамжуулах тухай хууль /1998/, Иргэний хууль болон яам, агентлагийн батална 10 орчим заавар, дүрэм, журмаар зохицуулж байна.

Монгол улс 1979 онд НҮБ-ын бие даасан төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагад гишүүнээр элсч үг байгууллагаас батлан гаргасан оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтад хамаарах Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парижийн конвенц /1985 / Патентийн хамтын ажиллагааны гэрээ /1991/ зэрэг олон улсын 30-аад гэрээнийг аравт нь нэгдэн ороод байна.

Дээр дурьдсан гэрээнд нэгдэн орсноор Монгол улсын хувьд оюуны өмчийн салбарт олон улсын хэмжээнд бусад улс орнуудтай хамтран ажиллах, эрхээ хамгаалуулах, хамтран ажиллах боломж нэмэгдэж байгаа юм.

Дан ганц хууль гаргаснаар асуудлыг шийдвэрлэх биш харин гаргасан хуулийг амьдралд зөв хэрэгжүүлэх, оюуны хөдөлмөрийн үр дүнг гадаадын болон дотоодын зах зээлд гаргаж, зөв ашигтай үнэлүүлэх, оюуны үйлдвэрлэл явуулах таатай орчинг хэрэхэн бий болгох, оюуны салбарт төрийн бодлогыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх гэсэн олон асуудлууд тулгарч байна.

3.3.1. Монгол Улсад анх 1960 онд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдэж эхэлснээс хойш өнөөг хүртэл шинэ бүтээл 1670, бүтээгдэхүүний загвар 1090, шууд мэдүүлгээр барааны тэмдэг 2980, ашигтай загвар 24150-ыг тус тус улсын бүртгэлд авч онцгой эрхийн баримт бичиг олгосон. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлээр ирсэн 18000 гаруй тэмдгийг улсын бүртгэлд бүртгэн авсан.

1996 онд Оюуны өмчийн газрыг шинээр зохион байгуулсан нь ДООБ болон бусад оюуны өмчийн талаархи бусийн, улс хоорондын байгууллагууд, гадаад бусад орнуудтай нэгдсэн бодлого чиглэлээр харилцах, дотоодод оюуны өмчийг хамгаалах, зохиогч, бүтээл туурвигчид, эрх ээзмшигчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах нэгдмэл үйл ажиллагаа явуулахад нэлээд дэхөмтэй болсон тедийгүй зохиогч, бүтээл туурвигчид иргэдэд ч ойртсон, төвөг бэрхшээлгүй зөв алхам болсон байна.

3.3.2. Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй оюуны өмчийн чиглэлээр байгуулагдсан 30 орчим төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрийн нэлээд нь өөрсдийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор оюуны өмчийг хөгжүүлэх, боловсон хүчнийг сургах, гишүүдийн эрх хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа боловч үйл ажиллагааны үр нөлөө нь хангалтгүй байна.

Зохиолчид, уран бүтээлчид өөрийн оюуны өмчээ хамгаалуулах зорилгоор төрийн бус байгуллага байгуулж болох тухай Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор Монголын хөгжмийн зохиолч, яруу найрагчдын эрхийг хамгаалах МОСРАК холбоог 2000 онд байгуулж үйл ажиллагаагаа эхлээд байна.

МОСРАК холбоо өнгөрсөн жил гаруйн хугацаанд нийт 51 зохиолч, уран бүтээлчдийг гишүүнээр элсүүлж, тэдний 3000 гаруй бүтээлийг бүртгэн авчээ. Гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулах талаар 30 орчим аж ахуйн нэгж, байгуллага,

иргэдтэй гэрээ байгуулжээ. /Эдийн засгийн эрхийн судалгааны тусгай багийн тайлан 2001 он/

Хэдийгээр оюуны бүтээл туурвигчид оюуны бүтээлээ хамгаалуулах эрх зүйн зохицуулалт бий болж, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор оюуны өмчийн хяналтын тогтолцоо үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг жил гаруй хугацаа өнгөрч байгаа боловч энэ төрлийн эрхийн зөрчил өсөх хандлагатай байна.

Оюуны өмчийн газар оюуны өмчийн эрх

зөрчигдсөн тухай 120-иод гомдлыг хүлээн авч барагдуулаад байна. Тэдгээрийн 50 орчим хүнь нь Зохиогчийн эрхийн тухай хууль зөрчсөн зөрчил, 25 хүнь нь Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль зөрчсөн, 25 хүнь нь Патентийн тухай хууль зөрчсөн зөрчлүүд байна.

Оюуны өмчийн газрын хяналтын улсын байцаагчдын илрүүлсэн зөрчлийн 17 хүнь нь Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр өмчлөгчийн эрхийг зөрчиж, барааны тэмдгийг хууль бусаар өөрийн бүтээгдэхүүнд хэрэглэсэн зөрчил байгаагаас үзэхэд Монгол Улсын нутгат дэвсгэрт нийтэд танил болсон барааны тэмдүүдийн албан ёсны жагсаалт гаргах, түгээмэл болсон гэдгийг тогтоох шалгуурыг бий болгох нь зайлшгүй хэрэгцээ болжээ.

Судалгаа болон шийдвэрлэгдсэн хэрүүдийн байдлаас үзэхэд оюуны өмчийн эсрэг гэмт хэрэгт шийтгүүлэгчдэд шүүх эдгээр зүйлүүдэд байгаа сонгомол ялаас торгуулийн ялыг сонгон авч хэрэглэдэг практик тогтсон байх бөгөөд торгуулийн ялын хэмжээ нь Патентийн тухай, Зохиогчийн эрхийн тухай хуулиудын захиргааны шийтгэлийн торгуулийн хэмжээнээс их биш байна.

Монгол Улсын шүүхийн нэгдсэн мэдээний дагуу оюуны үнэт зүйл ашиглах, патентийн тухай, зохиогчийн эрхийн тухай хуулиар гаргасан иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар судалсан дүнгээс үзэхэд улсын хэмжээнд 1996-2000 онуудад нийт 266 нэхэмжлэл хүлээн авч 169 буюу 63.5 хувийг хүлээн авахаас татгалзаж, 97 буюу 36.5 хувийг шийдвэрлэсэн байна. /Эдийн засгийн эрхийн судалгааны тусгай багийн тайлан 2001 он/

Шүүх оюуны үнэт зүйлийг ашиглахтай холбоотой хэргийг шийдвэрлэсэн байдлаас харахад зохиогчийн гэрчилгээтэй шинэ бүтээлийг гэрээгээр ашиглаж, гарсан эдийн засгийн үр ашиг, хэмнэлттэс зохиогчид бүтээлийг нь ашигласны шагналыг олгохгүй байгаа, бүтээгдэхүүний загварын патентийг хугацаатай эзэмшиж байгаа эзэмшигчийн эвшөөрөлгүйгээр бүтээгдэхүүнийх нь хэвийг хуулбарлаж үйлдвэрлэж худалдсан, эвшөөрөлгүй эрхэлсэн үйлдвэрлэл, худалдааны ашгийг патент эзэмшигчид олгох, ажил гүйцэтгэх гэрээний үүргийг хангуулах зэргээр гэрээний талуудын зөрчигдсөн эрхийг хамгаалсан байна.

3.4. Хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал

3.4.1. Эдийн засгийн шинэ нөхцөлд орсон учир 1992 оны Үндэсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн 1999 онд Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийг батлан гаргасан. Дээрх хууль нь НҮБ-аас батлсан хүний эрхийн пактууд, олон улсын хөдөлмөрийн байгуулламаас баталсан гэрээ, конвенцүүдийн агуулга, үзэл баримтлалтай нийцсэн гэж энэхүү судалгааны оролцон судлаачид үзсэн байна.

ОУХБ-аас гаргасан, Монгол улсын нэгдэн орсон 13 конвенцийн агуулгыг дотоодын хууль тогтоомжинд тусгасан байдлыг судлахад эдгээр конвенцийн заалтыг хэрэгжүүлэх механизм бүрдээгүй, хууль хэрэглэгчид конвенцийн заалтуудыг мэддэггүй, дотоодын хуулиудад бүрэн тодорхойлж чадаагүй байдал харагдаж байна.

3.4.2. Монгол улсын Үндэсэн хуульд заасан " Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх"-ээ хүн хэрэгжүүлэх үндсэн арга зам бол өөртөө хөдөлмөрлөхөөс гадна Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчтой "хөдөлмөрийн гэрээ" байгуулан ажиллах явдал юм.

Хөдөлмөрийн харилцааны оролцогч нэг тал нь (ажилтан) нөгөөгөөс (ажил олгогчоос) санхүүгийн хараат байдалтай байдгийг анхаарч, түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалан тэнцвэржүүлэх шаардлагын үүднээс судалхад юуны өмнө хүнийг ажилд авах, ажлаас халах, цалин хөлс олгох, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах хүрээнд зөрчил нилээд илэрчээ.

Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй байгаа нь хүний хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрхийг зөрчөөд зогсохгүй эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ч "давхар" зөрчдөг. Энэ нь хөдөлмөрийн таатай орчноор хангуулах эрхтэй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн Монгол Улсын Үндэсэн хуулийн заалтуудыг зөрчиж хүний амь нас, эрүүл мэндэд шууд заналхийлж байдаг учраас хөдөлмөрийн улсын хяналтыг чанаржуулах, байгуулагын дотоодын хяналтыг сайжруулах талаар хамтын гэрээнд тусгах талаар ҮЭБ, хөдөлмөрчдийн санал санаачилгыг дэмжлүүлэхэд анхаарах нь чухал юм.

Дорнод аймагт 558 ажилтныг хамарч хийсэн судалгааны ажил олгогч нь дарамт шахалт үзүүлдэг үү гэсэн асуултад судалгааны оролцогчдын 72.6% нь албан тушаалаарааа дарамталдаг гэж хариулжээ. Ажиллагчдын 49.9% нь байгуулага албан тушаалтнаас дарамт шахалт үзүүлдэг болоч шүүхэд ханддаггүй, ажлын байраа алдахаас айдаг, хуулийн байгуулага зөв шийдвэр гаргадаггүй гэж үзэж байна.

Түүний дотор судалгаанд хамрагдсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд "Тиань Пинь Гармент", "Гүүд Лайк Гармент", "Носерн Менч" зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэрүүд, өдөрт 9-12 цагаар ажиллуулаад хөлсийг хоёр дахин нэмэгдүүлж олгох хуулийн заалтыг зөрчдөг гэж судалгааны оролцогчид хариулжээ.

Зураг 2.3.1 Улүү цагийн хөлсөө авч чаддаг эсэх



Улүү цагаар ажиллагчдын 62.0 хувь нь зохих хөлсөө авч чаддагүй нь хүний эрхийнноцтой зөрчил мөн.

Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгохоо ямар саад бэрхшээл учирч байгааг судалсан дүнгээс үзэхэд нийслэлийн хэмжээнд тулгарч байгаа гол бэрхшээл нь нэгдугээрт, ажилд ороход танил тал хардаг /18.9 хувь/, хоёрдугаарт, цалин бага /14.4 хувь/, гуравдугаарт, мэргэжилгүй /11.2 хувь/ гэсэн шалтгаануудбайна. Мөн шинээр ажилд ороходаж ажил олгогчид хахууль авдаг /10.0 хувь/, нас, хүйсэр ялгадаг /5.6 хувь/ зэрэг нөлээд ноцтой шалтгаануудхүний уг эрхийн зөрчлийн үндэс болжээ.

Судалгаанд хамрагдсан 180 гаруй хүний 77.8 хувь нь авч буй цалин тэтгэвэр амьдралд хүрэлцдэггүй гэж хариулсан нь төрөөс цалин, хөлсийг амьжиргааны өртөгтэй уялдуулах тухайлсан бодлого боловсруулж явуулах шаардлагатайг харуулж байна.

Цалин, тэтгэвэр амьдралд нь хүрэлцэхгүй байгаа нь төр засгаас хамааралтай эсэх талаар юу гэж бодож байгааг Зураг 2.3.2-т харуулав.

Нийт хариулагчдын 65.6 хувь нь цалин тэтгэвэр хүрэлцэхгүй байгаа явдлыг төр засгаас хүний эрхийг зөрчиж байна гэж үзэж байгаа нь хүмүүс тэдний хэмжээгээр өөрсдийн хүрэлцээтэй цалин хөлс авах эрхээ мэддэгийг харуулж байгаа боловч уг эрхээ хангуулах талаар тедийлэн амжилт олж чадахгүй байна. Хөдөлмөрийн хөлс, үнэлгээ, амьжиргааны түвшний харьцаа төвөөс алслагдах тутамд тэнцвэргүй болж байна.

3.4.3. Улсын хэмжээнд бүй нийт ажил олгогч ААН, байгууллагад хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны хөдөлмөрийн хяналтын хэлтэс 2000 онд 982 ААН-д үзлэг шалгалт хийжэ 2599 зөрчил илрүүлсэн баримт байна.

Тус хяналтын албанд 82 улсын байцаагч ажилжж байгаагийн аймаг дүүрэг тус бүр бүрт 2 улсын байцаагч ажилжж байна. /Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч/

Хөлсөн авагчдын тоотой харьцуулахад хяналтын байцаагчийн тоо үнэхээр цөөхөн байгаа нь зөрчлийг төр бүр илрүүлэх боломжгүй байгааг харуулна.

2001 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн шүүх ажлаас үндэслэлгүй халагдсан гэсэн өргөдөл 239 хүлээн авснаас 153 хэргийг шийдвэрлэжээ. Хан-Уул дүүргийн шүүх 2001 оны сүүлчийн хагас жилд 13 хүний маргаан шийдвэрлэсний 10 нь буюу 77.7% нь ажлаас үндэсгүй халагдсан гэж тогтоожээ.

Эдгээрээс үзвэл хөдөлмөрийн харилцааны хүрээнд хууль зүй, эдийн засгийн хувьд дааны байдалтай тал болох ажил олгогч нь ажилтны эрхийг хууль бусаар көндөх, хязгаарлах явдал тархмал байна.

ДӨРӨВ: ХҮНИЙ НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд Олон Улсын гэрээ хэлэлцээр болон Үндсэн хуульд нийцүүлэн нийгэм, соёлын харилцаат зохицуулах хууль тогтоомжуудыг нийтэд нь шинэчилж, нийтийн үйлчилгээг зах зээлийн харилцааны жам ёсонд нийцүүлэн төлөвшүүлэх талаар олон зүйл арга хэмжээ авсан байна.

4.1. Нийгэм хангамжийн эрх

Үндсэн хуулиар баталгаажуулсан өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, тахир дутуу болсон, тэжээгчээ алдсан, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд. мөнгөний тусламж авах эрхийг нийгмийн халамж. нийгмийн даатгалын багц хуулиар зохицуулж байна. Дээрх ойлголтууд дээр ажилгүй болсон, нэн ядуу, өрх толгойлсон гэх мэт шинэ хүрээ нэмэгдэж иргэд нийгмийн даатгал, халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийн хүрээ ессн юм.

4.1.1. Манай улсын нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн хэсгээс бүрдэх болсон ба түүнд тохирсон хоёр сан бий болгов. Санг сайн дурын, албан жүрмын даатгал, хураамжийн гэсэн 2 эх үүсвэрээр бүрдүүлэхээр хуульд заасан. Ядуурлыг бууруулах стратегийн заврын баримт бичигт дүрдсанаар манай улсын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын 91.8% нь заавал даатгалд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 22.5% нь сайн дурын даатгалд, хүн амын 92.2% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байна. Тэтгэврийн даатгалын сангаас 250.0 орчим мянган хүн тэтгэвэр авагч байгаа бөгөөд тэдний тэтгэврийн дундаж нь 2001 оны байдлаар 18000 төгрөг байна. Энэ нь дээрх хүмүүсийн нэгд захын хэрэгцээнд хүрэлцэхүй бэрхшээл бий. Зарим ажахүйн нэгж ажиллагчдынхаа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийг цалингаас нь суутгадаг хирнээ даатгалын санд шилжүүлдэггүй. Хүн амын бэлэн мөнгөний орлого муудсанаас даатгалын санд орон сууц, барилга байшин, машин техник, зд бараа хүртэл авдаг болсноор даатгуулагчын эрхийг зөрчиж байна.

Нийгмийн халамжийн санг төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө, чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, байгууллага, хувь хүнээс олгосон хандив, тусламжаас бүрдүүлэхээр хуульд заасан. Энэ нь өрх гэрт үзүүлэх нийтлэг тусламж, эмээг бүлгийнхэнд

зориулсан тусламж үйлчилгээг эрхэлдэг ба тус сангаас хөгшид, тахир дутуу хүмүүс, тэжээгчээ алдагчид зэрэг 30,0 мянга гаруй хүн тэтгэвэр, олон хүүхэдтэй болон нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, өнчин хүүхдүүд зэрэг 200,0 гаруй мянган хүнд тэтгэмж, тусламж олгож, нийгмийн эмээр хэсгийн 400 гаруй хүнд асрамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Төрөөс нийгмийн халамжийн үйлчилгээнд багагүй зардал гаргаж байгаа боловч, тэр эрх нь үүссэн иргэн бүрт хүрэлцэхгүй байх хувааргилсан хөрөнгийг албан тушаалтнууд хэмнэх нөхцөл танаж хорогдуулах, улмаар иргэд хохирох нь түгээмэл байна.

- 2001 оны байдлаар Баянгол дүүргийн нийгмийн халамжийн байгууллагаас дунджаар нийт 1200 эх хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй болсныг тогтоосон. Гэтэл төсвөөс төлөвлөгдсөн 22 сая төгрөгөөр 900 эхэд хүүхэд асарсны тэтгэмж олгож, үлдсэн 300 эх хаанаас ямар эх үүсвэрээр энэ тэтгэмжийг авах нь тодорхойгүй байна. /Нийгэм соёлын эрхийн тусгай багийн тайлан 2001 он/

Аймгийн халамж үйлчилгээний төвийн нябо Мөнхцэцэгийн яриснаар халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь бүрэн өгч чадахгүй байна. Учир нь 2000 оны аймгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 740,0 сая төгрөгийн хэрэгцээ байхад 545,0 сая төгрөг батлагдаж иржээ. 2001 оны 10 сарын 01-ээс 5 нэрийн тэтгэмж нэмэгдэн боловч менгө нь орж ирээгүй байна. Үянга суманд хадгаламжийн тэтгэвэр, тэтгэмж 4 дүгээр сараас хойш олгоогүй байна. /Өвөрхангай аймгийн судалгааны тайлан 2001 он/

Нийгмийн хангамжийн төсвийг буруу тооцоолж дутуу батилдагаас иргэд тэтгэвэр, тэтгэмжээ авч чадахгүйд хүрч, хуулиуд хоорондоо зөрчилтэй байна. Нийгмийн халамжийн тухай хуульд "нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг, нийгмийн даатгалын сангаас олгох УОМШӨ-ний тэтгэвэр тэтгэмж төлбөр авах эрх үүсэзгүй, нэн ядуу амьдралтай ерхийн тахир дутуу гишүүн эмчлүүлэхээр аймгийн эмнэлэгийн мэргэжлийн комиссын шийдвэрээр нийслэлд ирж буцахад нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно" гэсэн заалт бий. Гэтэл энэ мөнгийг төсөвт суулгаагүйгээс өгч, авалцах боломжгүй.


Мөн хуульд жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед эмчийн заасснаар хийх үзлэг, шинжилгээ, эмчилгээ, үнэ төлбөргүй байна гэсэн байгаа боловч хэрэг дээрээ бүгд төлбертэй болж, иргэдийн эрх зөрчигдөж байна. Жишээлбэл, суулийн 4 жилийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлд 1-4 өрөө бүхий 493,3 сая төгрөгийн 59 орон сууцыг авч түүнд гол төлөв удирдах ажилтнууд өөрсдөө орж, үнийг нь төлөөгүй байна. /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын албаны 2000 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээс/

4.1.2. Хүн амын 35.6% /1998 оны байдлаар/ нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлогоор амьдарч, нийгмийн халамжийн гадна үлдэж байгаа хүмүүсийн тоо өссөөр байгаа нь өнөөгийн нөхцөлд төрөөс уг асуудалд онцгой анхаарах шаардлагатайг илтгэж байна. Ялангуяа шилжин суурьшигсдаар иргэний бүртгэлд ороогүй хүмүүсийн асуудлыг нэн тэргүүнд шийдэх хэрэгтэй болжээ. Эдгээр хүмүүс нь амьдралын элдэв шалтгаанаар төв суурин руу шилжэг бөгөөд бүртэлийн хураамж төлөх чадваргүй улмаас очсон газраа бүртгүүлж "харъяат" нь болж чаддагүй. Үүнээс улбаалан хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, ЭМНХ-ийн тусламж авах, орон сууцаар хангагдах, өлсгөлөнгөөс ангид байх, нийгмийн хангамж хүртэх гэх мэт олон зүйл эрхээ эдэлж чадахгүй байна.

4.2. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх


Монгол орны сүүлийн 10 жилд эрүүл мэндийн эрх зүйн аятай орчинг бүрдүүлж, ханган талаар ахиц гаргасан ч гэсэн анхаарах зүйл цөөнгүй байна.

4.2.1. Хүүхдийн эндэгдлийг багасгах



Нялхас ба 5 хүртэлх насны хүүхдийн 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 1989 онд 60.4 байсан бол 2000 онд 31.2 болтлоо буурчээ. Үүнд Засгийн Газраас Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрөөр хүүхдийн 90 гаруй хувийг хөхөөр хооллох зэрэг арчилгааны улламжлалт аргыг өргөжүүлсэн зэрэг нь зэрэгээр нөлөөлөв.

4.2.2. Эхийн эндэгдлийг бууруулах



Сүүлийн 10 жилээр үзвэл эхийн эндэгдэл 1993 он хүртэл огцом есөөд аажмаар буурчээ. Тийм огцом есөн шалтгаан нь амаржихын өмнө, хойно асарч сувилдаг амрах байрын нилээд нь 1990 оноос хаагдсан, эмэгтэйчүүд мэргэжлийн хяналтаас хөндийрсөн зэргээс болсон гэж мэргэжилтнүүд үздэг байна.

"Эх үрсийн эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд сургалт зохион байгуулж, эмчилгээ оношлогооны чанар, эмнэлэгийн тоног төхөөрөмж, зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эм тарианы хангамжийг сайжруулснаар эхийн эндэгдэл 1993 оноос буурч эхэлсэн. Гэвч харилцаа холбоо хөгжөөгүй, түргэн тусламжийн үйлчилгээний чанар муудсан нь уул эндэгдлийн түвшин тууштай буурахгүйн гол шалтгаан болж байна. /Хүний хөгжлийн илтгэл, 2000 он/ Түүнчлэн сумдын эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

4.2.3. Халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд оңцгой байр суурийг эзэлдэг.

Хүний тоо

Өвчний нэрээр	1990	1995	1996	1997	1998	1999	2000
Вируст гепатит	14278	7877	8198	9394	8042	5249	9235
Улаан бурхан	296	558	123	4	8	10	925
Гахайн хавдар	240	255	436	736	1287	426	874
Халдварт менингит	776	2781	881	533	303	242	223
Салхин цэцэг	810	401	386	253	375	297	569
Сальмонеллёз	866	360	323	256	239	243	284
Цусан суулга	1930	1589	2294	2146	1261	1383	1657
Бруцеллёз		850	1158	1122	1308	1482	992
Тэмбүү	705	718	810	1291	1329	1093	1647
Хүйтэн	2234	3308	3274	2934	3486	2207	5488
Хамуу	3822	11023	6660	2695	1232	893	530
Сурьеэ	1664	2543	3104	2723	2806	3221	2983
Бусад	408	450	466	1206	6614	6800	1150
Бүгд	**28029**	**32713**	**28113**	**25293**	**28290**	**23546**	**36911**

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 1990 онд 28,0 мянга байснаа 2000 онд 36,9 болсны дотор бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2 дахин өссөн байна. Энэ нь цаашид ДОХ-оор өвчлөгсөд нэмэгдэх аюулын дохио юм. Халдварт өвчин буурахгүй байгаа нь хүн амын дунд ядурал гүнзгийрч хоол хүнсний ариун цэвэр муудаж байгаатай холбоотой байна.

1990 онд эмнэлгийн тоо 1868 байсан бол 2000 онд 1434, больницийн орны тоо 26,4 мянга байсан бол 17,9 мянга болж буурсан нь эмнэлгийн үйлчилгээний хүртээмж багассан гэсэн хэрэг мөн. 10000 хүнд ногдох их эмч 1990 оноос хойш тедийлэн буурааргүй ч, дунд мэргэжилтэн 1990-1995 онд 61 хувь хүртэл буурч 1996 оноос үг бууралт зогссон байна. Улсын төсөв өсөөр эрүүл мэндийн салбарт зарцуулах зардал буурсан нь тус салбарын үндсэн үзүүлэлт буурах нэг гол шалтгаан болсон.

4.2.4. Төрөөс иргэдийнхээ эрүүл мэндийн зардлыг даадаг байсан "социалист тогтолцоотой" харьцуулахад энэ салбарын төсөв эрс буурсан хэдий ч эрүүл мэндийн даатгалын сангийн тал хувийг иргэд өөрсдөө даах болсноор санхүүжилтийн найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэхэд чухал алхам хийв. Тэгсэн хэдий ч хөгжсөн орнуудын тогтолцоог бодвол болжи, иргэддээ хүрч үйлчилж чадахгүй байгаа дутагдал байна. Эрүүл мэндийн даатгалтай өвчтөнийг хэвтэж эмчлүүлж байгаа нөхцөлд өөрөөс нь зардал гаргуулах ёсгүй байтал эмчилгээ, эмийн зардал гаргуулах, гаргасан эм, тарианы үнийг бүцааж олгохгүй байх, өөр эмнэлэгт шилжин хэвтэх тохиолдолд өвчтөнөөс заавал нэмэлт зардал гаргах зэргээр иргэдийн эрхийг хохироож байна.

Төсөв хэмнэх бодлого нь хэдээ орон нутагт ямар гажуудлыг бий болгож байгааг дараах жишээнээс харж болох юм.

- Сумын Засаг дарга, сумын эмнэлгийн эрхлэгч нарын хооронд байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай Өвөрхангай аймгийн Засаг даргын 1999 оны 18 тоот захирамж гаргасан байна. Уг гэрээний үлгэрчилсэн загварт: Төсвийн хэмнэлт гаргасан сумын эмнэлгийн эрхлэгчид нийт хэмнэлтийн 1/3-тэй тэнцэх хэмжээний урамшуулал олгоно, үг урамшуулалын түүний 12 сарын цалингаас хэтрэх ёсгүй, 1/3-тэй тэнцэх хэсгийг эмнэлгийн ажилтнуудад урамшуулал болгоно, үлдсэн 1/3-ийг эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад зориулсан арга хэмжээнд хоёр тал харилцан тохиролцсоны үндэсэн дээр зарцуулах гэсэн заалт оржээ. Иргэн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас эмчилгээний зардлыг авдаг. Эрүүл мэндийн даатгал нь нэг хоносон ч, 10 хоносон ч 22500 төгрөг байдаг. Дээд шатны байгууллагаас "төсвөө хэмнэ" өргүй гар гэдэг үүрэг өгдөг учир төсөв хэмнэх явдал ажлын гол үзүүлэлт болдог. Иймд байгууллагын төсөв захирагч нар өөрсдийн ажлыг сайн гэж үнэлүүлж их хэмжээний урамшил

хүртэхийн түлд халааалтын хүгацааг богиносгох, хоёр хүний хийх ажлыг нэг хүнээр хийлгэх, хоёр удаа хоол өгөх байсан бол нэг удаа өгөх, 5 терлийн эм тариа хийх байсан бол 3-ыг өгөх, эмнэлэгт зайлшгүй хэвтэж эмчлүүлэх

шаардлагатай өвчтнүүдийг эм тариа бичиж гэр рүү нь бүцаах гэх мэтээр төсөв хэмнэж байгаа нь ирэгдийн зүүлт мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг ноцтой зөрчиж байна. / Өвөрхангай аймгийн судалгааны багийн тайлан 2001 он/

Үүнээс харахад төсөв хэмнэх бодлогоос ашиг тус хүртэж байгаа хүн нь ганц

эрхлэгч болоод ирэгд чанартай, хүртээмжтэй эмнэлгийн үйлчилгээ хүртэх эрх нь хохирч үлдэх болж байна. Үгаас хомсон төсвийг хэмнэнэ гэдэг нь зүүл мэндээ хамгаалуулах ирэгдийн эрхийг хохироохоос өөр ашиг тус үгүй биз ээ. Зүүл мэндийн зарим үйлчилгээ үнэ төлбертэй болж, өмчийн олон хэлбэр нэвтэрч байгаа нь хүн амд зүүл мэндийн үйлчилгээг сонгох боломж бүрдүүлж байгаа хэдий ч ядуу хүмүүсийн хувьд энэ үйлчилгээнд хамрагдах боломж бүурсан. Чинээлэг хүч амьн зүүл мэндэд зарцуулах зардал ядуу хэсгийнхээс 9 дахин их байгаа болох нь амьжиргааны түвшин тогтоох судалгаанаас харагдаж байна. Мөн ядуучууд, малчид, алс хязгаар нутгийн хүмүүст хүрэх зүүл мэндийн үйлчилгээ, эмийн хүртээмж бага, эмнэлгийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, чанар муутай байна. Энэ нь тэгш бус байдал даамжирсныг харуулж байна.

Ихэнх аймгуудын багийн эмч нь байгүй, хэдээгийн малчдад эмнэлгийн түргэн тусламж үзүүлэхдээ унааны бензин унаа тэрэгний түлшний мөнгийг авдаг, эмийн хүрэлцүүр муу учраас өвчтөнөөс өөрөөс нь эм, тариа гаргуулдаг боловч мөнгийг нь олгодоггүй гэх мэтчилэн дутагдлууд нийтлэг байлаа. Түүнээс гадна хэдээгийн эмнэлгийн эмч нарын мэргэжлийн ур чадвар сул, эмнэлгийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, шинжилгээний багаж төхөөрөмжгүйгээс аймгийн төв, хот суурин газарт очиж шинжилгээ өгч, оношоо тодруулахын түлд их зардал гаргадаг гэх мэтчилэн зөрчлүүд байна.

4.3. Сурч боловсрох эрх

Шинэ Үндсэн хуульд нийцүүлэн Боловсролын тухай хууль (1995), Бага дунд боловсролын тухай хууль (1998). Дээд боловсролын тухай хууль (1995)-уудыг УИХ-аас батлаж гаргасан.

4.3.1. Албан боловсрол

А) Сургуулийн өмнөх боловсрол

2000-2001 оны байдлаар 3-7 настай бүх хүүхдийн 70.4% (171942) сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй байна. / Хэдээний сумдад 84.1% (114731) Ажиллаж байгаа нийт цэцэрлэгийн 17.9% нь барилгын болон халаалт, дулаан хэвийн бус нөхцөлтэй зүүл ахуйн нөөд захын шаардлага хангахгүй байна. /Боловсролын яамны статистик 2001 он/

Б) Ерөнхий боловсрол


Бага дунд боловсролын хуулиар ерөнхий боловсролыг дотор нь бага ба суурь боловсрол, бүрэн дунд боловсрол гэж ангилсан. Сургуульд элсэх насыг 8 байхаар заасан бөгөөд 6-7 настай хүүхдийг сургах нөхцөл бүрдсэн бол элсүүлж болно хэмээн нэмж заасан.

2000 оны байдлаар ерөнхий боловсролын 683 сургуульд 494544 хүүхэд сурадаж байна. Үүнээс төрийн өмчийн 606, төрийн бус өмчийн 77 сургууль байна. Сургуульд хамрагдагсдын түвшин бага сургуульд 96,5, дунд сургуульд 80.1 бүрэн дунд сургуульд 45,8 хувь байна.

4.3.2. Сургуулийн хүртээмж

Ирэгд сурч боловсрох эрхээ эдлэх анхны нөхцөл бол сургуулийн байр, хүчин чадал, боловсон хүчний хангалтын асуудлыг төрөөс хангаж өгөх явдал юм.

Ерөнхий боловсролын сургуулийн тоо



Дээрх графикаас харахад 1990 оноос хойш сургуулийн тоо нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна. Гэвч тэдгээрийн 24% болох хэдээний 130 сургуулийн хичээлийн байр, нийт дотуур байрны 26% болох 91 дотуур байны барилга, байгуулламжийн чанар, халаалтын систем муудсанаас өөлийн улиралд ажиллах боломжгүй болсон байна. Хэдээний ерөнхий боловсролын сургуулиудын барилгын 80% буюу 409 сургууль, дотуур байрны 84.9% буюу 298-д их засвар хийх шаардлагатай болжээ. Ерөнхий боловсролын сургуулийн 14.8% буюу 101 сургууль 3 эээжээр хичээллэж байна. / БСШУЯ-ны статистик, 2001 он/

Монгол Улсын нийт сургууль 280000 орчим хүүхдийг сургах хүчин чадалтай байхад 2000 оны байдлаар тэр хүчин чадлаар нийт 494544 хүүхэд Ерөнхий боловсролын сургуулийн тоо / УСГ, 2000 он, БСШУЯ-ны статистик, 2001/ сурадцаж байна. Энэ нь сургуулийн хүчин чадлаас 214544 орчим хүүхдээр буюу бараг 2 дахин илүү хүүхэд хичээллэж байна гээн үг. Иймэ байдал нь хот суурин газарт илүү их байна. Жишээ нь: Улаанбаатарын 1900-аас дээш хүүхэдтэй 65 сургуулийн 34 нь хэт ачаалалтай байна.

2001-2002 оны хичээлийн жилд нийт 92315 малчдын хүүхэд сурадцаж байгаагийн дөнгөж 24 хувь нь дотуур байранд суух бүй бөгөөд үлдэх 76 орчим хувь нь дотуур байр хүрэлцэхгүйгээс гадуур аргалж байна. Энэ нь хэдээний хүүхдүүдийн сургууль завсардалтыг бууруулах, сургалтын чанар

сайжруулахад бэрхшээл учруулдаг аж.

4.3.3. Сургууль завсардалт

2000 оны байдлаар 8-17 насны буюу 8 хүртэлх ангид суралцвал зохих хүүхдийн 13.5% буюу 68155 хүүхэд сургууль завсарддэж. Түүнчлэн нэгдүгээр ангид элссэн хүүхдийн 16.4% нь бага боловсролыг, 35% нь суурь боловсролыг хугацаандаа эзэмшиж чадахгүй гарч байна гэсэн статистикийг БСШУЯ-аас гаргажээ.

Сургууль завсардах болсон шалтгааныг судлахад амьдралын гачигдлаас болсон гэж 8.6%, сурах дургүйгээс гэж 7%, хөдөө ажил эрхлэхээр гэж 5.1%, суурин газар ажил эрхлэхээр гэж 0.7% нь хариулсан байхад, 79% буюу 10782 хүүхдийн шалтгаан тодорхойгүй үлджээ. "Шалтгаан тодорхойгүй" хүүхдүүдийн суралцахгүй байгаагийн учрыг тодруулах нь төрөөс сургууль завсардалтыг бууруулах арга замыг тодорхойлох үндэс болно гэж үзэж байна. 2000 оны хүн амын тооллогоор 8-15 насны 502.7 мянган хүүхэд байгаагаас ЕБС-д 433.8 мянга, техникийн болон мэргэжлийн сургууль 1,0 мянга, их сургууль, коллежид 84 мянга гаруй хүүхэд залуус суралцаж байна.

Сургууль хамрагдалтын хувь 13.5 буюу суурь боловсрол эзэмших насанд 27,2%-иар буурсны дотор эрэгтэй хүүхдүүд илүү завсардсан нь анхаарал татаж байна. Бүрэн бус дунд боловсролыг бүх нийтэйн албан ёсоор эзэмших ёстой хэдий ч улсын хэмжээнд 2000 оны эхний байдлаар 8-15 насны 68,2 мянган хүүхэд сургууль суралцаагүйн 42,1 мянга буюу 61,7 % нь хөвгүүд, 26,1 мянга буюу 38,3% нь охид байна. /2000 оны Хүн ам орон сууцны тооллого. УСГ. 2001 он, 78 дахь тал/

4.3.4. Мэргэжлийн анхан дунд шатны сургууль

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхэлснээс хойш үйлдвэр, аж ахуйн газрыг төвлөрсөн жүрмаар хангагдаг мэргэжлийн анхан, дунд шатны боловсролыг задалж, шинэ нөхцөлд зохицуулах хэрэгтэй болсон юм. 1989 онд 31494 хүүхэд энэ салбарт суралцаж байсан бол 1994 онд 7555 болтол буурсан нь энэ хувьслын туйл байв. 2000-2001 оны хичээлийн жилд төрийн өмчийн 32, хувийн өмчийн 4 мэргэжлийн анхан, дунд шатны сургуульд 12177 хүн суралцаж байгаа нь хамгийн их бууралтад хүрсэн 1994 онтой харьцуулахад суралцагчдын тоо 3870-аар нэмэгджээ.

2000 оны байдлаар бүрэн дунд боловсролын сургуульд нийт 16-17 насны хүүхдүүдийн 45.8%, мэргэжлийн анхан шатны сургуульд 11.4% нь хамрагдаж, 42,8% нь албан боловсролын системд хамрагдахгүй үлдэж буй өнөө үед өөртөө болон улс, хувийн салбарт ажиллах үйлдвэр үйлчилгээний "багa" мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх асуудал хурцаар тавигдаж байна. Гэтэл иргэд дээд боловсролыг хэт ихээр шүтэх болсон нь сөрөг нөлөөтэй байна. Энэ салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, ажилгүйчүүдийн боловсролын байдлыг судлахад 59.5% нь мэргэжилгүй гэсэн дүн гарсан нь МСҮТд мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх шаардлага зайлшгүй байгаар харуулжээ. Одоо сургуулиудын тоног төхөөрөмжийг сайжруулж, багш, боловсон хүчний мэргэжлийн үр чадварыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, стандартыг зах зээлийн нөхцөлд тохируулан эрчимтэй өөрчлөх зорилт тулгарч байна. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх, тусалж дэмжих болсон нь шинэчлэлт, өөрчлөлтөд чухал түлхэц өгч байна.

4.3.5. Дээд боловсрол

Иргэдийн сурч боловсрох эрхийг хамгаалах тогтолцоонд чухал үүрэгтэй дээд боловсролын тухай хуулиар энэ асуудлыг зохицуулж байна. Үг хуулиар дээд боловсролыг кредит цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн зэрэглэлтэй болгожээ. Монгол улсад 2000 оны байдлаар 172 Их сургууль, коллежид 84797 оюутан суралцаж байна. Үүнээс 53690 буюу 63.2% нь эмэгтэйчүүд байна.

Оюутан эзлэх бохир хувь

Он	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Суралцагчид	31434	28209	25225	28084	32774	38361	44088	50961	65272	74025
Эм	19209	17901	16760	19089	22751	26793	30512	31782	42380	47248
Эр	12225	10308	8465	8995	10023	11568	13576	16179	22892	26777
Сургуульд хамрагдалтын хувь	16.1	13.2	10.9	12.2	14.3	16.3	18.6	21.5	26.4	29.1
Эм	19	16.4	14.3	16.2	19.1	22.4	25.5	28.2	33.1	36
Эр	12.9	9.8	7.4	8	9.1	10	11.6	14.2	19.2	21.7

/УСГ, 2000 он, БСШУЯ-ны статистик, 2001 он/

Оюутнуудыг боловсролын түвшингээр нь үзвэл дипломын сургалтанд хамрагдах оюутны тоо 1990 оноос эрс буурч, 1993 оноос тогтворжиж байна. Бакалаврын сургалтанд байгаа оюутны тоо 1990 оноос өсөж эхэлсэн, харин магистр ба түүнээс дээш шатны сургалтанд хамрагдах оюутны тоонд огцом өөрчлөлт байхгүй.

4.3.6 Төрийн өмчийн бус хувийн дээд сургууль

Манай улсад хувийн 134 их, дээд сургууль, коллежид 28064 оюутан суралцаж байна. Тэдгээрт сургуулийн мэргэжлийн баримжаат харахад бизнесийн удирдлага, хууль зүй, хүмүүнлэгийн ухаан, нийгэм эдийн засгийн ухаан, багш сурган хүмүүжүүлэх ухаан гэсэн чиглэлээр 83.5% нь суралцаж байна. Эдгээр мэргэжлийн сургууль өсч байгаа нь сургалтын өөрийн өртөг багатай учраас ашиг ихтэй байдагтай холбоотой бололтой. Гэтэл техник, технологи, баялаг, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт хувийн сургууль ховор ердөө л 16.5% нь суралцаж байна.

Хувийн сургуулиудаас денгеж 9 нь магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан нь хувийн сургуулийн чанарыг илэрхийлж байна. Магадлан итгэмжлэл авааг сургуулиудын оюутан төрийн санхүүгийн эзэлтэй хамагдах "эрхүү" үчир, тус сургуульд суралцаж байгаа оюутнуудын хууль ёсны ашиг сонирхол нь хохирч байна.

4.3.7 Сургалтын төлбөр

1990-ээд оноос их, дээд сургууль, коллеж төлбөртэй сургалтын системд орсон билээ. Гэвч төрөөс сургалтын төлбөрөө төлөх чадваргүй иргэдэд сурах боломж олгох зорилгоор сургалтын сан байгуулж, БСШУЯ-ны нэгэн агентлагт хариуцуулж, өнөөгийн байдлаар энэ сангаас:

Хөнгөлттэй зээл

Буцалтгүй тусламж

Сургалтын төлбөрийн шагнал тус тус олгож байна. Үүнийг зөвхөн магадлан итгэмжлэгдсэн сургуулийн оюутанд дараахь жүрмаар олгодог байна. Үүнд

Нэн ядуу (бүсийн амьжиргааны түвшингийн 60%-иас доогуур орлоготой ерх)

Малчин (богд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай малчин ерх) 3.6а

түүнээс дээш хүүхэд их сургууль, коллежид зэрэг сурч байгаа бол магадлан итгэмжлэгдсэн сургуулийн өдрийн ангид суралцаж байгаа нэг сурагчид нь тус тус олгоно.

Шатлалд төрийн албан хаагчийн гэр бүлээс их сургууль, коллежийн

дипломын болон бакалаврын өдрийн ангид элсэн суралцаж байгаа нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даадаг.

Манай улсад хувийн 150 их сургууль, коллеж магадлан итгэмжлэлгүй учир оюутнууд нь төрөөс ямар нэгэн эзэл, тусламж авч чадахгүй хоцорч байна. Энэ нь ямар нэг байдлаар ялгаварласан, тэгш эрхийн зарчмыг зөрчсөн явдал гэж болно.

4.3.9. Гадаадын их, дээд сургуульд суралцач оюутнууд Монгол Улс нээлттэй гадаад бодлого явуулах болсноор монголчуудад социалист орнуудын хүрээнээс гадагшилж, хувийн, төрийн, олон улсын санхүүжилтэрэн дэлхийн өнцөг булан бүрт суралцах болсон. 2000 оны байдлаар нийт 24 улсын аспирантур, докторантурт 345 хүн суралцаж байна.

ДҮГНЭЛТ

Төр засаг, төв орон нутгийн байгууллагуудын болон албан тушаалтны үйл ажиллагаанд хууль ёсыг хэлбэрэлтгүй биелүүлдэг байх, хүний эрхийн аливаа асуудалд түйлын анхааралтай, хүндэтгэлтэй хандах зарчим, чиглэлийг баримтлах нь юу юунаас тулгамдсан асуудал болж байна.

Засаг, төр, албан тушаалтны үйл ажиллагаа нь бүхэлдээ хүний төлөө, эрхийг нь баталгаатай ханган нөхцөл бололцоог бий болгоход чиглэгдэж байх нь Үндсэн хуулийн чухал зарчим. Үндсэн хуулийн энэхүү өндөр шаардлагын хүрээнд авч үзвэл төрөөс иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ ханган биелүүлж байгааг илтгэлийн бараг бүх бүлэг, хэсгээс харж болно.

1. Ялангуяа хүний халдашгүй эрхийн өнөөгийн бодит байдал, тэнд орших бүй

нөцтой зөрчил дутагдал нь Монгол дахь хүний эрхийн хамгийн хурц асуудал болж байна. Хэдийгээр энэ салбарт хууль бус ажиллагаа, дураараа авирлах явдал, эрх мэдлээ хэтрүүлэн хүний эрхийг зөрчдөг талаар удирдлагын аль ч түвшинд ханган талаар мэдээ, мэдээлэл байдаг боловч гэм бүрүүтнуудад хариуцлага хүлээлгэх, хүний эрх , эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг тэр бүр хэрэгжихгүй байна.

Хуулийн үндэслэлгүйгээр саатуулагдсан, хоригдсон иргэд жил тутамд хэдэн зуугаар тоологдож, урьдчилан хорих байранд иргэдийг биеийн болон оюун сананы дарамт хүчирхийлэл оруулж, хилсээр хэрэг тулган хүлээлгэдэг, хоригдогдоор бие бие нийгэмд нь зодуулдаг, хорих байр, ерөө тасалгаа нь хуулийн шаардлага хангадаггүй, хүний эрүүл мэнд, амь насанд аюултай өөрчин, эмгэгийг нехцелдүүлж амь насыг хохироодог зэрэг нь алин эрт олон нийтэд ил тод болсон боловч эдгээрийг өөрчлөх талаар бодитой арга хэмжээ авагдахгүй, ам дамжин яригдсаар, үжигран даамжирсаар байна.

2. Улс төрийн эрхийн салбарт хүний эрхийн баталгаа, эрх зүйн зохицуулалт

олон улсын нийтлэг баримт бичгүүдийн түвшинд хүрьчлагдсан. Улс төрийн эрхийн хүрээн дэх хүний эрхийн зөрчил нь нэг талаас иргэд эрхээ мэдэж хуулиа хүндлэх, ниймийн идэвхи санаачилгаас нөгөө талаас хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаа. төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын дутагдлаас шалтгаалан гарч байна.

Төрийн захиргааны албан тушаалтныг намын харьяаллаар ялгаварлах, олноор нь ажлаас халдаг явдал уламжлал болон тогтох чиг хандлагатай байна. Улмаар энэ нь үйлчилгээний албан тушаалтны хүрээнд орж эхэлжээ.

Эдийн засгийн эрхийн хүрээнд хувийн өмчтэй болох, ээлжиих, захиран зарцуулах эрх нээлттэй байна боловч хувираа аж ахуй эрхлэх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад

төрийн байгуулагын зүгээс хүнд суртал, чирэгдэл ихтэй, зөвшөөрлийн тогтолцоог журамласан хууль гарсан боловч түүгай зөвшөөрлийн тоо тедийлэн бууралгүй байна.

Иргэнд газар өмчлүүлж болох тухай заалт Үндсэн хуульд байгаа хэдий ч энэ тухай хууль гараагүй, зөвшөөрлийн олон шат дамжлага бүхий тогтолцоо бий болсон.

Аж ахуй эрхлэхэд гааль, татварын дарамт их байгаа талаар иргэдийн гомдол, шүүмжлэл их гарч байна.

Нийгмийн үйлчилгээний эдийн засгийн бааз бэжээгүй, хөрөнгийн нөөц дутагдах болсон нь иргэдийн нийгэм, соёлын эрхийг ханган баталгаажуулахад бэрхшээл учруулж байна. Төсвийн хүндэлээсс шалтгаалан зарим иргэд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн эрхээ эдлэхгүй хохирох явдал байна.

Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт хүртэмжгүй, хөдөлмөрлөгч холбогдсон эрхийн зөрчил түгээмэл, хүмүүсийн авч буй цалин хөлс амьдралд хүрэлцэхгүй байгаа нь "ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргаг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц ... хөлс авах эрхтэй" гэсэн Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын заалтыг зөрчиж байна.

3. Хүний эрхийг баталгаатай хангах, албан тушаалтны үйл ажиллагаанд дур зоргын зан авир, араншинг хязгаарлахад хуулийн боловсруулалтын түвшинг сайжруулах, хуулийн хийдэл, давхардлаас зайлсхийх нь чухал ач холбогдолтой байна.

Бусдыг баривчлах, албадан саатуулах, орон байранд нь нэвтрэн орох, нэгжих эрх дархыг есөн хуулиар янз бүрийн ажил мэргэжлийн албан тушаалтнуудад олгосон байж жишээтэй.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг дотоодын хууль тогтоомжид туссан, хэрэгжих тодорхой механизмыг нарийвчлан тогтоохгүй байх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын зориптыг хувь хүний эрх, эрх чөлөөтэй тэнцвэртэй авч үзэхгүй нэг тал руу нь хэлбийлгэх нь байна. Хүний эрхэд халдах, көндөх хүрээ заагаг, үндэслэлийг зөвхөн хуулиар тогтоох асуудалд дутуу хандаж, зарим талаар гүйцэтгэх байгууллагын эрх, үзэмжийн асуудал болгон орхигдуулдгаас Үндсэн хуулийн үзэл санаанд харшилсан хэм хэмжээ, тогтоол шийдвэр гарч мөрдөгдөх явдал байна.

4. Төрийн захиргааны байгуулагуудын үйл ажиллагаа нь иргэнд үйлчлэх үйлчилгээний чиг үүргээсээ захиран тушаах, албадах хандлагад автагдсанаас тэнд хүнд суртал, чирэгдэл, эрх мэдлээ хэтрүүлэх, хууль зөрчих эзгүйгээ хүний эрх зөрчих үзэгдэл нийтлэг ажиглагдаж байна.

Төрийн захиргааны ажилтан, албан тушаалтнуудын хууль зөрчих, хүний эрхийн мэдлэг боловсрол туйлын хангалттүй байгааг судалгааны дүн харуулж байна. Иймэ байдлын улмаас үндэслэлгүй тушаал, шийдвэр гаргах, дураараа авирлах явдал их гарч байна.

Сүүлийн үед байгуулагын удирдлага өөрчлөгдөхөд шинэ дарга нар "бүтцийн өөрчлөлт", "бага бүрдүүлэх" нэрийн дор байгуулагынхаа бүх ажилтнуудыг нэг тушаалаар ажлаас нь халж, эргүүлэн түүвэрлэж ажилд томилдог "журам" хэвшиж тогтох хандлагатай болж байна. Тухайн албан байгуулага, ажлын байр, төсөв цалин нь байсаар байхад ингэж байгаа нь хуулийг бүдүүлгээр зөрчиж, дураараа авирлаж буйн баримт юм.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААБТ	Албан бус боловсролын төв
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
ДБХЯ	Дэд бүтцийн хөгжлийн яам
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДШСГ	Дулааны шугам сүлжээний газар
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НХХЯ	Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн яам
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгуулагга
ОСНААГ	Орон сууц нийтийн аж ахуйн газар
ТББ	Төрийн бус байгуулагга
ТҮЦ	Түргэн үйлчилгээний газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ХТҮХ	Хүүхдийн төлөө үндэсний хороо
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХЭА	Хөдөлмөр зохицуулалтын алба
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШБЕГ	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
УИХ	Улсын Их Хурал
УСАГ	Ус суваг ашигалтын газар
УДШ	Улсын Дээд шүүх
ЭМНХЯ	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам
ЭХ	Эрүүгийн хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 6.5 ☎ 329487





ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 39 (276)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Конвенцид нэгдэн орох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Мөрдөн байцаах албаны орон тоо, төсвийн тухай*
- *Шарын гол сум болон "Шарын гол" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ:

- *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх журмын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны аравдугаар сарын 23 №39 (276)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

533. Конвенцид нэгдэн орох тухай (2002-10-11-ний хуулЬ) 1247
534. Конвенцид нэгдэн орох тухай (2002-10-11-ний хуулЬ) 1248
535. Конвенцид нэгдэн орох тухай (2002-10-11-ний хуулЬ) 1248

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

536. Намсрайн Очирбатад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 134 1248
537. Мөнхдоржийн Чимидэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 135 1248
538. Дайчаагийн Доржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 136 1248
539. Ойдовын Лхагвад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 137 1249
540. Гомбосүрэнгийн Батмөнхөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 138 1249
541. Намжилын Дававцэрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 139 1249

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

542. Мөрдөн байцаах албаны орон тоо, төсвийн тухай Дугаар 179 1249
543. Шарын гол сум болон "Шарын гол" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 180 1250
544. Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 181 1251
545. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 182 1253
546. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 183 1269

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

547. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх журмын тухай Дугаар 275 1269

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Конвенцид нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оруулахаас сэргийлэх тухай, Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай нэмэлт Протоколуудад Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас Брюссель хотноо 1969 онд батлсан Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас Лондон хотноо 1966 онд батлсан Даацын тэмдэглээний тухай олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр — Дугаар 134 — **Улаанбаатар хот**

Намсрайн Очирбатад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Үүл уурхайн салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллан мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшиж, техникийн найдвартай ажиллагаатай ханган шинийг сэдэж үйлдвэрлэлд нэвтрүүлэн, нүүрс олборлох даалгаврыг тогтмол давуулан биелүүлж ирсэн хөдөлмөр бүтээлийг нь үнэлэн Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн экскаваторын машинч Намсрайн Очирбатад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр — Дугаар 135 — **Улаанбаатар хот**

Мөнхдоржийн Чимидэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж,манай улсын томоохон цахилгаан станцууд, өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугам сүлжээг барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх, эрчим хүчний хэвийн ажиллагаат хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн Эрчим хүчний удирдах газрын ажилтан Мөнхдоржийн Чимидэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр — Дугаар 136 — **Улаанбаатар хот**

Дайчаагийн Доржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

МУИС-ийн багш, декан, хичээлийн эрхлэгч, орлогч захирал, захирлаар олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж сургалт, судалгааны ажлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож шинэчлэх, химийн шинжлэх ухааны мэргэжилтэн бэлтгэх, залуу үеийг сургаж хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн химийн факультетын декан Дайчаагийн Доржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 137 Улаанбаатар хот

Ойдовын Лхагвад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухаан, боловсролын салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, өндөр боловсролтой мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, эрдэм судлалын шинэ чиглэлийг хөгжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Физик-электроникийн сургуулийн багш Ойдовын Лхагвад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 138 Улаанбаатар хот

Гомбосүрэнгийн Батмөнхөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

АУИС-д багш, тэхмийн эрхлэгч, декан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, сурах бичиг, судалгааны бүтээлүүд туурвиж, сургалтын агуулга арга зүйг боловсронгуй болгох, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн АУИС-ийн физиологийн тэнхмийн тэргүүлэх багш Гомбосүрэнгийн Батмөнхөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 139 Улаанбаатар хот

Намжилын Даваацэрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэнд, боловсролын салбарт он удаан жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, эмч, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэс заслын эмчилгээний дэвшилтэт арга барилыг чадамгай эзэмшин олон хүнийг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АУИС-ийн мэс заслын тэнхмийн багш, Улсын клиникийн төв эмнэлгийн зөвлөх эмч Намжилын Даваацэрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 179 Улаанбаатар хот

Мөрдөн байцаах албаны орон тоо, төсвийн тухай

"Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2002 оны 47 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын дэрэгэд мөрдөн байцаах албаа байгуулах болсонтой холбогдуулан тус албанд ажиллах 26 мөрдөн байцаагч, жолооч, бичээчийн орон тоог холбогдох төсвийн хамт Цагдаагийн ерөнхий газраас Улсын ерөнхий прокурорын мэдэлд зохих журмын дагуу шилжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын дэрэгэдэх мөрдөн байцаах албыг 2002 оны 10 дугаар сард багтаан ажлын байраар хангах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №39 (276)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Дугаар 180 Улаанбаатар хот

Шарын гол сум болон "Шарын гол" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Шарын гол" ХК-ийн дулааны станц, ус хангамжийн худаг, ус хуримтлуулах сангууд, цэвэрлэх байгууламж, тэдгээрийн дагалдах шугам сүлжээ, мах, ногооны зоорь зэрэг 2648,0 (хоёр тэрбум зургаан зуун дөчин найман сая) сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Шарын гол сумын орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд, Дархан-Уул аймгийн Засаг дарга Д.Хаянхярваа нарт даалгасугай.

2. Шарын гол сумын дулааны станц, шугам сүлжээг засварлах, шинэчлэх, цэвэр усны эх үүсвэрийг сайжруулах төсөл боловсруулан 2003 оноос аймгийн төсвийн санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дархан-уул аймгийн Засаг дарга Д.Хаянхярваа нарт даалгасугай.

3. Уулын ажлын технологийн зориулалтаар "Шарын гол" ХК-ийн ашиглаагүй талбайг нөхөн сэргээхэд шаардагдах тоног төхөөрөмж авах хөрөнгийн эх үүсвэрийн талаар олон улсын байгууллага, хандивлагч орнуудад санал тавьж шийдвэрлүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболд, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

4. "Шарын гол" ХК-ийн үйл ажиллагаагаа санхүүгийн хувьд дэмжих зорилгоор Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг "Тусламжийн орлогын сан"-д төлөлгүүлэх хугацааг 10 жилээр сунгах боломжийг судлан, шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт зөвшөөрсүгэй.

5. "Шарын гол" ХК-ийн хөрс хуулалтыг эрчимтэй явуулж, нүүрс гаргалтын хэмжээг өнөөгийн түвшингээс бууруулахгүй байхад зайлшгүй шаардагдатай тоног төхөөрөмж авах болон ажиллах байгаа тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор компанийн хөрөнгөөр барьцаалан үнэт цаас гарган зах зээлд борлуулах боломжийг судалж хэрэгжүүлэхэд арга зүй, мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/ болон Үнэт цаасны хороо / С.ГҮНДЭНБАЛ/-нд тус тус үүрэг болгосугай.

6. Шарын гол суманд нэгэнт бий болсон дэд бүтэц, ажиллах хүчний нөөцийг цаашид үр дүнтэй ашиглаж, Дархан, Эрдэнэтийн бус нутгийн нүүрсний хангамжийг сайжруулахын тулд уурхайн орчимд хийх нүүрс болон бусад ашигт малтмалын эрэл, үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг 2003-2004 оны улсын төсвийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгасугай.

7. "Шарын гол" ХК-ийн үүл, геологийн нөхцөл хүндэрч үйлдвэрлэлийн хэмжээ буурч байгаатай холбогдуулан хийх бүтээц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдөх ажилтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж олгох, мэргэжлийн дагуу ажлын байраар хангах, шинээр мэргэжил эзэмшүүлэх болон давтан сургах, сумын дэд бүтцийг түшиглүүлэн ажлын байр шинээр бий болгох зэрэг арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Дархан-Уул аймгийн Засаг дарга Д.Хаянхярваа нарт тус тус үүрэг болгосугай.

8. "Шарын гол" ХК-ийн зарим нэгжийг бие даасан салбар компани болгон өөрчлөн зохион байгуулах асуудлыг зохих журмын дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх, компанийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах арга хэмжээ авч, компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах талаар санал боловсруулж 2003 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг Төрийн өмчийн хороо / Л.ПҮРЭВДОРЖ/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Дугаар 181 Улаанбаатар хот

Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Мал өвөлжилтийн төлөв байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Улсын Шүүхийн онцгой комиссоос урьдчилан гаргасан дүгнэлт, мэдээллийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бэлчээрийн гарц, усан хангамж, газар нутгийн онцлогийг харгалзан мал оторлох бүс нутгийг сонгон жил бүрийн 9 дүгээр сарын 1-нд зураглал гаргасан байх, мал сүргийг оторлон өвөлжүүлэх талаар аймаг, сумын удирдлага 10 дугаар сарын 1-ний дотор гэрээ хийж бэлчээрээ зохицуулсан байх, өвөлжилтөд бэлтгэж нэмж засварлах хугацаа, уст цэгийн зураглалыг 9 дүгээр сарын 1-нд хийж засварын ажлыг чанар сайтай гүйцэтгүүлж 11 дүгээр сарын 1-нд хүлээн авсан байхаар тогтоосугай.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох нь:

а/отрын нутагт өвөлжүүлэх мал, өрхийн тоог нарийвчлан тогтоох, отрын түр штаб байгуулах, хүн, мал эмнэлэг, хүнс, өргөн хэрэглээний барааны үйлчилгээний цэгийг ажиллуулах, зам, даваа хаагдахаас өмнө өвс, тэжээлийн нөөцийг байршуулах, отор, нүүдлийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор багтаан зохион байгуулах арга хэмжээ авч байсугай;

б/хадлан, гар тэжээл (халтар хомоол, таана, хөмүүл, халгай, тарваганы ходоод гэх мэт) бэлтгэх, хашаа хороо, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, худаг засварлах ажилд иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хүчийг чиглүүлж 9 дүгээр сарын 1-нээс эхлэн 2 сарын зохистой ажил өрнүүлж ажилласугай;

в/малыг оторлон өвөлжүүлэх, ялангуяа адуу алсын оторт гаргахад нэг дор олон мал бөөгнөрч туурайн зуд болохоос сэргийлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;

г/аймаг дундын отрын бүс нутгийг тодорхой хуваарьтайгаар хамтран ашиглах, хашаа, худгийг шинээр нэмж барих, засч тохижуулах болон өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг холбогдох аймгийн удирдлагууд хамтран шийдвэрлэж байсугай;

д/хэт хуурайшилтын улмаас ой, хээрийн түймэр гарч ой, хадлан, бэлчээрийг сүйтгэж болзошгүй байгаа тул харуул, хамгаалалтыг өндөржүүлж, түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, нэгэнт гарсан түймрийг шуурхай унтраахад бүхий л анхаарал хүчийг төвлөрүүлэн ажилласугай.

3. Энэ жил нийт нутгийн 70 гаруй хувь гантай буюу гандуу байгаатай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь:

а/өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй аймаг дахь улсын нөөцийн цэг, салбарт байх өвс, тэжээлийн тоо хэмжээг 50 хувиар нэмэгдүүлж, оновчтой байршуулах ажлыг энэ оны 11 дүгээр сард багтаан зохион байгуулсугай;

б/гантай буюу гандуу нутаг бүхий аймгаас мал, мах бэлтгэж дотоодын зах зээлд нийлүүлэх, малын гоц халдварт өвчин гараагүй бүс нутгуудаас мах экспортлоход дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажилласугай;

в/"Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг үнэлж дүгнэх арга хэмжээ авсугай.

4. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Говь-Алтай, Баянхонгор аймгийн хилийн заагт орших Аргалант орчмын 118.6 мянган га газар нутгийг аймаг дундын

отрын нутаг болгохоор тогтоож, хилийн заагийг нь хавсралт ёсоор батлсугай.

5. Аргалантын аймаг дундын отрын нутгийг хөгжүүлэх, зохистой ашиглах, хамгаалах болон бусад асуудлыг Говь-Алтай аймгийн Засаг дарга хариуцан зохион байгуулж зохицуулж байхаар тогтоосугай.

6. Говь-Алтай аймгийн Засаг дарга Н.Жанчивдоржид даалгах нь:

а/отрын нутгийг ашиглах журмыг батлан гаргаж, захиргааны үйл ажиллагааг нь эхлүүлэх, шаардлагатай худаг, уст цэг, хашаа хороог засварлах, өвс, тэжээл нөөцлөх арга хэмжээг 2002 онд багтаан авсугай;

б/отрын нутгийг хөгжүүлэх арга хэмжээг 2003 оноос эхлэн төлөвлөгөө, тодорхой төслийн үндсэн дээр хэрэгжүүлсүгэй.

7. Энэ тогтоолын 3 дугаар зүйлийн "а" заалтыг хэрэгжүүлэх, өвс, тэжээлийг орон нутагт тээвэрлэн байршуулахад зориулж төсөвт тусгагдсан 1000.0 (нэг тэрбум) сая төгрөгийг энэ оны 9, 10 дугаар сард багтаан олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

8. Отрын бүс нутагт инженерийн хийцтэй худаг засварлах, шинээр барихад шаардагдах 116.5 (нэг зуун арван зургаан сая таван зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

9. Өнгөрсөн онд "Хадлан, тэжээл-2001" төслийн хүрээнд төсөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон 1050.0 /нэг тэрбум тавин/ сая төгрөгийн бүцаан төлөх хугацааг сунгаж, уг хөрөнгийг мал өвөлжилтийн бэлтгэлд түр хугацаагаар ашиглуулж 2003 онд нөхөн төлүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

10. Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Хүрхрэгийн услалтын системийн толгойн барилга, сувгийн их засвар, суваг болон талбайг элсний нүүдлээс хамгаалах, Алтайн хөх арвайн сорт тариалах, хадлангийн талбайг өргөтгөх зэрэг төслийг хэрэгжүүлэхэд зориулж эргэн төлөгдөх нөхцөлөөр 20.0 (хорин) сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Засаг даргын мэдэлд 2 жилийн хугацаагаар олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч, энэ хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

11. Хөрөнгийнх нь эх үүсвэрийг 2003 оноос эхлэн төвлөрсөн төсөвт тусгах замаар үүлэнд нөлөөлж зориудаар хур тунадас оруулах пуужингийн нөөцтэй болох, тэдгээрийг жил тутам нөхөн сэлбэж байхыг Батлан хамгаалахын сайд, Улсын байгуулын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, зориудаар хур тунадас оруулах талаар дэлхийн улс орнуудад хэрэглэж байгаа тэргүүний техник, технологийг судалж нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд нарт тус тус даалгасугай.

12. Ган, зуд зэрэг байгалийн гамшиг олон жил дараалан болсноос мал аж ахуй, газар тариаланд учирсан хохирлыг нөхөх, цаашид урьдчилан сэргийлэхэд дэмжлэг, туслалцаа авах талаар гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой судалгаа бүхий санал тавьж ажиллахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

13. Мал өвөлжүүлж, хаваржуулах зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, цагийн байдал хүндэрсэн үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байгуулын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

14. Тусгай хамгаалалтын болон хилийн эрэвээ газарт мал оторлон өвөлжүүлэх асуудлыг судалж энэ оны 11 дүгээр сарын 15-ны дотор багтаан зохицуулалт хийхийг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 181 дүгээр тогтоолын хавсралт

АРГАЛАНТЫН АЙМАГ ДУНДЫН ОТРЫН НУТГИЙН ХИЛИЙН ЗААГ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын нутагт орших 1881.0 тоот өндөрлөг, түүнээс зүүн урагш Говь-Алтай, Баянхонгор аймгийн хилийн зааг дахь Холбоо нуурын баруун дэнж дээр орших 1 тоот шон, түүнээсэх зүүн урагш Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын нутагт орших 1861.0, 1932.0, 1943.0 тоот өндөрлөгүүд, Бууцагаан сумын нутагт орших 1865.0, 1873.0, 1844.0, 1784.0, 1740.2 тоот өндөрлөгүүд, Мухарын хойд нурууны урдуур гарч Бууцагаан, Баянцагаан сумын хилийн зааг дахь 1495.0 тоотоос зүүн тийш 65 км-т орших 2 тоот шон, уг шонгоос баруун урагш хоёр аймгийн хилийн заагт орших Улаан шалын хоолойн модны овоо (1495.0), Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших 1513.6, 1543.6 тоот өндөрлөгүүд, 1543.6 тоотоос зүүн хойш орших 1605.0 тоот өндөрлөг, түүнээс баруун хойш орших Эрүү хайрхан (1772.2), Хар-Овоо (1798.1), түүнээс хойш Эрдэнэ сумын нутагт орших 1881.0 тоот өндөрлөг.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Дугаар 182 Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үс, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор, "Үс, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөрийн эхний шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд хамруулж зохицуулан шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2002 оны 182 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮС, ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ 2015 ОН ХҮРТЭЛХ ХУГАЦААНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Оршил

Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль-цаг уурын тааламжтай нөхцөл, боломжийг аж ахуйг эрхлэн хөтлөхөд бүрэн дүүрэн ашиглах, байгаль-цаг уурын болзошгүй аюул гамшгаас хүний амь нас, эд хөрөнгийг сэрэмжлүүлэн хамгаалах, улмаар XXI зууны улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх явдал энэхүү хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийн эрхэм зорилго мөн.

Үс, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбар (цаашид "салбар" гэх)-ыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжих хугацааны стратегийн зорилго нь монгол орны уур амьсгал, усны нөөц, түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол, орчны бохирдолд байгсын хяналт-шинжилгээ хийх, цаг агаарын төлөв байдлыг урьдчилан тодорхойлох (прогнозлох), шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилд тулгуурлан агаар мандлын үзэгдэл явцад зориуд нөлөөлөх арга технологи нэвтрүүлэх ажлын үндэс суурийг бэхжүүлэх замаар үндэсний үс, цаг уурын албаны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

Монгол орны эдийн засаг, нийгмийг үс, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллээр ханган улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, байгаль-цаг агаарын аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийн чанарыг дээшлүүлэх, салбарын хэмжээнд шинжлэх ухаан-технологийн дэвшлийг нэвтрүүлж, олон улсын хамтын нийгэмлэгээс тавьж байгаа шаардлагад

нийцүүлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах урт, дунд хугацааны бодлого, чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох нь энэ хөтөлбөрийн гол зорилт болж байна.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улам бүр хөвиран өөрчлөгдөж байгаа байгаль орчин, үүр ашгсгал, усны нөөцийг нийгмийн хэрэгцээнд зүй зохистой ашиглах, хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний дотор орны бохирдлыг бууруулах шинжлэх ухааны үндэслэлийг дэшлүүлэх боломж бүрдэж, байгаль-цаг агаарын аюул, гамшгаас сэргийлэх мэдээллийн чанар эрс дээшлэн салбарын шинжлэх ухаан-технологийн хөгжил Дэлхийн цаг үеэс буцаж байгуулага (ДЦУБ)-ын гишүүн орнуудын дундаж түвшинд хүрэх болно.

Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь дараах нөхцөл, байдлаас урган гарч байна:

1.1. Бэлчээрийн мал аж ахуй, усалгаагүй газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрлэл зонхилсон Монгол Улсын эдийн засгийн хөгжил байгаль-цаг агаарын эрхшээлд орсоор байна.

1.2. Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр дэлхийн уур амьсгал дулаарч байгаа өнөөгийн хандлага XXI зуунд улам эрчимжиж, шинэ зууны дунд үе гэхэд монгол орны жилийн дундаж агаарын температур одоогийнхоос 1.8-2.8 хэмээр, үүнээс өвлийн саруудад 1.4-3.6 хэмээр дулаарах төлөвтэй байна. Уур амьсгалын өөрчлөлтийг дагаад ландшафт, хөрс, ургамлын бүтцэд өөрчлөлт гарч болзошгүй, хээрийн бүс хойд зүг рүү түрэх магадлал их эсэх байна.

1.3. Агаар мандлын үзэгдэл, явцтай холбоотой байгалийн гамшгийн улмаас улс орондоо учирдаг хохирлын хэмжээ зарим жил дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувьд хүрдгийн дотор ган, зуд, байгалийн бусад аюулын улмаас хүний амь бие болон, олон сая толгой мал хорогдох явдал жил бүр нэмэгдэж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөн дор агаар мандлын гаралтай байгалийн аюул, гамшгийн давтагдал нэмэгдэх хандлагатай байгаагийн дээр өвөл бороо, зун цас орох, хэт халуун цаг агаар удаан хугацаагаар үргэлжлэх зэрэг мэт урьд өмнө нь тэр бүр ажиглагддаггүй байсан үзэгдэл цөөнгүй тохиолдох бололлоо. Уур амьсгалын өөрчлөлттэй уялдан ой, хээрийн түймэр гарах нөхцөл нэмэгдэж байна.

1.4. Ойн нөөцийн хомсдол, хөрс үргамлын бүрхэвчийн доройтолтой холбогдон усны үерийн үргэлжлэх хугацаа богиносч, эрч хүч нь нэмэгдэж, үлп хөрсний усны тэжээл багасч байна.

1.5. Монгол Улсын ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний уснын сүлжээний багаж хэрэгсэл, шинжилгээний арга зүй, технологи дэлхий дахины хөгжилийн өнөөгийн түвшнээс хоцорч хэмжлийн нарийвчлал, чанар, хамрах хүрээгээрээ ДЦУБ, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс тавьж байгаа жишиг шаардлагыг хангаж чадахгүйд хүрээд байгаа бөгөөд газрын гадарга орчмын ажиглалтын цэгийн нягтшил нь дэлхийн стандартаас 3 хувь, аэрологийн хэмжлийн цэгийн нягтшил нь 10 хувиар сийрэг, газрын доорхи усны сүлжээ огт байхгүй байна.

1.6. Монгол орны уур амьсгал, гадаргын усны нөөцийг зах хэзлийн өнөөгийн хэрэгцээ, шаардлагын хэмжээнд хүртэл судлан тогтоож чадаагүй, орчны бохирдол, төлөв байдлын өөрчлөлтийн судалгаа денгеж эхэлж байна.

1.7. Монгол орны байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл, хүн амын суурьшил, нийгэм эдийн засгийн хөгжлийн онцлогоос шалтгаалан Улаанбаатар хотын агаарын бохирдол дэлхийн том хотуудаас ч давж, хүмүүсийн амьдрах орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хэмжээнд хүрээд байна.

1.8. Ус, цаг уурын байгуулагаас нийтийн хэрэгцээнд гаргаж байгаа цаг агаар, усны богино хугацаа (12-24 цаг)-ны урьдчилсан мэдээний чанар нэлээд өндөр үзүүлэлттэй байгаа боловч аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээний чанар 67-70 хувь, зуны хур тундасны урьдчилсан мэдээний чанар 75 хувь орчим байгаа нь улс, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрэлт хэрэгцээг тедийлэн хангаж чадахгүй байна.

Хоёр. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний талаар төрөөс баримтлах бодлого, чиглэл

2.1. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний талаар төрөөс дараахь бодлого, чиглэлийг баримтална:

2.1.1. ус, цаг уур, орчны төлөв байдлын өөрчлөлтийн урьдчилсан болон горимын мэдээ, мэдээллээр улс орны нийгмийн хэрэгцээг хангаж, байгаль-цаг агаарын болзошгүй аюул гамшгаас сэргийлэх, учирч болох хохирлыг багасгах;

2.1.2. байгаль орчны хяналт-шинжилгээг улс орны эрх ашиг, эдийн засгийн үр өгөөжийг нь харгалзан улсын бүх нутаг дэвсгэрийг хамарсан нэгдсэн сүлжээтэй, мэдээлэл дамжуулах, боловсруулах орчин үеийн тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан үндэсний ус, цаг уур, орчны хяналт, мэдээллийн улсын сүлжээн дээр төвлөрүүлэн хийх;

2.1.3. агаар мандалд явагдах физик үзэгдэл, явц нь улс орны хил хязгаараас үл хамаарах шинжчанартай тул үндэсний ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний ажлыг ДЦУБ-аас тавьж байгаа

шаардлагад нийцүүлэн шинжлэх ухаан-технологийн төрүүний ололтод суурилан хөгжүүлэх.

2.2. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний талаар тереес баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.2.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээний тоготлцоог боловсронгуй болгох;

2.2.2. ус, цаг уур, орчны мэдээллийг гадаад, дотоодоос хүлээн авах, дамжуулах үйл ажиллагааг орчин үеийн техник, технологийн түвшинд хүргэх;

2.2.3. ус, цаг уур, орчны мэдээлэл боловсруулах технологийг бүрэн автоматжуулах;

2.2.4. тер засаг, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг ус, цаг уур, орчны үнэн зөв мэдээллээр хангах тогтолцоог бэжжүүлэх, түүний дотор байгаль-цаг агаарын болзошгүй аюул, гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх;

2.2.5. ус, цаг уурын шинжлэх ухааныг хөгжүүлж шинэ, дэвшилтэт арга, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөгжүүлэх;

2.2.6. салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, төв, орон нутгийн байгууллагууд, сүлжээний нэгжүүдийг боловсон хүчнээр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх.

2.3. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээний тоготлцоог боловсронгуй болгох бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.3.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээг ажиллуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2.3.2. агаар, гадаргын болон газрын гүний ус, херс, үргамал, цэвдэгт, шим мандал гэх мэт уур амьсгалын системийн бүрдэл хэсгүүдийн хувьсал, өөрчлөлтэд хийх хяналт-шинжилгээг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээн дээр төвлөрүүлэн хийх;

2.3.3.хяналт-шинжилгээний улсын сүлжээг автоматжуулах, зайнаас тандан судлах, газар-агаар-сансрын гурван түвшний судалгаа хийх чиглэлээр аль болох бага зардлаар бодит, найдвартай үнэн зөв, өндөр нарийвчлалтай мэдээллийг шуурхай хэрэглэх зорилтыг хэрэгжүүлэх;

2.3.4. хяналт-шинжилгээний улсын сүлжээний нэгжийн ажлыг суурин ба хайгуул, туршилт судалгааны аргаар орчны төлөв байдал, өөрчлөлтийг үнэлэх чадвартай байхаар зохион байгуулах;

2.3.5. шинэ, дэвшилтэт арга технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

2.4 Мэдээлэл дамжуулах, хүлээн авах тогтолцоог боловсронгуй болгох бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.4.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний шуурхай мэдээллийг өртөө, харуулаас мэдээлэл боловсруулах үндэсний төв болон аймгийн төвд шууд хүлээн авч шуурхай боловсруулан гадаад, дотоодын олон улсад оруулах;

2.4.2. Монгол Улс өөртөө хэрэгцээтэй ус, цаг уур, орчны болон цөмийн осол, сүйрэл, газар хөдлөлийн тухай зэрэг мэдээллийг ДЦУБ-ын харилцаа холбооны сүлжээний төрөлжсөн бүлэн харьяалах бүсийн төвүүдээс шуурхай хүлээн авах, өөрийн орны мэдээллийг тэдгээр төвүүдэд тухай бүр нь гаргах холбоо, мэдээллийн сүлжээний технологийг боловсронгуй болгох.

2.5. Мэдээлэл боловсруулах тогтолцоог боловсронгуй болгох бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.5.1. ус, цаг уур, орчны мэдээлэл боловсруулалтад өндөр хүчин чадалтай орчин үеийн тооцоолох техник ашиглах, мэдээллийг сүлжээгээр дамжуулах, ус, цаг уур, орчны бүх мэдээллийн санг цахим хадгалуурт шилжүүлэх;

2.5.2. төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллийн төв сан (банк)-гаас шаардлагатай мэдээллээ шуурхай авах боломжийг бүрдүүлэх.

2.6. Ус, цаг уур, орчны мэдээлэл хангалтын тогтолцоог боловсронгуй болгох бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.6.1. уур амьсгал, цаг агаар, усны нөөц, горимын өөрчлөлт, орчны бохирдлын дүн шинжилгээ, урьдчилсан мэдээний чанарын түвшинг дээлхий дахины жишигт хүргэх;

2.6.2. төр засгийн удирдах дээд байгууллагын шийдвэр гаргахад зориулсан мэдээллэл болон нийтийг хамарсан байгаль-цаг агаарын аюул, гамшиг, иргэдийн нийтийн хэрэгцээнд зориулсан мэдээллээс бусад төрлийн ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тусгай хэрэгцээний мэдээллээр аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээ хангах ажлыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн төлбертэй үйлчилгээ хийх зарчимд аажмаар шилжих;

2.6.3. ус, цаг уур, орчны төлөв байдлын мэдээллээр хэрэглэгчдийг хангах ажилд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

2.6.4. радио, телевиз, сонин сэтгүүл, нийтийн мэдээллийн хэрэгслээр ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллийг иргэдэд хүргэхэд тасралтгүй ажиллагаатай холбооны хэрэгсэл ашиглах, байгалийн аюул, гамшигийн мэдээллийг улсын иргэний хамгаалалтын шугамаар дамжуулах тогтолцоог боловсронгуй болгох.

2.7. Салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, төв, орон нутгийн байгууллагууд, сүлжээний нэгжүүдийг боловсон хүчнээр хангах бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

2.7.1. салбарын мэргэжлийн боловсон хүчний чадавхи, мэргэжлийн түвшинг Дэлхийн цаг уурын байгууллагын англилал, стандартад хүргэх;

2.7.2. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль, коллежүүдийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгож, олон улсын шаардлагад нийцүүлэх;

2.7.3. мэргэжлийн болон удирдах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах зохистой системийг боловсруулж мөрдөн ажиллах;

2.7.4. боловсон хүчний тогтвор суурьшил, цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэж, ижил тестэй бусад салбарын түвшинтэйс бууруулахгүй байх зарчим баримтлах.

Гурав. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд

хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний сүлжээний байршил, нягтшлыг үндэсний хөгжлийн үзэл баримтлал, ДЦУБ, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн тавьх бүй стандарт шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх, хэмжилийн нэгдмэл байдал, нарийвчлалыг хангах, үйл ажиллагаат нь автоматжуулах чиглэлээр дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1. цаг уурын харуулын тоог цаашид олшруулахгүйгээр хөтөлбөрийг өргөтгөх цаг уурын өртөө болгон зохион байгуулах замаар нэг өртөөнд хамрагдах газар нутгийн хэмжээг багасгаж улархаг нутагт 100-150 км.дөрвөлжин км, тал хээрийн говийн бүсэд 200-250 км.дөрвөлжин км болгоно;

3.1.2. агаарын дээд давхаргыг радио зондын аргаар судлах аэрологийн ажиглалтын тогтолцоог бэжүүлж, өртөөнүүдийн тоног төхөөрөмжийг 2004 онд багтаан бүрэн шинэчилж, цаашид нэг аэрологийн өртөөнд хамрагдах газар нутгийн хэмжээг багасгах зорилт тавин ажиллана;

3.1.3. нам өндийн салхины орон, хур тунадасны тархалтыг тодорхойлох боломжтой цаг уурын радарын ажиглалтын сүлжээ байгуулах ажлын суурийг тавина;

3.1.4. хот суурин газрыг үерээс хамгаалах зорилгоор Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс, Сэлэнгэ мөрөн, Орхон, Туул, Хэрлэн голын савд тунадас хэмжигч автомат багаж техөөрөмж байрлуулж ажиллуулах ажлыг 2003 оноос хэрэгжүүлж эхэлнэ;

3.1.5. гол мөрөн, нуурын усны ажиглалтын харуулын тоог 2004 онд 150, 2010 онд 200 болгон өргөтгөж, газрын доорхи усны судалгааг 2010 он хүртэлх хугацаанд 60 газарт 200 хүртэл цооногт хийдэг болгож өргөжүүлнэ;

3.1.6. цаг уур, ус судлалын өртөө, харуулуудын хяналт-шинжилгээний хөтөлбөрийг гүнзгийрүүлэн байгаль орчинд гарч байгаа хувирал өөрчлөлтийг судлан тогтооход чиглэсэн ажлыг өргөтгөнө. Мөн газрын гүний ус, мөнх цэвдэг, мөнх цас, мөс болон таримал ба бэлчээрийн ургамал, ойн өвчин, хортон, хөрсний элэгдэл эвдрэл, цөлжилт, хөрсний шим бодисын өөрчлөлт гэх мэт амьд байгальд гарч буй хувьсал өөрчлөлтийн хяналт-шинжилгээг хийнэ. 2004 он, 2005-2010 он, 2010-2015 онд тус бүр нэг мөстөл судлалын өртөө шинээр байгуулна;

3.1.7. ус судлалын хяналт-шинжилгээг усны биологи, усны химийн судалгаатай хослуулан өргөжүүлнэ;

3.1.8. дархан цаазат болон тусгай хамгаалалттай газар, байгалийн нөөц газар нутагт биогеоценозийн өртөөг 2004 оноос эхлэн байгуулж, 2010 онд 10-аас доошгүй судалгааны цэг бүй болгох ба хүнс тэжээл, мал, амьтан, үргамалд хүнд металл, цацраг идэвхт изотоп, ДДТ болон бусад хорт бодисын судалгааг хийж эхэлнэ;

3.1.9. иргэний агаарын тээврийн болон цэргийн зориулалттай нисэх онгоц, нисдэг тэргэнд цаг уурын ажиглалтын автомат төхөөрөмж суурилуулан хэмжилтийн үр дүнг хиймэл дагуулаар дамжуулан цаг уурын үндэсний холбооны төвд хүлээн авах, нислэгийн аюулгүй байдлыг ханган ашиглах, өндөр уулын як сарьдаг, мөстөл мөрөн голд цаг уурын автомат өртөө байгуулах замаар ус, цаг уурын элементийн тухай эх мэдээллийн хэмжээг нэмэгдүүлнэ;

3.1.10. салхи, температурын өндөөс өөрчлөгдөх байдлыг тодорхойлох тоног төхөөрөмж суурилуулан нислэгийн аюулгүй байдлыг ханган ашиглаж эхэлнэ;

3.1.11. ургамал, газар зүйн бүс бүслүүрээр хөрсний чийгшил тодорхойлох шинэ аргыг газар тариалангийн бүс нутгаас эхлэн нэвтрүүлнэ;

3.1.12. нарны хэт ягаан туяа, газар орчмын болон давхраат мандлын озон, агаар мандлын цахилгаан орон, агаарын булингаршил, хүлэмжийн хийн судалгааны цэгийг байгуулж дэлхий дахины сүлжээнд оруулна;

3.1.13. Хур тунадас, үер, цаг агаарын онцгой сонин болон аюултай, гамшигт үзэгдлийн ажиглалт хийдэг сайн дурын ажиглагчтай харуулыг 2004 оноос эхлэн байгуулж эхэлнэ.

3.2. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг ханган, сэлбэг материал, багаж техөөрөмжөөр хангах талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.1. агаарын температур, салхи, чийгшил, цасны зузаан, нягт, хур тунадас, голын усны температур, урсгалын хурд, түвшин хэмжих автомат

багажийг дотооддоо үйлдвэрлэх ажлыг 2004 оноос эхлэн зохион байгуулж агаарын чийгшил, агаар, ус, хөрсний температур, салхины зүг, хурдны хэмжилтийг автоматжуулна. Ус, цаг уурын бүх өртөег 2015 онд багтаан автомат цаг уурын багажаар хангана;

3.2.2. гадаадаас өндөр үнээр авдаг радиозондын шаардлагатай зөв ангийг худалдан авч дотооддоо радиозонд үгсрах туршилтын ажлыг 2004 оноос эхлэн хийнэ;

3.2.3. ус, цаг уур, орчны шинжилгээнд ашигладаг зарим тоног төхөөрөмжийг дотооддоо бөөнөөр үйлдвэрлэх ажлыг 2003 оноос зохион байгуулж, Цаг уурын багаж үйлдвэрлэл-зохион бүтээх товчоог төрийн өмчит үйлдвэрийн газрын хэлбэрээр, Хэмжлийн нэгдмэл байдалд хяналт тавих лабораторийг газрын бүтцэд ажиллахаар зохион байгуулна.

3.3. Мэдээлэл хүлээн авах, дамжуулах тоглолдоо боловсронгуй болгох талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллийг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний суурь мэдээний нэгжүүдээс үндэсний төвд хүлээн авах хугацааг богиносгох арга хэмжээг тухайн нэгжийн ажиллалтын хөтөлбөр, зэрэглэл, мөн Монгол Улсын харилцаа холбооны салбарын технологийн шинэчлэлттэй нягт уялдуулан хийж ажиллалт, хэмжилт хийснээс хойш 5-15 (H+5-15) минутын дотор төвд хүлээн авч 20 (H+20) минутын дотор ДЦУБ-ын бүсийн төвүүдэд гаргах техник зохион байгуулалтын арга хэмжээ авна;

3.3.2. цаг агаарын аюултай үзэгдэл, үер, орчны бохирдол, цацраг идэвхжил, газар хөдлөл, ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчлөл гарсан, үргамлын өвчин, хортон тархсан, химийн хорт бодис алдагдсан тухай мэдээ ("Аюул")-г ус, цаг уурын харилцаа холбооны суурь мэдээний сүлжээгээр дамжуулах ажлыг шуурхай зохион байгуулна;

3.3.3. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний ертөө, харуулд хийсэн хэмжилтийн үр дүнг компьютерээс холбооны сувгаар дамжуулан үндэсний төвд хүлээн авах технологийг 2008-2010 оноос ашиглаж эхэлнэ;

3.3.4. ус, цаг уурын холбооны үндэсний төв, аймгийн төвүүдийн хооронд өндөр хурдаар мэдээлэл солилицох технологи (VSAT систем, TCP/IP протокол)-д шилжих ажлыг 2003-2005 оноос хэрэгжүүлснээр дэлхийн хиймэл дагуулын болон цаг уурын радарын тоон мэдээлэл, цаг агаарын зураг, гадаад, дотоодын мэдээлэл боловсруулах төвүүдэд хийсэн тоон анализ, прогнозын үр дүнг орон нутагт ашиглах боломжийг дэзшлүүлнэ;

3.3.5. цаг уурын холбооны үндэсний төв, ДЦУБ-ын харилцаа холбооны бүсийн төв, мэдээлэл боловсруулах газар зүйн болон төрөлжсэн мэдээллийн төвүүдийн хооронд ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээлэл, түүний дотор цемийн осол сүйрэл, экологийн аюул, газар хөдлөлийн мэдээг 32-64 мянган бит/с хурдтай TCP/IP протоколоор солилцох боломжийг 2005-2010 оны хооронд бүрдүүлнэ.

3.4. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээлэл боловсруулах тоглолдоо боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1. Шуурхай мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг боловсронгуй болгох талаар:

3.4.1.1. ус, цаг уур, хөдөө ах ахуйн цаг уур, орчны бохирдлын анхдагч мэдээллийг таних, шалгах, хуваарилах, боловсруулсан мэдээллийг хадгалах шуурхай мэдээллийн сан (банк), уг сантай харьцан ажиллах хөдөө ах ахуйн цаг уур, орчны бохирдол, цаг агаарын мэдээлэл-прогноз, усны мэдээлэл прогнозын дэд сангуудыг өндөр хүчин чадалтай төв машин, түүнтэй хослон ажиллах компьютер, тусгай зориуллатын өндөр хүчин чадалтай компьютерийн сүлжээн дээр байгуулна. Үүний үр дүнд шуурхай мэдээллийн төв сангаас аймгийн төв, орон нутгийн ус, цаг уурын байгууллага, төр, засгийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хэрэгцээт мэдээллээ шууд авах боломжийг хангана;

3.4.1.2. дэлхийн хиймэл дагуул, цаг уурын радар, нисэх онгоцноос хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээ, ДЦУБ-ын мэдээллийн төвүүдээс авсан цаг агаарын бодит ба ирээдүйн төлөв байдлын мэдээлэл болон экологийн аюул, цацрагийн осол сүйрэл, газар хөдлөлийн тухай мэдээллийг шуурхай мэдээллийн сан нэг сар хадгалагдахаар зохион байгуулна;

3.4.1.3. монгол орны болон бүс нутгийн тухайн улирлын дотрохи уур амьсгал, гадаргын ус, орчны бохирдлын хяналт-шинжилгээ хийх, горимын мэдээллийн сан шуурхай мэдээллийн сангаас үүсгэж ашиглана.

3.4.2. Төв Азийн бүс, монгол орны нутаг дэвсгэр дээрх усны үер, цаг агаарын аюултай, гамшиг үзэгдлийн урьдчилсан мэдээний чанарыг дээшлүүлэх талаар:

3.4.2.1. Төв Азийн бүс нутгийн хэмжээний нутаг дэвсгэр дээр газрын гадаргаас 16 км өндөр хүртэлх үе давхрагын цаг уурын элементийг бодит хугацаанд тодорхойлох тоон анализийн загвар боловсруулна;

3.4.2.2. цаг уурын үндэсн элемент (даралт, геопотенциал өндөр, температур, салхи, чийгшил)-ийг 6, 12, 18, 24, 30, 36, 42, 48, 54, 60 цагийн урьдчилалтай прогнозлох гидродинамик тоон загварыг 2004-2006 онд боловсруулж, цаашид торлосон алхмаас бага хэмжээст процесс, цацрагийн

шилжилт тооцох хилийн үе давхрагын тоон загварт шилжих, торлосон алхмын хэмжээг 40-10 км хүртэл багасгах замаар түүний хэмжилтийн чанарыг сайжруулна;

3.4.2.3. цаг агаарын аюултай үзэгдэл: их бороо, цас, хүчтэй салхи, үер зэргийг 120-240 цаг (5-10 хоног) хүртэл хугацааны өмнөөс урьдчилан мэдээлэх гидродинамик-статистик арга боловсруулан нэвтрүүлж, дээрх үзэгдлийг урьдчилан мэдээлэх нутаг дэвсгэрийн нарийвчлалыг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хүргэж, цаг хугацааны алдааг ± 1-3 цагаас бага болгоно;

3.4.2.4. тусгай зориулалт (төмөр зам, өндөр хүчдэлийн шугамын дагуу)-ын цаг агаарын урьдчилсан мэдээг богино хугацаанд өндөр нарийвчлалтай гаргадаг болно;

3.4.2.5. агаарын температур, хур тунадас, усны урсацыг улирлын дотор 10 хоногийн нарийвчлалтай, жилийн дотор сарын нарийвчлалтай урьдчилан мэдээлэх арга боловсруулах, мөн уур амьсгалын өөрчлөлтийн хандлагыг 3-10 жилийн нарийвчлалтай урьдчилан мэдээлнэ.

3.4.3 Хөдөө аж ахуйн цаг уурын мэдээлэл-прогнозын имитаци систем байгуулах талаар:

3.4.3.1. монгол орны таримал болон бэлчээрийн зонхилох үргамлын өсөлт, хөгжлийн үе шат, үргац, өндөр, нам, өтгөн, сийрэг, өвчин, хортонд нэрвэгдсэн байдал, хөрсний 1м хүртэлх гүний чийгшил, малын 10 хоног тутмын амьдын жин, хөрсний агрофизик, агро-химийн үзүүлэлтийн мэдээллийн төрөлжсөн сан байгуулан шуурхай мэдээллийн төв сан (банк)-тай холбоно;

3.4.3.2. бэлчээрийн болон үр тариа, төмс, хүнсний ногооны үргалтын үе шат, үргац, хөрсний чийгшил, малын амьдын жин, ашиг шим (сүү, ноосны гарц, төллөх малын жилбэ)-ийн динамик, үргамлын өвчин, хортны гэнэтийн тархалтыг 7 хоногоос эхлэн улирлын урьдчилалтай мэдээлэх тоон загварыг боловсронгуй болгох, шинээр боловсруулан мэдээллийн сангаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэнэ;

3.4.3.3. ой, хээрийн түймэр гарах цаг уурын нөхцөлийг тодорхойлж 10 хоног хүртэл хугацааны урьдчилалтай сумын нутгийн хэмжээний нарийвчлалтай мэдээлнэ;

3.4.3.4. тариа тарих, хураах, мал төллүүлэх, нийлүүлэгт оруулах, хадлан бэлтгэх, пестицид, гербицид хэрэглэх гэх мэт агротехникийн арга хэмжээ зэрэг хөдөө аж ахуйн цаг үеийн үйлдвэрлэл явуулах цаг хугацаа, арга технологи боловсруулахад шаардагдах урьдчилсан мэдээ, мэдээлэл, зөвлөмж боловсруулна.

3.4.4. Монгол орны гадаргын усны урьдчилсан мэдээ, мэдээллийн имитаци систем байгуулах талаар:

3.4.4.1. монгол орны гол, мөрөн, нуур, мөстөл, булаг, газрын доорхи усны мэдээгээр усны физик, хими, биологийн мэдээллийн сан байгуулан шуурхай мэдээллийн төв сан (банк)-тай холбоно;

3.4.4.2. томоохон голын хур бороонд болон шар усны үерийн богино, дунд, урт хугацааны урьдчилсан мэдээний технологи боловсруулан шуурхай мэдээллийн сантай холбоно;

3.4.4.3. усны чанарын урьдчилсан мэдээ гаргаж эхэлнэ;

3.4.4.4. уруйн үерийн урьдчилсан мэдээний загвар боловсруулан нэвтрүүлнэ;

3.4.4.5. томоохон хотууд, эрдэс баялгийн орд бүхий газрын усны хангамжийг шийдвэрлэхэд тунадас, урсац-гүний усны холбоог ашиглан ашиглалтын зохистой горим тогтоохо;

3.4.4.6. усны чанар, горимын судалгаанд гидробиологи, гидрохимийн судалгааг хослуулна;

3.4.4.7. усны мэдээлэл боловсруулах, хэрэглэгчдэд үйлчлэх ажилд ДЦУБ-аас гишүүн орнуудад санал болгож байгаа мэдээлэл боловсруулах ИНФОГИДРОГОМС систем ашиглана.

3.4.5 Орчны бохирдлын урьдчилсан мэдээ-мэдээллийн тогтолцоог бий болгох талаар:

3.4.5.1. агаар, хөрс, усны бохирдлын мэдээллийн сан байгуулан шуурхай мэдээллийн төв сан (банк)-тай холбоно;

3.4.5.2. агаар, ус, хөрсний бохирдлын эх үүсвэрийн улсын тооллогыг 3-5 жил тутамд явуулан дээрх санд оруулна;

3.4.5.3.хөрс, уур амьсгал, усны тэнцлийн элементүүдтэй бохирдлын түвшинг холбон судална;

3.4.5.4. бохирдлын үнэлгээ, урьдчилсан мэдээний загвар боловсруулах, агаарын бохирдлыг хэмжих загварыг хилийн үе давхрагын загвартай холбон, орчны бохирдлын түвшний урьдчилсан мэдээг 7 хоног хүртэл хугацаагаар өгөх ажлыг 2005 оноос эхэлнэ;

3.4.5.5. хил дамжсан агаарын бохирдол, агаар, ус, хөрсний бохирдлын экосистем, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, хүчиллэг тунадас, агаарын булингаршлын мэдээллийн сантай болно;

3.4.5.6. цөмийн осол, сүйрэл, химийн хорт бодисын тархалтын прогнозын загвар боловсруулах, Бээжин, Токио, Обнинск, Талүүзэс цөмийн осол сүйрлийн үеийн радионуклеидийн тархалтын прогноз, өөрийн загвараар нарийвчлан мэдээллээр төр, засгийн байгууллагад үйлчилнэ;

3.4.5.7. гүний усны бохирдлын үнэлгээ

хийнэ.

3.4.6. Уур амьсгалын хяналт-шинжилгээний мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох талаар:

3.4.6.1. цаг уур, уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уур, ус, орчны төлөв байдал, бохирдлын мэдээллийг автоматжуулсан аргаар боловсруулж, Ус, цаг уур, орчны мэдээллийн сангуудад электрон шууданчаар татан авч шалган архивлах, шинэ технологид шилжсэнээр цаасан мэдээлэл дээр хийх гар дамжсан шалгалтыг зогсоож, мэдээллийг бодит хугацаанд боловсруулах, хэрэглэгчдийг шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлнэ;

3.4.6.2. ус, цаг уур, орчны мэдээллийн чанарыг шалгах, хэрэглэгчдийг үйлчлэхэд газар зүйн мэдээллийн систем ашиглах ажлыг 2004 оноос эхэлнэ;

3.4.6.3. уур амьсгалын мэдээллээр хэрэглэгчдийг үйлчлэхэд ДЦУБ-ын гишүүн орнуудын хэрэглэж буй ИНФОКЛИМ, КЛИКОМ системийн шинэ хувилбарыг авч ашиглана;

3.4.6.4. Төв Азийн уур амьсгал, монгол орны ган, зуд, цөлжилт, ой, хээрийн түймэр, орчны бохирдлын сар, улирал, жилийн тойм бэлтгэж эхэлнэ.

3.5. Ус, цаг уур, орчны мэдээлэл хангалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

3.5.1. Ус, цаг уур, орчны мэдээлэл, түүний дотор байгаль-цаг уурын аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийн хангалтын талаар:

3.5.1.1. цаг агаарын урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай мэдээллийг сум, хот, суурин бүрээр өндөр нарийвчлалтай гарган радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор мэдээллийн сүлжээгээр хэрэглэгчдэд түгээж, радиогийн нэг долгион, телевизийн тусгай сувгаар цаг агаарын болон орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээлэл тасралтгүй дамжуулах ажлыг 2006-2008 оноос хэрэгжүүлнэ;

3.5.1.2. байгаль-цаг уурын гамшгийн мэдээллээр хангах ажлыг хот, суурин газарт дохиоллын системийг ашиглан зохион байгуулна;

3.5.1.3. ус, цаг уур, орчны шуурхай мэдээллийн төв сан (банк)-д тухайн хэрэглэгч хандан өөртөө хэрэгтэй цаг агаарын мэдээллийг авах, аж ахуйн нэгж, байгууллага, малчдыг тухайн орон нутгийн 1-10 хоногийн мэдээллээр хангах боломж олгоно.

3.5.2. Ус, цаг уур, орчны горимын мэдээллийн хангалтын талаар:

3.5.2.1. дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн төлөв дээр тулгуурлан XXI зуны эхэн, дунд, сүүлч үеэр монгол орны уур амьсгал хэрхэн өөрчлөгдөх байдлыг үнэлж, цаашид байнга нарийвчилж байна;

3.5.2.2. уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл дор байгаль, газар зүйн бүс бүслүүр, ургамлын нөмөр, усны нөөц, мөнх цэвдэг зэрэг байгалийн нөөц хэрхэн өөрчлөгдөх, улмаар улс орны нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ хийж, 5 жил тутамд нарийвчилж байна;

3.5.2.3. байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт нь хүний эрүүл мэнд болон байгалийн нөөц, эрчим хүч, хөдөө аж ахуй, ойн ашиглалт, барилга, зам, тээвэр гэх мэт улс орны эдийн засгийн салбаруудад хэрхэн нөлөө үзүүлэх байдлыг үнэлж, үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, шингээгчийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эдийн засаг, экологийн хамгийн зохистой хувилбарыг тухайн салбарын төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна;

3.5.2.4. хүлэмжийн хийн үндэсний кадастр, озоныг задалдаг бодисын улсын тооллого явуулна;

3.5.2.5. олон улсын гэрээ, хэлэлцээр (Озоны үе давхрагыг хамгаалах тухай Венийн конвенц, Озоныг задалдаг бодисын тухай Монреалийн протокол, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Киотогийн протокол г.м)-ээр Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх ажлын хүрээнд хүлэмжийн хийг бууруулах, озоныг задалдаг бодисын хэрэглээг багасгах бодлого боловсруулна;

3.5.2.6. монгол орны уур амьсгалын хувиран өөрчлөгдөж байгаа хүчин зүйлийг төлөвлөлт, аж ахуйн удирдлагын үйл ажиллагаанд тооцох, зохистой ашиглуулах зорилгоор барилгын норм ба дүрэм (гидрологийн тооцооны стандарт, уур амьсгалын геофизикийн стандарт, норм), монгол орны уур амьсгалын стандарт, галлагааны хугацааны норматив, хөдөө аж ахуйн цаг уурын лавлах, хөрсний чийгийн лавлах, агаар, усны чанарын лавлах гэх мэт техникийн баримт бичгийг 5-10 жил тутамд шинэчилнэ;

3.5.2.7. агаар мандлын үзэгдэл, явцад зориуд нөлөөлөх замаар таримал болон бэлчээрийн ургамлын ургац нэмэгдүүлэх, ган, цөлжилтийн нөлөөг бууруулах, хүн хүрэх боломжгүй алслагдсан газар гарсан ой, хээрийн түймрийг унтраах зорилгоор хур тунадас нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөндөөс хамгаалах арга хэмжээ авна.

3.6. Салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, төв орон нутгийн байгууллагууд, үүлжээний нэгжүүдийг боловсон хүчнээр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх

талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.6.1. салбарын боловсон хүчний одоогийн хангалт, цаашдын хэрэгцээний судалгаа гаргаж, боловсон хүчин бэлтгэх, давтан сургах чиглэл боловсруулж ажиллана;

3.6.2. салбарын мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, шаардлагын захиалгыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гарган өгч боловсон хүчнээр тасралтгүй хангах арга хэмжээ авна;

3.6.3. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль, коллежтэй хамтран сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж мөрдөн ажиллана;

3.6.4. ус, цаг уурын харуулын ажиглагчийг коллеж төгссөн түгэвч дунд мэргэжлийн боловсон хүчнээр, өртөөг бакалавраас доошгүй түвшний зэрэгтэй боловсон хүчнээр хангах зорилтыг 2015 онд багтаан шийдвэрлэнэ;

3.6.5. боловсон хүчний цалин хөлс, орлогыг нэмэгдүүлэх, ахуй хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага

зохион байгуулалт

Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг хөгжүүлэх үндсэн дээр монгол орны байгалийн сэргээгдэх нөөцийг үр дүнтэй ашиглах, байгаль-цаг агаарын аюул, гамшгаас сэргийлэх арга хэмжээг төр, засгийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

4.1. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага:

4.1.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарын бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ус, цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна;

4.1.2. байгаль орчны төлөв байдалд хяналт-шинжилгээ хийх ажилд Шинжлэх ухааны академи, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд оролцоно;

4.1.3. байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг ашигласан улс орны тогтвортой хөгжлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дэд бүтцийн, хүнс, хөдөө аж ахуйн, санхүү, эдийн засгийн, хууль зүйн, боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд оролцоно;

4.1.4. орон нутгийн төр, захиргааны байгууллагууд өөрийн нутаг дэвсгэр дээр байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг үр ашигтай ашиглах, байгаль-цаг агаарын аюул гамшгаас сэргийлэх ажлыг зохион байгуулж, жилийн төсөөтөө ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээний ажиллагааны зардлыг тусгаж, тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэргэжлийн байгууллагууд:

4.2.1. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээг мэргэжлийн удирдлагаар хангах, ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллийг цуглуулах, боловсруулах, тэр, засаг, аж ахуйн нэгж, иргэдийн хэрэгцээнд зориулсан мэдээллээр үйлчлэх ажлыг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн болон туршилт зохион бүтээх байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.

4.3 Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний ажилд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо:

4.3.1. байгаль-цаг агаарын аюул, гамшгаас сэргийлэн хамгаалах ажилд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу нийт иргэд оролцоно;

4.3.2. ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний ажилд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохих эвөшөөрөл авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллага Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу оролцоно. Байгаль, цаг агаарын аюулыг цаг тухайд нь илрүүлэх, орчны доройтол, орчны бохирдолд төрийн хяналт тавих ажилд дэмжлэг үзүүлнэ.

Тав. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

5.1. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай нөхцөлийг бүрдүүлх хөрөнгө оруулалтын баталгаат хангахын зэрэгцээ ДЦУБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр болон бусад олон улсын байгууллага, гадаад орнуудаас энэ салбарт төсөл хэрэгжүүлэх, хандив, туслалж үзүүлэх явдлыг бүх талаар дэмжинэ.

5.2. Иргэний агаарын тээврийн нислэгийн аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсаас Олон улсын иргэний нисэхийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх хүрээнд гадаад, дотоодын иргэний агаарын тээврийн байгууллагаас нислэгийн цаг уурын хангалттай сайжруулах, агаарын хөлгөөс цаг уурын хэмжилт хийх талаар төсөл хэрэгжүүлнэ.

5.3. Гадаад, дотоодын жуулчын аюулгүй

байдлыг хангах, цаг уурын хангалтыг ергөтгөх талаар хамтын ажиллагаа ергежүүлнэ.

5.4. Дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдэд идэвхтэй оролцож монгол орны уур амьсгал, түүний өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлтэд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, өндөр технологи дамжуулах, хуурай газар-агаар мандлын хоорондох энергимассын солилцоо болон ерөнхий орчил урсгалын загварын ололтын мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр хамтарсан судалгаар ергежүүлнэ.

5.5. Инженер, техникийн ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэшүүлэх, шинжлэх ухаан, технологийн шинэ мэдээлэл олж авах зорилгоор эрдэмтэд, мэргэжилтнүүдийг гадаадад томилон ажиллуулах, бага хурал, симпозиум, үзэсгэлэн зохион байгуулах, гадаадын техник, технөөрөмжийг сонгох туршилт хийх зэргээр боловсон хүчний чадавхийг дээшлүүлнэ.

5.6. Хөдөө аж ахуйн цаг уур, уулархаг нутгийн цаг уур судлалаар ДЦУБ-ын сургалтын төвийг Монгол Улсад байгуулах асуудлыг дэмжиж, бүх талын туслалцаа үзүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй,

санхүүжилтийн бодлого

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүгнэх ажлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ. Хөтөлбөрийг ус, цаг уур, орчны шинжилгээний төрийн захиргааны байгууллага, түүний харьяа мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг төр, засгийн үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгах, хөтөлберт тусгагдсан тодорхой чиглэлээр тусгай хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, салбарын мастер төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах, хоёр болон олон талын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт тусгах, гадаад, дотоодын сонирхогч байгууллагуудад мэдээлэх, тендер шалгаруулах зэрэг аргаар хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт жил бүрийн эцэст танилцуулж байна.

6.2. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

6.3. Хөтөлбөрийн санхүүжилт:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

6.3.1. улсын төвлөрсөн төсөв;

6.3.2. орон нутгийн төсөв;

6.3.3. ус, цаг уур, орчны тусгай хэрэгцээний төрөлжсөн мэдээлэл болон агаар мандлын явцад зориуд нөлөөлөх зэрэг захиалгат ажлаар аж ахуйн нэгж, байгууллагыг үйлчилсний төлбөрийн орлого;

6.3.4. олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдээс өгч буй хандив, тусламж дэмжлэг, төслийн хөрөнгө;

6.3.5. улсын захиалгаар гүйцэтгэх ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний шинжлэх ухаан-технологийн төслүүдэд олгох хөрөнгө.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат,

гол үр дүн

7.1. Хөтөлбөрийг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат (2005 он хүртэл)-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж бие даасан төсөл, хөтөлбөр боловсруулах зэрэг арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2005-2010 он)–Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээ, мэдээлэл солилцоо, мэдээлэл боловсруулах ажилд технологийн шинэчлэл хийж, хүний үйл ажиллагаатай холбоотой гардаг сөрөг хүчин зүйлийн нөлөөг бууруулна.

Ус, цаг уур, орчны мэдээллээр хэрэглэгчдийг хангах ажил чанарын шинэ түвшинд гарч, тухайн хэрэглэгч хэрэгцээт мэдээллээ мэдээлэл үйлчилгээний сүлжээгээр дамжуулан шуурхай мэдээллийн төв сан (банк)-гаас шууд авч ашиглах боломжтой болно.

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс уламжлан экосистемд гарах өөрчлөлтийг нарийвчлан тогтоосноор улс орны эдийн засгийн салбарыг өөрчлөн зохицуулах хувилбаруудыг боловсруулах, арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.

Гуравдугаар үе шат (2010-2015 он)-Энэ үе шатанд үндэсний ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарын үйл ажиллагаа дэлхийн түвшинд хүрч, байгалийн сэргээгдэх нөөцийг зохистой ашиглах, байгаль-цаг агаарын болзошгүй аюул, гамшгаас улс оронд учруулж болох хохирлын хэмжээг мэдэгдэхүйц хэмжээнд хүртэл бууруулах болно.

Агаар мандлын үзэгдэл, явцад зориуд нөлөөлөх ажлыг төрийн бодлого, санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлнэ.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ 2015 ОН ХҮРТЭЛХ ХУГАЦААНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ШАТНЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2002 – 2005 он

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн	Санхүүгийн эх үүсвэр
1	Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээний тоглолцоог боловсронгуй болгох	1. Цаг уурын 20, ус судлалын 5 станцыг хэмжилтийн автомат тоног төхөөрөмжөөр хангана	2003-2005	Цаг уурын анхан шатны мэдээллийн чанар, үнэмшил эрс дээшлэх хүнээс хамаарч гардаг алдаа бүрэн арилна.	Олон улсын төслөөр
		2. Цаг уурын ажиглалтын 15 харуулыг өртөө болгон өргөтгөж, шаардлагатай газар харуул, өртөө шинээр байгуулах ажлыг зохион байгуулна	2003-2004	Ажиглалтын хөтөлбөр өргөжиж орон нутгаас авах мэдээллийн хэмжээ, чанар сайжирна.	Дотоод эх үүсвэр
		3. Аэрологийн түр хаагдсан 2 өртөөг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож ажилд оруулна	2003-2004	Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргахад зайлшгүй шаардлагатай агаарын дээд давхаргын тухай мэдээллэл нэмэгдэнэ.	Олон улсын төслөөр
		4. Салхи, температурын өндрийн өөрчлөлтийг нарийвчлан тодорхойлох тоног төхөөрөмжийг Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал дээр суурилуулж ашиглана	2003-2004	Иргэний нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай газраас дээшхи 30 км хүртэлх өндрийн салхины шилжлэг, температурын өөрчлөлтийг өндөр нарийвчлалтай тодорхойлох боломжтой болно. Нислэгийн аюулгүй байдал дээшилнэ.	Олон улсын төслөөр
		5. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний автомат багаж хэрэгслийг өөрийн оронд угсрах, засварлах, баталгаажуулалт хийх ажлыг зохион байгуулна.	2003-2004	Гадаадаас өндөр үнээр авдаг радиозонд мэтийн нарийн тоног төхөөрөмжийг өөрийн оронд угсардаг болсноор сэлбэг хэрэгслийн өртөг зардлыг багасгаж хангамжийг сайжруулна.	Дотоод эх үүсвэр, Олон улсын төслөөр
		6. Ус, цаг уур, орчны шинжилгээнд ашигладаг		Ажиглалтын өртөө, харуулыг тоног төхөөрөмж, сэлбэг материалаар хангах	

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 он, №39 (276)

		зарим тоног төхөөрөмжийг дотооддоо бөөнөөр үйлдвэрлэх ажлыг эхэлж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авна.	2002-2004	ажил сайжирч, Ус, цаг уурын тухай, Хэмжил зүйн нэгдмэл байдлын тухай хуулиудыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.	Дотоод үүсвэр	эх
		7. Газрын гүний ус, мөнх цас, мөс, цэвдэгт гарах хувьсал өөрчлөлтөд хийх хяналт-шинжилгээг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээн дээр төвлөрүүлэн хийх ажлыг эхэлнэ	2002-2004	Усны нөөц, горим, хувьсал өөрчлөлтийн тухай мэдээллийн хэмжээ нэмэгдэж, усны хангамжийг үнэлэх боломж нэмэгдэнэ.	Дотоод үүсвэр	эх
		8. Салхины чиглэл, хурдыг хэмжих хуучин техник технологийг сольж, 40-өөс доошгүй өртөө, харуулыг салхины хэмжилтийн автомат багажаар хангана	2003-2005	Автомат багаж хэрэгсэл нэвтрүүлснээр салхины ямарч хурдыг цаг агаарын ямарч нөхцөлд шууд автоматаар хэмжих боломжтой болно.	Дотоод үүсвэр	эх
		9. Ус, цаг уурын хэмжилтийн багаж төхөөрөмжийг шалгах эталон багажаар хангана	2003-2005	Өртөө, харуулд ажиллаж байгаа багаж төхөөрөмжийн стандартыг хянаж баталгаажуулах, хэмжил зүйн нэгдмэл байдлыг хангах боломж бүрдэнэ.	Дотоод үүсвэр, Олон улсын төслөөр	эх
		10. Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөн 2 лаборатори, 3 харуул шинээр байгуулна	2003-2005	Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ өргөсөж орчны чанарыг хянах ажлын хамрах хүрээ нэмэгдэнэ.	Дотоод үүсвэр	эх
		11. Ус судлалын 30 харуул, мөстөл судлалын 1 харуул байгуулж ажилд оруулна	2003-2005	Монгол орны гол, мөрөн, нуурын усны нөөц горим, өөрчлөлтийг нарийвчлан тогтоох, усны хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломж дээшилнэ.	Дотоод үүсвэр	эх
		12. Газрын доорхи усны мониторингийн сүлжээг байгуулах ажлыг эхэлж ажиглалтын 20 харуул байгуулна	2003-2005	Газрын доорхи усны нөөц, горимыг нарийвчлан үнэлж томоохон хот, суурин, үйлдвэр, аж ахуйн газрын усны хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эх мэдээлэл бий болно.	Дотоод үүсвэр	эх
		13. Дархан цаазат газар болон тусгай		Байгаль хамгаалах, улсын хамгаалалттай газар нутгийн экосистемийн төлөв байдлыг үнэлэх, түүний хувьсал өөрчлөлтийг тогтоох гол	Дотоод	эх

		хамгаалалттай газар, байгалийн нөөц газар нутагт биогеоценозийн 5 өртөө байгуулна	2004-2005	мэдээлэл бий болно.	үүсвэр
2	Мэдээлэл хүлээн авах, дамжуулах тоглолцоог боловсронгуй болгох	14. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний мэдээллийг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний сүлжээний нэгжүүдээс үндэсний төвд хүлээн авах хугацааг богиносгоно	2002-2004	Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өртөө, харуулд ажиглалт, хэмжилт хийснээс хойш 5-15 (H+5-15) минутын дотор төвд хүлээн авч, 20 (H+20) минутын дотор ДЦУБ-ын бүсийн төвүүдэд гаргах боломжтой болно. Энэ нь цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлэх боломжийг нэмэгдүүлнэ.	Олон улсын төслөөр
		15. Цаг агаарын аюултай үзэгдэл, үер, орчны бохирдол, цацраг идэвжил, газар хөдлөл, ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчлөл гарсан, ургамлын өвчин, хортон тархсан, химийн хорт бодис алдагдсан тухай мэдээг ("Аюул") ус, цаг уурын харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах ажлыг шуурхай зохион байгуулна	2003-2005	Ард иргэдийг байгаль, цаг уурын гамшигт үзэгдлээс хамгаалах, төр засгийн байгууллагуудыг мэдээллээр шуурхай хангаж учирч болох хохирлыг багасгах боломж бүрдэнэ.	Олон улсын төслөөр
		16. Ус, цаг уурын холбооны үндэсний төв, аймгийн төвүүдийн хооронд интернетийн гарц бүхий VSAT сүлжээ ашиглах шинэ технологид шилжих	2003-2005	Мэдээллийг цаг алдалгүй шуурхай, найдвартай дамжуулах техник, технологийн боломж нэмэгдэж найдвартай ажиллагаа дээшилнэ.	Олон улсын төслөөр
		17. Мэдээлэл солилцох сүлжээнд технологийн шинэчлэл хийж өндөр хурдаар мэдээлэл солилцох технологи (TCP/IP протокол)-д шилжинэ	2004-2005	Мэдээлэл дамжуулах хурд, найдвартай ажиллагаа нэмэгдэж, мэдээллийн шуурхай байдал бий болно. Дэлхийн хиймэл дагуулын болон цаг уурын радарын тоон мэдээлэл, цаг агаарын зураг, гадаад, дотоодын мэдээлэл боловсруулах төвүүдэд хийсэн тоон анализ, прогнозын үр дүнг орон нутагт ашиглах боломжийг дээшлүүлнэ,	Олон улсын төслөөр
		18. Цаг уурын өртөө, харуул, аймгийн төвүүдийн хооронд холбооны сүлжээний найдвартай ажиллагаат хангахын тулд радио болон	2004-2005	Цахилгааны болон телефон холбооны найдвартай бус ажиллагаанаас болж цаг уурын өртөө, харуулын мэдээг төвд шуурхай хүлээн авах ажиллагаа байнга	Дотоод эх

		Хөдөлгөөнт холбооны системийг ашиглах боломжийг эрж хайна 19. Цаг уурын байран (geostationary) хиймэл дагуулаас мэдээлэл хүлээн авч боловсруулах газрын станц байгуулж ашиглана		тасалдсан зөрчлийг арилгах боломж бүрдэнэ. Цаг уурын байран хиймэл дагуулаас мэдээлэл хүлээн авдаг болсноор 24 цагийн турш монгол орны нутаг дэвх цаг агаарын тухай мэдээллийг тасралтгүй хүлээн авах боломжтой болж урьдчилсан мэдээний чанар дээшилнэ.	үүсвэр, Олон улсын төлөөр Олон улсын төлөөр
3	Ус, цаг уур, орчны мэдээлэл боловсруулах технологийг бүрэн автоматжуулах	20. Холбооны сувгаар хүлээн авах шуурхай үйлчилгээний мэдээллийн анхдагч боловсруулалтын системийг шинэчилнэ 21. Уур амьсгалын горимын мэдээллийн боловсруулалт, мэдээллийн сангийн технологи, программ хангамжийг шинэчлэн боловсруулна 22. Ус судалын мэдээллийн боловсруулалт, мэдээллийн сангийн программ хангамжийг шинэчлэн боловсруулна 23. Мэдээлэл боловсруулалт, урьдчилан мэдээлэх үйл ажиллагаанд супер компьютер, өндөр хүчин чадалтай түгээй зориулалтын компьютер (ажлын станц) хэрэглэж эхэлнэ	2003-2005 2002-2005 2003-2005 2003-2004	Эх мэдээллийг богино хугацаанд шуурхай боловсруулах боломж бүрдсэнээр цаг агаарын урьдчилсан мэдээний чанар сайжирна. Уур амьсгалын үзүүлэлтүүдийн норм, стандарт тогтоох, хэрэглэгчдийг найдвартай үнэн зөв мэдээллээр үйлчлэх боломж нэмэгдэнэ. Гадаргын болон газрын гүний усны мэдээллийг авомэтжуулсан аргаар боловсруулж мэдээллийн сан үүсгэснээр усны горим, нөөцийн судалгааны чанар сайжирна. Цаг уурын практик супер компьютер, ажлын станц нэвтрүүлснээр их хэмжээний мэдээллийг боловсруулах, урьдчилан мэдээлэх үйл ажиллагаанд динамик тоон загваруудыг ашиглах боломжтой болж мэдээний чанар сайжирна.	Олон улсын төлөөр Дотоод эх үүсвэр Дотоод эх үүсвэр Дотоод эх үүсвэр, Олон улсын төлөөр
4	Ус,цаг уур, орчны мэдээлэл хангалтын	24. Цаг агаарын урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшиг үзэгдлийн тухай мэдээллийг хот, аймгийн төв бүрээр өндөр	2002-2005	Цаг агаарын урьдчилсан мэдээний нарийвчлал сайжирч, хэрэглэгчдэд шуурхай хүргэх боломж	Дотоод эх үүсвэр

	тогтолцоог боловсронгуй болгох, байгаль-цаг уурын аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх	нарийвчлалтай гарган радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернетийн сүлжээгээр хэрэглэгчдэд түгээнэ		дээшилнэ.	
		25. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн төлөв дээр тулгуурлан XXI зууны эхэн, дунд, сүүлч үеэр монгол орны уур амьсгал хэрхэн өөрчлөгдөх байдлыг нарийвчлан үнэлнэ	2002-2005	Монгол орны уур амьсгал XXI зуунд хэрхэн өөрчлөгдөх ерөнхий хандлагыг тодорхойлно.	Дотоод эх үүсвэр
		26. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр байгалийн бүс, бүслүүр, ургамлын нөмрөг, усны нөөц, мөнх цэвдэг зэрэг байгалийн нөөц хэрхэн өөрчлөгдөх, улмаар хөдөө аж ахуйн салбарт хэрхэн нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийнэ	2002-2005	Уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг үнэлэн тогтоосноор аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах боломжтой болно.	Дотоод эх үүсвэр
		27. Уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, шингээгчийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эдийн засаг, экологийн хамгийн зохистой хувилбаруудыг тухайн салбарын төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлж эхлэх арга хэмжээ авна	2002-2005	Уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, дасан зохицох арга хэмжээ авах боломж бүрдэнэ. Хүлэмжийн хийн хэмжээг бууруулах үндэсний хэмжээний бодлого боловсруулж хэрэгжүүлэх асуудлыг салбаруудын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж эхэлнэ.	Дотоод эх үүсвэр
		28. Хүлэмжийн хийн 1998-2000 оны үндэсний кадастр боловсруулна	2003-2004	Агаарт гаргаж байгаа хүлэмжийн хийн хэмжээг тогтоосноор түүний гол эх үүсвэрүүдээс ялгарах хүлэмжийн хийн хэмжээг багасгах арга хэмжээ авах боломж бүрдэж, олон улсын гэрээ, конвенцион хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой болно.	Дотоод эх үүсвэр
		29. Олон улсын гэрээ, хэлэлцээр (Озоны үе давхрагыг хамгаалах тухай Венийн конвенц, Озоныг задалдаг бодисын тухай Монреалийн протокол, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Киотогийн протокол г.м)-ээр Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх ажлын хүрээнд хүлэмжийн хийг бууруулах, озоныг задалдаг бодисын хэрэглээг багасгах	2002-2005	Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, озоныг задалдаг бодисын хэрэглээг багасгах бодлого боловсруулж хэрэгжүүлснээр олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх, байгальд халгүй техник, технологи нэвтрүүлэх боломж бүрдэнэ.	Дотоод эх үүсвэр

		бодлого боловсруулна 30. Агаар мандлын үзэгдэл, явцад зориуд нөлөөлөх үйл ажиллагаар орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар явуулна.	2003-2005	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлснээр хөрсний чийг, таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ган, цөлжилтийн нөлөөг бууруулах, хүн хүрэх боломжгүй алслагдсан газарт гарсан ой, хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлнэ. Мөн мөндөр сарниулах үйл ажиллагаа явуулж таримал ургамлыг мөндрөөс хамгаална.	Дотоод эх үүсвэр
5	Ус, цаг уурын шинжлэх ухааныг хөгжүүлж шинэ дэвшилтэт арга, техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	31. Цаг агаарыг урьдчилан мэдээлэх ажилд гидродинамик тоон загварчлалын арга, супер компьютер, тусгай хэрэгцээний өндөр хүчин чадалтай компьютер ашиглаж эхэлнэ	2003-2005	Цаг агаарын урьдчилсан мэдээ зохиоход илүү нарийн арга зүй ашиглаж, хэрэглэх мэдээллийн хэмжээ нэмэгдэж, урьдчилсан мэдээний чанар дээшилнэ.	Дээрх зорилтууды н хүрээнд шийдвэрлэн э.
		32. Байран хиймэл дагуулаас ус, цаг уур, байгалийн нөөцийн мэдээллэл хүлээн авч боловсруулах техник, технологи нэвтрүүлнэ	2003-2004	Хоногийн аль ч үед үүл, цасан бүрхүүл болон байгалийн бусад үзүүлэлтийн тухай мэдээлийг хиймэл дагуулаас авах боломжтой болж урьдчилсан мэдээний чанар дээшилнэ.	
		33. Өндрийн салхи, температурын өөрчлөлтийг тодорхойлох орчин үеийн тоног төхөөрөмж, технологийг ашиглаж эхэлнэ	2003-2004	Онгоцны хөөрөх, буух зурвасын дагуух салхины чиглэл, хурд, температурын өөрчлөлтийг өндөр нарийвчлалтай тодорхойлох боломжтой болж нислэгийн аюулгүй байдал дээшилнэ.	
		34. Цаг уурын болон усны автомат хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийг өргөнөөр нэвтрүүлж эхэлнэ	2003-2005	Мэдээллийг тасралтгүй бүртгэх боломжтой болж ажиглалтын мэдээний чанар дээшлэх, мэдээллийг шууд сүлжээгээр хүний оролцоогүйгээр дамжуулах боломж бүрдэнэ.	
		35. Цаг уурын холбооны мэдээлэл, сүлжээний орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлнэ	2003-2004	Өртөө, харуулын мэдээг шуурхай цуглуулан авч боловсруулан урьдчилсан мэдээ зохиоход ашиглах, ДЦУБ-аас тогтоосон хугацаанд олон улсын солилцоонд гаргах боломжтой болно.	

6	Салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, боловсон хүчнээр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	36. Салбарын боловсон хүчний одоогийн хангалт, цаашдын хэрэгцээний судалгаа гаргаж, боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ерөнхий чиглэл боловсруулж ажиллана	2002-2005	Салбарын боловсон хүчний хэрэгцээ, хангалтыг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу явуулж нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах боломжтой болно.	-
		37. Салбарын мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, шаардлагын захиалгыг боловсрол, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гарган өгч боловсон хүчнээр тасралтгүй хангах арга хэмжээ авна	2003-2005	Их, дээд сургуулиар мэргэжилтэй боловсон хүчнийг захиалгын дагуу бэлтгэж алслагдсан аймаг, орон нутгийг боловсон хүчнээр хангах боломж нэмэгдэнэ.	-
		38. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль, коллежтэй хамтран сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж мөрдөн ажиллана	2002-2004	Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөрийн чанар сайжирч, цаг үеийн шаардлага хангасан мэргэжилтэн бэлтгэх нөхцөл бүрдэнэ.	-
		39. Боловсон хүчний цалин хөлс, орлогыг нэмэгдүүлэх, тэдний ахуй хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар асуудал боловсруулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ	2002-2003	Ажиллагсдын цалин хөлс, орлого нэмэгдсэнээр тэдний ажиллах сонирхол дээшилж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл дээшилнэ.	-

Тайлбар: 1) Санхүүгийн дотоод эх үүсвэрийг жил жилийн төсөвт нэмэлт байдлаар тусгаж шийдвэрлэнэ.
2) Төлөвлөгөөнд туссан нэлээд олон асуудлыг 2002 оноос хэрэгжүүлж эхлэх Японы Засгийн газрын техникийн буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд шийдвэрлэхээр төлөвлөсөн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Дугаар 183 **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 7.10, 28.6.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 132 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон тогтоолын 1 дүгээр хавсралтын гарчгийн "Хүний эрхийн үндэсний комиссын" гэсний дараа "Төрийн албаны зөвлөл" гэж тус тус нэмж, мөн тогтоолоор батлагдсан 1 дүгээр хавсралтад дараахь агуулга бүхий хэсгийг нэмсүгэй:

Ангилал	Зэрэглэл	Төрийн албаны зөвлөлийн ажлын алба
Ахлах түшмэл	АА-6 АА-7 АА-8	Референт Ахлах шинжээч Шинжээч
Дэс түшмэл	АА-9 АА-10 АА-11	- Зааварлагч -

2. "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 232 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон мөн тогтоолын 2 дугаар хавсралтын гарчгийн "Үндсэн хуулийн цэц" гэсний дараа "Төрийн албаны зөвлөл" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 275 **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулийн /цаашид Эрүүгийн байцаан шийтгэх хууль гэнэ/ зарим зүйл,хэсэг, заалт болон "Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай" 2002 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Хуулийн 3 дугаар заалтыг нэг мөр ойлгож, 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс эвх хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Шүүхийн тухай шинэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Бүх шатны шүүх шинээр батлагдсан Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд энэ өдрөөс өмнө анхан шатны журмаар аймаг,нийслэлийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийг Улсын Дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

Харин аймаг,нийслэлийн шүүх 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө хүлээн авч,шүүхээр уг хэргийг хянах ажиллагааг нэгэнт эхэлж,яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарч,шүүх хуралдааны товыг нэгэнт зарласан бол тухайн шүүх анхан шатны журмаар хэргийг шинээр батлагдсан хуулийг баримтлан шийдвэрлэнэ.

Энэ шийдвэрт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303 дугаар зүйлд заасан давж заалдах гомдол,эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд гомдол,эсэргүүцэл гаргавал уг хэргийг Улсын Дээд шүүхэд давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

Хэрэв ялагдагчийг шүүхэд шилжүүлэхгүй бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 222.1-д заасны дагуу шүүгчийн захирамжаар хэргийг харьяалах сум,сум дундын болон дүүргийн шүүхэд нь шилжүүлнэ.

2. 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө шийдвэрлэгдэж таслан шийдвэрлэх тогтоол нь хүчин төгөлдөр болсон хэргийг Улсын Дээд шүүхэд хяналтын журмаар хянуулахаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342.1-д зааснаар гомдол,эсэргүүцэл гаргал уг гомдол,эсэргүүцэл нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303.1,342.1-д заасан заалт болон 320,321 дүгээр зүйлд заасан шаардлагыг хянасан хяналтын шатны гомдол, эсэргүүцэл мөн эсэхийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хянаж, хэргийг Улсын Дээд шүүхэд явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

Аймаг, нийслэлийн хяналтын шатны шүүхэд 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө эсэргүүцэл, дүгнэлт бичигдсэн ч хэлэлцэгдээгүй байгаа хэргийг Улсын Дээд шүүхэд хүргүүлнэ.

3.2002 оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө таслан шийдвэрлэх тогтоол нь хүчин төгөлдөр болсон хэрэг Улсын Дээд шүүхэд хяналтын журмаар урьд нь хянагдаж байгаагүй бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347.1-д зааснаар Улсын Дээд шүүх уг хэргийг хяналтын журмаар 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр байна

Харин Улсын Дээд шүүх урьд нь хэргийг хянаад өгсөн хариу, эсхүл УлсынДээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар нэг удаа хэлэлцэж гарсан тогтоол болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347.1-д зааснаар Улсын Дээд шүүхийн 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж гаргасан тогтоолыг хуульд харшилсан гэж үзвэл энэ хуулийн 347.2-т зааснаар Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар зохих албан тушаалтны дүгнэлтийг үндэслэн хянан хэлэлцэж болно.

4. Шүүхийн тогтоол,магадлалд давах болон хяналтын журмаар гарсан гомдол,эсэргүүцлийг уг хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхэд гаргана. Ийм тохиолдолд анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 305, 344 дүгээр зүйлд заасанаар оролцогч бусад талуудад гомдол, эсэргүүцэл бичигдсэн талаар болон хариу тайлбар бичих эрхтэй болохыг нь мэдэгдэнэ.

5. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 301 дүгээр зүйлд "Шийтгэх ба цагаатгах тогтоол үншиж сонсогмогц хуулийн хүчин төгөлдөр болно" гэснийг, мөн 306.1, 345.1-д "... тогтоолын биелэлт түдгэлзэнэ" гэснийг дараахь байдлаар ойлгож,хэргүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй:

а/ "Шийтгэх, цагаатгах тогтоол үншиж сонсогмогц хуулийн хүчин төгөлдөр болно" гэж хуульд нэгэнт заасан тул анхан шатны шүүх гэм буруутай этгээдэд хорих, баривчлах ял оногдуулсан тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээг цагдан хорихоор авах бөгөөд гомдол, эсэргүүцэл хуульд заасан хугацаанд гараагүй бол шийтгэх тогтоол биелүүлэх ажиллагаат Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 330 дугаар зүйлд заасанаар зохион байгуулна.

Харин давж заалдах болон хяналтын шатанд гомдол,эсэргүүцэл бичигдвэл тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

б/ Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гарсан үед "тогтоолын биелэлтийг түдгэлзэнэ" гэсэн нь урьд цагдан хорихоор авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх ойлголт биш, харин торгууль тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх ялыг биелүүлэх болон хохирол, төлбөрийг албадан гүйцэтгэхийг дээд шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл хойшлуулна гэсэн ойлголт болно.

6. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342.1-д зааснаар хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргахад 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 304.1-д заасан "10 хоног"-ийн хугацаа хамаарахгүй , эввэкн 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хойш шийдвэрлэгдсэн хэрэгт хамаарахыг тайлбарласугай.

7. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим /Д. Батсайхан/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **Ч. ГАНБАТ**

ШҮҮГЧ **М.ДАМИРАНСҮРЭН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2.6 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 40 (277)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ:

- *Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны аравдугаар сарын 30 №40 (277)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

548. Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Дугаар 68 1271

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

549. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 140 1273

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

550. Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тайлбарлах тухай Дугаар 276 1282

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 68 Улаанбаатар хот

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хавсралтын ёсоор батална.

2.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 68 дугаар тогтоолын хавсралт

ЭМИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

Эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэл (цаашид "эм" гэх)-ийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага болон хүн амыг шаардлагатай эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, түүний зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь Монгол Улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогын эрхэм зорилго мөн.

Нэг. Удирдлага, эрх зүйн зохицуулалт

1.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь Монгол Улсын холбогдох хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эмийн хангамж, үйлдвэрлэл, зохистой хэрэглээг; үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эмийн импорт, экспортыг тус тус зохицуулна.

3.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг удирдах, зохицуулах үүргийг эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эм зүйн мэргэжлийн албаар гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.

4.Улсын мэргэжлийн хяналтын газар нь эмийн эмчилгээний идэвхи, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтад хяналт тавина.

5.Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагаат төрөөс боловсролын талаар баримтлах бодлоготой уялдуулан явуулж, мэргэжилтний мэдлэг, чадварыг олон улсын жишигт хүргэхийг эрхэмлэнэ.

6.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд зориулагдсан судалгаа, шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоож, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаат өргөжүүлж, энэ талаарх санал, санаачлагыг дэмжинэ.

Хоёр. Эмийн хангамж, үйлдвэрлэл, санхүүжилт

1. Эмийн сонголт:

1/эрүүл мэндийн бүх шатны тусламжийн хүрээнд оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтэд нэн тэргүүнд шаардагдах эмийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын эмийн талаарх үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны өвөрмөц нөхцөлд тохируулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгох;

2/эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүн эмнэлгийн болон мал эмнэлгийн зориулалт бүхий эмийг шаардлагатай эмийн жагсаалт боловсруулж, 4 жил тутам шинэчлэн мөрдүүлж байх;

3/хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага нь эмчилгээ, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийг нэн тэргүүнд хэрэглэх;

4/уламжлалт эмийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд авч үзэж, шаардлага хангахуйц эмийг хүн эмнэлэг, мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэхийг дэмжих.

2.Эмийн санхүүжилт:

1/төрийн өмчийн эмнэлгүүдийг зайлшгүй шаардлагатай эмээр жигд, тасралтгүй хангах зардлыг улсын төсвөөс олгох;

2/иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэнд зайлшгүй шаардлагатай зарим эмийг зохих хувиар хөнгөлөлттэй олгохыг дэмжих;

3/зайлшгүй шаардлагатай эмийн үнийг олон улсын жишиг үнийн хэмжээнд зохицуулах бодлого баримтлах;

4/улсын нөөцийн болон эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээний эмийн үнийг улсын төсвөөс санхүүжүүлэх;

5/мал, амьтны халдварт паразит өвчнийг эмчлэн сэргийлэхэд шаардагдах эмийн үнийг улсын төсвөөс санхүүжүүлэх.

3. Эмийн хангамж:

1/төрийн болон хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллага нь хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага болон хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр нэн тэргүүнд хангах чиглэл баримтлах;

2/орон нутгийн хүн амын зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, түгээлтийг жигд, хүртээмжтэй байлгахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

3/эм хангамжийн магадлан итгэмжлэгдсэн байгууллага, эмийн сан эм хангах нийлүүлэх үйлчилгээ эрхлэх;

4/гадаадаас хандив, тусламжаар эм авахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хандив, тусламжийн эм, биобэлдмэлд тавьж буй шаардлагыг мөрдлөг болгох.

4. Эмийн үндэсний үйлдвэрлэл:

1/эмийн үндэсний үйлдвэрийн үйлдвэрлэл, технологи болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор шинэ техник, технологи нэвтрүүлэхэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;

2/эмийн үндэсний үйлдвэрээс зайлшгүй шаардлагатай эмийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3/эмийн үйлдвэрийг үндэсний "Эм үйлдвэрлэлийн дүрэм" /GMP/-ийн түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

4/эмийн үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх;

5/патентаар хамгаалагдсан эмийг Монгол Улсад импортлох, үйлдвэрлэх тохиолдолд Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр ба нийгмийн эрүүл мэндийн талаарх 2001 оны Дохагийн тунхаглалыг удирдлага болгох.

Гурав. Эмийн хяналт

1.Эмийн лаборатори, бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, хяналтын албадыг бэхжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

2.Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эм импортлох, эм импортлогч нарт дээр дурдсан шаардлага хангасан гадаадын үйлдвэрийн гэрээт борлуулагч байх нөхцөл бүрдүүлнэ.

3.Эмийн улсын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох замаар эмийн эмчилгээний идэвхи, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтад тавих шаардлагыг өндөржүүлнэ.

4.Одоо мөрдөж байгаа Монгол Улсын стандартыг үндэслэн үндэсний фармакопей боловсруулж мөрдүүлнэ.

5.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тэдгээрийн үүсвэр бодисын үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээнд хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

Дөрөв. Эмийн зохистой хэрэглээ

1. Эмийн сангаас хүн амд жороор эм олгох асуудлыг хууль тогтоомжийн дагуу тогтвортой мөрдүүлэхийг чухалчлана.

2.Ерөнхий нэршлийн эмийн хэрэглээг төлөвшүүлнэ.

3.Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, лавлах, зонхилон тохиолдох өвчний эмчилгээ, оношлогооны стандартыг боловсруулж мөрдүүлнэ.

4.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын эмийн талаархи үзэл баримтлалд тулгуурласан эмийн зохистой хэрэглээний тасралтгүй сургалтад эмнэлгийн мэргэжилтнийг хамруулна.

5.Эмийн тухай бодит мэдээллийг олон нийтэд хүргэх, хүн амд эмийн зохистой хэрэглээний мэдлэг олгох, түүнийг төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

6.Эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх сургалт, судалгааны ажлын зохион байгуулалтыг оновчтой болгоно.

7.Эмийн сурталчилгааг холбогдох хууль тогтоомж болон олон улсын хэмжээнд баримталдаг ёс зүйн хэм хэмжээний хүрээнд явуулах нөхцөл бүрдүүлнэ.

Тав. Бусад

1.Засгийн газар нь эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх явцад салбар хооронд зохицуулан, зохион байгуулж, байгууллагын ажиллах нөхцөл, уялдаа холбоог сайжруулахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

2.Төрийн ба төрийн бус байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн эм хангамжийн байгууллагаас гадаадын болон олон улсын байгууллагатай эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар үр ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг дэмжинэ.

3.Эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг Засгийн газар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамруулж, тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

4.Эмийн талаар төрөөс баримтлах бодлого нь ойрын 10 жилийн хугацаанд эм хангамжийн хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлох үндсэн баримт бичиг болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 3–ны өдөр Дугаар 140 Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Түлш, эрчим хүч, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Мөнхнасангийн Баянтөр - МУИС-ийн газар зүй, геологийн факультетын багш
2. Мядагийн Бум-Аюуш - Шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн "Эрчим" корпорацийн гүйцэтгэх захирал

3. Хамарын Дамдинжав	- АУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн гүн ухааны багш
4. Лувсандоржийн Дарамбазар	- "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн инженер
5. Доржийн Дашхүү	- Боловсролын хөгжлийн сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан
6. Дамбадаржаагийн Дорж	- Монголын Үндэсний олимпийн хорооны мэргэжилтэн
7. Төмөрбаатарын Доржжүгдэр	- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн хичээлийн эрхлэгч
8. Сампилын Жадамбаа	- Нүүрсний "Налайх-Од" ХХК-ийн захирал
9. Чойрогийн Жамсран	- Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч
10. Гэндэнгийн Намхайжанцан	- Ус, цаг уурын хүрээлэнгийн уур амьсгалын судалгааны секторын эрхлэгч
11. Зундуйн Өлзиймаа	- П. Н. Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлгийн нүдний мэс заслын тасгийн эрхлэгч
12. Цэвэлийн Төмөрбаатар	- Нийслэлийн "ДЦС-4" ХК-ийн зуухан цехийн засварчин
13. Жакулагийн Хавдлашим	- Орхон аймгийн "Эрдэнэт дулааны станц" ХК-ийн гүйцэтгэх захирал
14. Даваагийн Цолмон	- МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн багш
15. Мишигдоржийн Цэвэгмид	- Дорнод аймаг дахь Шаталсан сургалттай техник технологийн сургуулийн захирал
16. Сандаг-Очирын Юнрэн	- Завхан аймгийн Биеийн тамир, спортын хорооны дарга, бөхийн дасгалжуулагч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Төмирбекийн Авуталив	- Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 10 жилийн сургуулийн бага ангийн багш
2. Пүрэвийн Алгаа	- "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Дархан-Уул аймаг дахь Дархан Сэлэнгийн салбарын монтёр
3. Дэлгэрийн Амгаланбаатар	- "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Багануур-Чойрын салбарын ерөнхий инженер
4. Цогтын Баасан	- Булган аймгийн Булган сумын "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн багш
5. Лувсангийн Баасанбат	- Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа авто баазын жолооч
6. Балдангийн Баатар	- Нийслэлийн уул уурхайн олборлолт, борлуулалтын "Газрын элч" ХХК-ийн уурхайн дарга
7. Содномын Баатар	- Дорнод аймгийн Чойбалсан сумын 10 жилийн сургуулийн математикийн багш
8. Мөнхжаргалын Базаррагчаа	- МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн хэл шинжлэлийн тэнхимийн багш
583. Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-11-8-ны хууль) 1293
584. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-11-8-ны хууль) 1293

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

585. Дүрэм батлах тухай Дугаар 71 1293
586. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилттах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 73 1293
587. Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилттах төрийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 74 1300
588. Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 75 1301
589. Зарим улс төрийн болон тусгай албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 76 1301
590. Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 77 1301

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

591. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 168 1303
592. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг чөлөөлж, томилох тухай Дугаар 169 1303

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

593. Дүрэмд өөрчлөлт оруулах тухай Дугаар 186 1303
594. Тогтоолын хавсралтад хамаарууллах тухай Дугаар 187 1303
595. Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай Дугаар 189 1304
596. " Мянганы зам " - ын чиглэлийн автозамын санхүүжилтийн эх үүсвэрийн тухай Дугаар 191 1305
597. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 192 1305
598. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 193 1306
599. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 194 1306

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 10 дугаар сарын 31–ний өдөр — **Улаанбаатар хот**

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "БНМАУ-ын Консулын дүрэм"-ийг батлах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 42 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7–ны өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2002 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр байгуулсан Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төслийн хөгжлийн Зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7–ны өдөр — **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Нордикийн хөгжлийн сангийн хооронд 2002 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан боловсролын салбарын хөгжлийн хөрөнгө зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 8–ны өдөр — **Улаанбаатар хот**

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд "Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалинг Улсын Их Хурлаас тогтоосон төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг харгалзан Улсын Их Хурал тогтооно." гэсэн 28.10 дахь хэсэг нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 8–ны өдөр — **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуулийн 80.2 дахь хэсгийг "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчнь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаадаа тохирсон цалин авна." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

(Энэ хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хориг тавьсан тул Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр — Улаанбаатар хот

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Прокурорын байгууллагын тухай хуулийн 34.6 дахь хэсгийг "Улсын Ерөнхий прокурор нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаадаа тохирсон цалин авна." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

(Энэ хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хориг тавьсан тул Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр — Улаанбаатар хот

ХӨНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22.3 дахь хэсгийг "Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлдээ тохирсон цалин авна." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр — Дугаар 71 — Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: ёсоор баталсугай.

Монгол Улсын Консулын дүрмийг хавсралт

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 71 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН КОНСУЛЫН ДҮРЭМ

Нэг. Консулын албаны зорилт, зохион байгуулалт, бүрэлдэхүүн

1.Монгол Улсын консулын алба нь дипломат албаны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хилийн чанадад Монгол Улс, түүний иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй байгууллага мөн.

2.Консулын алба нь Монгол Улсаас гадаад улстай найрсаг харилцааг хөгжүүлэх, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн харилцаа, аялал жуулчлалыг өргөтгөхөд тус дэмжлэг үзүүлнэ.

3.Консулын алба нь консулын харилцааны асуудлаарх Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

4.Консулын алба нь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын консулын хэлтэс, Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газраас бүрдэнэ.

5.Консулын алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Дипломат албаны тухай хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэхүү дүрэм болон Монгол Улсын олон улсын гэрээг даган мөрдөж, олон улсын зан заншлын хэм хэмжээг хүндэтгэнэ.

6.Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

7.Консулын албаа Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, суугаа улсад байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний удирдлагын дор ажиллана.

8.Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байхүйл улсад суугаа консул нь гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр, суугаа улстай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын дипломат төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж болно.

9.Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын консулын хэлтсийг Ерөнхий консул буюу Консул зэрэгтэй дипломат ажилтан толгойлно. Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газрыг Ерөнхий консул, Консул, Консулын төлөөлөгч толгойлно.

10. Консул нь энэхүү дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Консул нь Монгол Улс болон суугаа улсын хууль тогтоомжид харшлахгүй бол энэхүү дүрэмд зааснаас өөр үүрэг гүйцэтгэж болно.

11.Консулын байгууллагын түвшин, байршлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, консулын тойргийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус тогтоно.

12.Консулын албаа нь тогтоосон загвараар үйлдсэн тамга хэрэглэнэ.

13.Консулын байгууллага нь Монгол болон суугаа улсын албан ёсны хэлээр бичсэн төрийн сүлд бүхий хаягтай байна.

14.Консулын байгууллага нь Монгол Улсын төрийн далбаат консулын байгууллага байрлаж буй албан байр, албан унаатагаа мандуулж, консулын байгууллагын тэргүүний албан тасалгаанд байрлуулна.

15. Консулд Ерөнхий консул, Консул, Дэд консул, Консулын төлөөлөгч тус тус хамаарна.

16.Консулын албан тушаалтанд Консулын газрын тэргүүн, Консул, Дэд консул, Консулын төлөөлөгч, Консулын газрын нарийн бичгийн дарга, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан дипломат ажилтан тус тус хамаарна.

17.Консулын газрын ажилтанд консулын газарт ажиллаж байгаа үйлчилгээний болон техникийн ажилтан хамаарах бөгөөд тэдгээр нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Хоёр.Консулын албаны эрх зүйн байдал, консулыг томилох журам

1.Консулын албан тушаалтан нь төрийн тусгай албан хаагч мөн бөгөөд Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагдана.

2.Консулын албан тушаалтан гагцхүү Монгол Улсын иргэн байна.

3.Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Ерөнхий консулыг, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга консулын бусад албан тушаалтныг томилно. Консулын албан тушаалтанд гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас консулын патент буюу түүнтэй адилтгах баримт бичгийг олгоно.

Гурав. Консул бүрэн эрхээ хэрэгжүүлэх журам

1.Консул нь суулгах улсаас зөвшөөрөл /"экзекватура"/ олгосны дараа бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлнэ.

2.Консул үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй буюу түүний түр эзгүйд консулын үүргийг түхайн консулын албаны өөр албан тушаалтан, суугаа улсад байгаа Монгол Улсын Консулын өөр газрын албан тушаалтан, эсхүл түхайн улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын дипломат ажилтны аль нэгээр гүйцэтгүүлж болно.

3.Консул нь тойргоороо тогтмол явж ажиллах үүрэгтэй.

4.Консул нь консулын үйл ажиллагаатай холбогдсон бүх асуудлаар түхайн улсын төр, засгийн болон тойргийнхоо эрх бүхий байгууллагатай харилцана.

5.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал эрхэлсэн хэлтэс /алба, газар/ консулын албан тушаалтан, консулын газрын ажилтан нарын үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг холбогдох газруудтай хамтран шалган дүгнэлт гаргаж, шаардлагатай гэж үзвэл эгүүлэн татах түхай саналын хамт гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлагад оруулж шийдвэрлүүлнэ.

6.Консул нь бусад улсын консулын үүргийг зөвхөн Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон суугаа улсын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэж болно.

Дөрөв. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбогдсон асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь Монгол Улсын болон суугаа улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын

гэрээг даган мөрдөж, олон улсын зан заншлын хэм хэмжээг хүндэтгэн, Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

2.Консул иргэний өргөдөл, хүсэлт, гомдлыг бичгээр хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.Консул нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах арга хэмжээ авна.

4.Консул нь тойрогтоо байнга болон түр оршин суух байгаа Монгол Улсын иргэний иргэний бүртгэлийг хөтөлнө.

5.Консул Монгол Улсын төрийн байгууллагын төлөөлөгч болон томилолтоор яваа Монгол Улсын иргэнд албан үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

6.Консул нь Монгол Улсын иргэнд суугаа улсын хууль тогтоомж, тухайн улсын зан заншлыг тайлбарлан таниулж байна. Монгол Улсын иргэн нь тэдний зорчих, шилжин суурьшихтай холбогдуулан гаргасан консулын шийдвэрийг биелүүлнэ.

7.Консул нь тойрогтоо байгаа Монгол Улсын иргэнд Монгол Улсын шинээр гарсан хууль тогтоомжийг тайлбарлан таниулах ба өөрийн улсын худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, урлагийн арга хэмжээ, сурталчилгаа зэрэг ажлыг зохион байгуулахад нь туслалцаа үзүүлэх.

8.Монгол Улсын иргэн өөрөө эзгүй байснаас буюу түүнийг төлөөлөх хүн байхгүйгээс, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалж чадахгүйд хүрвэл Консул нь түүнийг суугаа улсын зохих байгууллагад тусгай итгэмжлэхгүйгээр төлөөлөх эрхтэй. Төлөөлөл нь уг иргэн өөрийгөө төлөөлөх этгээдтэй болох буюу эрх, хууль ёсны ашиг сонирхлоо өөрөө хамгаалах боломжтой болох хүртэл үргэлжилнэ.

9.Консул нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэний цэргийн бүртгэлийг хөтөлж, цэргийн насны Монгол Улсын иргэнийг цэрэгт татах эсэх асуудлыг зохих байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

Тав. Монгол Улсын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллага, шүүхээс өгсөн даалгаврыг биелүүлэх асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

Консул нь олон улсын гэрээ болон суугаа улсын хууль тогтоомжоор хориглоогүй бол Монгол Улсын иргэний асуудлаар Монгол Улсын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллага, шүүхээс өгсөн даалгаврыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу биелүүлнэ.

Зургаа. Харгалзан дэмжих, үрчлэх, асран хамгаалах асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авсныг бүртгэх ба Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэхийг хүсэгч Монгол Улсын иргэн болон гадаадын иргэний хүсэлтийг хүлээн авч Гэр бүлийн тухай Монгол Улсын хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

2.Үрчлэлт хүчингүй болсон тохиолдолд Консул Гэр бүлийн тухай Монгол Улсын хуульд заасналаар тухайн хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй.

3.Консул нь тойрогтоо байгаа эцэг, эхийн асрамжгүй үлдсэн Монгол Улсын харьяат насанд хүрээгүй иргэн, эрүүл мэндийн улмаас эрх эдэлж, үүрэг хүлээх чадваргүй болсон Монгол Улсын харьяат насанд хүрсэн иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоохдоо Гэр бүлийн тухай Монгол Улсын хуульд заасан журмыг баримтлана. Суугаа улсын хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосон нь Монгол Улсын хуулиар хориглоогүй бол хүчинтэйд тооцно.

Долоо. Монгол Улсын иргэний эд хөрөнгөний асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1. Монгол Улсын харьяат иргэн нас барж, эд хөрөнгө нь үлдвэл Консул нь суугаа улсын хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна. Ийнхүү үлдсэн эд хөрөнгө бүхэлдээ буюу хэсэг нь түргэн муудаж гэмтэх зүйл байх, эсхүл уг эд хөрөнгийг хадгалахад зардал их гарахаар бол консул суугаа улсын хууль тогтоомжийн дагуу уг эд хөрөнгийг худалдаж, өмчлөх эрх бүхий этгээдэд мөнгийг илгээнэ.

2.Консул нь Монгол Улсад байгаа өв залгамжлагчид дамжуулан өгөхөөр өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авч, суугаа улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалах, шилжүүлэх, өвлүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

3.Консул нь Монгол Улсын иргэний хүсэлтээр мөнгө, үнэ бүхий зүйл, үнэт цаас, баримт бичгийг хадгалахаар хүлээн авч болно.

4.Эд хөрөнгөө хадгалуулсан хүн нас барвал түүний эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх асуудлыг энэхүү дүрмийн 7 дахь хэсгийн 1, 2-т заасныг баримтлан шийдвэрлэнэ.

5.Суугаа улсаас өөр газар оршин суугаа Монгол Улсын иргэнд өвлөгдөх эд хөрөнгө илэрвэл уг өвлөгдөх эд хөрөнгө, өв залгамжлагчийн талаар гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захир-

гааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Найм. Баривчлагдсан, саатуулагдсан, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэний асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Гэмт хэрэгт сэжиглэгдэж баривчлагдсан, саатуулагдсан, эсхүл хорих ял эдэлж байгаа, түүнчлэн шүүхийн буюу захиргааны журмаар иргэнийхээ эрх, эрх чөлөөг бусад хэлбэрээр хязгаарлуулсан Монгол Улсын иргэний эрхийг хамгаалж, суугаа улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг бариманталж байгаа эсэхэд консул хяналт тавина.

2.Консул нь иймхүү эрхээ хязгаарлуулсан иргэний байгаа нөхцөл нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг ханган байгаа эсэх болон түүнтэй зохих ёсоор харьцаж байгаа эсэхийг хянах, уг иргэний нэр төр, алдар хүндийг хамгаалах, хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэнд сонирхогч этгээдийн хүсэлтээр буюу өөрийн санаачилгаар эргэлт оруулах үүрэгтэй.

Ес.Паспорт, визийн асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь Монгол Улсын гадаад паспорт олгох, зээмших, хадгалах, түүнчлэн Монгол Улсын Дипломат болон Консулын төлөөлөгчийн газраас үндэсний энгийн гадаад паспорт олгох, хугацаат нь сунгах, хүчингүй болгох, бүртгэл хөтлөх, буцах үнэмлэх олгохтой холбогдуулан эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврын дагуу Монгол Улсын иргэнд гадаад паспорт олгох, хугацаат нь сунгах, хүчингүй болгох, буцах үнэмлэх олгох эрхтэй.

2. Консул нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль болон Монгол Улсын виз олгохтой холбогдуулан эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврын дагуу виз олгох, хугацаат сунгах, хүчингүй болгох ба урьд олгосон визэд өөрчлөлт оруулж болно.

Арав. Харьяатын асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь тойргоо оршин суугаа этгээдээс Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гаргасан хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилна.

2.Консул иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний баримт бичгийг шалган, хувийн байдлыг тодорхойлж, тодорхой саналын хамт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд албан бичгээр хүргүүлж, хувийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад явуулна. Хүсэлт гаргасан өргөдөл, холбогдох бусад баримт бичиг гадаад хэл дээр үйлдэгдсэн бол түүний албан ёсны орчуулгыг хавсаргана.

Арваннэг. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын иргэний гэр бүлийн байдлыг бүртэнэ.

2.Консул нь иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд өөрчлөлт оруулах, үрэгдсэн тэмдэг-пэлийг нөхөн сэргээх, овог, нэр солих талаар гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын иргэнээс гаргасан хүсэлтийг хүлээн авч, түүнийг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.Консул иргэний гэр бүлийн байдлыг бүртгэхдээ Иргэний бүртгэлийн тухай Монгол Улсын хууль, хилийн чанад дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газраас иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөхтэй холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан журам, зааврыг баримтална.

Арванхоёр. Нотариатын үйлчилгээ

1.Консул нь Нотариатын тухай Монгол Улсын хууль, эрх бүхий байгууллагаас баталсан нотариатын үйлдэл эрхлэн хийх зааврыг удирдлага болгон дор дурдсан нотариатын үйлдэл хийнэ.

Үүнд:

1/ Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл /гэрээ, гэрээслэл, итгэмжлэл зэрэг/-ийг батлан гэрчлэх;

2/ өв залгамжлах эрх, гэрээслэлийг гэрчлэх;

3/ өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох;

4/ гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрхийг гэрчлэх;

5/ баримт бичгийн бүрэн буюу хэсэгчилсэн хуулбарын үнэн эвийг гэрчлэх;

6/ баримт бичгийн гарын үсгийн үнэн эвийг гэрчлэх;

7/ баримт бичгийн орчуулгын үнэн эвийг гэрчлэх.

2.Нотариатын үйлчилгээг Монгол Улсын консулын албаны байранд хийнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд нотариатын үйлчилгээг өөр газарт хийж болно.

3.Нотариатын үйлчилгээ хийсэн Консул, нотариатын үйлчилгээтэй холбогдсон нууцыг хадгалах үүрэгтэй.

4.Нотариатын үйлчилгээ хийсэн тодорхойлолт, баримт бичгийг үйлчлүүлэгч үйлчилгээний хураамжийг төлсний дараа олгоно.

5.Нэмэлт мэдээ, баримт бичиг гаргуулах буюу баримт бичгийг шалгуулах шаардлагатай бол Монгол Улсын хууль тогтоомжид заасан үндэслэлээр нотариатын үйлчилгээ хийхийг хойшлуулж болно.

6.Нотариатаар батлагдах хэлцэл, өргөдөл, бусад баримт бичгийг үйлчлүүлэгч нотариатын үйлчилгээ хийх Консулын дэргэд гарын үсэг зурна. Хэлцэл, өргөдөл, бусад баримт бичигт Консулыг эзгүй байхад гарын үсэг зурсан бол тухайн этгээд баримт бичигт гарын үсэг зурснаа өөрөө батламжилна.

7.Нотариатын үйлчилгээ хийж байгаа Консул нь нотариатын үйлчилгээг буруугаар ашиглахаас сэрэмжлүүлэх үүднээс нотариатын үйлчилгээний үр дагаврын талаар танилцуулж, эрх, үүргийг нь үйлчлүүлэгчид тайлбарлаж өгөх үүрэгтэй.

8.Консул өөртэй нь болон гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнтэй нь холбоотой асуудлаар нотариатын үйлчилгээ хийж болохгүй.

9.Консул нь нотариатын баримт бичгийг монгол хэлээр хөтөлнө.

10.Нотариатын үйлчилгээ хийгэх этгээд баримт бичгийг хөтлөх хэлийг мэдэхгүй бол уг баримт бичгийн эхийг түүнд орчуулан өгнө.

11.Нотариатын үйлчилгээ хийх нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлахаар бол Консул тийм үйлчилгээ хийхээс татгалзана.

12.Нотариатаар гэрчлүүлэх баримт бичиг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд харшилсан буюу утга агуулгаараа улсын эрх ашигт хор хүргэх, эсхүл иргэний нэр төр, алдар хүндийг гутаах шинжтэй байна гэж үзвэл Консул түүнийг хүлээн авахгүй байж болно.

13.Нотариатын үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан үндэслэл, шалтгааныг үйлчлүүлэгчид мэдэгдэж, хэрэв эс зөвшөөрвөл гомдол гаргах журмыг тайлбарлаж өгнө.

14. Нотариатын үйлчилгээ хийхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

Арвангурав. Консулын баталгаа

1.Консул нь тойргийн эрх бүхий байгуулагын албан тушаалтны оролцоотойгоор үйлдсэн буюу тэдгээс олгосон баримт бичиг, актыг батална.

2.Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын байгуулагууд нь консулын баталгаа бүхий дээр дурдсан баримт бичиг, актуудыг өөрийн эрх хэмжээний хүрээнд хянан үзнэ.

3.Консулын баталгаа гаргах журмыг Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоно.

4. Баримт бичиг, акт нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлах буюу утга агуулгаараа улсын эрх ашигт хор хүргэх, эсхүл иргэний нэр төр, алдар хүндийг гутаах шинж чанартай байна гэж үзвэл Консул түүнийг батлахгүй.

Арвандөрөв. Консулын хураамж

1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад консулын үйлчилгээ хийсний хураамжийг Тэмдэгтийн хураамжийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үйлчлүүлэгч төлнө.

2.Консулын үйлчилгээний хураамжийг харилцан адил байх зарчим баримтлан тухайн улс Монгол Улсын иргэнээс авч буй үйлчилгээний хураамжийн хэмжээтэй адил байхаар тогтоож болно.

Арвантав. Монгол Улсын иргэний агаарын тээврийн асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1.Консул нь Монгол Улсын иргэний агаарын хөлгийн дарга, багийн бүрэлдэхүүн, зорчигчдыг тойргийн эрх бүхий байгуулагад, хүмүүсэй харилцахад нь бүх талын туслалцаа үзүүлнэ.

2. Консул иргэний агаарын тээврийн асуудлаар дор дурдсан эрх эдэлнэ:

1/ иргэний агаарын хөлөгт болсон хэрэг, явдлын талаар иргэний агаарын хөлгийн дарга, багийн гишүүдэд тодорхой асуулт тавьж хариулт авах;

2/ зайлшгүй шаардлагатай үед иргэний агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигчдыг эмчүүлэх буюу Монгол Улсад буцаах арга хэмжээ авах;

3/ иргэний нисэхтэй холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу аливаа баримт бичгийг хүлээн авах, үйлдэх, гэрчлэх.

3.Консул нь өөрийн хариуцсан тойргийн дотор Монгол Улсын иргэний агаарын хөлөг осолд орох, албадлагын улмаас бүрх тохиолдолд түүний багийн гишүүн, зорчигчдод шаардагдах тусламжийг үзүүлнэ.

4.Осолд орсон буюу албадлагын улмаас бүсан агаарын хөлөг, түүний ачаа тээш болон болсон хэрэг явдлыг нотлох баримтыг хамгаалах талаар консул өөрөөсөө шалтгаалах бүх арга хэмжээг авч, уг хэрэг явдлыг мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтнуудад тус дэмжлэг үзүүлнэ.

5.Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын

хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу үүргээ гүйцэтгэхэд нь иргэний агаарын хөлгийн даргад дэмжлэг үзүүлнэ.

6.Консул нь Монгол Улсад буцах өөрийн улсын иргэний агаарын хөлгөөр шаардлагатай үед Монгол Улсын иргэнийг буцаах, шуудан, ачаа, тээш явуулах эрхтэй.

7.Консул нь авто, төмөр зам, усан онгоцны тээвэртэй холбогдсон асуудлаар энэ хэсэгт заасан журмыг баримтална.

Арванзургаа. Мал эмнэлэг, ариун цэврийн хяналтын асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг

1. Консулын тойрогт гоц халдварт өвчин гарах, хэл хорих үед Консул нь хориотой бүс нутаг, өвчний байдал, суугаа улсын холбогдох байгууллагаас авч байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Энэ тухай Монгол Улсын сонирхогч бусад байгууллагад Консул мэдээлж болно.

2.Консул нь Монгол Улсад нэвтрэх зөвшөөрөл авсан иргэдэд тарилга хийлгэсэн тухай олон улсын гэрчилгээг Монгол Улсад орох үедээ заавал үзүүлэхийг мэдэгдэнэ.

3.Консулын тойрогт хүн, малын гоц халдварт өвчин гарах, хөдөө аж ахуйн хортон буй болох, мал, амьд амьтан үй олноор өвчлөх буюу өвчин дэлгэрэх аюул гарах үед Консул нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

4.Консул нь Монгол Улсад зорчих зөвшөөрөл авсан иргэдэд мал, амьд амьтад, тэдгээрийн гаралтай түүхий эд, хүнсний зүйлстэй авсан мал эмнэлгийн гэрчилгээг Монгол Улсад орох үедээ заавал үзүүлэх тухай болон Монгол Улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээр, ариун цэврийн талаарх хууль тогтоомжийн талаар мэдээлэл егнө.

Арвандолоо. Өргөмжит консул

1. Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад улстай тохиролцсоны үндсэн дээр консулын зарим үүргийг Өргөмжит консул томилон ажиллуулах замаар гүйцэтгүүлж болно.

2.Өргөмжит консул нь Монгол Улсын буюу гадаад улсын иргэн байж болно.

3.Өргөмжит консулын үйл ажиллагааг Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батална журмаар зохицуулна.

4.Өргөмжит консул нь Монгол Улсын төрийн албан хаагчид хамаарахгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Дугаар 73** **Улаанбаатар хот**

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг хавсралтаар батална.

2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адилтгах төрийн улс төрийн болон төрийн тусгай албан тушаалын зэрэглэл тогтоож байхыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДААТАЙ АДИЛТГАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛ

Зэрэг зиндаа	Улс төрийн албан тушаал	Захиргаа-ны албан тушаал	Тусгай албан тушаал	Адилтгах албан тушаалын зэрэглэл	Улс төрийн албан тушаал	Захиргааны албан тушаал	Тусгай албан тушаал
ТӨ-I	Монгол Улсын Ерөнхийлөгч						
ТӨ-II	Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд						
ТӨ-III	Монгол Улсын Их Хурлындэд дарга		Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч				
ТӨ-IV	Монгол Улсын Их Хурлынгишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд		Монгол Улсын Ерөнхий прокурор	ТӨ-IVA	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэрүүлэгч-дийн дарга, Нийс-лэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч		Төрийн хянан шалгах хорооны дарга
ТӨ-V	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын дээд шүүхийн шүүгч	ТӨ-VA	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Аймгийн ИТХ-ын Тэрүүлэгчдийн дарга, Аймгийн Засаг дарга	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга	Монгол Банкны Ерөнхийлөгч, Үндэсний статистикийн газрын дарга, МУ-ын Ерөнхий прокурорын орлогч, МУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга
ТӨ-VI	Дэд сайд			ТӨ-VIA	Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн, Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга	Монгол банкны дэд ерөнхийлөгч, Төрийн хянан шалгах хороо-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Үндэс-ний статистикийн газрын дэд дарга, МУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 74 Улаанбаатар хот

Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5, 28.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг хавсралтаар батлуулсугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан цалинг 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын дор дурдсан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай:

1/ "Цалин тогтоох тухай" 1994 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоол;

2/ "Ажилд томилох, цалин тогтоох тухай" 1994 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 49 дүгээр тогтоол;

3/ "Цалинг тогтоох тухай" 1995 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоол;

4/ "Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн болон албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай" 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 65 дугаар тогтоол;

5/ "Цалингийн хэмжээ тогтоох тухай" 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 67 дугаар тогтоол;

6/ "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн тухай" 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 66 дугаар тогтоол;

7/ "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 1997 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 73 дугаар тогтоол;

8/ "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 43 дугаар тогтоол;

9/ "Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол;

10/ "Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай " 2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоол;

11/ "Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүний сарын цалингийн хэмжээг тогтоох тухай" 2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 2 дугаар тогтоол;

12/ "Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай" 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 78 дугаар тогтоол.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их хурлын 2002 оны 74 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨНДӨР БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Төрийн өндөр албан тушаалын зэрэг зиндаа	Түүнтэй адилтгах төрийн албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ (сард төгрөгөөр)
ТӨ - I		203400
ТӨ - II		153300
ТӨ - III		118000
ТӨ - IV	ТӨ - IVA	113200
ТӨ - V	ТӨ - VA	104900
ТӨ - VI	ТӨ - VIA	100000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 8–ны өдөр Дугаар 75 Улаанбаатар хот

Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүний туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 65600 төгрөгөөр, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 43000 төгрөгөөр тус тус батална.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан цалинг 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтны цалинг тогтоох тухай" Улсын Их Хурлын 2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 13 дугаар тогтоол, "Улсын Их Хурлын гишүүний туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 79 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 8–ны өдөр Дугаар 76 Улаанбаатар хот

Зарим улс төрийн болон тусгай албан тушаалын албан жлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Багийн Засаг дарга нарт олгох албан жлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 15 хувиар тогтоосугай.

2. Улс төрийн болон тусгай албан тушаалын албан жлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг хууль тогтоомжоор тусгайлан тогтоосноос бусад тохиолдолд албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 1, 2 дахь хэсэгт заасан нэмэгдлийн хэмжээг 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 8–ны өдөр Дугаар 77 Улаанбаатар хот

Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28. 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээ"-г 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын сарын цалингийн хэмжээ"-г 2 дугаар хавсралтаар тус тус батална.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан цалинг 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор тогтоосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 80 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 77 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр)
1	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	100848
2	Нийслэлийн шүүхийн шүүгч	92729
3	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	96788
4	Аймгийн шүүхийн шүүгч	89777
5	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	90850
6	Дүүргийн шүүхийн шүүгч	86691
7	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	90850
8	Сум, сум дундын шүүхийн шүүгч	86691

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 77 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	АЛБАН ТУШААЛ	Албан тушаалын сарын цалин /төгрөгөөр/
1	Улсын ерөнхий прокурын газрын туслах прокурор	99678
2	Улсын ерөнхий прокурын газрын хяналтын прокурор	91654
3	Нийслэлийн прокурор	99195
4	Нийслэлийн прокурорын орлогч	92209
5	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	85500
6	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	84000
7	Аймаг, тээврийн прокурор	95202
8	Аймаг, тээврийн прокурорын орлогч	88305
9	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	85500
10	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	84000
11	Дүүргийн прокурор	87216
12	Дүүргийн прокурорын орлогч	85500
13	Дүүргийн прокурорын газрын туслах прокурор	84000
14	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	83223
15	Сум, сум дундын ахлах прокурор	87216
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	83223

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 168 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Базаррагчаагийн Баярсайханыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэндэвийн Тэрбишдагвыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 169 Улаанбаатар хот

Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг чөлөөлж, томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 7 дахь заалтыг баримтлан, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Даваажавын Батсайханыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээс чөлөөлсүгэй.

2. Найдангийн Төрбатыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын18-ны өдөр Дугаар 186 Улаанбаатар хот

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 100 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "хувийн хэрэг хетлөх", "Хууль зүйн сайд Л.Цог" гэснийг тус тус хассугай.

2. Засгийн газрын 1999 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Барилга байгуулалжийн ашиглалтын дүрэм"-ийн 19 дүгээр зүйлийг "19. Энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан улсын буртгэлийн гэрчилгээг Барилга техникийн хяналтын асуудал хариуцсан Засгийн газрын агентлаг олгоно." гэж өөрчлөн найруулж, мөн дүрмийн 18 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын18-ны өдөр Дугаар 187 Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад хамааруулах тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэл, аймгийн төвөөс бусад сум, суурин газарт байрладаг радиотехник, радиолокаторын анги, салбарын офицер, ахлагч нарт олгох хүнсний хангамжийг "Хүнсний

хангамжийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлсан хэмжээгээр тогтоосугай.

2.Нийслэл, аймгийн төвөөс бусад сум, суурин газарт байрладаг агаарын довтолгооноос хамгаалах радиотехник, радиолокаторын анги, салбарын офицер, ахлагч нарт олгох хүнсний хангамж, меҥгөн урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг 2003 оноос эхлэн төвлөрсөн төсөвт тусгаж байхыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18–ны өдөр **Дугаар 189** **Улаанбаатар хот**

Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Дотоодын цэргийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоог дарга 1, дэд дарга 1 байхаар тогтоож, түүний бүтцийг дор дурдсанаар батлсугай:

а/Эрүүгийн цагдаагийн алба;

б/Мөрдөн байцаах алба;

в/Хэрэг бүртгэх алба;

г/Хэв журам хамгаалах алба;

д/Замын цагдаагийн алба;

е/Цагдаагийн академи;

ж/Шинжилгээний хүрээлэн;

з/Санхүү, аж ахуйн алба;

и/Холбооны хэлтэс;

к/Мэдээлэл, судалгааны төв.

2. Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдлагад Дотоодын цэрэг /штаб/ ажиллуулахаар тогтоосугай.

3. Цагдаагийн ерөнхий газрын төв аппаратын орон тооны дээд хязгаарыг офицер, улирагч 45, энгийн орон тооны ажилчин, албан хаагч 14, бүгд 59 хүнтэй байхаар тогтоосугай.

4. Хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа цагдаагийн байгууллагад төвлөрч байгаатай холбогдуулан Зэвсэгт хүчний жанжин штабаас 25, Хил хамгаалах ерөнхий газраас 5, Гал түймэртэй тэмцэх газраас 26, Улсын гаалийн ерөнхий газраас 14, Үндэсний татварын ерөнхий газраас 13 хэрэг бүртгэгчийн орон тоог цалингийн сан, ашиглаж байгаа автомашин, холбогдох техник хэрэгслийн хамт Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоо, бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 180 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 191** **Улаанбаатар хот**

"Мянганы зам"-ын чиглэлийн авто замын санхүүжилтийн эх үүсвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мянганы зам"-ын Баяннуур-Дашинчилэнгийн чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам тавих ажилд шаардагдах хөрөнгийн 50 хувийг улсын төвлөрсөн төсвөөс, үлдсэн 50 хувийг зам тавьж дууссны дараа эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хязгаарлагдмал тендер зарлахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

2. Баяннуур-Дашинчилэнгийн чиглэлийн авто зам тавих тендерийн гүйцэтгэгчийг шалгаруулахдаа "Мянганы зам"-ын баруун чиглэлийн 1 км хатуу хучилттай авто замын дундаж өртгөөс хэтрүүлэхгүй байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

3. Авто замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг холбогдох хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 192** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 8, 9 дүгээр хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. 8 дугаар хавсралтын "Дэд дарга" гэсэн хэсэгт "-Улсын иргэний хамгаалалтын газрын дарга" гэж нэмж, мөн хавсралтын "Гишүүд" гэсэн хэсгээс "-Улсын иргэний хамгаалалтын газрын дарга" гэснийг хассугай;

2. 9 дүгээр хавсралтад "Гишүүд" гэсэн хэсгээс "Санхүү, эдийн засгийн дэд сайд" гэснийг хасч, "Дэд дарга –Санхүү, эдийн засгийн сайд" гэсэн нэмэлт оруулж, мөн хавсралтын "Дэд бүтцийн дэд сайд" гэснийг "Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 193** **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа 18851-50000 төгрөг хүртэлх бүрэн тэтгэвэр, 12376 төгрөгөөс дээших хувь тэнцүүлсэн тэтгэврийг 20 хувиар, 50001 төгрөгөөс дээших бүрэн тэтгэврийг 15 хувиар тус тус нэмэгдүүлж 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс тооцон олгох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

2. 2002 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 22600 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 14860 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 88 дугаар тогтоол, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 194** **Улаанбаатар хот**

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 20 хувиар, хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлж 2002 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эдэлгэ
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (280)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хоюордсон алтнаи, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаанд зохицуулах тухай*
- *Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Татварын сонхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арваннэгдүгээр сарын 22 №43 (280)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

600. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаог зохицуулах тухай (2002-11-7-ны хууль) 1308

601. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-11-7-ны хууль) 1311

602. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-7-ны хууль) 1311

603. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-7-ны хууль) 1312

604. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-11-7-ны хууль) 1312

605. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-7-ны хууль) 1312

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

606. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 195 1313

607. Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 196 1318

608. Хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 198 1318

609. Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах зарим арга хэмжээний тухай Дугаар 200 1318

610. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 201 1320

611. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 204 1320

612. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 206 1320

613. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 207 1320

614. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Дугаар 211 1321

615. Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай Дугаар 212 1321

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7–ны өдөр

Улаанбаатар хот

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци /цаашид "Конвенци" гэх/-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаагаа зохицуулах тухай хууль тогтоомж

2.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаагаа зохицуулах тухай хууль тогтоомж нь Амьтны аймгийн тухай[1], Байгалийн ургамлын тухай[2], Ан агнуурын тухай[3], Гаалийн тухай хууль[4], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь зөвхөн дэлхийд ховордсон Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүн /цаашид "эд зүйл" гэх/-ийг олон улсад худалдаалах хүрээнд үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

4 дүгээр зүйл. Конвенцийг хэрэгжүүлэх байгууллага

4.1. Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, орон тооны бус Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тус тус ажиллана.

4.2. Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.3. Удирдан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь байгаль орчин, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, гааль, мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага, байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байна.

5 дугаар зүйл. Удирдан зохицуулах зөвлөл

5.1. Удирдан зохицуулах зөвлөл дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Монгол Улсад Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. Конвенцийн хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх, нэмэлт тайлбар хийх тухай асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5.1.3. Конвенцийн хавсралтад шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Талуудын бага хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл боловсруулж Засгийн газарт уламжлах;

5.1.4. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлоход гаалийн хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох;

5.1.5. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг реэкспортлох болон далай тэнгисээс олборлон оруулах, Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлоход гэрчилгээ олгох;

5.1.6. энэ хуулийн 6.1-д заасан дүгнэлт, тодорхойлолтыг гаргуулахаар Шинжлэх ухааны зөвлөлд уламжлах;

[1] Амьтны аймгийн тухай-"ТМ" сэтгүүлийн 2000 оны № 19-д нийтлэгдсэн.

[2] Байгалийн ургамлын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6-д нийтлэгдсэн.

[3] Ан агнуурын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6-д нийтлэгдсэн.

[4] Гаалийн тухай-"ТМ" сэтгүүлийн 1996 оны № 9-д нийтлэгдсэн.

5.1.7. Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тайланг жил бүр Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх;

5.1.8. холбогдох хууль тогтоомжийн дагуу хураан авсан амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг борлуулах, устгах, байгальд нь эргүүлэн тавих ажлыг зохион байгуулах;

5.1.9. энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах.

6 дугаар зүйл. Шинжлэх ухааны зөвлөл

6.1. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан дүгнэлт, тодорхойлолт гаргах үүрэгтэй:

6.1.1. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, далай тэнгисээс олборлон оруулахад тухайн амьтан, үргамал оршин тогтноход хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт;

6.1.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг импортлож буй этгээд тухайн амьтныг арчилж маллах зохих нөхцөл бүрдүүлснийг нотолсон тодорхойлолт;

6.1.3. Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан, Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг гаршуулж тэжээсэн, үргамлыг тарьж үргүүлсан, тэдгээрийн гаралтай эд зүйл болохыг нотолсон дүгнэлт;

6.1.4. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдаа хийхэд байгаль орчинд хор хохирол учрах эсэх талаархи дүгнэлт.

6.2. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан асуудлаар Удирдан зохицуулах зөвлөлд зөвлөмж өгнө:

6.2.1. Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, үргамлын тоо хэмжээг харгалзан экспортыг хязгаарлах шаардлагатай эсэх талаар;

6.2.2. Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн талаар.

6.3. Энэ хуулийн 6.2-д заасан зөвлөмжийг Удирдан зохицуулах зөвлөл хүлээн аваагүй тохиолдолд Шинжлэх ухааны зөвлөл уг зөвлөмжийг хүлээн авах шаардлагатай гэж үзвэл байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл. Конвенцийн хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа

7.1. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалахыг хоригломо.

7.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвхөн судалгаа, шинжилгээ хийх, музей, амьтны хүрээлэнд байршуулах, циркэд тоглуулах зориулалтаар олон улсад худалдаалж болно.

7.3. Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалж болно.

7.4 Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу Конвенцийн хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахад тухайн амьтан, үргамлын оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүй, цаашид харшлахаар ашиглалт явуулахгүй байгаа нөхцөлийг ханган зорилгоор тусгай журмын дагуу явуулна.

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан журмыг байгаль орчны болон газлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

7.6. Энэ хуулийг зөрчиж Конвенцийн хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахыг хоригломо.

8 дугаар зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Конвенцийн хавсралтад орсон амьтан, үргамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтэй Удирдан зохицуулах зөвлөлд гаргана.

8.2. Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.3. Зөвшөөрөл, гэрчилгээний загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4. Зөвшөөрөл, гэрчилгээ нь олгогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хүчинтэй байна.

8.5. Зөвшөөрөл, гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хоригломо.

9 дүгээр зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох, олгохоос татгалзах

9.1. Удирдан зохицуулах зөвлөл нь дараахь нөхцөлийг харгалзан зөвшөөрөл, гэрчилгээ олгоно:

9.1.1. энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан дүгнэлт, тодорхойлолтыг авсан эсэх;

9.1.2. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 6.1.4-т заасан дүгнэлт авсан эсэх;

9.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нотлийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт;

9.1.4. реэкспортлох гэж буй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг энэ хууль болон зохих зөвшөөрлийн дагуу импортлосон эсэх;

9.1.5. амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх;

9.1.6. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохоо импортлогч улсын эрх бүхий байгууллагаас импортын зөвшөөрөл урьдчилан авсан эсэх;

9.1.7. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олж авахдаа Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай[1], Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль[2] заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.

9.2. Удирдан зохицуулах зөвлөл дараахь үндэслэлээр зөвшөөрөл, гэрчилгээ олгохоос татгалзана:

9.2.1. энэ зүйлийн 9.1-д заасан нөхцлүүдийг хангаагүй;

9.2.2. хуурамч баримт бичиг ашигласан нь тогтоогдвол.

9.3. Бусдад шилжүүлсэн, хүчинтэй байх хугацаа дуусан, зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүйд тооцно.

[1]Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 8-9-д нийтлэгдсэн.

[2] Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 8-9-д нийтлэгдсэн.

10 дугаар зүйл. Хөнгөлөлт

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг гаршуулан тэжээсэн, тарьж үрүүлсан бол тэдгээрийг Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамалд хамааруулан үзэж олон улсад худалдаалах зөвшөөрөл, гэрчилгээг энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

10.2. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний зүйлээ импортлох, эсхүл импортлогч орны зөвшөөрөл шаардагдахаас бусад тохиолдолд экспортлохдоо зөвшөөрөл авахгүй.

10.3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалтыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10.4. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг дамжуулан өнгөрүүлэхэд аливаа зөвшөөрөл авахгүй.

10.5. Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэлтэй эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ашиг олох зорилгогүйгээр түр ашиглах, бэлэглэх, хандивлах, солилцох, музейд хадгалуулах зориулалтаар Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвшөөрөлгүй импортлоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

11 дүгээр зүйл. Зөвшөөрөгдсөн боомт

11.1. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг Монгол улсын хилээр нэвтрүүлэх боомтыг Удирдан зохицуулах зөвлөлийн саналыг үндэслэн гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

12 дугаар зүйл. Конвенци, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах

12.1. Удирдан зохицуулах зөвлөл Конвенци, түүний хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх, нэмэлт тайлбар хийх тухай саналаа боловсруулж 14 хоногийн дотор Засгийн газарт уламжлана.

12.2. Засгийн газар үг асуудлыг 30 хоногийн дотор хэлэлцээд холбогдох шийдвэрийн төслийг

Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

12.3. Удирдан зохицуулах зөвлөл Конвенци, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж Засгийн газарт уламжилна.

12.4. Засгийн газар уг асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөн Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

13.1.Энэ хуулийн хэрэгжилтэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гаалийн болон орон нутгийн холбогдох байгууллага тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина

14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

14.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээнээ 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

15 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

15.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаат зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, гаалийн буюу байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурьдсан шийтэл ногдуулна:

15.1.1. энэ хуулийн 7.6 дахь хэсгийг зөрчиж Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохиз зөвшөөрөлгүйгээр олон улсад худалдаалсан иргэнийг 50000 хүртэл, албан тушаалтныг 60000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгож, тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хураан авч улсын орлого болгох;

15.1.2. энэ хуулийн 8.5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн, эсхүл хугацаа хэтэрсэн, хуурамч зөвшөөрөл, гэрчилгээ ашигласан иргэнийг 50000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгож, хууль бусаар олсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хураан авч улсын орлого болгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7–ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн "Усны тухай" гэсний дараа "Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7–ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 13 дугаар зүйлд дор дурдсан хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/ Монгол Улсын хүн амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан орлогод ногдох албан татвар."

2/ 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 19 дэх заалт:

"19/ орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татвар."

3/ 13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Төсвийн тэнцэлтэй холбогдуулан доод шатны төсвийн орлогын тодорхой хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлж болно."

2 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д зааснаас бусад хүн амын орлогод ногдох албан татвар;"

3 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дугаарыг "6" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7, 8 дахь заалт нэмсүгэй:

1/ 16 дугаар зүйлийн 7 дахь заалт:

"7/ хүн амын орлогын албан татвар;"

2/ 16 дугаар зүйлийн 8 дахь заалт:

"8/ орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар."

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 39 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Лиценз эзэмшигч нь энэ хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлберийн тайланг Үндэсний татварын албаанаас батлагдсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны эхний сарын 20-ны дотор Үндэсний татварын албанд тушаана."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5.3.18 дахь заалт:

"5.3.18. үсчин, гоо сайхны үйлчилгээ."

2/ 5.5 дахь хэсэг:

"5.5. Улс хооронд зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд дор дурдсан хэмжээгээр албан татвар ногдуулна:

Ажил үйлчилгээний төрөл	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/	
	Замын-Үүд, Алтан-булаг боомтоор	Бусад боомтоор
1. Улс хооронд зорчигч тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд:		
а/ 4 хүртэл хүний суудалтай автомашинаар	10000	6000
б/ 8 хүртэл хүний суудалтай автомашинаар	12000	8000
в/ 16 хүртэл хүний суудалтай автомашинаар	14000	10000
г/ автобусаар	18000	12000
2. Улс хооронд ачаа тээвэрлэх үйлчилгээ хийх тухай бүрд:		
а/ 1-3 тн-ын даацтай автомашинаар	16000	10000
б/ 3-5 тн-ын даацтай автомашинаар	18000	12000
в/ 5-8 тн-ын даацтай автомашинаар	20000	14000
г/ 8-аас дээш тн-ын даацтай автомашинаар	22000	16000
д/ тракторааp	10000	4000

3/ 5.6 дахь хэсэг:

"5.6. Автомашины суудлын хэмжээ, даац 2 ангилалд давхардсан тохиолдолд өмнөх ангиллаар тооцож албан татвар ногдуулна."

2 дугаар зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 6.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.2. Энэхүү хуулийн 5.3-д заасан ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, Улаанбаатар хотод 10000 төгрөг, Налайх, Багануур, Дархан-Уул , Орхон аймгийн төвийн сумд болон байгын ажиллагаатай боомттой сумдад 8000 төгрөг, бусад аймгийн төвийн сумдад 6000 төгрөг, бусад газарт 4000 төгрөгийг сар бүр бэлнээр буюу бэлэн бусаар урьдчилгаа хэлбэрээр төлж, албан татвар төлөгчийн гэрчилгээ авч тэмдэглүүлэн татварын тайлангаар дараа тооцоо хийж байна."

3 дугаар зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5.1.12-ын "/1 метр тутмаас/" гэснийг 5.3.9-ийн "улс" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 195** **Улаанбаатар хот**

Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захирагааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндэсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батална 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 224 дүгээр тогтоол, "Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 89 дүгээр тогтоол, "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 232 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/сард төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	42200	45200	49000	52000	55000	58600	61200	64600	68100	71600	75400	78700	82300
2	45200	48800	53100	56500	59800	63300	66100	69300	73300	76400	84400	87400	89600
3	48200	52400	57200	61000	64600	68100	71000	74000	78500	81100	93400	95100	96800
4	51300	56000	61300	65400	69400	72800	75800	78600	83600	85800	-	-	-
5	54300	59600	65400	69800	74200	77500	80600	83300	88700	90500	-	-	-

Тайлбар: Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний шинэ ба хуучин шатлалыг дор дурдсанаар дүйцүүлэн хэрэглэнэ.

Цалингийн сүлжээний шатлал	Цалингийн сүлжээний шатлал (хуучнаар)												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	1-3	1-3	1-5	1-6	1-6	1-5	1-4	1-3	1-3	1-3	1-3	1-3	1-3
2	4-7	4-7	6-11	7-12	7-11	6-11	5-9	4-7	4-8	4-7	4-12	4-10	4-9
3	8-11	8-11	12-15	13-16	12-16	12-15	10-14	8-12	9-12	8-11	13-16	11-14	10-12
4	12-16	12-16	16-20	17-22	17-22	16-22	15-19	13-17	13-17	12-15	-	-	-
5	17-20	17-20	21-23	23-25	23-25	23-25	20-22	18-20	18-20	16-18	-	-	-

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/сард төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	52200	55000	58600	61100	64600	68100	71500	74200	78100	82000	86000
2	56800	59800	63300	65900	69300	73000	76100	78600	85900	89400	93200
3	61400	64600	68100	70800	73900	77900	80600	83000	93600	96800	100500
4	65900	69400	72900	75600	78500	82800	85200	87500	-	-	-
5	70500	74200	77500	80500	83300	87700	89800	91900	-	-	-

Тайлбар: Ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээний шинэ ба хуучин шатлалыг дор дурдсанаар дүйцүүлэн хэрэглэнэ.

Цалингийн сүлжээний шатлал	Цалингийн шатлал (хуучнаар)										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	1-4	1-6	1-6	1-4	1-4	1-4	1-3	1-2	1-3	1-2	1-2
2	5-9	7-11	7-11	5-9	5-8	5-8	4-8	3-6	4-8	3-7	3-7
3	10-15	12-16	12-16	10-15	9-13	9-13	9-12	7-10	9-14	8-12	8-11
4	16-19	17-21	17-21	16-19	14-17	14-17	13-16	11-14	-	-	-
5	20-22	22-25	22-25	20-22	18-20	18-20	17-18	15-16	-	-	-

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	39200	42200	45200	48200	49500	50200	53200	55000	58700	59100	60100	61100	64600	68100	70400	74100	78100	82300
2	42300	45200	48800	52300	53700	54800	57900	59800	63200	63800	64900	66000	69300	73300	75400	83300	86700	89600
3	45400	48200	52400	56400	57900	59400	62600	64600	67600	68500	69700	70800	74000	78500	80400	92600	95300	96800
4	48500	51200	56000	60400	62100	64000	67200	69400	72100	73100	74400	75700	78700	83600	85300	-	-	-
5	51600	54300	59600	64400	66400	68600	71800	74200	76500	77800	79200	80500	83300	88700	90200	-	-	-

Тайлбар: Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний шинэ ба хуучин шатлалыг дор дурдсанаар дүйцүүлэн хэрэглэнэ.

Цалингийн сүлжээний шатлал	Цалингийн сүлжээний шатлал (хуучнаар)																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	1-2	1-2	1-2	1	1	1	1-2	1-2	1-2	1-2	1-2	1-2	1	1	1	1-2	1-2	1
2	3-5	3-4	3-4	2-3	2-3	2-3	3-4	3	3-4	3	3	3	2-3	2-3	2-3	3-5	3-5	2-4
3	6-7	5-7	5-8	4	4	4	5	4-5	5-6	4-5	4-5	4-5	4-5	4-5	4-5	6-7	6-7	5-6
4	8-10	8-10	9-10	5-6	5-6	5	6-7	6-7	7-8	6-7	6-7	6-7	6-7	6-7	6-7	-	-	-
5	11-12	11-12	11-12	7	7	6-7	8	8	9	8	8-9	8	8	8	8	-	-	-

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

Цалингийн доод жишгийн шатлал	Албан тушаалын зэрэглэл													
	ТУ-1	ТУ-2	ТУ-3	ТУ-4	ТУ-5	ТУ-6	ТУ-7	ТУ-8	ТУ-9	ТУ-10	ТУ-11	ТУ-12	ТУ-13	ТУ-14
1	32700	34300	36000	37900	40400	43700	47000	50300	53600	57800	61900	67700	74300	80900
2	35500	37000	38500	40200	43100	46600	49900	53200	56500	60700	68100	73500	79300	87400
3	38200	39600	40900	42500	45800	49500	52800	56100	59400	63600	74300	79200	84200	93900
4	40900	42300	43400	44800	48500	52400	55400	59000	62300	66500	-	-	-	-
5	43600	45000	45800	47000	51200	55300	58000	61900	65200	69300	-	-	-	-

Тайлбар: 1. Төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийн шинэ ба хуучин шатлалыг дор дурдсанаар дүйцүүлэн хэрэглэнэ.

Цалингийн доод жишгийн шатлал	Цалингийн шатлал (хуучнаар)													
	ТУ-1	ТУ-2	ТУ-3	ТУ-4	ТУ-5	ТУ-6	ТУ-7	ТУ-8	ТУ-9	ТУ-10	ТУ-11	ТУ-12	ТУ-13	ТУ-14
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1-2	1-2	1-2	1-2
2	2-3	2-3	2-3	2-3	2-3	2-3	2-3	2-3	2-3	2-3	3-5	3-5	3-5	3-6
3	4	4	4	4	4	4	4	4	4	4	6-7	6-7	6-7	7
4	5-6	5-6	5-6	5-6	5-6	5-6	5-6	5-6	5-6	5-6	-	-	-	-
5	7	7	7	7	7	7	7	7	7	7	-	-	-	-

2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн тогтоохдоо тэдний одоо авч байгаа албан тушаалын цалинг энэхүү доод жишгийн тохирох шатлалын өсөлтийн дундаж хувиар нэмэгдүүлэн тооцно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 196** **Улаанбаатар хот**

Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй:

Дүүргийн Засаг дарга	70600-83200
Сумын Засаг дарга	65600-78100
Хорооны Засаг дарга	53100-63100
Багийн Засаг дарга	46200-55600

2. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалын цалинг тухайн шатны Засаг даргын албан тушаалын цалинтай адил байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 233 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр **Дугаар 198** **Улаанбаатар хот**

Хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Олон улсын байгууллагын татвар, хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "51. Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр **Дугаар 200** **Улаанбаатар хот**

Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах зарим арга хэмжээний тухай

Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбогдон гарч байгаа нийтлэг дутагдлыг арилгах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах нийт санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 3500 /гурван сая таван зуун мянга/ мянган төгрөгөөр, суманд 850 /найман зуун тавин/ мянган төгрөгөөр тус тус тогтоож, эрийн гурван наадамд тэргүүн байр эзэлсэн бөх, морьд /уяачид/, сур харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Орон нутгийн чанартай наадам, урлагийн тоглолт, спортын төрөл бүрийн тэмцээн зохион байгуулах, уул, овоо тахих ёслол болон салбарын ойг тэмдэглэхтэй холбогдсон зардлыг төсөв, бизнес төлөвлөгөөндөө тусгахгүй, тусгасан ч өөрийн орлогоо давуулсан нэрийдлээр төсөв хэтрүүлэн

төрийн өмчийн байгууллагын болон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосугай.

3. Тухайн жилийн батлагдсан төсвөт тусгагдаагүй хөрөнгө оруулалтын чанартай засвар, үйлчилгээ хийх, автомашин, тавилга, тоног төхөөрөмж худалдан авахыг хориглохыг төсвийн байгууллагын бүх шатны эрх захирагч, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эрх баригчдад даалгасугай.

4. Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, дэд сайд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирал, тэдгээртэй адилтгах албан тушаалтнуудаас ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахдаа Засгийн газрын 1994 оны 76 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хүндэтгэлийн зоог барих болон ёслол хүндэтгэлийн бусад арга хэмжээг зохион байгуулахад соргууруулах үндаа хэрэглэх журам"-д заагдсан хэмжээг баримтлах, бусад тохиолдолд соргууруулах үндаа хэрэглэхийг хориглосугай.

5. Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагууд төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх албан ёсны шийдвэр болон хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбогдсон мэдээллээс бусад өөрийн байгууллага, хамт олныг суртаалчлах, танилцуулга явуулах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулахыг хориглосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ,ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны
200 дугаар тогтоолын хавсралт

Үндэсний баяр наадмын арга хэмжээнд зориулсан
эрийн гурван наадамд тэргүүлсэн бөх, морьд, сур харваачдад
төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээ

/мянган төгрөгөөр/

	Улсын наадам	Аймгийн наадам	Сумын наадам
А.БӨХ			
Түрүүлсэн	1000,0	200,0	50,0
Үзүүрлэсэн	700,0	150,0	35,0
Шөвгөрсөн	400,0	100,0	25,0
Б.МОРЬ			
Их нас, азарга			
Түрүү	600,0	200,0	50,0
Аман хүзүү	500,0	150,0	35,0
Гурав	400,0	100,0	25,0
БУСАД			
Түрүү	500,0	150,0	35,0
Аман хүзүү	400,0	100,0	25,0
Айрагдсан	300,0	50,0	15,0
В.СУР ХАРВАА			
1-р байр	400,0	150,0	35,0
2-р байр	300,0	100,0	25,0
3-р байр	200,0	50,0	15,0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 201** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 18 дахь заалт нэмсүгэй:

"18.Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын Монголын хэсэг:

Дарга Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга".

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 204** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Олон улсын байгууллагуудын татвар, хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "52.Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (ПЕКК)" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 206** **Улаанбаатар хот**

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1998 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Соёл, урлагийн сангийн дүрэм"-ийн 2 дугаар заалтын "... хөржүүлэх ..." гэснийг дараа "соёлын ажилтны мэргэшил дээшлүүлэх" гэж, мөн дүрмийн 14 дүгээр заалтад "м) соёлын ажилтны мэргэшил дээшлүүлэх" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 207** **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2000 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам"-ын 33 дугаар зүйлийн "хуулбарын" гэснийг хасч мөн зүйлд "Сургалтын төрийн сан зээлээр суралцан төгсөгчдэд дипломын хуулбарыг олгож байна." гэж нэмсүгэй.

2. Засгийн газрын 2000 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ын 7 дугаар заалтын "а"-гийн "500" гэснийг "700" гэж өөрчилсүгэй.

3. Боловсролын тухай багц хууль батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 96 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, мөн тогтоолоор батлагдсан журмын 1, 4, 7, 8, 9, 10, 12, 13 дугаар заалт, 17 дугаар заалтын "а", 20 дугаар заалт, 23 дугаар заалтын "а", "б", "г", 25, 41 дүгээр заалтад, "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 158 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, мөн тогтоолоор батлагдсан журмын 1, 2, 3 дугаар заалт, 8 дугаар заалтын "б", 9, 10 дугаар заалтад, "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1, 5 дугаар заалт, 6 дугаар заалтын "б", 7, 8, 9, 14, 15, 21 дүгээр заалтад тус тус "их сургууль" гэсний дараа "дээд сургууль" гэж нэмсүгэй.

4. Засгийн газрын 2000 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Терийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ын 6 дугаар заалтын "д"-г хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 211** **Улаанбаатар хот**

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Засгийн газраас олгосон хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Төмөртийн овооны уулын баяжуулах үйлдвэрийг барих БНХАУ-ын Өнгөт төмөрлегийн гадаад барилга, зураг төслийн компанийн 458 ажилтан, мэргэжилтнийг 2002 оны 10 дугаар сарын 16-наас 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

2. Дээрх компанийн 458 ажилтан, мэргэжилтнийг дурдсан хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 212** **Улаанбаатар хот**

Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай

Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл"-ийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Хавсралтад заасан чиглэлийн дагуу хилийн боомтуудын талаар хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрүүдэд өөрчлөлт оруулах асуудлаар ОХУ, БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай хэлэлцээ хийж, тохиролцох арга хэмжээ авахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, боомтын дэглэм сахиулах үйл ажиллагаа болон энэхүү чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хилийн боомтын хяналтын байгууллагуудыг холбоожуулах асуудлыг хамтран шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хилийн зарим боомтыг олон улсын боомт болгох тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоолын "...Баян-Өлгий аймгийн Өлгий хотын нисэх онгоцны буудал,..." гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Засгийн газрын 2002 оны
212 дугаар тогтоолын хавсралт

ХИЛИЙН БООМТУУДЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хэтийн төлөв, улс хоорондын болон дотоодын бүх төрлийн замын сүлжээ, Мянганы замын гол гарцууд, чөлөөт бүсийн байршилтай уялдуулан, дэд бүтцийн салбарын хөгжлийн ойрын болон хэтийн зорилт, хилийн бүсийн орон нутгийн ашиг сонирхол, хилийн боомтуудын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг харгалзан шинээр хилийн боомт нээх, хаах, хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрээр нэгэнт тогтоосон боомтуудын үйл ажиллагааг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд дор дурдсан чиглэл баримтална:

Нэг. Сайжруулан өргөтгөх боомтууд:

а. Монгол-Хятадын хилд

1. Булган-Такашикен авто замын боомт
Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох.

2. Бургастай-Лаоемяо авто замын боомт
Улсын хилд ойртуулан шилжүүлж, хэлэлцээрийн дагуу ажиллуулах.

3. Шивээхүрэн-Сэхээ авто замын боомт
Улсын хилд ойртуулан шилжүүлж, байнгын ажиллагаатай болгох.

4. Замын-Үүд-Эрээн авто замын боомт
Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох.

5. Бичигт-Зүүн хатавч авто замын боомт
Өргөжүүлэн тохижуулж, байнгын ажиллагаатай болгох.

б. Монгол-Оросын хилд

1. Цагааннуур-Ташанта авто замын боомт
Хэлэлцээрийн дагуу олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох.

2. Ханх-Монд авто замын боомт
Өргөжүүлэн тохижуулж, хэлэлцээрийн дагуу ажиллуулах.

3. Эрээнцав-Соловьёвск авто замын боомт
Хэлэлцээрийн дагуу олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох.

Хоёр. Хаах боомтууд

а. Монгол-Хятадын хилд

1. Даян-Хуншаньзюй авто замын боомт
Ганц модны чиглэлээр шинээр боомт нээх тохиолдолд хаах.

2. Байтаг-Улиастай авто замын боомт
Булган-Такашикен боомтыг байнгын ажиллагаатай болгох тохиолдолд хаах.

3. Баянхошуу-Өвдөг авто замын боомт
Тухайн хэсэгт Нөмрөг-Рашаантын чиглэлд шинээр боомт нээх тохиолдолд хаах.

б. Монгол-Оросын хилд

1. Давст-Сарыг Холь дамжин өнгөрөх боомт
Ашиглах шаардлагагүй тул хаах.

2. Тэс-Сарыг Холь дамжин өнгөрөх боомт
Ашиглах шаардлагагүй тул хаах.

3. Шишгэд гол-Ушь бэлдир түр ба улирлын ажиллагаатай боомт
Ашиглах боломжгүй тул хаах.

4. Хонгор-Овоо-Боций авто замын боомт
Ашиглах шаардлагагүй тул хаах.

Гурав. Шинээр нээх боомтууд

Монгол-Хятадын хилд

1. Нөмрөг-Рашаант авто замын боомт
Түмэн гол төслийн хүрээнд болон Мянганы замын зүүн хэсгийн гол гарц болох Дорнод аймгийн Сүмбэр сумын Нөмрөгийн чиглэлд шинээр байгуулах.

2. Ханги-Мандал авто замын боомт
Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг, хилийн 324 дүгээр тэмдгийн чиглэлд шинээр байгуулах.

3. Ганц модны авто замын боомт
Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг,хилийн 31 дүгээр тэмдгийн чиглэлд шинээр байгуулах.

Дөрөв.Хэвээр ажиллах боомтууд

Энэхүү чиглэлийн нэг, хоёр, гурав дахь бүлэгт дурдаагүй боомтууд хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрт заасны дагуу одоогийн журмаар хэвээр ажиллана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 44 (281)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай*
- *Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай*
- *Монгол Улсын 2003 оны төсвийн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арваннэгдүгээр сарын 29 №44 (281)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

616. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай (2002-11-20-ны хууль) 1324
617. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-11-20-ны хууль) 1327
618. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-11-21-ний хууль) 1328
619. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-11-21-ний хууль) 1328
620. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай (2002-11-21-ний хууль) 1328
621. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай (2002-11-21-ний хууль) 1329
622. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай (2002-11-21-ний хууль) 1329
623. Монгол Улсын 2003 оны төсвийн тухай (2002-11-21-ний хууль) 1329

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

624. Нийгмийн хамгааллын талаар санал боловсруулах тухай Дугаар 79 1331
625. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 81 1331
626. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 82 1331

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

627. Ким Жон Ре-г "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 170 1331
628. Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах тухай Дугаар 171 1332
629. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 173 1335

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

630. Монголын хүүхдийн биеийн тамир, спортын их наадам зохион байгуулах тухай Дугаар 213 1336
631. Жүрам батлах тухай Дугаар 214 1336

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

632. Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 03 1339

2002 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл
1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нэгдсэн төсөв, төсвийн захирагчийн эрх, үүрэг, төсвийн орлого, зарлагын ангилал, төсвийн гүйцэтгэлийн тайлагнах, төсвийн бүртгэлтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Төсвийн тухай хууль тогтоомж нь Ìîíãîë Óëñûí ¯íäñýí õóóëü[1], энэ хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль[2], тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл Төсөв, түүний бүрэлдэхүүн

3.1.Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийг жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэнэ.

3.2.Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс бүрдэнэ:

3.2.1.Улсын Их Хурлаас батлагдсан, Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ.

3.2.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг орон нутгийн төсөв гэнэ.

3.3. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

4 дүгээр зүйл.Төсвийн жил

4.1.Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

5 дугаар зүйл. Төсвийн захирагч

5.1.Улсын Их Хурал болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын батлагдсан төсвийг төсвийн жилд захиран зарцуулах, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх, гүйцэтгэлийг гаргаж тайлагнах үүрэг бүхий төрийн захирагааны болон төсөвт байгууллагын зохих эрх олгогдсон албан тушаалтныг төсвийн захирагч гэнэ.

5.2.Төсвийн захирагчийг ерөнхийлөн захирагч, шууд захирагч гэж ангилна.

5.3.Төсвийн захирагчийн хүлээх эрх, үүргийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

6.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь эрх, үүрэгтэй :

6.1.1. төсвийн захирагч, төсөвт байгууллагын төсвийн төсөөллийг хүлээн авч хянах, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн нэттэн боловсруулах;

6.1.2. төв, орон нутгийн санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

6.1.3. төсөвт байгууллагуудад мөрдөгдөх нийтлэг заавар, журмыг энэ хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, батлан мөрдүүлэх;

6.1.4. төсвийн байгууллагуудын харилцах дансны байршил, дансны бүтэц, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

6.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрийн орлогын зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан авах ;

[1] Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

[2] Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

6.1.6. санхүүгийн жилийн явцад эдийн засгийн гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс шалтгаалан батлагдсан төсөвт тодотгол хийх Засгийн газрын саналыг боловсруулах;

6.1.7. төсөвт байгууллагад олгогдсон төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг зохион байгуулж, тайланг гаргуулан авах;

6.1.8. тухайн жилийн төсвийг батална тухайн жилийн төсөв болон төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн орлого, зарлагын дэлгэрэнгүй ангилаар эрхэлсэн сайд нарт хуваарилан хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавих.

6.2. Дээлийг эргүүлж төлөх баталгааг Засгийн газрын зөвшөөрснөөр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана. Төсөөс нэмэгдэл санхүүжилт шаардагдах гэрээ, хэлэлцээрийг зөвхөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр байгуулна.

7 дугаар зүйл. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх

7.1. Тухайн шатны төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нь:

7.1.1. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргатай;

7.1.2. сум, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төсвийн орлого, зарлага

8 дугаар зүйл. Төсвийн орлого

8.1. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор бүх шатны төсөвт зохих хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн хуримтлуулж байгаа албан татвар, төлбөр, хураамж, хүү, торгууль болон гадаад, дотоод бусад эх үүсвэрээс бүрдэх орлогыг төсвийн орлого гэнэ.

8.2. Төсвийн орлого татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ:

8.2.1. татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар[3] тодорхойлсон албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ;

8.2.2. татварын бус орлого төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орох бусад орлогоос бүрдэнэ.

9 дүгээр зүйл. Улсын төсвийн орлого

9.1. Улсын төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

9.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар;

9.1.2. нэмэгдсэн өртгийн албан татвар;

9.1.3. онцгой албан татвар;

9.1.4. гаалийн албан татвар;

9.1.5. автобензин, дизелийн түлшний албан татвар;

9.1.6. ашигт малтмал\алт\-ын нөөц ашигласны төлбөр;

9.1.7. ашигт малтмалын хайгуулын болон ашигт малтмал ашиглах лицензийн төлбөр;

9.1.8. хүн амын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар.

9.2. Улсын төсвийн татварын бус орлого дараахь орлогоос бүрдэнэ:

9.2.1. төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

9.2.2. төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого;

9.2.3. хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт орох бусад орлого.

9.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь улсын төсвийн бүрэлдэхүүн байна.

10 дугаар зүйл. Орон нутгийн төсвийн орлого

[3] Татварын ерөнхий хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн - 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн

10.1. Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

10.1.1. хотын албан татвар;

10.1.2. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

10.1.3. газрын төлбөр;

10.1.4. үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

10.1.5. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар.

10.2. Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого дараахь орлогоос бүрдэнэ:

10.2.1. орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

10.2.2. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

10.2.3.улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт;

10.2.4. хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт орох бусад орлого.

10.3. Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

10.3.1.Монгол Улсын хүн амын орлогын àëáàí òàòâàðûí òóõàé[4] хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад;

10.3.2. бууны албан татвар;

10.3.3. улсын тэмдэгтийн хураамж;

10.3.4. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

10.3.5. ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж;

10.3.6. байгалийн үргамал ашигласны төлбөр;

10.3.7. ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;

10.3.8.түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;

10.3.9. ус, рашаан ашигласны төлбөр;

10.3.10. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татвар.

10.4. Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараахь орлогоос бүрдэнэ:

10.4.1. орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

10.4.2. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

10.4.3. хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого.

11 дүгээр зүйл. Төсвийн зарлага

11.1. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд батлагдсан төсөөс төсвийн захирагчийн үйл ажиллагаа, түүний үр дүнг санхүүжүүлэхээр хуваарилж, зарцуулж буй төсвийн хөрөнгийг төсвийн зарлага гэнэ.

11.2.Төсвийн хөрөнгийн хуваарилалт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлан гаргахтай холбогдсон харилцааг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар зохицуулна.

11.3. Орон нутгийн төсөөс санхүүжүүлэхээс бусад төрийн үйл ажиллагааг улсын төсөөс санхүүжүүлнэ.

12 дугаар зүйл. Төсвийн орлого, зарлагын ангилал

12.1. Төсвийн орлогыг дараахь байдлаар ангилна:

12.1.1. татварын нэр төрлөөр;

12.1.2. төсвийн орлогын нэр төрлөөр;

12.1.3. төсвийн орлогыг төвлөрүүлэгч байгууллагаар.

12.2. Төсвийн зарлагыг дараахь байдлаар ангилна:

12.2.1. эдийн засгийн ангиллаар хуваарилсан төсөв;

12.2.2. бүтээгдэхүүний ангиар хуваарилсан төсөв;

12.2.3. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв;

12.2.4. төсвийн ерөнхийлөн захирагчид хуулиар харьяалуулсан байгууллагын төсөв.

12.3. Төсвийн орлого, зарлагын дэлгэрэнгүй ангиллыг Засгийн газар тогтоож, батална.

12.4. Энэхүү ангиллыг төсвийн тухайн шатны захирагчид дагаж мөрдөх үүрэгтэй.

13 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сан

13.1. Засгийн газрын захиран зарцуулах

[4] Хүн амын орлогын албан татварын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

эрхийн хүрээнд Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй зардлын эрсдэлийн санг улсын төсвийн бүрэлдэхүүн хэлбэрээр, Улсын Их Хурлын зөвшөөрлөөр байгуулан зарцуулж болно.

13.2. Байгалийн гэнэтийн аюул, гамшигт үзэгдэл болон гадаад, дотоод зах зээлийн орчны нөлөөллийн улмаас нийт эдийн засаг, улсын төсөвт учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор жил тутам дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн санг байгуулж болно.

13.3. Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй зардлын эрсдэлийн санг бүрдүүлэх, зарцуулах , хуваарилагдаагүй зардлыг зарцуулах журмыг хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

14 дүгээр зүйл. Төсвийн өдөр тутмын гүйлгээг гүйцэтгэх

14.1.Монгол Улсын төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.

14.2.Төрийн сангийн дансыг Монголбанк, түүний харьяа салбарууд болон гэрээний үндэсэн дээр арилжааны банкуудад байршуулж болно.

14.3.Улсын төсвийн орлого, зарлагын холбогдох зарим гүйлгээг Монголбанк, бусад банк холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

14.4.Орон нутгийн төсвийн орлого, зарлагын тэнцэл хангагдаагүй нөхцөлд шаардлагатай аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

14.5.Төсвийн тэнцэлтэй холбогдуулан доод шатны төсвийн орлогын тодорхой хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлж болно.

15 дугаар зүйл.Төсвийн гүйцэтгэлийг тайлагнах

15.1.Засгийн газар улсын төсөв /үүний дотор Засгийн газрын тусгай сан, хуваарилагдаагүй зардал/-ийн гүйцэтгэлийг бүтэн жилээр гаргаж УлсынИх Хуралд өргөн мэдүүлнэ.

15.2.Улсын төсвийн гүйцэтгэлийг тайлагнах журмыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар зохицуулна.

16 дугаар зүйл. Төсвийн бүртгэл

16.1. Монгол Улсын төсвийн бүртгэл нь Засгийн газрын санхүүгийн бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байна.

16.2. Монгол Улсын төсвийн бүртгэлийн стандарт, ангилал, аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож, батална.

16.3. Төсвийн байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаархи журам, заавар, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ.

17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

17.1.Энэ хуулийг 2002 оны 11 дүгээр сарын 21 -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 20–ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Төсвийн тухай 1992 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: "14.4.Жирэмсний болон амаржсны нэг сарын тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтооно."

2/ 16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл. Олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрх, тэтгэмжийн хэмжээ

16.1.Дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлж байгаа эх /эцэг/ жил тутам олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрхтэй.

16.2.Олон хүүхэдтэйн тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтооно."

3/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: "17.2.Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтооно."

4/ 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: "19.2.Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн бол хүүхэд тус бүрт улирал тутам олгох тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтооно."

5/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

" 25.1.5.байнгын асрамжид байдаг /16 хүртэл насны/ тахир дутуу хүүхдээ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд нэн ядуу амьдралтай өрхийн гишүүн, асран хамгаалагч /нэг хүн/-д амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газраас тогтоосон хэмжээний тусламжийг хүүхдээ асрахад нь зориулж сар бүр олгоно;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

АХМАД НАСТАН, ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт: "2/ 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгараалтад оролцсон ахмад настан болон түүнд амь үрэгдсэн дайчны эхнэр, нөхөрт амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газраас тогтоосон хэмжээний тусламжийг жилд 2 удаа, гавъяат цолтон ахмад настанд жилд 1 удаа олгоно;"

2/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"2/амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газраас тогтоосон хэмжээний тусламжийг улиралд нэг удаа олгоно;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ТЭТГЭМЖИЙН ДООД ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмж болон нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэмжийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинг жишиг болгон бүсийн ялгаваргүйгээр тухайн оны түвшингээс бууруулахгүйгээр Засгийн газар тогтооно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль батлагдсантай холбогдуулан Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН 2003 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2003 оны төсвийн орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар батлсугай. Үүнд:

1.1.ОРЛОГО-БҮГД	**455.737.865.6**
1.1.1.Албан татварын орлого	**343.317.054.4**
1.1.1.аорлогын албан татвар	64.174.097.5
1.1.1.б.нэмэгдсэн өртгийн албан татвар	113.327.680.0
1.1.1.в. онцгой албан татвар	59.238.400.0
1.1.1.г. автобензин, дизелийн түлшний албан татвар	5.789.400.0
1.1.1.д. гаалийн албан татвар	26.643.200.0
1.1.1.е. бусад албан татвар	16.091.507.7
1.1.1.ж. нийгмийн даатгалын шимтгэл	58.052.769.2
1.1.2.Татварын бус орлого	**104.220.811.2**
1.1.2.а хувьцааны ногдол ашиг	5.752.036.0
1.1.2.б бусад орлого	12.421.170.0
1.1.2.в. түрээсийн орлого	8.850.000.0
1.1.2.г. газрын төсөө орлого	660.000.0
1.1.2.д.төсөөт байгууллагын өөрийн орлого	59.037.605.2
1.1.2.е.навигац /еңгөрөлт/-ийн орлого	12.500.000.0
1.1.2.ж. Монголбанкнаас орох орлого	5.000.000.0
1.1.3.Гадаад тусламжийн орлого	**8.200.000.0**

2 дугаар зүйл. Монгол Улсын 2003 оны төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин,хөрөнгө оруулалтын санхүүжилт, төсөө захиргачдын төсвийн багц, тэтгэврийн даатгалын санд өгөх татаасын дээд хэмжээг дор дурдсанаар батлсугай.

2.1.ЗАРЛАГА-БҮГД	**558.198.727,8**
2.1.1.Монгол Улсын Еренхийлөгчийн төсөө	796.550.5
2.1.2. Монгол Улсын Их Хурлын төсөө	2.543.208.5
2.1.3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөө	66.206.1
2.1.4 Улсын Дээд шүүхийн төсөө	167.709.0
2.1.5.Шүүхийн ерөнхий эзэлөлийн төсөө	227.014.5
2.1.6.Орон нутгийн шүүхийн төсөө	1.806.989.0
2.1.7.Прокурорын байгууллагын төсөө	1.670.527.1
2.1.8.Үндэсний аюулгүй байдлын эзэлөлийн төсөө	54.189.7
2.1.9.Монгол Улсын Ерөнхий сайдын төсөө	139.756.0
2.1.10.Тагнуулын ерөнхий газрын төсөө	2.881.045.8

2.1.11.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөв 12.865.520.4

2.1.12.Гадаад хэргийн сайдын төсвийн багц 8.020.157.7

2.1.13.Санхүү, эдийн засгийн сайдын төсвийн багц 123.555.938.9

2.1.14.Хууль зүй, дотоод хэргийн сайдынтөсвийн багц 40.934.040.6

2.1.15.Байгаль орчны сайдын төсвийн багц 4.280.421.0

2.1.16.Батлан хамгаалахын сайдын төсвийн багц 18.186.771.1

2.1.17.Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багц 126.863.406.4

2.1.18.Дэд бүтцийн сайдын төсвийн багц 46.769.366.8

2.1.19.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багц 114.667.160.8

2.1.20.Үйлдвэр, худалдааны сайдын төсвийн багц 2.290.673.2

2.1.21.Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багц 11.260.608.8

2.1.22.Эрүүл мэндийн сайдын төсвийн багц 62.299.687.4

2.1.23.Төрийн захиргааны албаны зөвлөлийн төсөв 121.417.3

2.1.24.Сонгуулийн ерөнхий хорооны төсөв 43.552.0

2.1.25.Хүний эрхийн үндэсний комиссын төсөв 70.777.1

2.1.26.Төрийн хяналт шалгах хорооны төсөв 581.478.6

2.1.27.Үнэт цаасны хорооны төсөв 75.561.6

2.1.28.Үндэсний статистикийн газрын төсөв 431.782.2

2.1.29.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын төсөв 2.181.980.4

2.1.30.Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн төсөв 26.844.0

2.2.1.Цалингийн сан 109.108.407.9

2.2.2.Тэтгэврийн даатгалын санд өгөх татаас 24.422.288.0

2.2.3.Хөрөнгө оруулалт 37.046.000.0

Үүнээс:

-шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг 15.531.200.0

Үүний дотор: 2003 онд санхүүжүүлэх объектын төсөвт өртөг 6.415.200.0

3 дугаар зүйл.Улсын төсвөөс аймгуудын төсөвт олгох санхүүжилтийн дээд хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

3.1.ДҮН	**3.090.795.4**
3.1.1.Архангай	71.189.6
3.1.2.Баян-Өлгий	173.877.9
3.1.3.Баянхонгор	380.658.9
3.1.4.Булган	73.707.3
3.1.5.Говь-Алтай	433.835.4
3.1.6.Дорноговь	0.0
3.1.7.Дундговь	207.756.3
3.1.8.Завхан	224.698.7
3.1.9.Өвөрхангай	315.600.7
3.1.10.Өмнөговь	157.936.5
3.1.11.Сүхбаатар	248.462.6
3.1.12.Сэлэнгэ	0.0
3.1.13.Төв	107.109.4
3.1.14.Увс	344.437.8
3.1.15.Ховд	78.184.6
3.1.16.Хөвсгөл	129.619.0
3.1.17.Хэнтий	62.041.3
3.1.18.Говь-Сүмбэр	81.679.4

4 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай.

4.1.ДҮН	**14.907.872.0**
4.1.1.Дорнод	68.896.8
4.1.2.Дархан-Уул	582.746.9
4.1.3.Улаанбаатар	11.529.140.3
4.1.4.Орхон	2.729.088.0

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны11 дүгээр сарын 22–ны өдөр Дугаар 79 Улаанбаатар хот

Нийгмийн хамгааллын талаар санал боловсруулах тухай

Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2003 онд эдийн засгийн өсөлт, төсвийн гүйцэтгэлийг бүрэн хангах, төрийн албаны шинэчлэлтийг хэрэгжүүлэх үндсэн дээр нэмэлт эх үүсвэр бүрдүүлэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийгмийн хамгааллын зорилтыг ханган биелүүлэх талаар санал боловсруулж, 2003 оны 9 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны11 дүгээр сарын 22–ны өдөр Дугаар 81 Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн14,3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурал 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр батлагдсан "Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны11 дүгээр сарын 22–ны өдөр Дугаар 82 Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн14,3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурал 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр батлагдсан "Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны11 дүгээр сарын 5–ны өдөр Дугаар 170 Улаанбаатар хот

Ким Жон Ре-г "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол-Солонгосын ард түмний найрсаг харилцааг хөгжүүлэх, монголын түүх, соёлыг өөрийн оронд болон дэлхий дахинд сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын өдөр тутмын "Чосон Ильбо" сонины хэлтсийн эрхлэгч Ким Жон Ре-г "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 171 Улаанбаатар хот

Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах тухай

Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дах заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг хавсралтын ёсоор батална.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дүрмийг батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 111 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 171 дүгээр зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Зэвсэгт хүчний Жанжин штаб/цаашид ЗХЖШ гэх/ нь төрийн цэргийн байгуулагуудыг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах дээд байгууллага мөн.

Цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлага гэж улс орны аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах төрийн цэргийн байгуулагуудын үйл ажиллагаог ЗХЖШ-аас Монгол Улсын хуулийн хүрээнд, нэгдмэл зорилт, нэгдсэн стандартаар зохицуулахыг хэлнэ.

1.2. ЗХЖШ-ын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монгол Улсын Зэвсэгт хүчнийг цэргийн мэргэжлийн удирдлагаар хангаж , төрийн цэргийн бодлогыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг цэргийн мэргэжлийн зөвлөмжөөр хангах, Төрийн захиргааны болон цэргийн байгуулагуудад цэргийн бодлого, төлөвлөлтийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

1.3. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн ЗХЖШ-ын тайван болон дайны байдлын үеийн бүтэц, бие бүрэлдэхүүний тооны дээд хязгаарыг тогтооно.

1.4. Хуулиар хүлээсэн чиг үүргээ зэвсэгт хүчин хэрэгжүүлэх үйл ажиллагаат цэргийн мэргэжлийн удирдлагаар хангахад ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтэц нийцэж байна.

1.5. ЗХЖШ-ыг Монгол УлсынЕрөнхийлөгчийн зарлигаар томилогдсон дарга тэргүүлнэ.

ЗХЖШ-ын дарга нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлага дор ажиллана.

1.6. ЗХЖШ үйл ажиллагаага Монгол Улсын хууль тогтоомж , цэргийн дүрэм, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, удирдамж, Засгийн газрын тогтоол , батлан хамгаалах асуудал эрхэлсэн болон төрийн захиргааны бусад төв байгууллагын шийдвэр, ЗХЖШ-ын даргын тушаал, үүргийн хүрээнд явуулна.

1.7. ЗХЖШ тайван цагт ерөнхий зориулалтын цэрэг болон төрийн цэргийн бусад байгуулагын харилцан ажиллагааны үндсийг тодорхойлж, тэдгээрийн штабуудад хууль, дүрмээр хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд удирдамж, чиглэл өгнө.

1.8. ЗХЖШ-ын даргын дэргэд түүнд зөвлөх эрхтэй зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг ЗХЖШ-ын дарга тогтооно.

Зэвсэгт хүчин, цэргийн болон иргэний байгууллагуудын хамтын ба харилцан ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэхэд зөвлөлийн хуралдаанд тэдгээрийн удирдах албан тушаалтныг оролцуулж болно.

1.9. ЗХЖШ зохих журмын дагуу тогтоосон тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Зэвсэгт хүчний Жанжин штабын үүрэг

2.1. Монгол Улсын цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын хувьд ЗХЖШ

дараахь үүрэг хүлээнэ.

2.1.1. Төрийн цэргийн бодлогын асуудлаар санал боловсруулж, холбогдох дээд байгууллагад оруулах;

2.1.2. Олон улсын болон бүс нутгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегийн байдлыг байнга судлан дүгнэлт хийж, төр, засгийн дээд байгууллагуудыг энэ тухай мэдээллээр тогтмол хангах;

2.1.3 Зэвсэгт хүчний удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн холбоо, удирдлагын автоматжуулсан системийн найдвартай байдлыг хангах техник, технологийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;

2.1.4. Монгол Улсын агаарын орон зайд нислэг үйлдэх журмыг тогтоож, биелэлтийг хянах, гадаадын нисэх хэрэгслэлийн нислэгийн байдалд цэргийн мэргэжлийн хяналт тавих;

2.1.5. Орон нутгийн хамгаалалтын бодлогыг тодорхойлоход оролцож, түүний төлөвлөлт, зохион байгуулалтыг хэрэжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

2.1.6. Улсын нөөцөд байх зэвсэгт хүчний хэрэгцээт материал хэрэгслэлийн төрөл, тоо хэмжээ, байршлын талаар санал боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд өргөн мэдүүлэх;

2.1.7. Батлан хамгаалах эрх ашгийн үүднээс нутаг дэвсгэрийн судалгаа явуулах , түүнийг төхөөрөмжлөх талаар санал боловсруулах, цэрэг-стратегийн ач холбогдолтой объектуудын байршлыг тогтоох талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

2.1.8. Цэргийн тагнуулыг зохион байгуулах удирдамж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, дүгнэх;

2.1.9. Цэргийн боловсрол, сургалт бэлтгэлийн болон албаны стандартыг тогтоож мөрдүүлэх;

2.1.10. Зэвсэгт хүчнийг шинэ зэвсэг, техник, материал хэрэгслэлээр хангах санал боловсруулах;

2.1.11. Бүх цэргийн Их хар сүлдний хадгалалт, хамгаалалт, үйлчилгээ, залж цэнгүүлэх, тахилга үйлдэх ёслолыг тогтоосон журмын дагуу зохион байгуулах;

2.1.12. Зэвсэгт хүчинд судалгаа шинжилгээний ажил явуулах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.2 Цэргийн стратегийн төлөвлөлтийн төв байгууллагын хувьд ЗХЖШ дараахь үүрэг хүлээнэ:

2.2.1. Зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг боловсруулан, батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

2.2.2. Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн дэлгэх, түүнийг дайнд ашиглах, улсын хил халхлах ерөнхий төлөвлөлтийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах;

2.2.3. Зэвсэгт хүчний тайван цагийн ба дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

2.2.4. Алан хядах болон тагнуул-хорлон сүйтгэх ажиллагаатай тэмцэх ажиллагаанд зэвсэгт хүчин, цэргийн нэгтгэл, ангийг оролцуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.2.5. Зэвсэгт хүчинд хадгалах материал хэрэгслэлийн нөөцийн хэмжээг тогтоох, бүрдүүлэх, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах.

2.3 Төрийн цэргийн байгууллагуудыг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах дээд байгууллагын хувьд ЗХЖШ дараахь үүрэг хүлээнэ:

2.3.1. Зэвсэгт хүчин, цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудын байлдааны томилгоот бүс, чиглэл, үүргийг тодорхойлох;

2.3.2. Зэвсэгт хүчин, цэргийн нэгтгэл, ангиудын байлдааны жижүүрлэлтийн горимыг тогтоож, гүйцэтгэлд хяналт тавих;

2.3.3. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангуулах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн албан хаагч, цэргийн багийг захиргааны удирдлагаар хангах;

2.3.4. Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн албан тушаалын шалгуур үзүүлэлтийг тогтоох;

2.3.5. Төрийн цэргийн байгууллагуудын офицер, ахлагч нарын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийн жишгийг тогтоох санал боловсруулан холбогдох дээд байгууллагад оруулах;

2.3.6. Цэргийн нийтлэг дүрмүүдийн заалтын хүрээнд цэргийн албыг зохион байгуулах зааврыг батлан гаргах;

2.3.7. Цэргийн мэргэжлийн зэргийн үндэсн

шалгуур үзүүлэлтийг тогтоох;

2.3.8. Цэргийн хүрээ, хотхоны хязгаарыг тогтоох, албан тушаалтнуудыг томилох;

2.3.9. Цэргийн, анги, байгууллагуудад захидал, харилцааны дугаар олгох;

2.3.10. Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд цэргийн хүч хэрэгслээр тусалцаа дэмжлэг үзүүлэх санал, тооцоог боловсруулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.3.11. Аймаг, нийслэлийн цэргийн штабуудыг цэргийн мэргэжлийн удирдлагаар хангах;

2.3.12. Цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний нэгдсэн тооцоог хөтлөх;

2.3.13. Төрийн ёслолын цэргийн арга хэмжээг зохион байгуулж явуулах.

2.4. Ерөнхий зориулалтын цэргийг удирдах дээд штабын хувьд ЗХЖШ тайван цагт дараахь үүрэг хүлээнэ:

2.4.1. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын тайван болон дайны байдлын үеийн орон тоог батлах;

2.4.2. Ерөнхий зориулалтын цэргийн бие бүрэлдэхүүний сургалт, штабуудын бэлтгэлийн чиглэл, арга хэлбэрийг тодорхойлон төлөвлөж, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.4.3. Ерөнхий зориулалтын цэргийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, тэдгээрийг бэлтгэх, давтан бэлтгэх, зохистой байршуулах арга хэмжээ авах;

2.4.4. Ерөнхий зориулалтын цэргийн бие бүрэлдэхүүний бие бялдар, сэтгэл зүй, ёс суртахууны өндөр чанарыг хангах;

2.4.5. Ерөнхий зориулалтын цэргийн ар тал, зэвсэглэл, техникийн бүх төрлийн хангалт, үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах;

2.4.6. Ерөнхий зориулалтын цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудыг байгалийн гамшиг, гэнэтийн аюул осолтой тэмцэх чиглэлээр сурган бэлтгэж, шаардлагатай үед оролцуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4.7. Ерөнхий зориулалтын цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудыг улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр томилгоожуулах, сурган дадлагажуулах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах;

2.4.8. Тайван цагт ерөнхий зориулалтын цэргээр улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх санал, тооцоог боловсруулах,гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.4.9. Цэргийн нийтлэг дүрмүүд , цэргийн албыг зохион байгуулах зааврын хэрэгжилтийг ерөнхий зориулалтын цэрэгт зохион байгуулах;

2.4.10. Ерөнхий зориулалтын цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдаас авах цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах;

2.4.11. Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн нууц хамгаалах журам, цэргийн далдуур удирдлагын горим тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.12. Ерөнхий зориулалтын цэргийн нэгтгэл, ангийн байлдааны туг, тамга, тэмдгийг тогтоосон журмын дагуу үйлдүүлэх;

2.4.13. Ерөнхий зориулалтын цэргийн зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг хангаж, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сэргээн сайжруулалт, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслэлийн хангалтыг төлөвлөж хэрэгжүүлэх;

2.4.14. Ерөнхий зориулалтын цэргийн байлдааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах;

2.4.15. Ерөнхий зориулалтын цэргийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, худалдах, шилжүүлэх, шинээр авах санал боловсруулж батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;

2.4.16. Ерөнхий зориулалтын цэргийн бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах ажлыг эрх хэмжээнийхээ хүрээнд зохион байгуулах;

2.4.17. Ерөнхий зориулалтын цэргийн төсвийн төслийг боловсруулж, батлан хамгаалах болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

2.5. Засгийн газрын тохируулагч агентлагын хувьд ЗХЖШ дараахь үүрэг хүлээнэ:

2.5.1 Зэвсэгт хүчний хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомж, бүх нийтээр дагаж мөрдөх журам, цэргийн тангараг, дүрэм ЗХЖШ-ын даргын тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

2.5.2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн болон дүйцүүлэх албаны бие бүрэлдхүүний сургалт, давтан сургалтанд нутгийн захиргааны

байгууллагуудад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх;

2.5.3 Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын байршил, тэдгээрт тусгай зориулалтаар олгох газрын талаар санал боловсруулах;

2.5.4. Орон нутгийн цэргийн бүтэц, зохион байгуулалт, түүнийг ашиглах бодлогыг тодорхойлох;

2.5.5 Аймаг, нийслэлийн цэргийн дайчилгааны даалгаврыг тогтоох;

2.5.6. Аймаг, нийслэлийн цэргийн дайчилгааны төлөвлөгөө, батлан хамгаалах газрыг дэлгэх болон орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөөг хянан батлах, тэдгээрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх;

2.5.7. Цэргийн дайчилгааны даалгавар бүхий төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжид бие даан эсхүл эрх бүхий байгууллагуудтай хамтран шалган туслах ажил явуулах.

Гурав. Зэвсэгт хүчний Жанжин штабын эрх

3.1 Зэвсэгт хүчний Жанжин штаб дараахь эрх эдлэнэ:

3.1.1Цэргийн бодлоготой холбогдох асуудлаар Монгол Улсын хууль тогтоомж, бусад удирдамжийн баримт бичгийн төсөлд мэргэжлийн санал, дүгнэлт өгөх;

3.1.2 Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд эрх зүйн акт гаргаж, тогтоосон журмын дагуу мөрдүүлэх;

3.1.3 Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр гадаад орнуудын цэргийн дээд штабуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах;

3.1.4 Цэрэг-стратегийн ач холбогдол бүхий иргэний байгууламжийн байршлыг тогтооход мэргэжлийн дүгнэлт гаргах:

3.1.5 Цэргийн төлөвлөгөөт сургууль,дайчилгааны цугларалтын үед МонголУлсын хууль,тогтоомжийн дагуу дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүн,холбоо, тээврийн болон шаардлагатай бусад материал,хэрэгслэлийг дайчлан татах.

3.1.6 Өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар ерөнхий зориулалтын цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд, төрийн цэргийн бусад байгууллагууд, аймаг, нийслэлийн цэргийн штабаас гаргуулан авах хугацаат мэдээний жагсаалтыг тогтоох, шаардлагатай мэдээ, тайлан гаргуулан авах:

3.1.7 Төрийн албаны төв байгууллагаас дүгнэлт гаргуулдгаас бусад ерөнхий зориулалтын цэргийн офицер, ахлагч нарыг албан тушаалд томилох, чөлөөлөх:

3.1.8 Холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд ерөнхий зориулалтын цэргийн офицер, ахлагч нарт цэргийн цол олгох, хасах, цэргийн жинхэнэ албанаас халах болон бэлтгэлд байгаа офицер, ахлагч нарыг цэргийн жинхэнэ албанд татах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны11 дүгээр сарын 8–ны өдөр **Дугаар 173** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашдаваагийн Чулуундоржийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Тугалхүүгийн Баасансүрэнг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 213** **Улаанбаатар хот**

Монголын хүүхдийн биеийн тамир, спортын их наадам зохион байгуулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын хүүхдийн биеийн тамир, спортын их наадмыг 2002-2003 оны хичээлийн жилд орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

2. Их наадмын уралдаан, тэмцээнийг аймаг, орон нутгийн хэмжээнд зохих журмын дагуу санхүүжүүлэн зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, шигшээ багуудын тэмцээнд шаардагдах хөрөнгийг 2003 оны төсвөөс гаргахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 214** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ыг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжихдээ иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэлд хамрагдаагүй иргэдийг 2002 онд багтаан бүртгэлд хамруулах ажил зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 47 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн Газрын 2002 оны 214 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ИРГЭН ШИЛЖИН СУУРЬШИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын иргэн байгаа оршин суух байгаа засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд бүрмөсөн буюу түр шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэн байнга оршин сууж байсан засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног болон түүнээс доош хугацаагаар шилжин суухыг түр шилжин суурьших гэнэ.

1.3. Бүх шатны сургууль, дамжаанд суралцах болон эмчлүүлж сувилуулахаар шилжигчид хугацаа харгалзахгүйгээр түр шилжсэнд тооцогдоно.

1.4. Иргэнийг аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх ажлыг удирдан зохион байгуулах, мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг дарга хүлээнэ.

1.5. Иргэнийг аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх ажлыг удирдан зохион байгуулах, мэдээлэх үүргийг сум, дүүргийн Засаг дарга хүлээнэ.

1.6. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхтэй холбоотой харилцаог Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу зохицуулна.

1.7. Энэхүү журмын биелэлтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, түүний орон нутгийн алба болон тэдгээрийн холбогдох албан тушаалтан (иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч зэрэг) эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

Хоёр. Иргэн шилжин суурьших тухай хүсэлт гаргах, түүнийг хүлээн авч шийдвэрлэх

2.1. Аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьшихыг хүссэн иргэн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, аймаг, нийслэлийн дотор шилжин суурьшихыг хүссэн иргэн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт байнга оршин сууж байгаа баг, хороогоороо уламжлан өргөдөл гаргана.

2.2. Өргөдөлдөө овог, эцэг (эх)-ийн нэр, нэр, ам бүлийн байдал, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эрхэлж байгаа ажил, мэргэжил, шилжих болсон шалтгаан, аль сум, дүүрэг, баг, хороонд шилжин суурьших болон амьдрах хаягийг тодорхой бичнэ.

2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь шилжин суурьших тухай иргэдийн хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

2.4. Иргэний шилжин суурьших тухай өргөдлийг шийдвэрлэх асуудлыг дор дурдсан үндэслэлээр түр хойшлуулж болно:

2.4.1. шүүхийн тогтоолоор баривчлагдсан, ял тэнсэн, эсхүл албадан ажил хийж байгаа бол шийтгэлийн хугацааг дуустал;

2.4.2. гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэгдтэл;

2.4.3. гэр бүлээ цуцлуулах өргөдөл өгсөн бол энэ тухай шүүхийн шийдвэр гартал;

2.4.4. ажиллаж байсан байгууллагадаа өр төлбөртэй бол түүнийг барагдуултал;

2.4.5. асран хамгаалагч, харгалзан дэмжигчээ орхиж байгаа бол түүнийг хэрэхийг шийдтэл;

2.4.6. иргэний баримт бичгийн зөрчилтэй бол түүнийг арилгатал;

2.4.7. цэргийн албыг биеэр хаахаар татагдсан бол тухайн албыг хаах хугацаа дуустал;

2.4.8. хуульд заасан бусад үндэслэл.

Гурав. Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх

3.1. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу дараахь баримт бичгийг үндэслэн иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх дэвтэр (цаашид "Бүртгэлийн дэвтэр" гэх)-т бүртгэнэ:

3.1.1. Монгол Улсын иргэний үнэмлэх;

3.1.2. Монгол Улсын иргэн 16 нас хүрээгүй бол түүний төрсний гэрчилгээ;

3.1.3. гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн бол үндэсний гадаад паспорт;

3.1.4. хорих газраас суллагдсан хүн бол шүүхийн шийдвэр биелүүлэх газраас олгосон магадалгаа;

3.1.5. иргэнийг тухайн хүн мөн болохыг гэрчлэх бусад баримт бичиг;

3.1.6. батлан хамгаалах болон цагдаагийн байгууллагын алба хаагч бол томилогдсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

3.1.7. оршин сууж байсан нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хорооны хүн амын бүртгэлээс хасуулсан тухай тодорхойлолт.

3.2. Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар буюу бүрмөсөн шилжиж ирсэн бол 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт оршин суугаа газрынхаа хаягаар бүртгүүлж иргэний үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ.

3.3. Түр шилжин суурьших хөдөлгөөнийг дор дурдсан журмаар бүртгэнэ:

3.3.1. иргэн 31-180 хоногийн хугацаагаар буюу түр шилжин суурьших тохиолдолд байнга оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ бүртгэлийн дэвтэрт "түр эзгүй" гэсэн тэмдэглэл хийлгэж, түр оршин сууж байгаа нутаг дэвсгэрийнхээ баг, хорооны Засаг даргад долоо хоногийн дотор бүртгүүлэх бөгөөд баг, хорооны Засаг дарга нь бүртгэлийн дэвтэрт "түр суугч" гэсэн тэмдэглэлийг заавал хийж түр шилжин суурьшигчын мэдээг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт сар бүрийн 5-ны дотор ирүүлнэ;

3.3.2. иргэн түр оршин суух хугацаандаа байнга оршин суудаг нутаг дэвсгэртээ хүндэтгэх шалтгаанаар бүцаж чадахгүйд хүрвэл түр оршин суух тэмдэглэлдээ сунгалт хийлгэж болох бөгөөд сунгах хугацаа нь 180 хоногоос илүүгүй байна;

3.3.3. өөр аймаг, сумаас бүх шатны сургуульд суралцагчдыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар оршин суугаа хаягаар нь бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ;

3.3.4. иргэдийн аймаг, нийслэлийн дотор түр шилжин суурьших хөдөлгөөнийг тэдний өргөдөл болон энэ журмын 3.1-д заасан холбогдох баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аймаг, хот дотор шилжин суурьших хөдөлгөөнийг энэ тухай тодорхойлолт (ХААТР-22 маягт), хүн амын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг үндэслэн бүртгэнэ;

3.3.5. иргэдийн аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт түр шилжин суурьших хөдөлгөөнийг тэдний өргөдөл болон энэ журмын 3.1-д заасан холбогдох баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар; аймаг, хотод бүрмөсөн шилжин суурьших хөдөлгөөнийг энэ тухай тодорхойлолт (ХААТР-24 маягт), хүн амын бүртгэлээс хасуулсан тухай тодорхойлолт, аймаг, нийслэлд бүрмөсөн шилжин ирэх хөдөлгөөнийг энэ тухай тодорхойлолт (ХААТР-23 маягт)-ыг үндэслэн тус тус бүртгэнэ;

3.3.6. бүртгэлийн дэвтрийн загвар, маягтыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв батална.

3.4. Шилжин суурьших хөдөлгөөнийг дор дурдсан журмаар мэдээлнэ:

3.4.1. шилжин ирэгсэд, явагсдын бүртгэлийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар эрхлэн хөтөлж, сумын Засаг даргын Тамгын газар сар бүрийн мэдээг дараа сарын эхний 10 хоногийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт, аймгийн Засаг даргын Тамгын газар түүнийг мөн сарын эхний 15 хоногийн дотор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд;

3.4.2. дүүргийн Засаг даргын Тамгын газар сар бүрийн мэдээг дараа сарын эхний 10 хоногийн дотор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд мэдээлнэ;

3.4.3. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв шилжин суурьших хөдөлгөөний мэдээг хагас жил тутамд нэгтгэн Үндэсний статистикийн газарт гарган өгнө.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтанд сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга болон иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №44(281)

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2002 оны11 дүгээр сарын 13–ны өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15 цаг 30 минут.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүн Ж.Болдбаатар, Л.Рэнчин, Д.Чилхаажав /илтгэгч/, Н.Чинбат, Ч.Дашням, В.Удвал, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанаар Нийслэлийн Баянгол дүүрэгт оршин суугч Г.Алтан, Чингэлтэй дүүрэгт оршин суугч Ө.Мөнхтуяа, Баянзүрх дүүрэгт оршин суугч Д.Ламжав нарын өргөдлөөр үүссэн Компанийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэв.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргасан иргэн Д.Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганбямба, Х.Балсандорж нар оролцов.

Иргэн Г.Алтан, Ө.Мөнхтуяа нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлнь ... Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3; Арван дөрөвдүгээр зүйл; Арван зургадугаар зүйлийн 3, 14; Арван есдүгээр зүйлийн 1; Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байх тул ... энэ асуудлыг хянан шийдвэрлэж Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлийг хүчингүй болгож өгнө үү " гэжээ.

Иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлнь миний үзэж байгаагаар Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2; Арван дөрөвдүгээр зүйлийн 2; Арван зургадугаар зүйлийн 3; Арван есдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна... Миний энэхүү өргөдөлд дурдсан нэхэмжлэлээр Үндсэн хуулийн маргаан үүсгэж хянан шийдвэрлэж өгөхийг гүнээ хүсье" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж,

"1.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Хувьнийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно" гэсэн заалтын "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэснээс бусад заалт; 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн хувьцааны хяналтын багцыг дангараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан едреесөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй"; 2 дахь хэсгийн "Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй. Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцааг худалдан авах саналыг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ. Энэ саналд хяналтын багц хувьцааг худалдан авсан этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, хаяг, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо, худалдан авах үнийн санал болон саналыг хаах эцсийн хугацаа зэргийг тусгасан байна"; 3 дахь хэсгийн "Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацаа нь хувь нийлүүлэгчдэд саналаа явуулснаас хойш 30 бүтүүнээс дээш хоног байхаар тогтоно"; 4 дэх хэсгийн "Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол

энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал нь энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана"; 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3; Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2; Арван зургадугаар зүйлийн 3), 14); Арван есдүгээр зүйлийн 1; Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно" гэсэн заалтын "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн заалтыг зөрчиж байна.

3.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"; мөн зүйлийн 2 дах хэсгийн "Компани болон түүний энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компани болон өөрт учирсан хохирлыг энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 6-д заасан этгээдэр нөхөн төлүүлэхээр энэ хуулыд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй" гэсэн заалт; түүнчлэн 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компаний төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалтуудад байгаа Компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"; "Хүнийг ...хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

4.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, терийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн 03 дугаар дүгнэлт гаргажээ.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолд:

"1.Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэснээс бусад заалт, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2,3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", мөн хуулийн 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1,2 дахь хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна", "Хүнийг ... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг, мөн хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн холбогдох заалтуудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Ганбаямба Цэцийн хуралдаан дээр "Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь өмчлөгчийн эрхийг зөрчсөн бус харин хувь нийлүүлэгчид тодорхой асуудлыг шийдвэрлэх арга замаа өөр хоорондоо харилцан тохиролцож

түүнийгээ дүрэмдээ тусгах замаар цаашид тухайн асуудлыг шийдвэрлэх боломжийг хуулиар нээж өгч байгаа зохицуулалт юм.

Харин Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2; 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь хувь нийлүүлэгч тус бүр нь удирдлагаас гаргасан шийдвэр бүрийн талаар компанийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаад байх нь шийдвэр гаргах, бие даан үйл ажиллагаа явуулах зэрэгт хүндрэл үүсгэдэг тул дээрх хоёр хүчин зүйлийг тэнцүүлэх үүднээс энгийн хувьцааны нэгээс дээш хувийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчид энэхүү эрхийг эдлэхээр хуульчилсан юм" гэсэн тайлбар өгөв.

ҮНДЭСЛЭЛ:

Нэг. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалт; түүнчлэн 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалтууд нь компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн компанид учирсан хохирлыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байх тул Үндэсн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Хоёр.Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт, 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...болон өөрт..." гэсэн заалт, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2; Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалт; Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр..." гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн заалт, мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна. Учир нь Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт нь гагцхүү хуулиар хязгаарлагдахаар Үндэсн хуулинд заасан иргэдийн өмчлөх эрхийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлахаар болжээ.

2.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...болон өөрт..." гэсэн өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарласан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна"; 2 дахь хэсгийн "хүнийг ...хөрөнгө чинээгээр нь ялгаварлах үл болно" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Компанийн тухай хуулийг бусад хуулиас дээгүүр тавьж, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн хууль байсан ч компанийн хуультай л харшлаагүй бол хүчин төгөлдөр байж болох мэт ойлгогдохоор хуульчилсан нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, терийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдож байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС:

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар

зүйлийн 2,4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн энгийн хувьцааны нэг бэ түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"; 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ...хөренге чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

2.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал егөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно" гэсэн заалтын "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр... " гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...өмчлегчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн заалтыг зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

3.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...болон өөрт..." гэсэн заалтад байгаа компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна"; "Хүнийг ... хөренге чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна"; "Хүнийг ... хөренге чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...болон өөрт..." гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

4.Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгуллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

5.Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

6.Энэ тогтоол эцсийн шийдвэр бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

ДАРГА
ГИШҮҮД

Н.ЖАНЦАН
Л.РЭНЧИН
Ж.БОЛДБААТАР
Д.ЧИЛХААЖАВ
Ч.ДАШНЯМ
В.УДВАЛ
Н.ЧИНБАТ
Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхэтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 – ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (282)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Биогаюулгүй байдлын тухай Картагений Протоколыг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*
- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арванхоёрдугаар сарын 6 № 45 (282)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

633. Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-22-ны хууль) 1344
634. Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-22-ны хууль) 1344
635. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-11-22-ны хууль) 1345
636. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай (2002-11-22-ны хууль) 1345
637. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-11-22-ны хууль) 1345
638. Биоаюулгүй байдлын тухай Картагений Протоколыг соёрхон батлах тухай (2002-11-28-ны хууль) 1346

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

639. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 78 1346
640. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 80 1347
641. Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай Дугаар 83 1381
642. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Дугаар 84 1381

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

643. Цэргийн бодлогын салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай Дугаар 175 1381
644. Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 176 1382

Залруулга

" Төрийн мэдээлэл " эмхтгэлийн 2002 оны арваннэгдүгээр сарын 29-ний өдрийн 44 дүгээрт нийтлэгдсэн " Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу " Олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрх буюу тэтгэмжийн хэмжээ" гэсэн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн " Дөрөв ба түүнээс дээш хүүхэд ... " гэснийг " 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэд ..." гэж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын Хуулийн хэлтэс

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 31.4 хэсэг нэмсүгэй:

"31.4.Иргэний бүртгэл болон иргэний баримт бичгийн бичилтэд өөрчлөлт, залруулга хийх журмыг хуульд зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно."

2 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 12.11.1-ийн "эцгийн нэр," гэсний дараа "нэр," гэж, 34.1, 35.1-ийн "Засаг даргын " гэсний дараа "болон иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийн" гэж, 38.2-ын "аймаг," гэсний дараа "нийслэл," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 12.11.2; 31.2; 38.5-ыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/12.11.2. дахь заалт:

"12.11.2. эцэг, эхийн овог, эцэг, эхийн эцгийн(эхийн) нэр, эцэг, эхийн нэр;"

2/ 31.2. дахь хэсэг:

"31.2.Иргэний бүртгэл, иргэний баримт бичиг тусгагдсан мэдээлэл давхардсан буюу бүрэн бус, үг, үсгийн алдаатай бичигдсэн бол энэ талаар сум, дүүргийн Засаг даргын, эсхүл иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан залруулга хийнэ."

3/ 38.5. дахь хэсэг:

"38.5. Энэ хуулийн 38.2.-т заасан улсын байцаагч нь Иргэний бүртгэлийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоож зохих журмын дагуу шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчид захиргааны хариуцлага хүлээлгэх эрх эдэлнэ."

4 дүгээр зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 24.1.-ийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэснийг "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д заасан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэж, 26.5.-ын "энэ хуулийн 36-д заасан журмыг" гэснийг "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 7.1.1.-ийн "Монгол Улсад оршин суух үнэмлэх," гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 7.1.3; 26.3.6. дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харьяатын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "цагдаагийн төв байгууллага" гэсний дараа ",Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв " гэж; мөн хэсгийн "орон нутгийн цагдаагийн байгууллага," гэсний дараа "иргэний бүртгэл, мэдээллийн алба," гэж ; мөн зүйлийн 5 дахь хэсгийн "Цагдаагийн төв байгууллага" гэсний дараа "болон Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэж; мөн зүйлийн 6 дахь хэсгийн " орон нутгийн цагдаагийн байгууллага " гэсний дараа "болон иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Харьяатын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "албанд хүргүүлнэ." гэснийг "албаар дамжуулан Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлэх бөгөөд тус төв Иргэний бүртгэлийн тухай хуулийн 29.1-д заасан иргэний бүртгэл, мэдээллийн сан дахь холбогдох мэдээлэлд бичилт хийнэ." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн гарчгийн болон мөн зүйлийн "хадгалах" гэсний дараа ",шилжин суурьших хөдөлгөөний бүртгэх , мэдээлэх " гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тэмдэгтийн хураамжийн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "7/ эцэг, эх тогтоосныг бүртгэхэд 150 төгрөг; 8/ нас барсныг бүртгэх, гэрчилгээ олгоход 150 төгрөг," гэсэн 7, 8 дахь заалт нэмсүгэй.

2 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамжийн хуулийн 8 дугаар зүйлийн гарчгийн болон 5 дугаар зүйлийн 3 дахь заалтын "иргэний" гэсний дараа "гэр бүлийн" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамжийн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4,5,6 дахь заалт мөн зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/эцэг, эхийн болон хүүхдийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсөн баримт бичиг олгоход 100 төгрөг;"

2/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5/гэрлэлт сэргээснийг бүртгэхэд хүн тус бүрээс 200 төгрөг;"

3/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"6/үрчлэлтийг бүртгэж , гэрчилгээ олгоход 150 төгрөг;"

8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт:

"3/ иргэний үнэмлэх дээр бичигдсэн иргэний оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт хийхэд 50 төгрөг;"

4 дүгээр зүйл. Тэмдэгтийн хураамжийн хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон мөн хэсгийн 1 дэх заалтын "паспорт" гэснийг "үнэмлэх" гэж, 2 дахь заалтын "паспортын" гэснийг "үнэмлэхийн" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

БИОАЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ КАРТАГЕНИЙ ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Биологийн төрөл зүйлийн тухай Конвенцийн Биоаюулгүй байдлын тухай Картагений Протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр — Дугаар 78 — Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсийн 7, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар батлагдсугай.

1. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дунд улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /О.Чулуунбат/-нд даалгасугай.

3. Олон Улсын байгууллагаас арилжааны банкуудаар дамжуулан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зээлийн үр дүнг хамтран судалж, Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар/ Н.Энхбаяар/, Монголбанк/О. Чулуунбат/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2002 оны 78 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2003 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэлийн зорилт нь суүлийн жилүүдэд гарсан макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтворжилтыг бэхжүүлэх, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг дэмжихүйц мөнгө санхүүгийн орчинг бүрдүүлэх, санхүүгийн зуучлалыг бүх чиглэлээр гүнзгийрүүлэх, санхүү банкны үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэхэд чиглэгдэнэ.

Төрийн мөнгөний бодлогын зорилтыг хангахын тулд дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэг. Мөнгө болонханшийн бодлогын талаар

1.1 Инфляцийг жилийн 5 хувь орчимд байлгах зорилгоор Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслүүдийн уялдаа холбоог сайжруулан, түүний үр өгөөжийг нэмэгдүүлж, мөнгөний бодлогын үр дүнг ил тод тайлагнах ажлыг эрчимжүүлнэ.

1.2 Эдийн засаг дахь хүүгийн түвшинг бууруулах, мөнгө санхүүгийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулна.

1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан байдлыг хадгалж, гадаад худалдааны нөхцөл, банк хоорондын валютын захын эрэлт нийлүүлэлтийн дагуу уян хатан тогтоох нөхцлийг хангана.

Хоёр. Санхүү банкны тогтолцооны талаар

2.1 Санхүү зуучлалын үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнийг

дэмжих үүднээс банкны салбар дахь төрийн оролцоог бууруулах, түүхайлбал Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах, Хадгаламжийн банкны хувьчлалын бэлтгэл ажлыг эхлүүлнэ.

2.2 Банкны үйл ажиллагааг тавих хяналтыг боловсронгуй болгох үүднээскомпанийн зохистой засагллын зарчмыг банкуудад нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн, банкуудын төлбөрийн чадвар, үйл ажиллагаагнийтэд ил тод, нээлттэй болгох арга хэмээг авч хэрэгжүүлнэ. Банкуудын үйл ажиллагааг тавих гадаад, дотоод аудиторуудын хяналтыг өндөржүүлнэ.

2.3 Банк, санхүүгийн байгууллагын санхүү, төлбөрийн чадварыг бэхжүүлэх, тэдгээрийн эрсдлээс хамгаалах чадавхийг сайжруулах зорилгоор Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтыг банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаан дахь эрсдлийн удирдлагын хяналтад илүүтэйгээр төвлөрүүлэн, хяналт шалгалтын хүрээнд олон улсын шинэлэг арга барилыг нэвтрүүлнэ.

2.4 Банк санхүү, зээлийн үйлчилгээний хүрээээг тэлж хүртээмжийг өргөжүүлэх чиглэлээр хөдөөгийн санхүү, орон сууц болон бусад ниймийн шинж чанартай зээлийг дамжуулан зээлдүүлэх хэлбэрээр олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллана. Санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх үйл ажиллагааг идэвхтэй дэмжих чиглэлийг баримтлана.

2.5 Төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэрийг хэвшүүлэх, бэлэн мөнгөний эргэлт хэрэгцээг багасгах зорилгоор бэлэн бус төлбөр тооцооны үндэсний сүлжээг байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.6 Бэлэн бус төлбөр тооцоо, цахим худалдаа, банкны нууцлал зэрэг санхүүгийн хэрэгсэлийг зохицуулах хэм хэмжээг бий болгох, сайжруулахын зэрэгцээ банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийг хангана.

2.7 Төв банкны бие даасан байдлыг бэхжүүлэх, Монголбанкны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах хүрээнд Монголбанкны Зөвлөлийг өргөтгөх эрх зүйн орчин, Монголбанкнаас төрийн мөнгөний бодлогыг боловсруулах тогтолцоог боловсронгуй болгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 80** **Улаанбаатар хот**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар батална.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан өөрсдийн эрхлэх ажилд хамаарах асуудлын биелэлтийг шуурхай зохион байгуулж, явцын тухай мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргаж, дараа сарын 5-ны дотор Засгийн газарт хүргүүлж байхыг Монголбанк, Үнэт цаасны хороо, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн газарт үүрэг болгосугай.

4. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлах, хянах ажиллагаагболовсронгуй болгох талаар санал боловсруулж 2003 оны I улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2003 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Бодлогын зорилт	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх эзэн
1	2	3	4
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:			
Эдийн засаг, нийгмийн хүрээний бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, мөнгө, ханш, гадаад худалдааны оновчтой бодлого явуулж, дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2003 онд 5.2 хувьд хүргэнэ.			
1.Эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчныг сайжруулж, дэмжлэг үзүүлнэ.	-Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн макро эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	жилдээ	Ч.Улаан О.Чулуунбат
	-Боловсруулах аж үйлдвэр, газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг Д.Насанжаргал
	-Бизнесийг өргөжүүлэхэд дэмжлэг болох дэд бүтцийн салбарын хөгжлийг эрчимжүүлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг түлхүү татах замаар бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг Б.Жигжид Д.Насанжаргал
	-Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн санхүүгийн бодлого явуулж хөдөөд бизнесийг өргөжүүлнэ.	жилдээ	Ч.Улаан О.Чулуунбат
	-Инфляцийг эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг урамшуулах түвшинд байлгана.	жилдээ	О.Чулуунбат
2.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.	-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй уялдаж 2003 оноос салбарын төсөв төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоонд шилжинэ.	оны эхээс	Ч.Улаан сайд нар
	-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан гаргах ажилд шинэчлэл хийж, холбогдох заавар, журмыг батлан мөрдүүлнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Төрийн сангийн болон төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн сүлжээг шинээр бий болгож, программ	жилдээ	Ч.Улаан

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 он, №45(282)

1	2	3	4
	хангамжаар хангана.		
	-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлд нийцүүлэн татварын орлого төвлөрүүлэлтийг боловсронгуй болгоно.	Оны эхнээс	Ч.Улаан
	-Бүтээгдэхүүнд суурилсан удирдлага, санхүүжилтийн тогтолцоонд шилжихтэй холбогдсон нягтлан бодох бүртгэлийг шинэчлэх талаар сургалт зохион байгуулна.	Сүүлийн хагасаас	Ч.Улаан холбогдох сайд нар
	-Төсвийн хөрөнгийг захиран зарцуулах, байгууллагын орон тоо, цалингийн санг тогтоох, ажилд хүн томилох, халах, урамшуулах зэрэг ергөн эрх мэдлийг байгууллагын еренхий менежерт шилжүүлэх тухай заавар, журмыг гаргаж мөрдүүлнэ.	жилдээ	Ч.Улаан холбогдох сайд нар
	-Төсвийн байгууллага, ажиллагчдаас бүтээгдэхүүн худалдан авах талаар байгуулах үр дүнгийн гэрээ, түүний гүйцэтгэлд үнэлгээ хийх чадавхийг бүрдүүлнэ.	I улирал	Ө.Энхтүвшин Ч.Улаан
3.Төсвийн зарлагын удирдлагыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлнэ.	-Урсгал төсвийн тэнцлийн ашгийн ДНБ-д эзлэх хувийг 3.6-д хүргэнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог төлөвшүүлж, төсвийн зарлага санхүүжилтэд тавих хяналтыг сайжруулж, ил тод байдлыг хангана.	жилдээ	Ч.Улаан
	-Төрийн сангийн нэгдсэн цахим сүлжээг бүрдүүлж, төсвийн санхүүжилт, зарцуулалтын тайлан, мэдээг шуурхай болгоно.	Оны эхнээс	Ч.Улаан
	-Төрийн сангийн хэрэгжилтийн явцад дотоодын шуурхай хяналт тавьж ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	Оны эхнээс	Ч.Улаан
	-Гаалийн хөгжлийн сан, Замын сан зэрэг сангуудын эх үүсвэрийн бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтыг ил тод болгож, төсвийн тайлагналтад хамруулах бэлтгэлийг хангана.	жилдээ	Ч.Улаан Б.Жигжид
	-Хугацаа хэтэрсэн урсгал ерийг хугацаанд нь барагдуулах талаар арга хэмжээ авч, нийтэд мэдээлж байна.	жилдээ	Ч.Улаан
4.Төрийн албаны шинэчлэлийг үргэлжлүүлж, төсвийн зарлага, төрийн албаны үр өгөөжийг дээшлүүлнэ.	-Үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүйгээр орлогоороо зардлаа нөхөж, үйл ажиллагаа явуулж чадах их, дээд сургууль, коллеж, эмнэлэг, соёл урлагийн байгууллага, рашаан сувиллыг хувьчлах арга хэмжээ авна.	жилдээ	А.Цанжид П.Нямдаваа Ч.Улаан
	-Төрийн албаны шинэчлэлийн цогц хөтөлберийг боловсруулж мөрдүүлнэ.		
	-Төрийн албанд үйлчилгээ үзүүлдэг туслах үйл ажиллагааг	Эхний	Ч.Улаан

1	2	3	4
5.Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд эдийн засаг дахь мөнгөний эрэлтийг оновчтой удирдана.	компанийн зохион байгуулалтад шилжүүлж, бараа, үйлчилгээ худалдаж авах хэлбэрт оруулах боломжийг судалж шийдвэрлэнэ. -Гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгод нийцүүлэн уян хатан, чөлөөтэй хөвөх ханшны бодлогыг үргэлжлүүлэн явуулж, төгрөгийн ханшийг зах зээлийн хүчин зүйлээр тодорхойлогдох нөхцөлийг хангана. -Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн мөнгө, зээлийн бодлогын арга хэрэгслүүдийг оновчтой, зөв ашиглана. -Гадаад валютын цэвэр албан нөөцийг импортын барааны 15 долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнээс дээшгүй байлгана. -Монголбанкны үйл ажиллагаанд гаднаас тавих хяналтыг бий болгох зорилгоор захирлуудын зөвлөлийг өргөтгөх чиглэлээр төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. -Төлбөрийн карт, вексель зэрэг бэлэн бус тооцооны хэрэгслийг өргөн ашиглах нөхцөлийг бүрдүүлж, банкаас гадуур байгаа бэлэн мөнгөний урсгалыг багасгана. -Мөнгөний зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	хагаст жилдээ жилдээ жилдээ эхний хагаст жилдээ жилдээ	О.Чулуунбат Ч.Улаан О.Чулуунбат О.Чулуунбат О.Чулуунбат О.Чулуунбат
6.Банк, санхүүгийн байгууллагын зуучлалын хүрээг өргөтгөнө.	-Орон нутагт бэлэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор хадгаламж зээлийн хоршоо байгуулан ажиллах эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. -Хөдөө аж ахуйн банкийг хувьчилна. -Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр байгуулсан сангуудын удирдлагыг нь олон улсын жишигт ойртуулж, үр ашгийг нь дээшлүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ. -Харьцангуй төрөлжсөн хэлбэрийн үйл ажиллагаатай арилжааны банкуудад бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, Хадгаламжийн банкны санхүү, төлбөрийн чадварыг нь дээшлүүлж, олон улсын санхүүгийн байгууллагын туслалцаатайгаар бүтцийн өөрчлөлт хийнэ.	жилдээ жилдээ жилдээ жилдээ	О.Чулуунбат Д.Насанжаргал Ч.Улаан Ч.Ганзориг О.Чулуунбат Ч.Улаан О.Чулуунбат
7.Банк бус санхүүгийн тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлж, тогтвортой орчинг бий болгоно.	-Хөдөө орон нутагт банк, санхүүгийн үйлчилгээг хүргэх, орон нутгийн засаг захиргаа, бизнес эрхлэгчдийн хүч чармайлтад тулгуурлан тухайн бүс нутагт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг дэмжинэ. -Санхүүгийн болон нийт зах зээлийг тэлэх, өрсөлдөөнт орчныг	жилдээ жилдээ	Ч.Улаан Д.Насанжаргал Ч.Улаан

1	2	3	4
	бий болгох зорилгоор банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээг өргөтгөнө.		
	-Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, үр ашигтай явуулах нөхцөлийг хангах үүднээс Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль гаргана.	жилдээ	Ч.Улаан О.Чулуунбат
	-Бэлэн бус төлбөр тооцооны хэлбэрүүдийг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, зардлыг бууруулах зэрэг арга хэмжээг ОУХА-ийн туслалцаатайгаар авч хэрэгжүүлнэ.	жилдээ	О.Чулуунбат
	-Санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөтгөх, бодит эдийн засгийг дэмжих үүднээс Иргэдийн хадгаламжийн даатгалын тухай хуулийг боловсруулан батлуулна.	жилдээ	Ч.Улаан
8.Монгол улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулна.	-Монгол улсын зэрэглэлийн асуудлыг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан судалж, холбогдох дүгнэлтийг хийж, зэрэглэлээ ахиулах талаар туушатай ажиллана.	жилдээ	Ч.Улаан
9. Үнэт цаасны зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгоно.	-Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс "Үнэт цаасны тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулна.	жилдээ	С.Гүндэнбал
	-Үнэт цаасны зах зээлд оролцогчдын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоож, чанаржуулна.	жилдээ	С.Гүндэнбал
10. Арилжааны даатгалын хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.	-Аливаа эрсдэлийн улмаас үчирсан эдийн засгийн хохирлыг барагдуулах хөрөнгийн эх үүсвэрийг арвижуулах үүднээс даатгалын нөөцийн санг хөрөнгө оруулалтад ашиглах замаар нэмэгдүүлнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Хариуцлагын даатгалын төрөл зүйлүүдийг тогтоон, хуульчилна.	жилдээ	Ч.Улаан
	-Зарим хэлбэрийн даатгалыг холбогдох салбарын хуулиудад тусгах замаар боловсронгуй болгоно.	жилдээ	Ч.Улаан
	-Даатгалын хяналт шалгалтын үр ашгийг дээшлүүлэх хүрээнд даатгалын хяналт шалгалтын журам ба шалгалт хийх стандарт, аргачлалыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Монгол орны онцлог нөхцөлд тохирсон малын даатгалын тогтолцоог бий болгоно.	жилдээ	Ч.Улаан Д.Насанжаргал
	-Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоонд гишүүнээр элсэх замаар олон улсын даатгалын зах зээлд мердөж байгаа зохих журам, стандартуудыг нэвтрүүлнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Даатгалын ашиг тус, ач холбогдлыг нийт хүн амд сурталчлан,	жилдээ	Ч.Улаан

1	2	3	4
	дэлгэрэнгүй ойлголт өгөх замаар даатгалын хамрагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.		
	-Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол Улсын хуулийн дагуу заавал даатгалд даатгуулах ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ч.Улаан
	-"Терийн өмчийг 2003 онд хувьчлах хөтөлбөр"-ийн төслийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин
11. Эдийн засгийн үр ашиг, үндэсний аюулгүй байдалд нийцүүлэн үнэ цэнэ бүхий аж ахуйн нэгүүдийг хувьчилна.	-Терийн өмчийн томоохон "НИК" ХК, Дулааны II цахилгаан станц, Улаанбаатарын цахилгаан түгээх шугам сүлжээний газар, "Монгол даатгал" компани, "Хүнс Трейд" ХК, "Булигаар" ХК, автозамын компануид зэрэг үнэ цэнэтэй аж ахуйн нэгүүдийн хувьчлалыг явуулж 14,2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин Ч.Улаан Б.Жигжид Ч.Ганзориг
	-Нийгмийн салбарын хувьчлалын хөтөлбөр, холбогдох заавар, журмыг боловсруулан хэрэгжүүлэх замаар зарим эмнэлэг, сургуулийг хувьчилж эхлэнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин
	-Нийгмийн салбарт хувьчлагдах болон бүтцийн өөрчлөлт хийх байгууллагуудын жагсаалтыг гаргаж, зохих бэлтгэлийг хангасны дараа хувьчлал болон бүтцийн өөрчлөлтийг хийнэ.	жилдээ	Ч.Улаан П.Нямдавваа А.Цанжид Ш.Батбаяр
	-Нийгмийн салбарт хувьчлагдах болон бүтцийн өөрчлөлт хийгдэх байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх үүднээс шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, үйлчилгээ авч чадахгүй иргэдэд дэмжлэг үзүүлэх оновчтой механизм боловсруулна.	жилдээ	Ч.Улаан Ш.Батбаяр
12. Эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны хүрээ, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	-Эдийн засгийн гадаад хамтын ажиллагаат бизнесийн хүрээнд өргөжүүлэх чиглэлээр гаднаас авч ашиглах зээл, тусламжийн бодлого, санал чиглэлийг боловсруулж шинэчилнэ.	жилдээ	Ч.Улаан
	-Токиод болох Монголд хандивлагчдын зөвлөгөөнийг нийгмийн салбарт аль болох тусламж авах чиглэлээр бэлтгэлийг нь хангана.	I-II улирал	Ч.Улаан
	-Экспортын барааны гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор манай улстай хөрш болон гадаад	жилдээ	Ч.Ганзориг

1	2	3	4
	худалдааны арилжаа хийдэг орны хил, гаалийн татвар, тээврийн зардлыг бууруулах чиглэлээр гэрээ хэлцэл хийж, бизнесийн гадаад орчныг сайжруулах арга хэмжээ авна.		
	-Гадаад худалдааг хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлж, экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөхцөлийг хангана.	жилдээ	Ч.Ганзориг
	-Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээрийн шинэ үе шатанд өөрийн улсын ашиг сонирхлыг хамгаалан оролцоно.	жилдээ	Ч.Ганзориг
	-Үндэсний тооцооны системийн статистик, мэдээллийн бодит байдлыг хангах зорилгоор мэдээ гаргах аргачлалыг боловсронгуй болгон олон улсын жишигт нийцүүлэх, бараа, үйлчилгээний гадаад худалдаа, төлбөрийн болон олон улсын хөрөнгө оруулалтын тэнцлийг Олон Улсын Валютын Сангийн аргачлалын дагуу бүрэн гаргах арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Улаан
	-Гадаад худалдааны хөнгөлөлт, нэн тааламжтай нөхцөл авах, эдлэх талаар Европын холбоо, холбогдох улс орнуудтай хамтарч ажиллана.	жилдээ	Ч.Ганзориг
13. Эдийн засаг, нийгэм, удирдлагын хүрээнд хийх бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлнэ.	-Эдийн засаг, худалдааны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор цөөн нэр төрлийн импортын барааны гаалийн ялгавартай албан татвар ногдуулах боломжийг судална.	жилдээ	Ч.Улаан Ч.Ганзориг
	-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй уялдаж холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад өөрчлөлт оруулж нийцүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин Ч.Улаан
	-Хуулийн дагуу төрийн албыг арилжааны горимд үе шаттайгаар шилжүүлэх боломжийг ханган, сургалт зохион байгуулна.	жилдээ	Ө.Энхтүвшин Ч.Улаан
	-Салбар тус бүрээр хөтөлбөр боловсруулан бэлтгэлийг ханган, улмаар нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэлт хийх, хувьчлал явуулах, хувьчлагдах байгууллагын жагсаалт гаргах замаар эхний ээлжинд мэргэжлийн боловсролын салбарыг хувьчлах ажлыг хэрэгжүүлнэ.	жилдээ	А. Цанжид П.Нямдаваа Ш.Батбаяр

1	2	3	4
	ХОЁР. ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД		
	Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж 2003 онд 15,0 хувьд хүргэнэ.		
1.Боловсруулах аж үйлдвэрийн салбарын сэргэлтийг бататгаж, ерселдех чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	-Хандивлагч зарим орны тусламжтайгаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд монгол ноолуурын чанарын үзүүлэлтийг олон улсын стандартын түвшинд хүргэх бэлтгэлийг ханган а.	жилдээ	Ч.Ганзориг Д.Насанжаргал
	-Үйлдвэрийг сэргээх хүрээнд аж ахуйн нэж, байгууллагын техник технологийг боловсронгуй болгоход чиглэсэн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, олон улсын зээл, тусламжид хамруулах ажиллагааг ергежүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг Ч.Улаан
	-Гадаад орнуудын өндөр технологи бүхий томоохон үйлдвэрүүдийг барьж байгуулах санал, төслүүдийг дэмжиж холбогдох арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалт, ерселдех чадварыг нэмэгдүүлэх асуудлыг "Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт" төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан аж үйлдвэрийн парк байгуулах бүс нутгийг сонгох судалгаа явуулна.	жилдээ	Ч.Ганзориг Б.Жигжид
	-Хонины ноос боловсруулах шинэлэг технологийг боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Оёмол бүтээгдэхүүний экспортын өнөөгийн түвшинг хадгалж үйлдвэрлэлийн хэмжээг бууруулахгүй байх зорилгоор Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжих үүднээс Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинээр үүсгэн бий болгох механизмыг "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж, 8 аймагт бөөний худалдааны сүлжээ байгуулж, түүхий эд бэлтгэлийн ажлыг сайжруулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Хөдөө, орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч.Ганзориг аймгийн Засаг дарга нар

1	2	3	4
	-Хөтөлийн гангийн үйлдвэрийн дутуу суурилагдсан дамжлагыг зураг төслийн дагуу ашиглалтанд оруулах, барилга, техникийн эд анги, ялангуяа хөдөө аж ахуйн машины сэлбэг үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлэх үүднээс уг үйлдвэрийг 2003 онд багтаж хувьчилна.	жилдээ	Ч.Ганзориг Б.Жигжид Д.Насанжаргал
	-Мод боловсруулалтын түвшинг дээшлүүлж хаягдлыг багасгах, түймэрт нэрвэгдсэн болон таваарлаг чанар муутай модыг механик, химийн аргаар гүнзгий боловсруулж гадаад, дотоод зах зээлд нийлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх үүднээс Улаанбаатар, Бугант, Хялгант, Түнхэлийн модны үйлдвэр, аж ахуйд техник технологийн шинэчлэлт хийх, энэ арга хэмжээнд гадаадын зээл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Ганзориг У.Барсболд Ш.Батбаяр Ч.Улаан
	-Мод, модон түүхий эдийн импортыг дэмжих эдийн засгийн хөшүүрэг, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг У.Барсболд
2. Түлш, эрчим хүчний салбарын үйлчилгээний хүрээг өргөжүүлж үр ашгийг дээшлүүлнэ.	-Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль боловсруулан мөрдүүлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Улаанбаатар хотын IV дулааны цахилгаан станцын шинэчлэлийн 2 дахь шатны ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Түлш, эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, хувьчлалыг эхлүүлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн техникийн шинэчлэлтийг дуусгаж, орон нутгийн нүүрсний уурхайнуудыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Б.Жигжид

1	2	3	4
	-"Шарын гол" ХК-д бүтцийн өөрчлөлт хийж, уурхайн орчимд нүүрсний нөөц есгех хайгуул хийж, энэ районы нүүрсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид
	-Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний үйлдвэрүүдийн шугамын алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Эхний ээлжинд эрчим хүчний нэгдсэн системд холбогдох боломжгүй байгаа төв, суурингуудад өндөр хүчин чадалтай салхин цахилгаан станц барих төслүүдийг дэмжинэ.	жилдээ	Б.Жигжид
	-"Буман нарны гэр" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, 10000-аас доошгүй хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүртэй болгоно.	жилдээ	Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга нар
3. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний тогтвортой есөлтийг хангаж, тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	-Исэлдсэн болон балансын бус хүдрийг гидрометаллургийн аргаар боловсруулж жилд 10-15 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэх хүчин чадлыг бий болгох техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Эрдэнэт үйлдвэрийн үндсэн дамжлагад ертөг багатай баяжмал үйлдвэрлэх технологийн шинэчлэл хийх төсөл боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Монгол улсын өмнөд бүсэд нээгдсэн ашигт малтмалын ордуудыг ашиглахад шаардлагатай дэд бүтцийн цогцолборыг бий болгох талаар санал боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Алтны уурхайнуудын байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох бодлого боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг У.Барсболд
	-Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, олборлолтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг
4. Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геологийн зураг зохиох, ашигт малтмалын ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.	-Улаанбаатар-Сүхбаатарын чиглэлийн төмөр замын дагуу орших 38,9 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд 1:200.000-ны масштабтай геологийн зураг зохиох ажлыг эхлүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Увс аймгийн 13.4 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд хийж байгаа 1:200.000-ны масштабтай геологийн зургийн ажлыг дуусгана.	жилдээ	Ч.Ганзориг

1	2	3	4
	-Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн 15.0 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд 1:200000-ны масштабын хүндийн хүчний орны судалгааг үргэлжлүүлж, 25.0 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд хэрийн судалгааны ажлыг шинээр хийнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг 8.2 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд үргэлжлүүлэн хийж, 10.0 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд шинээр эхлүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Эрдэнэт хотын ундны болон ахуйн хэрэгцээ, техникийн зориулалтын усан хангамж, газрын доорхи усны хайгуулын ажлыг үргэлжлүүлж, Улаанбаатар хотын хүн амын усан хангамжийн шинэ эх үүсвэр илрүүлэх судалгааг эхлүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Мянганы замын баруун чиглэлийн, Архангайн Чулуутын гүүрнээс Тэрхийн гүүр, Завханы Их-Уулын Цэцүүх бригадаас Яруу сумын төв хүртэл хэсэгт замын барилгын материалын эрэл, хайгуулын ажлыг шинээр эхлүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Геомэдээллийн сан хөтөлбөрийн хүрээнд 1:200.000-ны масштабын буюу үндсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлж, ашигт малтмалын зарим орд, талбайн талаар багц мэдээлэл бэлтгэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хангана.	жилдээ	Ч.Ганзориг
5.Байгаль цаг уурын өөрчлөлтөд зохицсон бизнесийн орчинг бүрдүүлэх хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах, бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	-Газар тариалангийн салбарт төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж, түүнд усалгаатай тариаланг хөгжүүлэх, хөрсний чийгийг нэмэгдүүлэх, хамгаалах, шинэ технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Хүн амын мах, сүүний хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Шилмэл хээлтүүлэг хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын чанарыг сайжруулах замаар ашиг шимийг нэмэгдүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Бэлчээрийн удирдлагыг сайжруулах чиглэлээр гадаадын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж сумдад бэлчээр ашиглах төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал

1	2	3	4
	-Бэлчээрийн 300,0 гаруй мянган га талбайд үлийн цагаан оготнотой, 25,0 мянган га талбайд царцаатай хими, биологийн аргаар тэмцэх бэлчээр хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Алтай таван богдын салбар уулсаар нүүдэллэн ирж буй хөнөөлт царцаатай хими, биологийн аргаас гадна механик арга хэрэглэж тэмцэх царцаа, дэвхрэгээр малын тэжээл, бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ.	жилдээ	У.Барсболд Д.Насанжаргал
	-Инженерийн хийцтэй 150-аас доошгүй худгийг засварлаж бэлчээрийг усжуулах арга хэмжээ авна.	жилдээ	Д.Насанжаргал Аймгийн Засаг дарга
	-Говь, тал хээрийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр Япон Улсын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр судалгааны төсөл хэрэгжүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын аюулаас хамгаалах тэжээлийн нөөц, аймаг, сумын нөөцийн цэгүүдийн агуулах, хашаа, саравчийг шинэчлэн засварлаж, өвс тэжээл хадгалах нөхцөлийг сайжруулна.	жилдээ	Д.Насанжаргал аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны олоттыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг өргөжүүлж малчдад зах зээлийн талаар сургалт явуулж аж ахуйгаа эрхлэх арга ухаанд сургана.	жилдээ	Д.Насанжаргал
	-2003 оныг хоршооллын хөдөлгөөнийг дэмжих жил болгож, хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, инженерийн хийцтэй уст цэгийг эзэмшүүлэх зөвлөмж, журмыг гарган эрх зүйн үндсийг бий болгож хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Д.Насанжаргал Аймгийн Засаг дарга
	-Малын "А" зэрэглэлийн өвчний голомтыг устгах арга хэмжээг зохион байгуулж, бүх малын 90 хувийг угаалга, туулгад хамруулна.	жилдээ	Д.Насанжаргал Аймгийн Засаг дарга
6.Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, түүний тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад	-Газар тариалангийн тухай хуулийг боловсруулж, газар тариалан эрхлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	II-IV улирал	Д.Насанжаргал
	-Тариалангийн талбайн хог үргамалтай тэмцэх ажлыг 2002 оныхоос 40 хувиар, уринш боловсруулалтыг 10 хувиар тус тус нэмэгдүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал

1	2	3	4
чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ.	-Цомхотгосон элдэшүүлгийн технологийг нэвтрүүлэх, бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар нэг га-гаас авах ургацыг дээшлүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээхээр олгогдсон дотоод, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын хяналтыг чангатгах, эргэн төлөлтийг сайжруулах, "Газар тариаланг дэмжих сан" байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.	жилдээ	Д.Насанжаргал
7.Хүн амыг чанарлаг, хүртээмжтэй хүнсээр хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангах бодлого баримтална.	-"Мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага" үндэсний стандарт, "Махны хяналтын дүрэм"-ийн мөрдөлтийг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн дотоод хяналтаар хэрэгжүүлж, түүнд тавих хөндлөнгийн хяналтыг чангатгаж, махны үйлдвэрүүдийн эрүүл ахуй, чанарын шаардлагыг өндөржүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
	-Загас, загасан бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх талаар гадаад улс оронтой хамтран ажиллана.	жилдээ	Д.Насанжаргал
	-Бэлчээрийн маллагаатай монгол малын махны найрлага, экологийн үзүүлэлтүүдийг гадаад орнуудын судалгааны үр дүнтэй харьцуулан боловсруулж, сурталчилгааны лавлах гаргана.	жилдээ	Д.Насанжаргал
	-Хүний биед байх амин дэм, бичил бодисын дутагдлыг нөхөх, хүүхдийн болон сувиллын зориулалттай хоол тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Д.Насанжаргал
8.Ачаа, зорчигч тээвэрийн хэрэгцээ, аюулгүй байдлыг хангаж, тээвэрийн үйлчилгээг өргөжүүлнэ.	-Гадаадын төслийн хүрээнд Авто тээвэрийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны станцуудыг Улаанбаатар хот, зарим аймгийн төвд байгуулна.	жилдээ	Б.Жигжид
	-Ази, Европын орнуудтай байгуулсан авто тээвэрийн харилцааны тухай хэлэлцээрийг хэрэгжүүлж, зарим оронтой тээвэрийн харилцааг нээх арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид
	-Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах хүрээнд агаарын хөлгийн ажиглалтын хамааралтай сүлжээ нэвтрүүлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Төмөр замын тээвэрийн үйлчилгээг өргөтгөж, мэдээллийн орчин үеийн сүлжээ бий болгох арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид

1	2	3	4
	-Бус нутгийн болон эх газрын тээврийн сүлжээнд темөр замын тээврийн эрсэлдэх чадварыг нэмэгдүүлэх бодлого боловсруулна. -Төмөр замын удирдлага, зах зээлийг сайжруулах судалгаа хийж, үйл ажиллагаг нь оновчтой болгох арга хэмжээ авна. -Улаанбаатар хотын орон сууцны хороолын дотоорхи автозамыг засч сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Б.Жигжид Б.Жигжид Б.Жигжид
9. Аялал, жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлчилгээний чанарыг сайжруулж, аялалын чиглэл, төрлийг нэмэгдүүлнэ.	-Өмнөговь аймаг дахь жуулчны гол чиглэлийн дагуу аялал жуулчлалын цогцолбор байгуулах саналчлага, төслийг дэмжинэ. -"Монголд зочлох жил болгохтой уялдуулан олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, нислэгийн шинэ чиглэл нээх, Даланзадгадын онгоцны буудлын бүух хөрөнгө зурвасыг хатуу хучилттай болгох зураг, төсвийг хийж, ажлыг эхлүүлэх, Хатгалын онгоцны буудлын шороон зурвасыг сайжруулах, нислэгийн удирдагаын тоног төхөөрөмжийг сууриулах арга хэмжээ авна. -Улаанбаатар хот орчимд аялал жуулчлал хөгжүүлэх өөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	жилдээ жилдээ	Б.Жигжид Б.Жигжид
10. Мэдээлэл, холбооны технологийн шинэчлэлтийг гүнзгийрүүлж, харилцаа холбооны нэвтрүүлэх арга хэмжээ авна. Үйлчилгээний хүрээг тэлж, чанарын түвшинг дээшлүүлнэ.	-Харилцаа холбооны үндсэн сүлжээг өргөтгөн шинэчлэх хүрээнд Говь-Алтай-Завхан, Ховд-Увс аймгийн төвүүдийн хооронд агаарын шилэн кабелийн дамжуулах сүлжээг байгуулна. -Өвөрханган-Баян-Өлгий, Улаанбаатар-Дорнод, Дундговь-Өмнөговь чиглэлд интернет, үүрэн телефоны шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ авна. -Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн радио өргөн нэвтрүүлгийн их хүчний радио станцыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ. -Сум, багт шуудан хүргэх давтамжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулна. -"Мэдээллийн технологийн парк" байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. -Төв, Сэлэнгэ аймгийн сумдын холбоог өргөтгөн шинэчилнэ. -Хот хоорондын холбооны автоматжуулалтын түвшинг 80 хувьд хүргэнэ.	жилдээ жилдээ жилдээ жилдээ жилдээ	Б.Жигжид Б.Жигжид Б.Жигжид А.Цанжид Б.Жигжид Б.Жигжид

1	2	3	4
ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:			
Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг эрчимжүүлэх замаар тогтвортой хөгжлийн үгтвар нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, экологийн харилцан уялдаатай бодлого явуулна.			
1.Бүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засаг, эрхзүйн зохицуулалтыг сайжруулах замаар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бүх шатанд хэрэгжүүлж эхэлнэ.	-Бүс нутгийн хөгжлийг дэмжих тухай хуулийг батлуулан бусад холбогдох хууль тогтоомжийн уялдааг хангаж, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авна.	I-II улирал	Ө.Энхтүвшин Ч.Улаан Ц.Нямдорж
	-Бүс бүрийн хөгжлийн дунд хугацааны стратегид үндэслэн бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, төслийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	жилдээ	Ч.Улаан холбогдох яам, газар, аймаг, нийслэлийн Засаг дарга
	-АХБ-ны техник туслалцаагаар бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн нэгдсэн арга зүй, зохион байгуулалтыг бий болгох төслийг хэрэгжүүлнэ.	II улирлаас	Ч.Улаан Б.Жигжид
	-Сонгон авсан бүсийн хүрээнд ХБНГУ-ын техникийн туслалцаагаар орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төслийг хэрэгжүүлнэ.	II-III улирлаас	Ч.Улаан Ч.Ганзориг Д.Насанжаргал
	-Ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд орон нутгийн тогтвортой амьжиргааг дэмжих төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Улаан Ш.Батбаяр Д.Насанжаргал Ч.Ганзориг
	-"Орон сууц барих санг бүрдүүлж иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах арга хэмжээ авна."	жилдээ	Б.Жигжид Ч.Улаан
	-Аймгийн төв, Бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх арга замыг төслийн хүрээнд судалж, бүсийн тулгуур төв хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг эхлэнэ.	жилдээ	Ч.Улаан Б.Жигжид

1	2	3	4
	-Аймгуудын бүсчлэлийн хандлагад үндэслэн бүлэг суурингийн оновчтой тогтолцоо бүрэлдүүлэх асуудлыг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх аажлыг дэмжин зохион байгуулна.	жилдээ	Ч.Улаан Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Монгол Улсын дэд бүтцийн хэвтээ болон босоо тэнхлэгүүдийн авто замыг үргэлжлүүлэн барьж Мянганы замын авто тээврийн хөдөлгөөнийг эхлүүлнэ. Үүнд:	жилдээ	Б.Жигжид
	• Босоо тэнхлэгийн Налайх-Маанът-Чойр, Ховд-Улаангом-Хандгайт, Ховд-Булган-Ярантын хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн барина.	жилдээ	Б.Жигжид
АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцаа зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж

2.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Төрийн хяналт, шалгалтын тухай[2], Хилийн тухай[3], Ургамал хамгааллын тухай[4], Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль[5], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "мал эмнэлгийн гэрчилгээ" гэж экспортлогдож буй амьтан, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл шаардлагыг хангаж байгааг гэрчлэн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг;

3.1.2. "ургамлын хорио цээрийн гэрчилгээ" гэж экспортлогдож буй ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал байхгүй болохыг гэрчлэн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг;

3.1.3. "импортын гэрчилгээ" гэж амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулахыг зөвшөөрч, хилийн боомт, гүний гаалийн дэргэдэх мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчаас /цаашид "улсын байцаагч" гэх/ энэ хуулийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт дурдсан баримт бичгийг /цаашид "экспортын гэрчилгээ" гэх/ хураан авч, оронд нь олгож буй баримт бичгийг;

3.1.4. "эрсдэл" гэж хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс тодорхой хугацааны туршид амьтан, ургамал, хүн амын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө учрүүлж болох үр дагаварын хэмжээ өндөрсөх магадлалыг;

3.1.5. "зөвшөөрөгдөх эрсдэл" гэдэг нь амьтан, ургамал, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн эрсдэлийн түвшинг;

3.1.6. "эрсдэлийн задлан шинжилгээ" гэж аюулыг олж тогтоох, эрсдэлийн үнэлгээ гаргах, эрсдэлийг бууруулах, мэдээлэл дамжуулахад чиглэсэн үйл ажиллагааг;

3.1.7. "эрсдэлийн үнэлгээ" гэж импортлогч орны нутаг дэвсгэрт эмгэг төрүүлэгч зүйлүүд нэвтрэн орох, тархахаас үүдэн гарах биологи, эдийн засгийн үр дагаварыг тодорхойлон үнэлэх үйл ажиллагааг;

3.1.8. "эрсдэлийг бууруулах" гэдэг нь эрсдэлийг зөвшөөрөх түвшинд хүргэхэд ашиглаж

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

[2] Төрийн хяналт, шалгалтын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 4 дүгээрт нийтлэгдсэн

[3] Хилийн тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

[4] Ургамал хамгаллын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 5 дугаарт нийтлэгдсэн

[5] Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн

болох арга хэмжээг тодорхойлох, сонгох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

3.1.9. "аюул" гэж амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болох ямар нэгэн эмгэг төрүүлэгч зүйлийг;

3.1.10. "хог ургамал" гэж ургамлыг тариалж, үржүүлж буй талбайд тархаж ургах өөр ургамлыг.

4 дүгээр зүйл. Хорио цээрийн хязгаарлалт, шалгалтад хамаарах зүйл

4.1. Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хязгаарлалт, шалгалтад хамруулна:

4.1.1. бүх төрлийн сүүн тэжээлтэн тэжээвэр болон зэрлэг амьтан, хэвлээр явагч усны амьтан, шувуу, зөгий, тэдгээрийн үр, хөвөл үр, үржлийн өндөг;

4.1.2. мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны ед, сэд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн;

4.1.3. байгалийн болон таримал дээд, доод ургамал, мод, тэдгээрийн үр, суулгац, хэсэг;

4.1.4. үр тариа, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээл, үрлэн кофе, хөнгөн болон хүнсний үйлдвэрт хэрэглэгдэх ургамлын гаралтай бусад түүхий эд, ургамлын хатаадас, цуглуулга, тасалбар, зүсмэл мод, түүний хэсэг, бүх төрлийн жимс, жимсгэнэ, гүрил, будаа, элсэн чихэр, амтлагч зэрэг ургамлын гаралтай аливаа зүйлс;

4.1.5. цус болон цусны ийлдэс, сийвэн;

4.1.6. ангийн олзворт;

4.1.7. төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой, шавьж, бичил биетний өсгөвөр;

4.1.8. амьтны хүүр, сэг, ялгадас, эмгэгт материал;

4.1.9. хөрс, хүлэр, чулуу;

4.1.10. тээвэрийн хэрэгсэл, чингэлэг, сав, баглаа боодол, чигжээс, эвөлбөө, дэвсгэр, хашлага, хөвөнгийн "хөвөр", амьтны тоног хэрэгсэл, уяа татлага.

5 дугаар зүйл. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

5.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хязгаарлалт, шалгалтын /цаашид "хорио цээрийн хязгаарлалт, шалгалт" гэх/ талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хорио цээрийн хязгаарлалт, шалгалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх арга хэмжээ болоовсруулж хэрэгжүүлэх;

5.1.2. гадаад улс, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;

5.1.3. амьтны гоц халдварт өвчин болон ургамлын гадаад хорио цээртэй өвчний халдвар, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед улсын мэргэжлийн хязгаарлалтын дүгнэлтийг үндэслэн хилийн боомтод хорио цээр тогтоох, тогтоосон хорио цээрийг цуцлах;

5.1.4. энэ хуулийн 5.1.3-т заасан хорио цээр тогтоосон үед баримтлах нийтлэг журам /дэглэм/-ыг тогтоох;

5.1.5. ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөвөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудыг тогтоох;

5.1.6. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хязгаарлалт, шалгалт хийх журам, заавырыг батлах;

5.1.7. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журмыг батлах;

5.1.8. хилийн боомтод амьтан, ургамлын хорио цээрийн хязгаарлалт, шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

5.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн /цаашид "амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн" гэх/-д шинжилгээ, эмчилгээ, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэл хийх үйлчилгээний хөлсний жишиг үнийг улсын мэргэжлийн хязгаарлалтын дүгнэлтийг үндэслэн санхүүгийн асуудал эрхэлсэн сайд тогтооно.

5.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ импортоор оруулж ирсэн амьтан, ургамлыг хуульд тогтоомжид заасны дагуу хорио цээрийн дэглэмд байлгах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

6 дугаар зүйл. Хорио цээрийн улсын хяналт, шалгалт, түүний зохион байгуулалт

6.1. Хорио цээрийн улсын хяналт, шалгалт нь хилийн боомт, гүний гаалиар нэвтрүүлж буй

амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтыг хийж, зөрчилтэй болон эрсдэлтэй зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэгдэнэ.

6.2. Хорио цээрийн улсын хяналт, шалгалтыг улсын хэмжээнд амьтан, ургамлын хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн улсын мэргэжлийн хяналтын байгууллага /цаашид "улсын мэргэжлийн хяналтын байгууллага" гэх/, хилийн боомт, гүний гааль бүхий газарт улсын байцаагч тус тус хэрэгжүүлнэ.

6.3. Улсын байцаагч нь мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн мэргэжил эзэмшсэн, дээд боловсролтой хүн байна.

7 дугаар зүйл. Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын эрх, үүрэг

7.1. Улсын мэргэжлийн хяналтын байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1 хорио цээрийн хяналт, шалгалтын талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хангах;

7.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын болон гаалийн хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт хийх ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, хяналт тавих;

7.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө эрсдэлийн зардлан шинжилгээ хийж импортын мэдэгдэл олгох;

7.1.4. Монгол Улсын хилээр нэвтэрсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийн сан бүрдүүлж, улсын хэмжээнд нэгтгэх, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх;

7.1.5. улсын байцаагчийн хийсэн үзлэг, бичиг баримтын шалгалтаар илэрсэн зөрчил нь энэ хуулийн 13.1-д хамаарч байгаа бол тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах буюу устгах арга хэмжээ авахуулах;

7.1.6. улсын байцаагчийг мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэшүүлэх;

7.1.7. гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний зөрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах;

7.1.8. Малын зөрүүл мэндийн олон улсын байгууллагаас тогтоосон "А" жагсаалтын өвчин / цаашид "амьтны гоц халдварт өвчин" гэх/, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, хог ургамал, мөрэгч амьтан /цаашид "ургамлын хорио цээртэй зүйл" гэх/ илэрсэн тохиолдолд тухайн хилийн боомт, гүний гаальд хорио цээр тогтоох саналыг Засгийн газарт оруулах, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хянах;

7.1.9. экспортлох эрх бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, хянан магадлагаа хийх.

8 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх үүрэг

8.1. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. экспортын гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл нь бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, худалдааны гэрээ, төөрийн хэрэгслийн талаархи мэдээлэл, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо, хэмжээтэй тохирч буй эсэхийг шалгах;

8.1.2. бүтээгдэхүүн, түүхий эдийн сав, баглаа боодол, тээвэрлэлтийн нөхцөл нь импортлогч улсын шаардлагад нийцсэн, хаяг, шошго жинхэнэ эсэхийг шалгах;

8.1.3. хилээр нэвтрүүлж буй ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хорио цээрийн анхдагч үзлэг хийх;

8.1.4. хилээр нэвтрүүлж буй амьтан нэг бүрийг бүртгэж, зөрүүл мэндийн үзлэг хийх;

8.1.5. анхдагч болон зөрүүл мэндийн үзлэгээр халдварт өвчний шинж тэмдэг, хөнөөлт шавьж, мөрэгч амьтан, хог ургамал илэрвэл амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын байранд түр саатуулж, лабораторийн шинжилгээний дээж авч, хорио цээрийн хяналтад оруулах;

8.1.6. экспортийн гэрчилгээ бүсад дагалдах бичиг баримт зөрчилтэй, тээвэрлэлтийн нөхцөл нь энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй бол амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхгүй байх;

8.1.7. хорио цээрийн хяналтанд байгаа амьтан, ургамал, түр саатуулагдсан түүхий эд, бүтээгдэхүүнтэй холбогдсон асуудлыг энэ хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх;

8.1.8. экспортын гэрчилгээ болон дагалдах бичиг баримт, хорио цээрийн нөхцөлийн талаар зөрчил илрээгүй зөрүүл амьтан, ургамал, гэмтэж муудаагүй түүхий эд, бүтээгдэхүүнд импортын гэрчилгээ олгож, улсын хилээр нэвтрүүлэх;

8.1.9. үзлэг, шалгалт, шинжилгээ хийсэн,

хорио цээрийн хяналтад оруулж тур саатуулсан, экспортлогч улсад буцаасан, устгасан болон улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаархи бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, мэдээг тогтоосон хугацаанд улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх;

8.2. Улсын байцаагч нь ажлын байр, үзлэг, шинжилгээний багаж, хэрэгсэл болон амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг хийх, хорио цээрт оруулж тур саатуулах зориулалтын тусгайлан тоноглож, төхөөрөмжилсэн хашаа, байр, талбай, агуулах, багаж хэрэгсэл, болон устгал хийх байгууламжаар хангагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх

9 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага

9.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:

9.1.1. Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид заасан стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөх;

9.1.2. экспортлогч улсын хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хорио цээрийн үзлэг, шалгалтанд оруулах;

9.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийн хашлага, дэвсгэр, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн үзлэг, шалгалтыг хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбай дээр хийлгэх;

9.1.4. биологийн эмгэгт материал, бичил биетний омог, өсөвөрийн дээж, хөрс, хөрстэй ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар хил нэвтрүүлэх ба хүлээн авагч улсын холбогдох этгээдэд хүргэх хүртэл сав, баглаа боодол, битүүмжлэлийг задлахгүй байх.

10 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход тавих шаардлага

10.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн нь амьтны гоц халдварт өвчин гараагүй, ургамлын хорио цээртэй зүйл тархаагүй тайван улс, бүсээс гаралтай байх;

10.1.2. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх эрсдэлийг тогтоолгосон байх.

11 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн экспортлоход тавих шаардлага

11.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

11.1.1. импортлогч улстай тохиролцсон хорио цээрийн нөхцөл, эсхүл хорио цээрийн талаарх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцсэн байх;

11.1.2. экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх.

12 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэхэд тавих шаардлага

12.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэхэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

12.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтэд энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын мэргэжлийн хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэж, зохих мэдэгдэл авсан байх;

12.1.2. амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн дэгдэлт гараагүй тайван улс, бүсээс гаралтай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байх;

12.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чингэлэгийн лац, ломбо бүрэн бүтэн байх.

12.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэх үед улсын

мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгахыг хориглоно.

12.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас болон амраах, услах, тэжээх зорилгоор амьтныг маршрутын дагуу урьдчилан тогтоосон цэгт улсын байцаагчийн хяналтын дор тээврийн хэрэгслээс буулгах үйл ажиллагаанд энэ хуулийн 12.2 дахь хэсэг хамаарахгүй.

12.4. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх замд амьтны гоц халдварт өвчин, үргамлын хорио цээртэй зүйл илэрсэн тохиолдолд улсын мэргэжлийн хяналтын байгууллага энэ тухай импортлогч, экспортлогч улсын хяналтын эрх бүхий байгууллагад яаралтай мэдэгдэж, энэ хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

13 дугаар зүйл. Амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглох

13.1. Дараахь тохиолдолд амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно:

13.1.1. энэ хуулийн 10.1, 11.1-д заасан шаардлагыг хангаагүй;

13.1.2.хорио цээрийн хяналт, шалгалтанд ороогүй, эсхүл гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл зөрүүтэй буюу дагалдах бичиг баримт нь хуурамч болох нь хяналт, шалгалтын явцад тогтоогдсон.

13.2. Энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан шаардлагыг хангаагүй амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглож, энэ тухай улсын мэргэжлийн хяналтын байгууллага нь экспортлогч улсын хилийн боомтын хяналтын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан үндэслэлээр амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдлийг улсын байцаагч хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.

13.4. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх үед түр саатуулах

14.1. Улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтаар өвчний шинж тэмдэг илэрсэн амьтан, шавьж илэрсэн үргамал, гэмтэх муудсан нь тогтоогдсон түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагч 21 хүртэл хоногийн хугацаагаар түр саатуулж, энэ тухай мэдэгдлийг хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.

14.2. Түр саатуулах тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбайд тусгайлан бэлтгэсэн хашаа, байр, агуулах, талбайд улсын байцаагчийн шийдвэрээр, түүний хяналтын дор амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгслээс буулгаж нарийвчилсан үзлэг хийлгэнэ.

14.3. Улсын байцаагч хорио цээрийн нарийвчилсан үзлэг хийж, шинжилгээний дээж аван холбогдох лабораторид хүргүүлнэ. Дээж хүлээн авсан лаборатори нь 14 хоногийн хугацаанд багтаан шинжилгээний хариуг гаргана.

14.4. Лабораторийн шинжилгээний хариу болон хорио цээрийн хугацаанд хийсэн ажиглалт, үзлэгийн дүнг үндэслэн амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх эсэхийг хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэнэ.

14.5. Лабораторийн шинжилгээнд орсон зүйлээс амьтны гоц халдварт өвчин оношлогдсон, үргамлын хорио цээртэй зүйл илэрсэн бол амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийг тээвэрлэхэд хэрэглэсэн хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, сав, баглаа, боодол, чигжээсийг энэ хуулийн 15.2-т заасны дагуу устгана.

14.6. Энэ хуулийн 12.1.1-д заасан шаардлагыг хангаагүй амьтан үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар түр саатуулж, экспортлогч улсын хорио цээрийн хяналтын байгууллагад мэдэгдэн, зөрчлийг арилгуулсаны үндэсэн дээр дамжуулан өнгөрүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон амьтан,үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах

15.1. Хорио цээрийн хяналт, шалгалтын явцад дараахь нөхцөл байдал үүссэн бол амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгана:

15.1.1. энэ хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу амьтан, үргамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад экспортлогч орны хилийн боомтын эрх бүхий байгууллагад мэдэгдэхэд буцаах хүлээн авахаас татгалзсан;

15.1.2. тухайн амьтан нь гоц халдварт өвчний халдвартай болох нь оношлогдсон;

15.1.3. тухайн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд ургамлын гадаад хорио цээртэй зүйл илэрсэн;

15.1.4. хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөний улмаас түүхий эд, бүтээгдэхүүнд учирсан гэмтэл нь хүн, амьтны эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй нь тогтоогдсон;

15.1.5. түүхий эд, бүтээгдэхүүнд үүссэн хими, биологи, цацрагийн бохирдлын түвшин олон улсын стандартын зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн.

15.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах ажлыг гухайн хилийн боомт, гүний гааль байрлаж буй сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг улсын байцаагчийн хяналтын дор зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

15.3. Энэ хуулийн 15.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ амьтныг тарчлаахгүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй, халдвар үүсгэгчийг бүрэн устгаж чадахуйц аргыг хэрэглэнэ.

16 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

16.1. Улсын байцаагчийн хяналтын дор мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн дараахь зүйлд эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ:

16.1.1. амьтны гоц халдвартаас бусад халдвартай өвчин оношлогдсон болон эерэг урвал үзүүлсэн амьтан;

16.1.2. ургамлын дотоод хорио цээртэй зүйл илэрсэн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн;

16.1.3. энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хэрэглэсэн хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, сав, баглаа боодол, чигжээс, тэдгээртэй адилтгах зүйлс;

16.1.4. энэ хуулийн 15.1.1, 16.1.1, 16.1.2-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгсэл, чингэлэг, тэдгээртэй адилтгах бусад зүйлс;

16.1.5. энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн байсан байр, агуулах, талбай, халдвараар бохирлогдсон байж болзошгүй орчны хэрс, барилга, байгууламж.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн болон тээврийн хэрэгсэл, хашлага бусад зүйлд холбогдох мэргэжлийн байгууллагаар эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгүүлсэний үндэсн дээр хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зорчигчийн гар тээш болон илгээмжийн хорио цээрийн хяналт, шалгалт

17 дугаар зүйл. Зорчигчийн гар тээшийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн шаардлага

17.1.Зорчигчийн хувийн хэрэглээний амьтан, ургамал, түүхий эд бүтээгдэхүүнд шаардлагатай тохиолдолд улсын байцаагч анхдагч үзлэг хийнэ.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан үзлэгийн явцад, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, амьтны гоц халдварт өвчин гарсан улс, бүс нутгаас гаралтай болох нь тогтоогдсон амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагч энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

17.3. Энэ хуулийн 17.1 дэх хэсэг нь үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнд хамаарахгүй.

18 дугаар зүйл. Амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний илгээмжид тавих хорио цээрийн хяналт

18.1. Илгээмжийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бүхий илгээмж ирсэн тухай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын холбогдох байгууллагад мэдэгдэж үзлэг, шалгалт хийлгэнэ.

18.2. Энэ хуулийн 10.1.1-д заасан нөхцөлийг хангасан, хорио цээрийн анхдагч үзлэгээр ургамлын хорио цээртэй зүйл илрээгүй, гэмтэж муудаагүй түүхий эд, бүтээгдэхүүнийг илгээмжээр хил нэвтрүүлнэ.

18.3. Энэ хуулийн 18.2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангаагүй илгээмжийг илгээгчид мэдэгдэж буцаах буюу устгах арга хэмжээ авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх

19 дүгээр зүйл. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавих шаардлага

19.1. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь дараахь шаардлагыг хангасан байна:

19.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний ачуулгүй байдал, таатай нөхцөлийг хангасан, халуун, хүйтний хэмийг тохируулах боломжтой байхаар тоноглогдсон байх;

19.1.2. тээвэрлэлтийн өмнө технологийн дагуу цэвэрлэж, ариутгаж халдваргүйжүүлсэн байх;

19.1.3. чингэлэг, хашлагыг нээх үед амьтны хэвтэр, ялгадас, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн асгарахаргүй ачигдсан байх.

19.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журмыг улсын мэргэжлийн хяналтын төв байгууллага тогтооно.

20 дугаар зүйл. Тээврийн хэрэгсэлд хийх хорио цээрийн үзлэг, шалгалт

20.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үед дараахь үзлэг шалгалт хийнэ:

20.1.1. энэ хуулийн 19.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх;

20.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд дагалдах бичиг баримт нь тээврийн хэрэгслийн талаархи мэдээлэлтэй тохирч буй эсэх;

20.1.3. тээврийн хэрэгсэл нь амьтны гоц халдварт болон халдварт өвчний үүсгэгч, үргамлын хорио цээртэй зүйлсээр бохирлогдсон эсэх.

20.2. Хорио цээрийн хяналт, шалгалтын үед амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зөвхөн улсын байцаагчийн хяналтын дор тээврийн хэрэгслээс буулгана.

20.3. Үзлэг шалгалтаар тээврийн хэрэгсэлд хорио цээртэй зүйл илэрвэл дээж авч лабораторийн шинжилгээнд өгнө.

20.4. Үзлэг шалгалт хийх үед тээвэрлэгчийн төлөөлөгчийг байцуулна.

21 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

21.1. Хорио цээртэй зүйлээр халдварлагдсан тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага, иргэн улсын байцаагчийн хяналтын дор зохих журмын дагуу хийнэ.

21.2. Тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх талбайг улсын байцаагч тогтооно.

21.3. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөлөөр хангана.

22 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийг хорио цээрт оруулах

22.1. Амьтны гоц халдварт өвчин, үргамлын хорио цээртэй зүйлийн голомт үүссэн бүс нутгаас амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгслийг хилийн боомт дээр ирмэгц улсын мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэрээр хорио цээрт оруулна.

22.2. Энэ хуулийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу хорио цээрт оруулсан тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Импорт, экспортын өмнөх хяналт, баталгаажуулалт

23 дугаар зүйл. Импортын мэдэгдэл

23.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох иргэн, хуулийн этгээд хусэлтэв улсын мэргэжлийн хяналтын байгууллагад дор дурдсанаас доошгүй хугацааны өмнө гаргана:

23.1.1. салаа туурайтай амьтан, адуу импортлоход 60 хоног;

23.1.2. тахиа, галуу, нугас, цацаг яруул, гургууль зэрэг тэжээвэр шувуу импортлоход 40 хоног;

23.1.3. таримал болон байгалийн үргамлын үр суулгац импортлоход 30 хоног;

23.1.4. Энэ хуулийн 23.1.1-23.1.3-т зааснаас бусад амьтан, ургамал, түүхий эд, зарим бүтээгдэхүүнийг оруулахад 20 хоног.

23.2. Хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээд нь дараахь мэдээллийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хусэлтийн хамт ирүүлнэ:

23.2.1. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах гэрээ, бэлэгшлэлийн гэрээ болон түүнтэй адилтгах бичиг баримт;

23.2.2. импортлогч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

23.2.3. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл;

23.2.4. нэвтрүүлэх хилийн боомт, хугацаа;

23.2.5. түүхий эд, бүтээгдэхүүний тоо хэмжээ, боловсруулалтын байдал, /хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, шинэ гэх мэт/ савлалт, шошго, чанар, аюулгүй байдлын талаарх мэдээлэл.

23.3. Улсын мэргэжлийн хяналтын байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

23.3.1. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгож, хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байцаагчид хүргүүлэх;

23.3.2. зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээнээс хэтэрсэн, түүнийг бууруулах боломжгүй тохиолдолд хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэх.

24 дүгээр зүйл. Импорт, экспортын өмнөх хорио цээрийн хяналт, шалгалт, баталгаажуулалт

24.1. Хууль болон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол импортлох салаа туурайтныг 21, адууг 15, тахиа, нугас, галуу, цацаг хяруул, гургуулийг 21, ургамлын үр 60, ургамлын суулгац, үржүүлгийн материалыг 30 хоногийн хугацаанд экспортлогч улсын нутаг дэвсгэр дээр хорио цээрийн хяналтад оруулна.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан амьтныг үржлийн болон эдэлгээний зориулалтаар импортлох бол хорио цээрийн хяналтад байх хугацааны турш өдөр бүр эрүүл мэндийн үзлэг хийж, биеийн халууныг хэмжин тэмдэглэл хөтөлнө.

24.3. Энэ хуулийн 24.1-д заасан амьтан, ургамлыг экспортлоход импортлогч улстай байгуулсан гэрээ, хэлэлцээр болон энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн хорио цээрт оруулж, үзлэг, шинжилгээ хийнэ. Шинжилгээг олон улсын стандартад нийцсэн аргаар хийнэ.

25 дугаар зүйл. Импорт, экспортын гэрчилгээ

25.1. Импортын гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаас олгосон экспортын гэрчилгээ, улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон импортын мэдэгдэл, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагч олгоно.

25.2 Экспортын гэрчилгээг хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан тусгайлан эрх олгосон мэргэжлийн байгууллага олгоно.

25.3. Экспорт, импортын гэрчилгээ нь олон улсын амьтны халдварт өвчний болон ургамал хамгааллын байгууллагын баталсан загварын дагуу хийгдэж, экспортлогч, импортлогч улсын харилцан тохиролцсон хэлээр бичигдсэн байна.

25.4. Экспортын гэрчилгээг тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг ачуулахын өмнө 24 цагийн дотор олгосон байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Эрсдэлийн задлан шинжилгээ, үнэлгээ, зөвшөөрөгдөх эрсдэл

26 дугаар зүйл. Эрсдэлийн задлан шинжилгээ, үнэлгээ хийх

26.1. Монгол Улсын хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндийг хамгаалах, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлээс урьдчилан сэргийлэх зорилгоор импортын эрсдэлийн задлан шинжилгээ хийнэ.

26.2. Эрсдэлийн задлан шинжилгээгээр импортлож буй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнээс дараахь зүйлд үчирч болох аюулыг тодорхойлно:

26.2.1. хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндэд;

26.2.2. улсын эдийн засагт;

26.2.3. хүрээлэн буй орчинд.

26.3. Эрсдэлийн задлан шинжилгээг дор дурдсан үндэслэлээр хийнэ:

26.3.1. импортын уламжлалт харилцаагүй улс, бүс нутгаас анх удаа мал, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн Монгол Улсад импортлох бол;

26.3.2. импортын уламжлалт харилцаатай боловч тухайн улсад амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, хими, физикийн бохирдлын эрсдэл өссөн байж болзошгүй нөхцөлд Монгол Улсад импортлох бол;

26.3.3. хэд хэдэн улсын нутаг дээгүүр дамжуулан тээвэрлэх бол.

26.4. Эрсдэлийн задлан шинжилгээг улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас томилогдсон мэргэжлийн баг гүйцэтгэнэ.

27 дугаар зүйл. Зөвшөөрөгдөх эрсдэлийг тооцох

27.1. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагаг

улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байгууллага олон улсын стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

27.2. Зөвшөөрөгдөх эрсдэлтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний импортыг хүлээн зөвшөөрч мэдэгдэл олгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

28 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх

28.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараахь эрх эдлэнэ:

28.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон хорио цээрийн нөхцөл, шаардлагын талаархи мэдээллийг хорио цээрийн байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

28.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх талаар гаргасан хүсэлтийг энэ хуулийн 23.3-д заасан хугацаанд шийдвэрлүүлэх;

28.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон, саатуулсан талаар албан ёсны тайлбар авах;

28.1.4. хорио цээрийн үзлэг, шалгалт, хяналтын талаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах.

29 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг

29.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

29.1.1. энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлт, мэдээллийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлэх;

29.1.2. улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаар улсын мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчид мэдүүлэх;

29.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед экспорт, импортын болон бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг улсын байцаагчид шалгуулах;

29.1.4. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг үзлэг, шинжилгээнд хамруулах;

29.1.5. улсын мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

29.1.6. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ хийж баталгаажуулах, тэдгээрийг саатуулах, эмчилгээ, цовэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийхэд шаардагдах зардлыг хариуцах.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

30 дугаар зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны санхүүжилт

30.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн арга хэмжээтэй холбогдуулан дараахь зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ:

30.1.1. хил, гүний боомтод амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн буюу илэрч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хэрэгжүүлэх хорио цээр, ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалын арга хэмжээнд шаардагдах хөрөнгө.

31 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, хорио цээрийн үзлэг, шалгалт хийхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

31.1. Иргэн, хуулийн этгээд улсын байцаагчийн зөрөнд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, хорио цээрийн үзлэг, шалгалт хийхтэй холбогдон үүссэн маргааныг улсын мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэх бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл иргэн, хуулийн этгээд, улсын байцаагчын шүүхэд гомдол гаргаж болно.

32 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

32.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол

эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

32.1.1 хорио цээрийн хяналт, шалгалтын үед амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрлэн хэрэгслээс буулгасан бол иргэнийг 15000-50000, хуулийн этгээдийг 50000-150000 төгрөгөөр торгох;

32.1.2. энэ хуулийн 19.1.2, 19.1.3-т заасны дагуу тээвэрлэн хэрэгслэгээ, ачилтыг хийлгээгүй бол иргэнийг 25000-50000, хуулийн этгээдийг 50000-150000 төгрөгөөр тус тус торгох;

32.1.3. импорт, экспортын гэрчилгээгүй болон гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл ялгарамч, дагалдах бүсад баримт бичигтэй тохирохгүй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглож, зөрчил гаргасан иргэнийг 1000 - 50000, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр торгох;

32.1.4. энэ хуулийн 9.1.4-т заасан сав, баглаа боодлын битүүмжлэлийг задалсан иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 25000-80000 төгрөгөөр торгох;

32.1.5. энэ хуулийн 18.1-д заасан илгээмжийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн бүхий илгээмж ирсэн тухай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагад мэдэгдэж үзлэг, шалгалт хийлгээгүй бол зөрчил гаргасан албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр торгох;

32.1.6. энэ хуулийн 29.1.1-29.1.5-ыг зөрчсөн иргэнийг 1000-25000, хуулийн этгээдийг 25000-80000 төгрөгөөр торгох;

32.1.7. энэ хуулийн 29.1.6-д заасан зардлыг төлөхөөс зайлсхийсэн иргэнийг 5000-50000, хуулийн этгээдийг 50000-200000 төгрөгөөр торгох;

32.1.8. энэ хуулийн 13.4-т заасныг биелүүлээгүй иргэнийг 50000-150000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгож, буцаах болон устгахтай холбогдон гарсан зардлыг гаргуулах.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"12 дугаар зүйл. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх

12.1. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээр, ариун цэврийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"10 дугаар зүйл. Ургамал, түүний гаралтай түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх

10.1. Ургамал түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 он №46(283)
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр
Улаанбаатар хот

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж

2.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж нь Үндэсний хууль[1], Үндэсний аюулгүй байдлын тухай[2], Эмийн тухай[3] хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис" гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны НҮБ-ын Конвенци, "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байгаавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг;

3.1.2."мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт" гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хүвааралах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, түс улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагаат;

3.1.3."мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх" гэж байгальд үргадаг мансууруулах үйлчилгээ бүхий үргамлыг түүж цуглуулах, тарьж ургуулах, хураан авах, цэвэршүүлэх, дахин боловсруулж хувирган өөрчлөх, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авахыг;

3.1.4."мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эд" гэж хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан, тус улсад хяналтад байгаавал зохих мансууруулах үйлчилгээ бүхий үргамал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, дахин боловсруулахад хэрэглэгддэг бодисыг;

3.1.5."мансуурах дон" гэж мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгүйн өвчнийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнд тавих хяналт

4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ашиглах, хэрэглэх

4.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурдсан зорилгоор дараахь байгууллага ашиглаж болно:

4.1.1.эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эмнэлэг, эрдэм шинжилгээний байгууллага;

4.1.2.лабораторийн шинжилгээ хийх, сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага;

4.1.3.харьцуулалт хийх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаат илчлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага.

[1] Монгол Улсын Үндэсн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн
[2] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн
[3] Эмийн тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн

4.2. Эмчийн заалтаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэх жор авсан өвчтөн үг эмийг хэрэглэж болно.

4.3. Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын болон байгууллагын жагсаалт, ашиглах журмыг Засгийн газар батална.

5 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх

5.1. Эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг эмчийн тусгай жороор олгоно.

5.2. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сан сум, дүүрэгт нэг байна. Түүнийбайршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага тогтооно.

5.3. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор ашиглах журам, нөхцөлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, хуудлах журмыг тогтоохдоо Эмийн тухай хуулийн 16[1].1-д заасныг баримтална.

6 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх

6.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

6.2. Экспортлогч, импортлогч талууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө харилцан гэрээ байгуулна.

6.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг экспортлогч, импортлогч талуудын байгуулсан гэрээ, эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

6.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг энэ хуулийн 6.3-т заасан тусгай зөвшөөрлийг үндэслэн Засгийн газраас тусгайлан тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлнэ.

6.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүрт Улсын мэргэжлийн хяналтын газарт 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

6.6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журмыг гаалийн удирдах төв байгууллага батлан мөрдүүлнэ.

7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах

7.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг зохих шаардлага хангасан байр, агуулахад хадгалах бөгөөд сав, баглаа боодол нь түүний бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр хийгдсэн байна.

7.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг дараахь тохиолдолд устгана:

7.2.1. эрх бүхий байгууллагын хяналтын үйл ажиллагааны явцад хууль бусаар ашиглаж байгааг илрүүлэн хураж авсан бөгөөд цаашид ашиглах чанарын шаардлага хангахгүй бол;

7.2.2. эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж байсан болон нөөцөлж хадгалсан боловч хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан;

7.2.3. сав, баглаа боодол нь шошго, нэр хаягүй бол.

7.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад зориулалтаар үйлдвэрлэх, худалдах, ашиглах, хэрэглэхийг хориглоно.

8.2. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн үүргаар бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

8.3. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн

байгууллага нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, хадгалах шаардлага, тусгай нөхцөл хангасан агуулахтай байна. Уг агуулахын талаар Улсын мэргэжлийн хяналтын газраас дүгнэлт гаргана.

8.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд бэлтгэх, үйлдвэрлэл явуулах, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгоно.

8.5.Тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[4] хуулиар зохицуулна.

9 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн ашиглалт, зарцуулалтын тайлан

9.1. Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүр гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 14.5-д заасан байгууллагад тус тус ирүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх

10 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг

10.1. Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэгтэй.

10.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

11 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа

11.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүнчлэн эрүүл мэнд, хөвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй.

11.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгайлан тусгана.

11.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Монгол Улсын хилээр нэвтрэх гаалийн мэдүүлэгт монгол, орос, хятад, англи хэл дээр хөвлэмэлээр бичсэн байна.

11.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд агуулсан сав, баглаа боодлын шошго дээр түүний хор аюултайг анхааруулсан тусгай санамж бичиг байна.

11.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар эрх бүхий байгууллагаас бэлтгэж, хянасан сурталчилгааны материалыг хөвлэн мэдээллийн хэрэгслээр ямчийн хэлбэр харгалзахгүй түгээх үүрэгтэй.

12 дугаар зүйл. Мансуурах донтой этгээдийг эмчлэх

12.1. Мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ.

12.2.Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ.

13 дугаар зүйл. Хориглох зүйл

13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно:

13.1.1.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шуудангийн илгээмжээр явуулах;

13.1.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хөвлэмэл зүргийг нийтэд түгээх, хөвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах;

13.1.3. мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг жоронд заасан тоо, хэмжээнээс илүү олгох;

13.1.4.эмчилгээнд хэрэглэхийг хориглосон мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг худалдах;

---

[4] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

13.1.5.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн эмчилгээний бус жүрмаар хэрэглэх;

13.1.7.тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгж хоёр талын гэрээнд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг төстэй өөр зүйлээр орлуулах болон зөвшөөрсөн тоо, хэмжээг хэтрүүлэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.8.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, худалдах, хадгалах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.9.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг насанд хүрээгүй хүнд худалдах, олгох;

13.1.10.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүүхдийн бусад байгууллага байрладаг нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, хадгалах.

14 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих

14.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртээл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

14.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолтод хяналт тавина.

14.3.Гаалийн болон хил хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох үүрэгтэй.

14.4.Цагдаа, татнуул, хил хяналтын болон холбогдох бусад байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

14.5. Энэ хуулийн 14.1.- 14.4-т заасан байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүрэгтэй байгуын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

15 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлтэй хийх тэмцэлд дэмжлэг үзүүлэх

15.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад зайлшгүй шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс гаргана.

15.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор амьтан сургах, хяналтын болон лабораторийн шинжилгээний техник хэрэгслээр хангахад төрөөс зохих дэмжлэг, хөнгөлөлт үзүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан захиргааны дараахь шийтэл ногдуулна:

16.1.1.энэ хуулийн 13.1.7, 13.1.8, 13.1.10 дахь заалтыг зөрчсөн бол иргэнийг 45000-50000, албан тушаалтныг 50000-60000, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.2.энэ хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.4, 13.1.5 дахь заалтыг зөрчсөн бол иргэнийг 40000-50000, албан тушаалтныг 45000-60000, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

16.1.3.энэ хуулийн 13.1.3, 13.1.6, 13.1.9 дэх заалтыг зөрчсөн этгээдийг 30000-50000 төгрөгөөр торгох.

16.2. Тусгай зөвшөөрөл олгох журам зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан зөрчил гаргасан гадаадын иргэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай[5] хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

17 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах

17.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс олгосон олсон, илт хууль бусаар олж авсан орлого гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан хуулийн этгээдийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхийн

[5] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

шийдвэрээр татан буулгана.

18 дугаар зүйл. Улсын орлого болгох

18.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг эрх бүхий төрийн байгууллагаас олгосон зөвшөөрөл болон экспортлогч,импортлогч талуудын байгуулсан гэрээнд заасан нэр төрөл, тоо, хэмжээнээс илүү байвал хураж, хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын орлого болгоно.

18.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс олсон орлогыг хураж, хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын орлого болгоно.

18.3.Хураагдсан ба илэрч олдсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүхий эд, тэдгээрийг бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх зориулалтын тоног төхөөрөмжийг мэргэжлийн болон холбогдох бусад байгууллага цаашид ашиглах боломжтой тухай дүгнэлт гаргасан нөхцөлд улсын орлого болгож, энэ хуулийн 8.2–т заасан байгууллагын хүсэлтээр ашиглуулж болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй:

1/ 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан бол."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.1.-ийн "хар тамхи" гэсний дараа "хуульд өөрөөр заагаагүй бол", мөн хуулийн 15.12.4.-ийн "үйлдвэрлэл, худалдаа эрхлэх" гэсний дараа ",импортлох" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн үйлчлэлийн тухай Протоколыг Засгийн газрын өрөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1990 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Стамбул хотноо байгуулсан Бараат түр хугацаагаар оруулах тухай Конвенци, түүний Бараа тээврийн хэрэгслийг түр оруулах бичиг баримтын тухай хавсралт А, Үзэсгэлэн, яармаг, уулзалт болон бусад тестэй үйл ажиллагааны үеэр үзүүлэх, ашиглах бараат түр оруулах тухай хавсралт В1, Мэргэжлийн багаж төхөөрөмжийг түр оруулах тухай хавсралт В2, Боловсрол, шинжлэх ухаан, соёлын зориулалттай бараат түр оруулах тухай хавсралт В5-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 85** **Улаанбаатар хот**

Төрийн албаны зөвлөлийн дүрэм батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 34.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн дүрмийг хавсралтаар батлалсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Улсын Их Хурлын 1995 оны 35 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 85 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) нь төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг улсын хэмжээнд нэгдсэн арга чилалаар хангаж хэрэгжүүлэх ажлыг эрхлэх төрийн албаны төв байгууллага мөн.

Зөвлөл нь хараат бус бие даасан байдлаар ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

2. Зөвлөлийн зорилт нь төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, төрийн албыг мэргэшсэн, мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлэх замаар Монгол Улсын төрийн албан хаагчийн тогтвортой, үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Зөвлөл нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд бүтээгдэхүүнээ нийлүүлнэ.

5. Зөвлөл нь үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөтэй ажиллана.

6. Зөвлөл нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд жилийн төсвөө үйл ажиллагааны стратеги (хэт)-ийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулж мөрдөн ажиллана.

7. Төрийн албаны зөвлөл нь ажлын албатай

байна. Ажлын алба нь Зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, Зөвлөлийн хэвийн ажиллах нөхцөлийг хангах, хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон мэргэшлийн туслалцаа үзүүлж, Зөвлөлийн өмнө ажлаа хариуцна.

8. Зөвлөл нь яам, аймаг, нийслэлд салбар зөвлөлтэй байх бөгөөд агентлагт салбар зөвлөл ажиллуулах асуудлыг төрийн албан хаагчдын тоог харгалзан Төрийн албаны зөвлөл шийдвэрлэнэ. Салбар зөвлөлийн дарга нь яаманд Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлд Засаг даргын Тамгын газрын дарга, агентлагт тухайн агентлагийн дарга байна. Зөвлөл нь салбар зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг тогтооно.

Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн хянан шалгах хороо, Монголбанк, Үнэт цаасны хороо, Үндэсний статистикийн газрын ажлын албаны салбар зөвлөлийн эрхлэх боловсон хүчний холбогдолтой асуудлыг Төрийн албаны зөвлөл хариуцна.

Харин Төрийн хянан шалгах хороо, Монголбанк, Үнэт цаасны хороо, Үндэсний статистикийн газрын харьяа орон нутгийн салбар байгууллагын боловсон хүчний холбогдолтой асуудлыг Төрийн албаны зөвлөлийн тухайн аймаг дахь салбар зөвлөл хариуцна.

9. Салбар зөвлөл хэвийн үйл ажиллагаагаа явуулахад нь аймаг, нийслэлд Засаг даргын Тамгын газар, яам, агентлагт түүний ажлын алба үйлчилж, туслана.

10. Төрийн албаны зөвлөлийн гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлнэ. Зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлтэд нь тогтоосон хугацаанд хариу өгч байна.

11. Зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Зөвлөлийн эрх, үүрэг

Зөвлөл нь Төрийн албаны болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1. удирдлагын үндэсний чадавхийг хөгжүүлэх болгосыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа уялдуулан зохицуулах, зохион байгуулалтын удирдлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх;

2. төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх нэгдсэн журам тогтоож мөрдүүлэх;

3. төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, нийт төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;

4. төрийн албаны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, түүний үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал боловсруулан холбогдох байгууллагад оруулах;

5.төрийн жинхэнэ албан хаагчийн хэрэгцээг төлөвлөх, төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, мэдлэг чадвар бүхий албан хаагчаар хангах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

1/ Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан шаардлага, мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан болзолыг хангасан, төрийн жинхэнэ албанд орох хүсэлтэй Монгол Улсын иргэнээс мэргэшлийн шалгалт авах асуудлаар журам тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалт, арга зүйн удирдлагаар хангах, түүнчлэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журмыг тогтоож мөрдөх;

2/ төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаарх дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгөх;

6. төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, үүний дотор үр дүнгийн гэрээ байгуулах асуудлаар журам тогтоож, хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах;

7. Зөвлөлийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар яам, агентлаг, төрийн захиргааны бусад байгуулагатай, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа шалган зааварлах, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

8. төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдол бүхий шаардлагатай мэдээ, судалгаа, материалыг яам, агентлаг, төрийн захиргааны

бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах, энэ талын мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, шаардлагатай бол төрийн бусад байгууллагыг хангах;

9. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасан албан тушаалд болон нийт төсвийн байгууллагад ажиллах чадвартай хүмүүс, мэргэшлийн шалгалтаар тэнцсэн иргэдийн талаар нөөцийн судалгааг эрхлэн, энэ талаарх мэдээллээр төсвийн байгууллагуудыг хангах;

10. төрийн жинхэнэ албан хаагчийн сургалтыг зохион байгуулж, төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохицуулах, санал дэвшүүлэх;

11. төрийн байгууллагын бүтцийн ерөнхий бүдүүвч, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жиших тогтоохоо санал өгөх, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 46.1-д заасан албан тушаалтны цалин хөлсний талаар төсвийн ерөнхийлөн захирагчид санал гаргах;

12. улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих жүрмын дагуу санал гаргах;

13. төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаат хангахад чиглэсэн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

14. хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг шалгаж дүгнэлт гаргах;

15. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 65 дугаар зүйлд зааснаар төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийн дагуу шалгалт хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах;

16. яам, агентлаг, аймаг, нийслэл дэх салбар зөвлөлийн үйл ажиллагаар удирдлагаар хангаж, мэргэшил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх;

17. Төрийн албан хаагчаас салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн маргааныг хянан шийдвэрлэх;

18. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Гурав.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

1. Зөвлөл нь хамтын удирдлагын байгууллага бөгөөд түүний үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

2. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга, эсхүл гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулна. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

3. Хуралдаанаар Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах ямар ч асуудлыг хэлэлцэж болно. Хуралдаанд Зөвлөлийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцох бөгөөд асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4. Зөвлөл нь хуралдаанаараа хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд Зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

5. Зөвлөлийн ажиллах дотоод журам, хуралдааны дэгийг Зөвлөл тогтооно. Хуралдааны явцын талаар тэмдэглэл хөтөлнө.

6. Зөвлөлийн гишүүд нь ажил үүргийн хуваарьтай байх бөгөөд түүнийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн батална.

7. Зөвлөл нь ажлынхаа тайланг жил бүр Улсын Их Хуралд иргүлнэ.

8. Зөвлөлийн дарга нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ Зөвлөлийн болон ажлын албаны үйл ажиллагаег ерөнхий удирдлагаар ханган зохицуулах;

2/ Зөвлөлийн хуралдаан даргалж, холбогдох асуудлыг хэлэлцүүлэх;

3/ Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийн талаар санал боловсруулах, түүний гүйцэтгэлд болон Зөвлөлийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

4/ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу тухайн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болохын хувьд энэ хуулийн 12.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

5/ дотоод, гадаадад болон бусад байгууллага, албан тушаалтантай Зөвлөлийг төлөөлөн харилцах.

9. Зөвлөлийн дарга өөрийн дотоод асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

10. Зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг даргын шийдвэрээр орон тооны аль нэг гишүүн түр орлон гүйцэтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 86** **Улаанбаатар хот**

Кассын машин ашиглах тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.3-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Кассын машин ашиглах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хүлээн авах боломжгүй байх тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

Засгийн газраас 2002 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Дугаар 172** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Дайчилгааны тухай Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

"Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийг дайчлах журам"-ыг хавсралтын ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 172 дугаар зарлигийн хавсралт

ДАЙЧИЛГААНЫ БЭЛТГЭЛ НӨӨЦИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ТЭДГЭЭРИЙГ ДАЙЧЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дайчилгааны тухай Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу бүх нийтийн болон хэсэгчилсэн дайчилгаа зарласан үед дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.

2. Зэвсэгт хүчин, цэргийн нэгтгэл, ангийг дайчилгаагаар өргөтгөн байлдааны цагийн орон тоогоор хангах, нөхөн хангах, орон нутгийн цэргийг байгуулах тухай Улсын Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчилна.

3. Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг нь дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах үндэслэл болно.

Хоёр. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн

1. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн нь Дайчилгааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрүүл мэндийн хувьд цэргийн жинхэнэ албанд тэнцэх дараахь насны иргэдээс бүрдэнэ:

1/ цэргийн бэлтгэл албанд байгаа 60 хүртэлх насны дээд офицер;

2/ цэргийн бэлтгэл албанд байгаа 55 хүртэлх насны ахлах офицер;

3/ цэргийн бэлтгэл албанд байгаа 50 хүртэлх насны дунд офицер, ахлагч;

4/ цэргийн бэлтгэл албанд байгаа 50 хүртэлх насны эмэгтэй офицер, ахлагч;

5/ цэргийн бэлтгэл албанд байгаа 45 хүртэлх насны байлдагч, түрүүч;

6/ цэргийн жинхэнэ албанд тэнцэх 18-45 насны иргэн.

Гурав. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлын зохион байгуулалт

1. Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас тогтоосон даалгаврын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн

бүрэлдэхүүнд дайчлах хуудсыг хүргэх ажлыг сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна.

3. Гадаадад оршин сууж байгаа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнд хамаарах насны иргэдийг бүх нийтийн дайчилгаа зарласан үед эх оронд нь дуудаж ирүүлэх ажлыг батлан хамгаалах болон гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулна.

4. Гадаадад оршин сууж байгаа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнд хамаарах насны иргэдийг эх оронд нь дуудаж ирүүлэх асуудлыг Монгол Улсаас гадаад улсад сууж байгаа дипломат төлөөлөгчийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

5. Гадаадад оршин сууж байгаа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнд хамаарах насны иргэдийг эх оронд нь ирүүлэхэд шаардагдах тээврийн хэрэгслийг дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.

6. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад Засагийн газар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахтай холбогдсон асуудлаар Засагийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгөх, удирдлагаар хангах;

2/ Дайчилгааны явц, үр дүнгийн талаар Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчид мэдээлэх.

7. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай удирдлагаар хангах;

2/ Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайлан, зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг байлдааны цагийн орон тоогоор өргөтгөн зохион байгуулах ажлыг захиргааны удирдлагаар хангах;

3/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар цэргийн мэргэжлийн удирдлагын дэзд байгуулагад удирдамж, чиглэл өгөх, хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт илтгэх;

4/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах, тэдгийг цуглараас байр болон алба хаах ангид нь тээвэрлэн хүргэх үеийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгөх.

8. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1/ Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг төрийн захиргааны төв , нутгийн захиргааны байгууллагад хүргүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажилд хянлт тавьж, үр дүнг Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлж байх.

9. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад төрийн захиргааны бусад төв байгууллага дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2/ өөрийн салбарын болон харьяа байгууллагын ажиллагсдыг үнэн зөв мэдээллээр хангах.

10. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад цэргийн мэргэжлийн удирдлагын дэзд байгуулага дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг хүлээн авч, цэргийн нэгтгэл, ангийг өргөтгөн зохион байгуулах ажлыг дайчилгааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх;

2/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг хүлээн авах, тэдгийг сургаж бэлтгэхтэй холбогдсон асуудлаар цэргийн нэгттэл, ангийн удирдлагад үүрэг, тушаал өгч, хэрэгжилтэд хяналт тавих;

3/ зэвсэгт хүчин, цэргийн нэгттэл, ангиудыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнээр хангасан байдлын талаар нэгдсэн тооцоог хөтлөх.

11. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах комисс томилж, үүрэгт ажилд нь оруулах;

2/ "цуглараx байр"-ыг дэлгэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаа нь удирдах;

3/ дайчилгааны бэлтгэл нөөцийн

бүрэлдэхүүнийг заасан хугацаанд дайчилж, тэдний холбогдох баримт бичгийн хамт алба хаах нэттэл, ангид хүргэх ажлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулах;

4/ дайчилгааны явцын тухай батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагад зохих журмын дагуу илтгэж байх;

5/ дайчлагдан татагдсан дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг томилгоот нэгтгэл, ангид тээвэрлэн хүргэх үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах;

6/ иргэний өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх.

12. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад сум, дүүргийн Засаг дарга дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг шуурхай зохион байгуулж, тэдгийг заасан хугацаанд холбогдох баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн цугларах байранд хүргэх ажлыг зохион байгуулах;

2/ дайлчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн цугларах байранд тээвэрлэн хүргэх үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

3/ дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах ажлын явц, үр дүнгийн талаар дээд шатны Засаг даргад танилцуулах.

13. Дайчилааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахад аж ахуйн нэгж, байгууллагын дарга /захирал/ дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ дайчилганны ажилд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2/ тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдыг үнэн зөв мэдээллээр хангах;

3/ цэргийн үүрэгтэнг түүний зарлан дуудах хуудсанд заасан хугацаанд цугларах байранд хүрэлцэн очих нөхцөл бололцоог хангах.

Дөрөв. Бусад зүйл

1. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлахдаа өвчтэй гэж мэдүүлснээс бусад цэргийн үүрэгтэнг эрүүл мэндийн үзлэгт оруулахгүй.

2. Дайчлагдсан цэргийн бэлтгэл үүрэгтэн иргэний болон цэргийн бэлтгэл үүрэгтний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтрээ биедээ авч явна.

3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг цугларах байранд 6-аас илүү цагаар байрлуулах бол тухайн нутгийн захиргааны байгууллага тэдгийг хооллор хангана.

4. Дайчилгааг цуцалсны дараа цэргийн жинхэнэ албанаас халагдсан дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлд хүргэхэд шаардагдах тээвэр, хоолны болон бусад зардлыг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, сум, дүүрэгт хүргэхэд шаардагдах дээрх зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус хариуцна.

5. Гадаадад оршин суух байгаа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнд хамаарах насны иргэдийг эх орондг нь авчрахад шаардагдах виз, тээврийн болон бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 23-ны өдөр **Дугаар 216** Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон улсын байгууллагуудын татвар, хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "53.Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо" гэж нэмсүгэй.

2. Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооны гишүүний жилийн хураамж болох 5000 (таван мянган) ам.долларыг 2003 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Санхүү, эдийн засгийн сайд **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 23-ны өдөр | **Дугаар 217** | **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор батлаж, 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Хорих байгууллагын албан хаагчдад олгох хоригдолтой ажилласны нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн цалингийн сангаа багтаан зохицуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Заавар батлах тухай" Засгийн газрын 1994 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 145 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Хууль зүй, дотоод хэргийн сайд **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2002 оны 217 дугаар тогтоолын хавсралт

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАСНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Хорих байгууллагын албан хаагчид хоригдолтой ажилласны нэмэгдэл тогтоож олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Хорих байгууллагад ажиллаж байгаа офицер, ахлагч, Тогтоол гүйцэтгэх газрын мөрдөн хөөх, эрэн сурвалжлах албаны ажилтанд хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

№	Хорих ангийн дэглэмийн төрөл	Хоригдолтой ажилласны нэмэгдлийн хэмжээ (хувиар)
1	Жирийн дэглэмтэй хорих ангид	6
2	Чанга дэглэмтэй хорих ангид	7
3	Нэгдсэн эмнэлэг болон сүрьеэгийн хорих ангид	8
4	Онцгой дэглэмтэй хорих ангид	8
5	Гянданд	9
6	Мөрдөн хөөх, эрэн сурвалжлах	9

3. Хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн байгууллагын даргын тушаалаар зөвхөн дээр дурдсан анги, салбарт ажилласан байх хугацаанд олгоно. Албан хаагч өөр дэглэмтэй хорих ангид шилжин ажиллах тохиолдолд түүнд шилжин очсон хорих ангийн дэглэмийн төрөлд хамаарах нэмэгдлийг бодож олгоно. Ингэхдээ нэмэгдлийн зөрүүг тооцохгүй.

4. Хорих байгууллагын албан хаагч хоригдол оруулсан, хоригдолтой ажиллах үүргээ биелүүлээгүй зэргээр ажлын хариуцлага алдаж, зөрчил гаргасан тохиолдолд байгууллагын даргын тушаалаар түүний хоригдолтой ажилласны нэмэгдлийг хасч болно.

5. Хорих байгууллагын албан хаагчид хоригдолтой ажилласны нэмэгдлийг тухайн байгууллагын төсвөөс олгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 23-ны өдөр **Дугаар 218** **Улаанбаатар хот**

"Мэдээллийн технологийн парк" төслийн дотоод эх үүсвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэдээллийн орчин үеийн өндөр хурдацтай сүлжээ байгуулах болон шинээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа мэдээллийн компаниудад инкубаторын орчин бүрдүүлэх зорилгоор БНСУ-ын буцалтгүй тусламжаар "Мэдээллийн технологийн парк" төслийг шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

2. "Мэдээллийн технологийн парк" төслийг хэрэгжүүлэхэд Монголын талаас гаргах барилгын засвар болон өндөр хурдны сүлжээний кабелийг Мэдээллийн технологийн үндэсний паркийн барилгад оруулахад шаардагдах зардлыг хянаж шинжлэх ухаан, технологийн салбарын 2002 оны санхүүжилтэд зохицуулалт хийх замаар санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд **А.ЦАНЖИД**

Санхүү, эдийн засгийн сайд **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 220** **Улаанбаатар хот**

Тогтоол, тогтоолын зарим заалтыг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийтлэг журам гаргах тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 54 дүгээр тогтоол, "Татварын албаны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 222 дугаар тогтоолын 1, 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан татварын албаны материаллаг баазыг бэхжүүлэх, тус албаны боловсон хүчний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх болон тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан Татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан татварын хөнгөлийн сангийн хөрөнгийг жил бүрийн төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Санхүү, эдийн засгийн сайд **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 221** **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 122 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулгатай 7 хэсэг нэмсүгэй:

"7. Түгээмэл зориулалтын барилга байгууламж

1. Төрийн ордон, Монгол улсын Ерөнхийлөгч,Улсын Их Хурлын дарга,Ерөнхий сайдын албан ажлын байр,Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууцны зураг төсөл, үгсралт, засвар үйлчилгээ, тавилга, техник, тоног төхөөрөмж, материал, программ хангамж.

2.Улсын Их хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны танхим, Төрийн харш болон хилийн чанадад ажилжаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын албан ажлын байрны тавилга, техник, тоног төхөөрөмж, материал, программ хангамж, засвар үйлчилгээ.

3. Төрийн ордны аюулгүй байдлыг хангах зориулалттай дохиолол, хамгаалалтын түгээмэл техник хэрэгсэл, программ хангамж, засвар үйлчилгээ."

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга **Ө.ЭНХТҮВШИН**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №46(283)

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2002 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14 цаг 00 минут

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Амарсанаа даргалж, гишүүдэд Н.Чинбат /илтгэгч/, Л.Рэнчин, Ч.Дашнэм, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Долгор нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороонд оршин суугч Д.Батболд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж мөн оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний шинэ хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Хуульд заасан тохиолдолд Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны энэ хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг хэрэглэж болно" гэсэн заалтыг мөн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг эвдэхэн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ" гэсэн заалтуудыг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтын "гагцхүү хуульд захирагдана" гэсэн хэм хэмжээг зөрчсөн байна.

Учир нь шүүгч гагцхүү хуульд захирагдана гэдэг нь хуулийг бүх нийтээр дээдлэх, хуулинд хэн боловч адил тэгш захирагдах ёстой гэсэн өргөн багтаамжтай ойлголтын хүрээнд юуны түрүүнд шүүгч өөрөө багтаж байгаар илэрхийлдэг тедийгүй шүүгчийн бүхий л үйл ажиллагаа, эдлэх эрх, гүйцэтгэх үүрэг хуулиар тодорхойлогдож "эвэхэн хууль буюу парламентын батилсан актыг баримтлана гэсэн үг юм". Нөгөөт хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа нь тэдний үйл ажиллагааны үндсэн хэсэг учраас энэ ажиллагаа мөн л хуульд захирагдана. Хууль нь шийдэгч гаргахад баримтлах ганц хэмжүүр нь болж, тэнд шүүгч эвэхэн хууль хэрэглэж хэрэг маргааныг шийдвэрлэж байдаг.

Харин өөр бусад эрх зүйн акт хэрэглэвэл хатуу чанд үйлчлэх Үндсэн хууль түүний зарчим зөрчигдөх нь гэдэг нь маргаангүй мэт санагдана. Иймхүү шүүгч эвэхэн хууль хэрэглэснээрээ л хуулинд захирагдсан болох бөгөөд хуулинд захирагдсанарааа л хараат бус байгаа нь харагдаг гэж бодож байна.

Иймд Иргэний хуулийн дээр дурдсан заалтууд Шүүхийг өөр бусад эрх зүйн акт хэрэглэж болно хэмээн зааснаараа Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн үзэл баримтлалд нийцэхгүй байгаа бөгөөд "Шүүгч ...гагцхүү хуульд захирагдана" гэсэн хэм хэмжээг шууд зөрчсөн байна" гэжээ.

Хоёр. Нийслэлийн Хан-Уул дүүргийн оршин суугч Д.Батболд 2002 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийнхөө зарим хэсгээс татгалзах тухай өргөдөлдөө:

"Миний бие 2002 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж өргөдөл гаргасан билээ.

Гэтэл Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг эвэхэн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ" гэсэн хэм хэмжээ нь анх өргөдөл гаргаснаас хойш хугацаанд хийсэн судалгааны явцад Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй болох нь тогтоогдсон юм.

Учир нь хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гэдэг нь нэгдүгээрт Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5-д тусгагдсан эрх зүйн хэм хэмжээний актыг тодорхойлоогүй байж. Хоёрдугаарт "нөхөн зохицуулна" гэдэг нь хувийн эрх зүйн харилцааны оролцогчдын өөр хоорондоо харилцан тохиролцож хэм хэмжээ тогтоосон акт. Тэр хувь этгээдүүдийн хоорондын хуулиар зохицуулаагүй харилцаг зохицуулдаг тийм иргэний ниигмийн шинж чанартай хувь этгээдүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалсан институт байжээ. Үүнийг эрх зүйн онолд эрх зүйн үйлчлэх асуудлын орчин бүюу материаллаг эрх

зүйн эх сурвалж гэж үздэг байна. Шүүх ч үүнийг хэрэглэх нь хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт. Иймд би Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх өргөдлийн шаардлагаасаа татгалзаж байна" гэжээ.

Гурав. Д.Батболд 2002 оны 11 дүгээр сарын 25- ны өдөр Үндэсэн хуулийн цэцэд гаргасан нэмэлт тайлбартаа:

"Шүүх Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны эрх зүйн актыг бус / цаашид хуулийн дэд акт гэж нэрлэнэ/ зөвхөн хууль хэрэглэх нь юун түрүүн төрийн эрх мэдэл хуваарилах зарчимтай холбоотой. Эл зарчмыг хүний эрх, эрх чөлөөг төрийн засагчаллын дүр зоргоос хамгаалах, ардчилсан төр засаг өөрөө туйлын зохион байгуулалттай байх шаардлагын язгуур үндэс бөгөөд хийх ажил, түйлэтгэх үүрэг, эдлэх эрхийн хил хязгаарыг туйлын тодорхой тодорхойлсон "Цаас" тедийгүй бас дээрх эрх мэдлүүд нь Үндэсэн хуулиар тогтоогдсон өөрийн статусын үндэсэн дээр органик хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд ажил хэргийн нарийн үялдаатайгаар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ гэсэн ойлголтуудыг илэрхийлдэг гэж үздэг. Мөн түүнчлэн эрх мэдлүүд нь бие даасан байдалтай, бие даасан байдал нь хязгаартай байх ёстой. Өөрөөр хэлбэл хууль тогтоох эрх мэдлээс хуулийг зөвхөн тогтооно, түйлэтгэх эрх мэдлээс зөвхөн хэрэгжүүлнэ, шүүх зөвхөн хууль хэрэглэнэ гэсэн агуулгатай зарчим гэж нийтэлсэн нь элбэг байдаг.

Харин Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар төсөөлбөл өөрөөр хэлбэл, бидний маргааны хүььд хууль тогтоох болон түйлэтгэх эрх мэдэл шүүхийн хэрэглэдэг, түүний цорын ганц "дарга" болох эрх зүйн актыг хоёулаа тогтоодог болчихлоо. Үнэндээ энэ нь Улсын Их Хурал, Засгийн газраар хязгаарлагдахгүй төрийн эрх бүхий байгууллагууд, албан тушаалтнууд гээд олон тооны субъектүүдээр нэмэгдлээ гэж ойлгож болохоор байна. Төсөөлж бичихэд түйлэтгэх эрх мэдлийн байгууллага нэмэгдсэнээр шүүх эрх мэдэл рүүгээ нөгөө хоёр нь адил функцээр шахсан, улмаар төрийн эрх мэдлийн гурван салааны дунд эн тэнцүү байр эзлэх шүүх эрх мэдлийн байр суурь доошилж түйлэтгэх эрх мэдлийн байр суурь дээшилсэн мэт санагддаг.

Ардчилсан нийгэмд шүүх эрх мэдэл хууль тогтоох болон түйлэтгэх эрх мэдэлтэй эн тэнцүү байр эзэлж тэдгээрт хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах учиртай. Даян дэлхий, ардчилсан нийгмийн эрхэм нандин үнэт зүйлс болсон хүний эрх, эрх чөлөө шударга ёсны талаархи гомдол маргаан шүүхээр эцэслэн шийдвэрлүүлдэг журамтай. Энэ хосгүй ариун шударга, эгэл бус ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчих магадлал хамгийн өндөр байдаг захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг барьж маргааныг шийднэ гэдэг нь төр иргэнийхээ хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх үндэстэй нөхцөл байдал бий болгодог.

Хэрэв энэ хуулийн заалт хүчин төгөлдөр хэвээр үлдвэл дараах нөхцөл байдал үүсч болно.

1.Хууль тогтоогч иргэний хуулийн 3-ын 5-д заагдсан хуулийн дэд актуудыг хэрэглэхэд тавигдах шаардлагуудыг тоочихдоо "энэ хуульд нийцүүлэн гаргасан" гэсэн нэг шалгуурыг хуульчилжээ. Хэрэв хэрэглэх гэж буй хуулийн дэд актын нийцэн гарсан Иргэний хуулийн тухайн заалт өөрөө Үндэсэн хууль зөрчсөн байсан тохиолдолд Иргэний хуулиар халхавч хийж уг дэд актууд шүүхийн хяналтаас гарах боломжтой. Иймхүү хяналтаас гарснаараа захиргааны байгууллага, албан тушаалтны шударга бус үйлдэл, ашиг сонирхол Үндэсэн хууль зөрчсөн хэм хэмжээнүүд нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болох аюултай.

2.Хуулийг бус түүнийг хэрэгжүүлэх талаар гаргасан хуулийн дэд актуудыг хэрэглэснээрээ салбарын болон салбар дундын хуулиудад суусан Үндэсэн хуулийн үзэл баримтлал, тухайн хуулийн зарчим утга санаа бүдэгрэх, шүүгч гагцхүү хуульд захирагдаж байгаа үзэгдэл нь улам бүр үгүй болох чиг хандлагатай болно.

3.Шүүгч гагцхүү хуульд захирагдах зарчимтай холбоотойгоор шүүх зөвхөн хууль хэрэглэж хэрэг, маргаан шийддэг зөв зүгт зүглэсэн шүүгч нар элдэв заавар журам, тушаал хэрэглэдэг болсноороо өмнөх тогтолцооны шүүхүүд шиг диктатурын байгууллага болох шинжтэй болно.

4.Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүдийг хуулийн дэд актыг нэг мөр ойлгож зөв хэрэглэдэг практик тогтоолгохоор тэдгээрийг тайлбарлах үүрэг нэмэгдэнэ. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүд хэрэглэж буй эх сурвалжаа янз янзаар ойлгож гарч буй шийдвэрийнх нь үр дүн өөр өөр байгаа үед Улсын дээд шүүх хуулийн дэд актыг тайлбарлахаас өөр аргагүй л болох болов уу.

Мөн Үндэсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1-ийн 4 болон Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт анализ хийхэд шүүх нь хуулийн дэд актуудыг бус гагцхүү хууль хэрэглэнэ гэсэн санаа гарч байна. Үүнд:

1.Хууль зүйн шинжлэх ухааны онолд аливаа эрх зүйн актыг хэрэглэж эрх зүйн шийдэл гаргагч нь тухайн эрх зүйн актыг тайлбарладаг гэсэн "аксиом" байдаг. Жишээ нь: Үндэсэн хуулийг хэрэглэж эрх зүйн шийдэл гаргадаг субъект нь Үндэсэн хуулийн шүүх бөгөөд Үндэсэн хуулийг ганцхан Үндэсэн хуулийн шүүх л тайлбарлах эрхтэйг бид мэднэ. Харин ердийн шүүх зөвхөн хууль хэрэглэдэг учраас тэдэнд хууль тайлбарлах бүрэн

эрх олгогдсон байдаг. Энэ хоёр үзэгдлээс нэгдүгээрт, хэрэглэх эрх байдаг л бол мөн тайлбарлах эрх олгогдсон байдаг гэсэн дүгнэлт хийж болно. Хоёрдугаарт, хуулийн дэд актыг хэрэглэдэггүй учраас Улсын дээд шүүхэд түүнийг тайлбарлах эрх олгогдоогүй байна гэсэн логик дүгнэлт хийж болно. Энэ бол Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1-ийн 4-өөс хийсэн дүгнэлт.

Нөгөөтэйгүүр Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 нь өөрөө шүүх эвэхэн хууль хэрэглэх ёстойг тунхагласан шинж чанартай байна. Үүнийг тайлбарлахын тулд эхлээд хоёр ойлголтыг дурдах хэрэгтэй байна.

1.Шүүхээс хууль хэрэглэх зарчим нь шүүгч гагцхүү хуульд захирагдах зарчимтай холбоотойгоор урган гардаг гэсэн эрдэмтдийн үзэл бодолтой санал нэг байна.

2.Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3-ыг "эсэргээр нь үншвал" Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцсэн, албан ёсоор нийтлэгдсэн хуулийг хэрэглэх эрхтэй гэж буюу байна. Иймээс энэ заалт нь шүүх хууль хэрэглэх талаар заасан тедийгүй тэр нь ямар шалгуурруудыг хангасан байхыг тодорхойлсон цорын ганц заалт юм.

Хэрэв шүүгч гагцхүү хуульд захирагдах зарчимтай холбоотойгоор шүүхээс хууль хэрэглэх зарчим урган гардаг юм бол Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-ээс Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 урган гарсан байх ёстой гэсэн нэгдэх дүгнэлтийг хийж болно. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д "Шүүгч ...гагцхүү хуульд захирагдана" гэсэн нь хуулиас өөр ямар нэгэн эрх зүйн актанд захирагдахгүй гэсэн санаа байгаа нь маргаангүй тул тэр нь Тавьдугаар зүйлийн 3-т заавал илрэх ёстой бөгөөд ийнхүү илрэхдээ мөн л өөр ямар нэг эрх зүйн акт хэрэглэхгүй гэсэн санаа тэнд гарсан байх ёстой гэсэн логик дүгнэлт хийхэд хүргэж байна. Тиймээс ч эвэхэн хууль хэрэглэх ёстойг бичиж улдээгээгүй харин хэвшил болсон ойлголтон дээрээ үндэслэн түүний шалгуурруудыг шууд тоочин нэрлэсэн байна.

Иймд шүүх маргааныг шийдвэрлэхдээ легитемт шинж чанартай Парламентаас батална эрх зүйн актыг бариманлж шударга ёс, хүний эрх, эрх чөлөөний баталгаа болж байдаг гэсэн тэрхүү сонгодог ойлголтыг Үндсэн хуулийн цэц шийдвэрээрээ дахин нэг тунхаглах байхаа гэж найдаж байна.

Харин Иргэний хуулийн 3-ын 5-д тодорхойлсон эгтээдүүдийн баталсан эрх зүйн актууд нь хуульгүй зүйн үндэслэлээ тодорхойлсон хуулиа тухайн дэд актыг батлагч этгээд хэрхэн яаж ойлгож байгааг илэрхийлэх бөгөөд хууль хуулийн дэд актуудаар хэрэгжих буйг, хуулиар нөгдуулсан үүргээ албан тушаалтан биелүүлж байгааг л хэм хэмжээ тогтоох маягаар харуулдаг шинж чанартай. Үүнийг шүүхэд маргагч талууд нэхэмжлэлийн үндэслэл, татгалзлаа нотлох нотолгооны хэрэгсэл болгон ашигладаг. Шүүхийн хувьд хуулиа хэрэглэхийн түлд түүнээс иш татан ашиглаж нотлох бариментын түвшинд үнэлдэг зүй тогтолтой" гэжээ.

Дөрөв. Улсын Их Хурлын дөрөвдүгээр сарын 7-ны өдрийн 175 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Б.Долгор Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

"1. Хууль тогтоогч Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийг иргэний эрх зүйн аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхэд байнга тохиолддог асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгасан.

Зарим маргааныг шийдвэрлэхэд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хуульд тодорхой заагаагүй, төсөөтэй хэрэглэх хуулийн заалт байхгүй байх тохиолдол олонтаа гардаг.

Нөгөө талаар иргэний эрх зүйн харилцааг бүхэлд нь хуулиар зохицуулах боломжгүй тул хуулиар шууд зохицуулаагүй харилцаг терийн эрх бүхий байгууллагаас гаргасан актаар зохицуулах зайлшгүй шаардлагатай.

Тийм ч учраас Иргэний хуульд дээрх заалтуудыг тусгаснаас гадна 380 дугаар зүйлийн 2-т "Зорчигч буюу ачаа, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд нийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрмээр тодорхойлогдоно" гэж заасан.

Эдгээр журам нь хуульд нийцсэн байх ёстой бөгөөд хэрэв хуульд нийцээгүй бол эрх зүйн актыг хэрэглэж болохгүй нь ойлгомжтой.

2.Иргэний хуулийн 3.5-д эвэхэн "нийтэр дагаж мөрдөх" эрх зүйн актыг хэрэглэж болохоор заасан бөгөөд энэ нь "хуульд нийцсэн байх" ёстой.

Засгийн газрын 1997 оны 178 дугаар тогтоолоор "Яам, тохируулагч агентлагаас нийтэр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичгийг хянаж буртгэх журам"-ыг батална бөгөөд уг журмын Нэгийн 2-т "Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичиг гэдэг нь яам, тохируулагч агентлагаас хуулиар олгогдсон бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан тухайн салбарын болон улсын хэмжээнд байнга дагаж мөрдүүлэх заалт бүхий эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг /тушаал, тогтоол/-ийг хэлнэ" гэж заасан байна.

Түүнчлэн яам, тохируулагч агентлаг нь эвэхэн хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон нөхцөлд нийтээр дагаж мөрдүүлэх эрх зүйн баримт бичиг гаргах ба нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичигт тусгайлан эрх олгосон хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоолын заалтыг үндэслэл болгон заавал дурдаж байх юм.

Яам, тохируулагч агентлаг нь нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичгийнхээ эх хувийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж хуульд нийцсэн эсэхийг хянуулах үүрэгтэй бөгөөд хэрэв уг акт бүхэлдээ буюу аль нэг заалт нь Үндэсн хууль, бусад хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн байвал Хууль зүй, дотоод хэргийн яамны дүгнэлтийн дагуу уг баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах ёстой.

Иймд хуулийн заалтыг үндэслэн, хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг шүүх хэрэгслэнийг "хуульд захирагдсангүй" гэж үзэх үндэслэлгүй юм.

З.Д.Батболд гаргасан өргөдлөө: "...шүүгч хуульд захирагдана гэдэг нь хуулийг бүх нийтээр дээдлэх, хуулинд хэн боловч адилхан захирагдах ёстой гэсэн өргөн багтаамжтай ойлголтын хүрээнд юун түрүүн шүүгч өөрөө багтаж байгааг илэрхийлдэг тодийгүй шүүгчийн бүхий л үйл ажиллагаа, эдлэх эрх, гүйцэтгэх үүрэг хуулиар тодорхойлогдож "эвхэн хууль буюу парламентын батапсан актыг баримтлана гэсэн үг юм..." гэжээ.

Юуны өмнө Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн дээр дурдсан заалтуудад "хуулинд хэн боловч адилхан захирагдах ёстой" гэсэн зарчмыг зөрчсөн агуулга байхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Иргэний хуулийн дурдсан заалтуудад шүүгч эрх зүйн актыг хэрэглэж болох тухай л заасан бөгөөд харин хуульд захирагдах эсэх тухай асуудлыг хөндөөгүй.

Нөгөө талаар "хуульд захирагдах", "эрх зүйн актыг хэрэглэх" гэсэн ойлголтууд нэг утгыг агуулсан гэж үзэж болохгүй.

Хуульд захирагдана гэдэг бол хууль, түүнд нийцсэн эрх зүйн актыг дагаж мөрдөх, хууль зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй байх, харин "эрх зүйн актыг хэрэглэх" гэдэг нь шүүгч маргааныг шийдвэрлэхдээ уг эрх зүйн актыг харгалзан үзэж, хуулийг баримтлан шийдвэрлэнэ гэсэн үг гэж ойлгож байна.

Эдгээрийг үндэслэн иргэн Д.Батболдын өргөделд дурдсан Иргэний хуулийн дээрх заалтууд Үндэсн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна. " гэжээ.

Тэв. Иргэн Д.Батболд Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад: "Хуульд захирагдана гэсэн ойлголтод хууль хэрэглэх гэдэг нь багтсан явцуу ойлголт юм. Иймд шүүх, Засгийн газар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны актыг хэрэглэхээр тогтоосон нь Үндэсн хууль зөрчсөн гэж үзэж байна" гэсэн тайлбар хийв.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Долгор: "Хуульд захирагдах, хууль хэрэглэх гэсэн ойлголтуудыг ялгаатай авч үзэх ёстой. Иймд Иргэний хуулийн холбогдох заалт Үндэсн хууль зөрчөөгүй" гэсэн тайлбар хийв.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хэт хавтайруулсан, шүүхээс хэрэглэх хэм хэмжээний хүрээ Үндэсн хуулийн агуулгатай зөрчилдсөн байна. Мөн заалтад хуульд заасан тохиолдолд Засгийн газар эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрх олгогдсоныг Үндэсн хуулийн агуулгатай зөрчилдөөгүй гэж үзлээ. Үндэсн хуулиар тодорхойлогдсон хууль дээдлэх зарчмын агуулгад хуульд хэрэглэх үйл ажиллагаа бүрнээ нийцэж байх ёстой. Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж буй эрх зүйн акт шүүхэд маргаан шийдвэрлэх явцад нотолгооны ач холбогдолтой хэрэгсэл болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон,

ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..." гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч... гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА Ж.АМАРСАНАА

ГИШҮҮД Л.РЭНЧИН
Ч.ДАШНЯМ
Ц.САРАНТУЯА
Н.ЧИНБАТ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс: 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (284)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арванхоёрдугаар сарын 20 № 47 (284)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

663. Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-5-ны хууль) 1412
664. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-5-ны хууль) 1412
665. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-5-ны хууль) 1413
666. Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-6-ны хууль) 1413

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

667. "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д өөрчлөлт оруулах тухай Дугаар 87 1413
668. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 88 1414
669. Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын 1995 оны 42 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 89 1414

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

670. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 177 1414
671. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 178 1414
672. Домийн Төмөртогоод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 179 1416
673. Нямын Жадамбаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 180 1417
674. Бадамжавын Чогсомд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 181 1417
675. Гомбын Равданд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 182 1417
676. Бямбын Дагвадоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 183 1417
677. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 184 1418

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

678. Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай Дугаар 219 1422

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

ХӨНӨ АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөнө амын орлогын албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн "8 дугаар зүйл," гэсний дараа "4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт," гэж; 8 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "1, 3, 4, 5, 6, 7, 8" гэсний дараа "болон 7 дугаар зүйлийн 5" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хөнө амын орлогын албан татварын хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана."

2/ 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2 дахь заалтад заасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана."

3/ 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор гаргаж, харъяалагдах татварын албанд тушаана."

3 дугаар зүйл. Хөнө амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Гадаад валютаар олсон орлогыг тооцохдоо уг валютыг банкинд худалдах буюу Монголбанкнаас тогтоосон ханшаар төгөөрөг шилжүүлнэ." гэсний "Гадаад валютаар олсон орлогыг төгөөрөг шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг үндэслэнэ." гэж; 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "2003" гэснийг "2005" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хөнө амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын "байгууллага болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгууллагдсан олон улсын бусад" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Хөнө амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "ногдол хувь, хувьцаа," гэсний дараа "терийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувьцаа болон" гэж; 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "шилжүүлнэ." гэсний дараа "Энэ тухай тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор улирал бүр өссөн дүнгээр, жилийн эцсийн тайланг дараа оны эхний сарын 10-ны дотор гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана." гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "Өмч хувьчлах тухай хуулийн дагуу" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 5–ны өдөр — **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дараахь заалт нэмсүгэй.

"11.3.4. энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.6, 9.1.10, 9.1.13, 9.2.15-д заасан үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ."

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 3.1.10 дахь заалтын "дагуу" гэсний дараа "болон олон улсын тусламжийн байгууллагын шугамаар" гэж "байгууллагаас өгсөн санхүүжилт" гэсний өмнө "болон буяны" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9.1.1-ийн "з" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 **дүгээр зүйл.** Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 6–ны өдөр — **Улаанбаатар хот**

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

"6/ "эрдэнийн чулуу" гэж олон улсад хэвшсэн ангилалд хамрагдах үнэт, хагас үнэт чулууг хэлнэ."

2 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "нарийвчлалтайгаар" гэсний дараа "үнэт чулууг каратаар" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5/ "байгалийн төрц" гэж онцгой чамин дүрс хэлбэртэй, байгалийн тогтоц хэлбэрээрээ олдсон үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ."

4 дүгээр зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтын "гадаадад" гэсний "дотоод, гадаадад"; 2 дугаар зүйлийн "Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах тухай" гэсний "Соёлын өвийг хамгаалах тухай"; 3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 4, 5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 4 дэх заалтын "эрдэнийн" гэснийг "үнэт"; 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын "түүх соёлын үнэт дурсгалт" гэснийг "түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт"; 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын "буюу" гэснийг "эсхүл"; "металлыг" гэснийг "металл, үнэт чулууг"; 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "эрдэнийн чулуугаар" гэсний "үнэт чулуу, тэдгээрээр"; 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Сангийн яамны хяналтын зохих албаар" гэсний "Сорьцыг асуудал хариуцсан улсын хяналтын албаар"; мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "Соёлын сайд" гэснийг "Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "цагаан мөнгийг" гэснээс "цагаан" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 5–ны өдөр — **Дугаар 87** — **Улаанбаатар хот**

"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.1.5.-ын 2 дахь хэсгийг "Монголын иргэний агаарын тээвэр ТӨҮГ-ыг төрийн өмчийн хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн хувьцааны 49 хувийг хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа, үйлчилгээг нь сайжруулах, техник

технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий иргэний агаарын тээврийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллагад уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах" гэж өөрчлөн найруулсугай.

2."Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.1.2-ын "Монгол Улсын алслагдсан аймаг, сум дахь шатахуун түгээх станцыг нефть бүтээгдэхүүнээр хангах талаар шинэ өмчлөгчийн зүгээс хүлээсэн үүрэгийн биелэлтийг хангуулах зорилгоор Засгийн газар алтан хувьцаа 5 жилийн хугацаатай гаргах" гэсэн хэсгийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 5–ны өдөр Дугаар 88 Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн С.Оюуны 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай" хуулийн төслөөр зохицуулах гэж буй харилцаа нь одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор нэгэнт зохицуулагдсан, нэмэлт оруулах заалт нь энэ хуулийн зохицуулах хүрээний асуудал биш гэж үзсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 12–ны өдөр Дугаар 89 Улаанбаатар хот

Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын 1995 оны 42 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 7.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтын Үндэсэн хуулийн цэцийн ажлын албаны "тэргүүн түшмэл" гэсэн ангиллын "АА-1" гэсэн зэрэглэлд "Тамгын газрын дарга" гэсэн заалт нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 19–ний өдөр Дугаар177 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндэсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь :

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ойдовын Нямдавааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жанцангийн Гэлгээг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 20–ны өдөр Дугаар178 Улаанбаатар хот

Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай

"Прокурорын байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 3 дахь заалтыг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. "Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг 1дүгээр хавсралтын, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 81 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 178 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Прокурорын мэргэжлийн зөвлөл /цаашид "зөвлөл" гэх нь / нь прокурорын үйл ажиллагаа,мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэх үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль,Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, энэ журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын тушаалыг баримтална.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 10 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь Монгол Улсын ерөнхий прокурор байх бөгөөд түүний эзгүйд Улсын ерөнхий прокуророос эрх олгосон зөвлөлийн гишүүн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

2.3. Зөвлөл нь эрх зүйн өндөр мэдлэг, хуульч мэргэжлийн ур чадвар,дадлага туршлага бүхий прокурор,бусад хүмүүсээс бүрдэнэ.

2.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь прокурорын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан прокурор байна.

Гурав. Зөвлөлийн эрх хэмжээ

3.1. Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг 3 жилд нэг удаа шалгаж дүгнэлт гаргана:

3.1.2. Зөвлөлийн даргын шийдвэрийг үндэслэн тухайн прокурорын мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэлт гаргана.

3.2. Зөвлөлийн дарга нь гишүүний эрхээс гадна дараахь бүрэн эрхийг зөвлөнэ:

3.2.1. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах бүрэлдэхүүнийг зөвлөлийн гишүүдээс томилох:

3.2.2. Шалгалтын материалтай урьдчилан танилцаж, нэмэлт үүрэг чиглэл өгөх:

3.2.3. Зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах,хуралдааныг удирдах.

3.2.4. Зөвлөлийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл зөвлөлийн хуралдааныг дахин нэг удаа хуралдуулах:

3.2.5. Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн хүмүүсийг үндэсн байгууллагатай нь тохиролцон шалгалтанд татан оролцуулах.

3.3. Зөвлөлийн гишүүн дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

3.3.1. Прокурорын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг шалгах;

3.3.2. Зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

3.3.3. Зөвлөлийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдон илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах;

3.3.4. Прокурорын ёс зүйг зөрчсөн аливаа зөрчлийг илрүүлсэн тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдэгдэж шийдвэрлүүлэх.

3.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараахь үүргийг хүлээнэ:

3.4.1. Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах;

3.4.2. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх.

Дөрөв. Зөвлөлийн ажиллах журам

4.1. Зөвлөл нь прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгахдаа бичгээр, сонгуураар шалгалт авах, ярилцлага хийх, тухайн прокурорын хариуцсан ажлын чанар, хянаж шийдвэрлэсэн хэрэг, өргөдөл, гомдолтой танилцах, прокурорын газрын удирдлага, хамт олны болон шаардлагатай гэж үзвэл бусад байшууллага, ажилтны үнэлэлтийг сонгох зэрэг хэлбэрээр ажиллана.

4.2. Нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгасан дүнг Улсын ерөнхий прокурорт урьдчилан танилцуулсан байна.

4.3. Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг нийт гишүүдийн тавиас доошгүй хувийн ирцтэй хэлэлцэнэ.

4.4. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах бүрэлдэхүүний ахлагчийн эзгүйд түүний даалгасан гишүүн шалгалтын дүнгийн талаар Зөвлөлийн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд шалгалтын бүрэлдэхүүнээс асуулт тавьж, хариулт авах, шалгалтын дүн бусад бариматай танилцсаны эцэст тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинд өгөх дүгнэлтийн талаар саналаа гаргаж, санал хураалт явуулна. Санал хураалтад Зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцохгүй.

4.5. Санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана. Зөвлөлийн дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

4.6. Зөвлөлийн дүгнэлтэд тухайн прокурор үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн хувьд ямар

байгаа, эрхэлсэн ажилдаа тэнцэх эсэх талаар тодорхой тусгасан байна.

4.7. Тодорхой хэрэг, өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ тухайн прокурор мэргэжлийн алдаа гаргасан гэж үзсэн тохиолдолд түүнд сахилгын шийтгэл оногдуулах санал гаргаж болно.

4.8. Зөвлөлийн дүгнэлт зөвшөөрөх байна.

4.9. Хуралдааны тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

Тав. Бусад асуудал

5.1. Зөвлөлийн хуралдааны дэгийг Улсын ерөнхий прокурор батална.

5.2. Зөвлөлийн хуралдаанд оролцсон байдлыг харгалзан Зөвлөлийн гишүүдэд Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр мөнгөн урамшуулал олгож болно.

5.3. Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын ерөнхий прокурорын газар хариуцна.

5.4. Зөвлөл Улсын ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 178 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн
дарга М.Алтанхуяг -Монгол Улсын ерөнхий прокурор

Зөвлөлийн нарийн
бичгийн дарга
П.Дайрийжав -Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн хяналтын прокурор

Зөвлөлийн гишүүд:
Б.Цэрэнбалтав -Улсын ерөнхий прокурорын орлогч

Ц.Ариунболд -Улсын ерөнхий прокурорын туслах, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

Ц.Баярсайхан -Улсын ерөнхий прокурорын туслах, Шүүхэд терийг төлөөлөх хэлтсийн дарга

О.Нямаа -Улсын ерөнхий прокурорын туслах, Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

Ж.Оюунчимэг -Улсын ерөнхий прокурорын туслах, Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн дарга

Т.Сүхбаатар -Улсын ерөнхий прокурорын туслах, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

Д.Даваадорж -Нийслэлийн прокурор

Д.Батсайхан -Улсын дээд шүүхийн шүүгч

Л.Рэнчин -Өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч

Д.Зүмбэрэллхам -Цагдаагийн академийн дэд захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар179** **Улаанбаатар хот**

Домийн Төмөртогоод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, монгол хэл шинжлэлийн уламжлал, түүхэн хувьсал хөгжлийн судалгааны дорвитой бүтээлүүд туурвиж, энэ салбарын мэргэжилтэн багш, судлаачид бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын багшийн их сургуулийн проректор Домийн Төмөртогоод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар180** **Улаанбаатар хот**

Нямын Жадамбаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөө орон нутагт байгуулагдсан анхны дээд сургуулийг хөгжүүлж бэхжүүлэх, дээд боловсролтой багш бэлтгэх, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгыг боловсронгуй болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын багшийн их сургуулийн төгсөлтийн дараах сургалтын албаны дарга Нямын Жадамбаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар181** **Улаанбаатар хот**

Бадамжавын Чогсомд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Дүрүрслэх урлагийн мэргэжлийн сургуулиудад багшилж зураач, урчуудыг бэлтгэх, уран сайхны шинэ эрэл хайгуул хийн хүмүүсийн аж байдал, хөдөлмөр, байгалийн сэдэвт олон зургийг мэргэжлийн өндөр төвшинд туурвиж, монголын дүрслэх урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч, зураач Бадамжавын Чогсомд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар182** **Улаанбаатар хот**

Гомбын Равданд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл, урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, үзэгч, сонсогчдын талархлыг хүлээсэн жүжиг, киноны гол, туслах дүрүүд бүтээж, радио телевизийн уран сайхны нэвтрүүлэг хийж, тайз дэлгэцийн болон өгүүлэхүйн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын радиогийн нэвтрүүлэгч, жүжигчин Гомбын Равданд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар183** **Улаанбаатар хот**

Бямбын Дагвадоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэнд, боловсролын салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, эмч мэргэжилтэн бэлтгэх, хоол боловсруулах эрхтний эмгэгүүдийг оношлох, эмчлэх, сэргийлэх, хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Элэг засал" эмнэлгийн захирал Бямбын Дагвадоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар184** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, үйлчилгээ, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Долгорын Буяндалай -Дархан-Уул аймгийн Зураач урчуудын холбооны бие даасан уран бүтээлч
2. Лувсансүрэнгийн Дамдинсүрэн -Монголын хүнсчдийн холбооны гүйцэтгэх захирал, ШУҮ-ийн "Хүнстех" корпорацийн эрдэм шинжилгээний төрүүлэх ажилтан
3. Цэрэнжавын Доржпалам -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Борнойн Амарсайхан -Үйлдвэр худалдааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
2. Мижидийн Баасанжав -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бодлого зохицуулалтын газрын дарга
3. Ламжавын Бадамжав -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 60 дугаар цэцэрлэгийн арга зүйч багш
4. Довдонгийн Базар -Улаанбаатар төмөр замын Барилга орон сууцны П ангийн мастер
5. Лунжгийн Батаа -Улсын Филармонийн "Баянмонгол" чуулгын хөгжимчин
6. Гомбосүрэнгийн Батболд -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга
7. Могойн Батсуурь -Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Засаг дарга
8. Тарангийн Баян -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4 дүгээр 10 жилийн сургуулийн биеийн тамирын багш
9. Уртнасангийн Борчулуун -Үйлдвэр, худалдааны яамны Бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
10. Ламдангийн Буянжаргал -Увс аймгийн зам засварын "АЗЗА-Увс" ХХК-ийн замчин
11. Суурийн Бямбаа -Архангай аймгийн Өгий нуур сумын байгаль хамгаалагч
12. Цэрэндоржийн Бямбаа -Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
13. Го Сүо Чүгийн Володя -Улсын филармонийн симфони найрал хөгжмийн хөгжимчин
14. Машбатын Гомбосүрэн -Нийслэлийн татварын газрын Төрийн захиргаа, удирдлагын тасгийн дарга
15. Дашцэрэнгийн Гүнгаа -Монголын урчуудын эвлэлийн хорооны мэргэжлийн уран бүтээлч
16. Далхын Гүрдорж -МҮЭ-ийн Соёлын төв ордны аж ахуйн албаны дарга
17. Чойжилын Даваажав -Завхан аймгийн Тосонцэнгэл сумын татварын тасгийн улсын байцаагч
18. Цэдэнлхамын Дагвадорж - Өвөрхангай аймгийн "Баянтээг" ХК-ийн нүүрсний уурхайн токарьчин
19. Даваасүрэнгийн Дашдаваа - Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга
20. Данзанхорлоогийн Дашпүрэв - Олон улс судлалын дээд сургуулийн эвлэх профессор
21. Сэрээтэрийн Дүнчээ - Боловсролын хөгжлийн сургуулийн арга зүйч эрдэм шинжилгээний ажилтан
22. Дугарын Жаргал -Улаанбаатар төмөр замын Барилга үйлдвэрлэлийн нэгдлийн ажилчин
23. Алешийн Жүрагат -Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын татварын улсын байцаагч
24. Чулууны Лхагва -МОНЦАМЭ агентлагийн Гадаад мэдээний редакцийн орчуулагч-редактор
25. Аюушийн Лхагвадулам -Улсын филармонийн хүний нөөцийн ажилтан
26. Лутын Лханаам -Хөдөлмөрийн дээд сургуулийн багш
27. Дэмбэрэлийн Маам -Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын геологийн мэдээллийн төвийн архивын эрхлэгч
28. Жигжидийн Магсаржав -Улсын геодези зураг зүйн газрын Аэрогеодезийн

	үйлдвэрийн ахлах техникч
29. Лувсангийн Маяа	-Дархан-Уул аймгийн Боловсрол, соёлын төвийн арга зүйч
30. Намсрайн Маяа	-Нийслэлийн Барилга үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн хангамжийн албаны дарга
31. Шонхорын Мөнхбат	-Төв аймгийн Эрдэнэсант сумын 10 жилийн сургуулийн захирал
32. Лувсандоржийн Мундагбаатар	-Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын эвлэлөх
33. Лодонгийн Намхай	-Нийслэлийн "Ус дэвжих" ХХК-ийн гүнийн худгийн ёрмийн мастер
34. Ширнэнгийн Одончимэг	-Нийслэлийн Баянгол дүүргийн татварын хэлтсийн тасгийн дарга
35. Нүрэздийн Орсоо	-Баянхонгор аймгийн Зураач, урчуудийн холбооны дарга
36. Лувсанданзангийн Очирбаатар	-Эрчим хүчний "Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийн инженер
37. Гончигийн Очирсум	-Цагдаагийн ерөнхий газрын музейн эрхлэгч
38. Ядамсүрэнгийн Оюунчимэг	-Дүрслэх урлагийн дээд сургуулийн ахлах багш
39. Гиваандондогийн Пүрэвсамбуу	-МОНЦАМЭ агентлагийн Гадаад сурталчилгааны газрын дарга
40. Баглайн Рагчаа	-Радио төлевизийн техникийн төвийн станцын инженер
41. Дагвазундуйн Рагчаа	-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн "Энэрэл" багийн ерхийн эмч
42. Лувсанпүрэвийн Рэнцэндагва	-Булган аймгийн Хангал сумын "Хялганат" ХК-ийн инженер
43. Намсрайн Сандаг-Очир	-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн их эмч
44. Намхайцэрэнгийн Санчир	-Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч
45. Намжагийн Содном	-Монгол урчуудын эвлэлийн хорооны зураач
46. Хайнзангийн Содномцэрэн	-Дүрслэх урлагийн дээд сургуулийн ахлах багш
47. Чойнзонгийн Содномцэрэн	-Хөдөө аж ахуйн их сургуульд төслийн удирдагч
48. Самдангийн Тараа	- Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжимийн удирдаач
49. Содномын Төгс-Оюун	-Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч
50. Дайвийнямын Төмөрхүү	-Санхүү эдийн засгийн дээд сургуулийн дуу, хөгжмийн багш
51. Ойдовын Түвд	-Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн "Жаргалант"-ын алтны уурхайн ерөнхий инженер
52. Чадраабалын Хасбат	-Завхан аймгийн Эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн ерөнхий инженер
53. Нүрэздийн Хаянхярваа	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын эрчим хүчний салбарын дарга
54. Ядамын Хүрлээ	-Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын Тамгын газрын дарга
55. Чойндогийн Хүрэлбаатар	-Монголын урчуудын эвлэлийн хорооны дэд дарга
56. Гончигийн Цэвээнжав	-Ховд аймгийн Эрчим хүчний барилга угсралтын "Алтай"трест УҮГ-ын жолооч
57. Балжиннямын Цэдэв	-Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 31 дүгээр сургуулийн хөдөлмөрийн багш
58. Дамдинхүүгийн Цэдэндорж	-Улсын геодези зураг зүйн газрын Аэрогеодезийн үйлдвэрийн захирал
59.Чойжилын Цэнд-Аюуш	-Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны үндраа" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч
60.Зундуйн Цэндрагчаа	-Нийслэлийн Эрчим хүчний"Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийн инженер
61. Намжидын Цэрэн	-Говь Алтай аймгийн ардын дуу, бүжгийн "Алтай" чуулгын хөгжимчин
62. Мангалжавын Цэрэндолгор	-Эрчим хүчний тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын үйлдвэрийн лабораторийн эрхлэгч
63. Бүрдээгийн Цэрэндулам	-Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын статистикч их эмч
64. Цэвээндэндэвийн Цэрэнпэлжид	-Нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн улсын байцаагч
65. Балдангийн Цээлэй	-Увс аймгийн зам засварын"АЗЗА-Увс" ХХК-ийн замын инженер
66. Шагдаржавын	

Чимэддорж -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

67. Тогтохын Шархүү -Нийслэлийн Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч

68. Думаасүрэнгийн Шатар -Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын байцаагч

69. Дарийбумын Энхзул -Улсын филармонийн гоцлол дуучин

70. Доржнямжавын Энэбиш -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн "Амин хүч" ерхийн эмнэлгийн эмч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Рэнцэндоржийн Ганбат -Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын ерөнхий найруулагч

2. Дашдондовын Жамбал -Төрийн түсгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн их эмч

3. Намнангийн Насанбаяр -Архангай аймгийн Цагдаагийн хэлтсийн хэв журмын тасгийн дарга

4. Гүнчингийн Сүхбат -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын ахлах офицер

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дугарын Адъяабат - МОНЦАМЭ агентлагийн техникийн хэлтсийн сүлжээний техникч

2. Сандагийн Алтангэрэл - "Дэлгэц" кино компаний зураач

3. Равсалын Алтанхуяг -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

4. Дашзэвэгийн Алтанцэцэг -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

5. Лхамжавын Баасанхүү -Нийслэлийн эрчим хүчний "Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийн реле хамгаалалтын инженер

6. Дашдондогийн Бадам -Урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

7. Содовын Бадамсүрэн -Хөвсгөл аймгийн Тариалан сумын Засаг даргын Тамгын газрын улсын байцаагч

8. Самбуугийн Бадарч -Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн Баярсонстракшн"ХХК-ийн цехийн дарга

9. Даваахүүгийн Базаргарам -Завхан аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагч

10. Цэрэнчимэдийн Байгалмаа -Үнддэсний архивын газрын сан хөмрөгийн эрхлэгч

11. Довдонгийн Батбаяр -Монголын хүүхдийн ордны уран зүргийн дугуйлангийн багш

12. Жамсрандоржийн Батдэлгэр -Улсын багшийн их сургуулийн Цэцэрлэгийн багшийн сургуулийн захирал

13. Нагвааны Батжаргал -Нийслэлийн Баянзүрх дүүргийн хот байгуулалт газрын харилцааны албаны дарга

14. Баянтөрийн Бат-Очир -Үйлдвэр худалдааны яамны Геологи эрдэс баялгийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн

15. Балганы Баянцэцэг Эрчим хүчний "Деспитчерийн үндэсний төв" ХХК-ийн инженер

16. Уртнаагийн Болдбаатар -Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын дуучин

17. Чүлтэмийн Болдбаатар -МУИС-ийн багш

18. Лхагвын Бумандорж -Дүрслэх урлагийн дээд сургуулийн уран сайхны удирдагч

19. Магсарын Бүүвэй -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ерхийн эмч

20. Бадарчийн Бэхбаатар -Улаанбаатар төмөр замын Барилга үйлдвэрлэлийн нэгдлийн бригадын дарга

21. Болд-Очирын Гантулга -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 135-р цэцэрлэгийн тогооч

22. Бадамбазарын Ганчимэг -Улсын филармонийн симфони найрал хөгжмийн хөгжимчин

23. Цогзолын Даваасүрэн -Дархан-Уул аймгийн Барилгын үйлдвэрлэлийн "Хаш цамхаг" ХХК-ийн бригадын дарга

24. Сэрээтэрийн Дагвадорж -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

25. Дэмбэрэлийн Дамдин -Монгол Улс, ОХУ-ын хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн мэргэжилтэн асан

26. Дэндэвийн Дамдингив -Өвөрхангай аймгийн "Баянтээг"ХХК-ийн

нүүрсний уурхайн дизельчин

27. Оршихын Дарамбазар -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

28. Дашзэвэгийн Дашдорж -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

29. Лувсангийн Дашзэвэг -Монголын урчуудын эвлэлийн хорооны үзэсгэлэнгийнтанхимын зураач

30. Ёндонжамцын Долгор -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 68 дугаар сургуулийн бага ангийн багш

31.Пэрэнлэйн Долгор -Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын үйлчлэгч

32. Батсүхийн Доржпалам -Нийслэлийн Багануур дүүргийн "Багануур-Ус" ОНӨҮГ-ын цахилгаанчин

33. Чулууны Доржпалам -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн тасгийн эрхлэгч

34. Арцадын Дүүрэн -Орхон аймгийн зураач, Урчуудын холбооны дарга

35. Үржиндоржийн Дэлгэрмаа -Үндэсний архивын газрын түүхийн баримтын төвийн эрхлэгч

36. Жамцын Жадамбаасүрэн -Нийслэлийн уул уурхайн "Монголын алт"ХХК-ийн уурхайн дарга

37. Дагвасамбуугийн Жамсран -Улсы багшийн их сургуулийн Цэцэрлэгийн багшийн сургуулийн хөгжмийн багш

38. Сандуйжавын Жамц -Үндэсний архивын газрын кино, дуу, дүрсний баримтын төвийн эрхлэгч

39. Дамбийнямын Ичинноров -Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын улсын байцаагч

40. Шаравын Магван -Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч

41. Хазаны Майра - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нийгмийн даатгалын байцаагч

42. Пүрэвийн Мэлс -Дорнодд аймгийн Зураач, урчуудын холбооны зураач

43. Дэмчигийн Мягмар -Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

44. Цэндсүрэнгийн Нарангэрэл -Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

45. Гонгорын Наранхүү -Нийслэлийн "Ус дэвжих"ХХК-ийн ёрмийн мастер

46. Бямбаагийн Нямбаяр Улсын филармонийн симфони найрал хөгжмийн хөгжимчин

47. Цэрэнчимэдийн Нямдаваа -Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн эмч

48. Намхайдагвын Орхон -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

49. Чимэдийн Очирбат -Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын дарга

50. Рэнцэнгийн Оюунчимэг -Улаанбаатар төмөр замын Барилга орон сууцны II ангийн мастер

51. Шийлэгийн Пэлжид -Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн "Ачлахуй"өрхийн эмнэлгийн сувилагч

52. Тогтохын Рагчаа -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн их эмч

53. Сэдэдийн Роза -Нийслэлийн "Илгээмжийн худалдаа" компаний ерөнхий нягтлан бодогч

54. Сэр-Одын Саранцацралт -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

55. Сэрээтэрийн Саранчимэг -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

56.Содномын Содномцэрэн -Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

57.Зандарваагийн Соотонгоо -Дархан-Уул аймгийн "Монгол алт"ХК-ийн ерөнхий механикч

58. Дарийн Сумъяа -Үндэсний архивын газрын орчин үеийн баримтын төвийн эрхлэгч

59. Гүрцоогийн Тайхар -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч

60. Бадарчийн Төмөрбаатар -Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

61. Ламзавын Төмөрбат -МОНЦАМЭ агентлагийн "МОНЦАМЭ-гийн мэдээ" сэтгүүлийн олшруулагч

62. Лхамаагийн Түмэндорж -Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 1 дүгээр багийн Засаг дарга

63. Нанжидын Хишгээ -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх нийтлэг үйлчилгээний газрын ахлах нягтлан бодогч

64. Энхсүхийн Хэнчбиш -Монголын урчуудын эвлэлийн хорооны даргын нарийн бичгийн дарга

65. Готовын Цогбаяр -Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

66. Жанлавын

Цолмонхүү	-Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч
67. Пэлжээгийн Цэгмид	-"Хасар"ХХК-ийн ерөнхий захирал, чөлөөт уран бүтээлч
68. Цэрэндуламын Цэвээнням	-Үндэсний статистикийн газрын ахлах мэргэжилтэн
69.Бидэръяагийн Цэрэнханд	-Үндэсний статистикийн газрын судалгааны товчооны орлогч дарга
70. Намжилын Цоцэнчимэг	-Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
71. Надмидын Чулуунбат	-Нийслэлийн Багануур дүүргийн "Багануур - Ус"ОНӨҮГ-ын эдийн засагч
72. Цэндийн Энхболд	-Үйлдвэр, худалдааны яамны Бодлого зохицуулалтын газрын орлогч дарга
73.Цагаандарийн Энхжаргал	-Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч
74. Паламдоржийн Энхтуяа	-Нийслэлийн Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн тасгийн дарга
75.Цэрэнчимэдийн Эрдэнэцог	-УБИС-ийн дүрслэх урлаг, дизайны тэнхимийн багш
76.Бэгзсүрэнгийн Эрдэнэчимэг	-Улсын багшийн их сургуулийн Цэцэрлэгийн багшийн сургуулийн сургалтын албаны эрхлэгч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дугарсүрэнгийн Амарсанаа	-Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер
2. Лхамдооровын Батмөнх	-Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын бүжигчин
3. Чойжилжавын Гансүх	-Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын дарга
4. Батмөнхийн Мөнхцэцэг	-Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжимчин
5.Жагвуугийн Отгончулуун	-Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжимчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 25-ны өдөр | **Дугаар 219** | **Улаанбаатар хот**

Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай

Гаалийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лицэнз олгох журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бараат улсын хилээр нэвтрүүлэх экспорт, импортын лицэнз олгох асуудлыг хянан шийдвэрлэж байхыг холбогдох сайд нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бараат улсын хилээр нэвтрүүлэх экспорт, импортын лицэнз олгосон мэдээг Үйлдвэр, худалдааны яаманд улирал бүр хүргүүлж байх, лицэнз олгох үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг шат дамжлагагүй, ил тод байдлыг хангах чиглэлээр хянан шинэчлэн боловсруулж мөрдүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт тус тус даалгасугай.

4. Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалтад заасангүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд экспорт, импортын лицэнз олгохоор тусгайлан заасан барааны тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага нь энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан журмын дагуу лицэнз олгож байхаар тогтоосугай.

5. Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалтад заагдаагүй боловч улсын хилээр нэвтрүүлэхэд төрийн захиргааны байгууллагаас эвшээрэл авч байхаар холбогдох хууль тогтоомжид заасан бараат улсын хилээр нэвтрүүлэх журмыг энэ онд багтаан батлаж энэхүү тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн нэгэн зэрэг мөрдүүлэхийг холбогдох сайд нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 54 дүгээр тогтоолын 2, 3 дугаар зүйл, мөн тогтоолын 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэ тогтоолыг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Үйлдвэр, худалдааны сайд Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ХИЛЭЭР ЛИЦЕНЗТЭЙ НЭВТРҮҮЛЭХ КОДЛОСОН БАРААНЫ ЖАГСААЛТ

Бараог тодорхойлох кодлох уялдуулсан системийн зүйл, мөр, үндэсний код	Барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа	Лиценз олгох байгууллага
	ҮРЖЛИЙН МАЛ	Гаргах	ХХААЯ
0101.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн адуу		
0101.90.00	Үржлийн бусад адуу		
0102.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн үхэр		
0102.90.00	Үржлийн бусад үхэр		
0103.10.00	Цэвэр үүлдрийн гахай		
0104.10.00	Хонь		
0104.20.00	Ямаа		
0106.90.10	Тэмээ		
	АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, АН АМЬТНЫ ХОЛБОГДОЛТОЙ СУДАЛГААНЫ АЖЛЫН СОРЬЦ, ДЭЭЖ, МАЛ, АМЬТНЫ ҮР ХӨВРӨЛ, БИЧИЛ БИЕТНИЙ ӨСГӨВӨР	Гаргах	БОЯ, ХХААЯ
	Нэн ховор амьтан Амьтны аймгийн тухай хуульд заасан 26 нэрийн амьтан		БОЯ (Засгийн газрын зөвшөөрлийн үндсэн дээр)
	Ховор амьтан Амьтны аймгийн тухай хуулийн дагуу ховор амьтны жагсаалтыг Засгийн газар батална		БОЯ
0507.90.11 0507.90.21 0507.90.29	Бүгын цусан эвэр Бүгын ясан эвэр Аргаль, янгирын эвэр		БОЯ
0510.00.11	Хүдрийн заар		БОЯ
0510.00.12	Бүгын чив засаа		БОЯ
0511.10.00	Бухын үр		ХХААЯ

0511.99.10	Үржлийн мал, амьтны үр (бухын үр орохгүй), ийлдэс		ХХАА9
0511.99.90	Үржлийнхээс бусад мал, амьтны үр хөврөл		ХХАА9
	УРАНЫ БУЮУ ТОРИЙН ХҮДЭР БА БАЯЖМАЛ	Гаргах	Улсын мэргэжлийн хяналтын газар
2612.10.00	Ураны хүдэр ба баяжмал		
	ОНЦГОЙ ХОРТОЙ ХИМИЙН БОДИС (Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1998 оны 83/А/160 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын А-д заасан 96 нэрийн химийн бодис)	Гаргах, оруулах	БОЯ (Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дүгнэлтийн үндсэн дээр)
	ЗАЙЛШГҮЙ ХЯНАЛТАД БАЙХ ЭМЧИЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИУЛАЛТТАЙ ЭД ЭРХТЭН, ДОНОРЫН ЦУС, БИЧИЛ БИЕТНИЙ ӨСГӨВӨР	Гаргах, оруулах	ЭМЯ, ХХАА9
3001.10.00	Хатаасан, нунтагласан буюу нунтаглаагүй булчирхай, бусад эрхтэн		ЭМЯ
3001.20.00	Булчирхай болон бусад эрхтэний ханд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн ханд		ЭМЯ
3002.10.00	Эсрэгийлдэс ба цусны бусад фракц, биотехнологийн болон бусад аргаар гарган авсан дархлалын хувирмал бэлдмэл		ЭМЯ
3002.20.00	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин		ЭМЯ
3002.30.00	Мал эмнэлгийн зориулалттай вакцин		ХХАА9
3002.90.00	Бусад: донорын цус, бичил биетний өсгөвөр		ЭМЯ
	ТЭСРЭХ БОДИС	Гаргах, оруулах	ҮХЯ (Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штабын тодорхойлолтын үндсэн дээр)
3601.00.00	Дарь, тийрэлтэт түлш		
3602.00.00	Дарь, тийрэлтэт түлшнээс бусад тэсрэгч бэлдмэл		

3603.00.00	Гал дамжуулах утас, тэсэлгээний утас, цохилтын буюу тэсэлгээний бялтат бүрхүүл, асаагуур, цахилгаан тэслүүр		
36.04	Гэрэл гарган шатагч зүйлс, дохионы гэрэлтүүлэгч пуужин, аадар эсэргүүцэх, манантай үеийн дохионы пуужингууд, пиротехникийн бусад хэрэгсэл		
	БУУ, ЗЭР ЗЭВСЭГ, БАЙЛДААНЫ ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК, ТЭДГЭЭРИЙН ЭД АНГИ, ТОНОГ ХЭРЭГЛЭЛ (байлдааны зориулалттай хэрэгсэл, техникийг улсын хилээр нэвтрүүлэхэд тусгай журмаар зохицуулна)	Гаргах, оруулах	ҮХЯ (Галт зэвсгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулах комиссын шийдвэр,ҮХ-ны сайдын зөвшөөрлийн үндсэн дээр)
93.01	Револьвер, гар буу болон БТКУ Системийн Зүйл 93.07-д заасан бусад зэвсгээс өөр цэргийн зориулалттай зэвсэг		
93.02	БТКУ Системийн Зүйл 93.03 буюу 93.04-т зааснаас бусад револьвер болон гар буу		
93.03	Тэсэрдэг цэнэгээс гал авч ажилладаг бусад галт зэвсэг болон тэдгээртэй адил төстэй хэрэгсэл (жишээ нь: спортын үрлэн сумтай буу болон винтов, хар дариар гол төмрийг нь цэнэглэдэг буу, дохионы гар буу болон зөвхөн дохио өгөхөд зориулагдсан бусад хэрэгсэл, хоосон цэнэгтэй сумтай револьвер болон гар буу, толгойтой бялт хэлбэрийн ангийн буу, хийн буу)		
93.04	БТКУ Системийн Зүйл 93.07-д зааснаас бусад зэвсэг (жишээ нь: пүрш, агаар, хийгээр ажилладаг буу, гар буу,цагдаагийн бороохой)		

93.05	БТКУ Системийн Зүйл 93.01–93.04-т заагдсан бүтээгдэхүүний эд анги ба тоног хэрэгсэл		
93.06	Бөмбөг, гранат, торпед, мина, тийрэлтэт сум болон тэдгээртэй тестэй байлдааны зэвсэг, тэдгээрийн эд анги; хонгиотой сум болон бусад зэвсгийн хэрэгсэл, сум, тэдгээрийн эд анги (сумны бөглөөс, жийрэг орно)		
XXI Хэсэг	УРЛАГИЙН БҮТЭЭЛ, ЦУГЛУУЛГЫН ЗҮЙЛС БА ЭРТНИЙ ҮНЭТ, ХОВОР ЗҮЙЛС	Гаргах	БСШУЯ
	А.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл Засгийн газрын 1995 оны 241, 1998 оны 126, 1999 оны 110 дугаар тогтоолоор батлагдсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс хамаарна	Гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор БСШУЯ-ны тогтоосон хугацаагаар	
	Б.Түүх, соёлын үнэт болон ердийн дурсгалт зүйл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг БСШУ-ны сайд батална. Энэ бүлэгт БСШУ-ны сайдын тушаалаар батлах түүх, соёлын үнэт дурсгалт зүйлс хамаарна	Эргүүлж авчрах нөхцөлтэйгээр 2 жилээс дээшгүй хугацаагаар	
9705.00.00	Амьтан, ургамал эрдэс судлал, анатоми, археологи, палеонтологи, үгсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн цуглуулга ба цуглуулгын зүйлс	Гаргах горимыг Засгийн газар, БСШУ-ны сайдаас батлагдсан тухайн зүйлийн зэрэглэлийн дагуу мөрдөнө	

Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ХИЛЭЭР ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДОР НЭВТРҮҮЛЭХ БАРААНД ЭКСПОРТ, ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол Улсын олон улсын гэрээнд улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан барааны экспорт, импортын лиценз /цаашид "лиценз" гэх/ олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Улсын хилээр нэвтрүүлэх барааны экспорт, импортын лицензийг төрийн захиргааны эрх бүхий байгууллага /цаашид "лиценз олгогч" гэх/ олгоно.

1.3. Лиценз олгох үйл ажиллагааг үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд хөнгөвчлөх, нэг цэгийн үйлчилгээний зарчмыг баримтлах хэлбэрээр зохион байгуулна.

1.4. Лиценз олгогч лиценз олгох эрх бүхий

албан тушаалтны нэр, гарын үсгийн баталгааг Улсын гаалийн ерөнхий газарт хүргүүлнэ.

Хоёр. Лиценз авах өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам

2.1. Барааг экспортлох, импортлох лиценз хүссэн өргөдлийг лиценз хүсэгч энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "E" маягтаар гаргана. Өргөдөлд дурдсан мэдээллийн үнэн зөвийн хариуцлагыг өргөдөл гаргагч хүлээнэ.

2.2. Лиценз олгох өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

- өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол нотариатаар батлуулсан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- өргөдөл гаргагч нь иргэн бол нотариатаар батлуулсан иргэний үнэмлэхийн хуулбар;
- тухайн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэхээр заасан бол нотариатаар баталсан тусгай зөвшөөрлийн хуулбар.

2.3. Лиценз хүсэгч өөрөө бүрдүүлэхээр хуульд тусгайлан зааснаас бусад шаардлагатай тодорхойлолт, дүгнэлтийг барааны онцлогоос шалтгаалан лиценз олгогч холбогдох байгууллагаас гаргуулна.

2.4. Лиценз олгогч өргөдөл болон хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

2.5. Лиценз олгогч шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд лиценз хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

2.6 Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "D" маягтаар олгоно.

2.7 Лицензийг 1 жил хүртэл хугацаагаар олгоно. Лицензийг нэг эх хувь, хоёр хуулбар / дубликат/ хувь үйлдэнэ. Лицензид нэр заасан барааны хадгалах, борлуулах хугацааны шаардлага болон тээвэрлэлт, хамгаалалт, чанар, стандартын нөхцөлийг хангасан байх үүргийг лиценз эзэмшигч өөрөө хариуцна.

2.8 Лицензийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж болохгүй.

Гурав. Лицензийн хугацааг сунгах, лицензид нэмэлт, өөрчлөлт оруулах, лицензийг хүчингүй болгох

3.1 Экспорт, импортын гэрээний үүрэг биелүүлэх хугацаа, шаардлагатай уялдуулан лицензийг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

Лиценз олгогч лиценз сунгах болон лицензид заасан барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, нэвтрүүлэх боомтын нэрийг өөрчлөх, тодотгох өргөдлийг 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Лиценз сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах өргөдлийг лицензэ хүчинтэй байх хугацаанд гаргана.

3.2 Лиценз олгогч дараахь тохиолдолд лицензийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгоно:

- энэ тухай лиценз эзэмшигч хүсэлт гаргасан;
- лиценз эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;
- лиценз эзэмшигч иргэн нас барсан, сураггүй алга болсон;
- лиценз авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
- олгосон лицензийг засварласан;
- гаалийн бүрдүүлэлт хийхэд хуурамч мэдээлэл өгсөн.

3.3 Лиценз олгогч лицензийг хүчингүй болгосон тухайгаа шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор лиценз эзэмшигч болон гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

Дөрөв. Лицензийн тайлан, мэдээ гаргах журам

4.1 Лиценз олгогч олгосон лицензийн мэдээллийг энэхүү журмын 3, 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу Үйлдвэр, худалдааны яаманд улирал тутам хүргүүлнэ.

4.2 Үйлдвэр, худалдааны яам лиценз олгох талаар мөрдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, олгосон лицензийн тухай нэгдсэн мэдээллийг Дэлхийн худалдааны байгууллагад зохих журмын дагуу мэдээлж байна.

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лицензэ олгох журмын 1 дүгээр хавсралт

/ MNS 5022:2001 стандартын "Е" хавсралт/

Худалдагч/Seller	Экспорт, импортын лицензэ олгох өргөдөл Application form for export, import license				
	Гэрээний дугаар/ Contract №		Он,сар, өдөр, /Date		
Хүлээн авагч/Consignee	Худалдан авагч/ Buyer				
	Илгээх улс/Country of delivery		Гэрээт улс/Contracting country		
	Гарал үүсэл/Country of origin		Хүлээн авах улс/Country of destination		
Тээврийн төрөл/ Mode of transport	Төлбөрийн нөхцөл/ Terms of payment				
	Валютын нэр /Currency		Ханш/ Rate	Хэлцлийн төрөл/Type of trade	
Хилийн боомт/Port	Нэмэгдэл тайлбар/Supplementary details				
Барааны код Code	Барааны тодорхойлолт Commodity specification	Хэмжих нэгж Unit	Тоо хэмжээ Quantity	Нэгж үнэ Unit price	Үнэ Total
Гаалийн мэдүүлгийн №/Number of customs declaration of goods received		Өмнө засан лицензийн гүйцэтгэл/Use of previous license		Дүн/ Total	

Хавсаргасан баримт
Attached documents
.....

Өргөдөл гаргасан/Applied by
.....
Байгууллагын/иргэний нэр
Name of organization/person
.....
Албан тушаалын нэр/Position
.....
..... Гарын үсэг/ Signature
Харилцах утас/Telephone

Он, сар, өдөр/ Date

Хянасан/Revised by:
.....яамны
.....газрын ажилтан Гарын үсэг/Signature

Танилцсан/Seen by:
.....газрын дарга Гарын үсэг/Signature

Тусгай тэмдэглэл/Notes

Он, сар, өдөр/ Date

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх барааг экспорт, импортын лиценз олгох журмын 2 дугаар хавсралт

/ MNS 5022:2001 стандартын D хавсралт/

Лиценз / License

Худалдагч/Seller	ORIGINAL		
	Лицензийн дугаар/ License№	Хүчинтэй хугацаа/Valid until	
	Гэрээний дугаар/ Contract №	Он,сар, өдөр, /Date	
Хүлээн авагч/Consignee	Худалдан авагч/ Buyer		
	Илгээх улс/Country of delivery	Гэрээт улс/Contracting country	
	Гарал үүсэл/Country of origin	Хүлээн авах улс/Country of destination	
Тээврийн төрөл/ Mode of transport	Төлбөрийн нөхцөл/ Terms of payment		
	Валютын нэр /Currency	**Ханш/ Rate**	Хэлцлийн төрөл/Type of trade
Хилийн боомт/Port	Нэмэгдэл тайлбар/Supplementary details		

Барааны код Code	Барааны тодорхойлолт Commodity specification	Хэмжих нэгж Unit	Тоо хэмжээ Quantity	Нэгж үнэ **Unit price**	Үнэ Total

Дүн/ Total

.....Он, сар, өдөр/ Date

Тэмдэг/Stamp

олгосон/issued by

.....

.....Гарын үсэг/ Signature

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх барааг экспорт, импортын лицензээс олгох журмын 3 дугаар хавсралт

..... ЯАМ, ГАЗРААС ОЛГОСОН ЭКСПОРТЫН ЛИЦЕНЗИЙН МЭДЭЭЛЭЛ

(... оны ... улирал)

Импортлогч улс	Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл, мөр, үндэсний код	Барааны бичиглэл	Барааны тоо хэмжээ

(Тамга) Мэдээлэл гаргасан :

Байгууллагын нэр:.....
Албан тушаал .....
Овог нэр .....

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх барааг экспорт, импортын лицензээс олгох журмын 4 дүгээр хавсралт

..... ЯАМ, ГАЗРААС ОЛГОСОН ИМПОРТЫН ЛИЦЕНЗИЙН МЭДЭЭЛЭЛ

(... оны ... улирал)

Экспортлогч улс	Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл, мөр, үндэсний код	Барааны бичиглэл	Барааны тоо хэмжээ

(Тамга) Мэдээлэл гаргасан :

Байгууллагын нэр:.....
Албан тушаал .....
Овог нэр .....

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 48 (285)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Үнэт цаасны зах зээлийн тухай*
- *Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны арванхоёрдугаар сарын 27 № 48 (285)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

679. Үнэт цаасны зах зээлийн тухай (2002-12-12-ны хууль) 1432
680. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-12-12-ны хууль) 1444
681. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-12-ны хууль) 1444
682. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (2002-12-12-ны хууль) 1445
683. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-12-12-ны хууль) 1450
684. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-12-12-ны хууль) 1450
685. Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-12-ны хууль) 1451

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

686. Үндэсний статистикийн газрын даргыг чөлөөлөх, томилох тухай Дугаар 94 1453
687. Д.Батбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Дугаар 95 1453
688. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай Дугаар 96 1453

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

689. Борис Иосифович Писарскийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 185 1454
690. Владимир Павлович Тихомиров, Виктор Алексеевич Благодатских нарыг одон, медалиар шагнах тухай Дугаар 186 1454
691. ОХУ-ын зарим иргэнийг "Шудрага журам" медалиар шагнах тухай Дугаар 187 1454
692. Долгорсүрэнгийн Дагвадоржид Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 188 1454
693. Ким Үн Согийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 189 1455
694. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг ойуун ухаан, ёс суртахууны хүрээнд төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж, мөрдөх тухай Дугаар 190 1455
695. Дүрэм батлах тухай Дугаар 191 1455
696. Шүүхийн сахилгын хорооны даргыг томилох тухай Дугаар 192 1459
697. Журам батлах тухай Дугаар 193 1460

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №48(
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2002 оны 12 дугаар сарын 12–ны өдөр
Улаанба хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцаат зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж

2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Компанийн тухай хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "үнэт цаас" гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцаат худалдах, худалдан авах эрхийн опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Үнэт цаасны хороо /цаашид "Хороо" гэх/-ноос энэ хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;

3.1.2. "биет үнэт цаас" гэж тогтоосон журмын дагуу биет байдлаар хэвлэсэн үнэт цаасыг;

3.1.3. "биет бус үнэт цаас" гэж тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тооцоолох машины санах байгууламжид байгаа үнэт цаасыг;

3.1.4. "үүсмэл үнэт цаас" гэж тодорхой үнэт цаастай холбоотой гаргасан, түүнээс үнэ, ханш нь хамаарч байдаг, хувьцаа худалдах, худалдан авах эрх олгосон опцион, энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг тодорхой хугацаанд дотор энгийн хувьцаанд хөрвүүлэх эрх олгодог бусад үнэт цаасыг;

3.1.5. "хувьцаа" гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, но ашиг авах, компанийг татан буулгасны дараа үл эд хөрөнгийг хуваалцах эрх бүхий орлогоос хувь хүртэх болон хувьцаар тогто бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг;

3.1.6. "өрийн бичиг" гэж тодо хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мө эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эр хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн цаасыг;

3.1.7. "үнэт цаасны зах зээл" гэж цаас гаргах, бүртгүүлэх, худалдах, арил хадгалах, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эр шилжүүлэхтэй холбогдсон харилцааг;

3.1.8. "үнэт цаасны анхдагч зээл" гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа өөрөө андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компа дамжуулан худалдах, арилжихтай холбог харилцааг;

3.1.9. "үнэт цаасны хоёрдог зээл" гэж анхдагч зах зээлд гарсан үнэт ца дахин худалдах, худалдан авах, арилжи холбогдсон харилцааг;

3.1.10. "брокерийн үйл ажилл гэж үнэт цаасны зах зээл дээр бусдын нэ өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худа авах ажиллагаа;

3.1.11. "дилерийн үйл ажилл гэж үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорил үнэт цаасыг өөрийн хөрөнгөө худалдан а худалдах, арилжих ажиллагаа;

3.1.12. "андеррайтерийн ажиллагаа" гэж үнэт цаас гаргагчтай байгуу гэрээний дагуу гаргаж буй үнэт цаасны т танилцуулга бэлтгэх, шинээр болон нэмж га байгаа үнэт цаасыг бүгдийг буюу түүний тодо хэсгийг худалдан авах, худалдах, эсхүл үнэт гаргагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг нь н санал болгон арилжих ажиллагаа;

3.1.13. "нийтэд санал болгох үнэт цаас гаргагчаас үнэт цаасны арилжаа эр байгууллагаар дамжуулан Хороонооос тогто журмын дагуу үнэт цаасаа 50-иас дээш т эзэмшдэг этгээдэд санал болгож худалдахаа мэдэгдэх

3.1.14. "тендер санал гаргах тогтоосон журмын дагуу нээлттэй хуваа компанийн энгийн хувьцааны хяналтын багц түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэг сонирхолтой этгээд худалдан авах саналаа н зарлахыг;

[1] Иргэний хууль –"Төрийн мэдээлэл" эмхтэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн
[2] Компанийн тухай -"Төрийн мэдээлэл" эмхтэлийн 1999 оны 34 дугаарт нийтлэгдсэн

3.1.15. "дотоод мэдээлэл" гэж үнэт сны ханшид нөлөөлж болох, үнэт цаасны лжаанд орөлцоход давуу тал олгох, Хороноос тоод мэдээлэл гэж тогтоосон нийтэд аагдаагүй мэдээллийг;

3.1.16. "үнэт цаасны зах зээлд ллах мэргэжилтнүүд" гэж үнэт цаасны зах зээлд лцогч мэргэжлийн байгууллагын үндсэн чиг гийг гүйцэтгэх ажил эрхэлдэг, Хороноос үнэт сны зах зээл дээр мэргэжлийн ажил, үйлчилгээ улах эрх авсан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Үнэт цаас гаргах, худалдах, арилжих

4 дүгээр зүйл. Үнэт цаас гаргагч

4.1. Ашгийн төлөө үйл ажиллагаа үлж байгаа хуулийн этгээд Компанийн тухай ь болон энэ хуулийн дагуу үнэт цаас гаргаж но.

4.2. Засгийн газар Улсын Их Хурлын шөөрлөөр, аймаг, нийслэлийн Засаг дарга дийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр гэд санал болгон үнэт цаас гаргаж болно.

Засгийн газар, аймаг, нийслэлийн эг дараагаас гаргасан үнэт цаас нь бусад үнэт сны нэгэн адил Хороо болон Хөрөнгийн биржид гэлтэй байна.

4.3. Засгийн газар, аймаг, слэлийн Засаг даргаас гаргах үнэт цаасыг нийтэд ан болгон худалдахад энэ хуулийн 5-9 дүгээр хамаарахгүй.

5 дугаар зүйл. Үнэт цаас гаргах

5.1. Үнэт цаасыг нийтэд санал гон арилжихаар, эсхүл нийтэд санал охгүйгээр хаалттай худалдахаар гаргаж болно.

5.2. Үнэт цаас гаргагч гадаад орны ээлд өөрийн үнэт цаасаа арилжаалж болно.

5.3. Нийтэд санал болгон үнэт цаас ах тухай шийдвэрийг үнэт цаас шинээр болон к гаргах тухай бүрт гаргана. Уг шийдвэрт энэ ийн 6 дугаар зүйлд заасан үнэт цаасны үүлбэрт заасан үзүүлэлтэзс гадна дор дурдсан ийг тусгах бүюу хавсаргана:

5.3.1. үнэт цаас эзэмшигчийн эрх, уг йг хэрэгжүүлэх талаар үнэт цаас гаргагчийн эх үүрэг;

5.3.2. үнэт цаасыг биет байдлаар ах тохиолдолд түүний загварын хуулбар.

5.4. Энэ хуулийн 5.3-т заасан двэрийг хоёр хүнь үйлдэх бөгөөд нэг хүнь нь цаас гаргагчид, нөгөө хүнь нь Хороонд тус тус алгдана. Эдгээр нь хоорондоо зөрвөл Хороонд алагдаж байгаа хувийг эх хүнь гэж тооцно.

5.5. Хороонд болон үнэт цаас гаргагчид хадгалагдаж буй дээрх шийдвэртэй үнэт цаас эзэмшигч танилцах эрхтэй.

5.6. Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг үнэт цаасыг бүртгүүлсний дараа өөрчилж үл болно.

6 дугаар зүйл. Үнэт цаасны бүрдүүлбэр

6.1. Үнэт цаас нь дараахь бүрдүүлбэртэй байна:

6.1.1. үнэт цаасны нэр, төрөл;

6.1.2. үнэт цаас гаргагчийн оноосон нэр;

6.1.3. үнэт цаасны нэрлэсэн үнэ;

6.1.4. нэрийн үнэт цаасны хувьд үнэт цаас эзэмшигчийн нэр;

6.1.5. хүү төлөх нөхцөл;

6.1.6. төлбөр хийгдэх нөхцөл;

6.1.7. үнэт цаасны бүртгэлийн болон регистрийн дугаар;

6.1.8. үнэт цаас гаргагчийн тамга;

6.1.9. үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг.

6.2. Үнэт цаас эзэмшигч хүсвэл түүний үнэт цаас өмчлөх эрхийг нотолсон гэрчилгээ олгоно.

7 дугаар зүйл. Үнэт цаасыг бүртгэх

7.1. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар гаргахдаа тогтоосон журмын дагуу Хороонд бүртгүүлнэ. Үнэт цаасыг хаалттай худалдахаар гаргахад энэ журам хамаарахгүй.

7.2. Урьд нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг нэмж гаргахдаа хаалттай худалдахаар шийдвэрлэсэн бол Хороонд бүртгүүлнэ.

7.3. Үнэт цаас гаргагч үнэт цаасаа бүртгүүлэхдээ өргөдөл, танилцуулга, үнэт цаас гаргах тухай шийдвэр, хувьцаа гаргах замаар хувьцаат компани үүсгэн байгуулж байгаа бол хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг, тухайн төрлийн үнэт цаас гаргахад эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл шаардагдах нөхцөлд уг зөвшөөрөл, Хорооноос тогтоосон бусад баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

7.4. Үнэт цаас гаргах тухай танилцуулгад дор дурдсан зүйлийг тусгана:

7.4.1. үнэт цаас гаргагч /үүсгэн байгуулагч/-ийн нэр, оршин байгаа хаяг;

7.4.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

7.4.3. үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаархи мэдээлэл;

7.4.4. үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг үнэт цаас гаргагчийн үнэт

цаасыг эзэмшдэг бол түүний хувь, хэмжээ;

7.4.5. үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, хөрөнгийн талаарх мэдээ;

7.4.6. үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, үнэт цаасны тоо ширхэг, түүний нэрлэсэн үнэ, үнэт цаасны хяналтын багцыг эзэмшиж байгаа үнэт цаас эзэмшигчийн нэрсийн жагсаалт;

7.4.7. үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл;

7.4.8. үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл, үнэт цаас гаргах эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо;

7.4.9. Хороноос тогтоосон бусад шаардлага.

7.5. Энэ хуулийн 7.4.3, 7.4.5, 7.4.6, 7.4.9 дэх заалт нь шинээр үүсгэн байгуулагдаж буй хувьцаат компанид хамаарахгүй. Харин зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хувьцаат компани болон өөрчлөгдөж буй хуулийн этгээдэд хамаарна.

7.6. Хороонд ирүүлэх өргөдөл, танилцуулга, бусад баримт бичиг үнэт цаас гаргагч этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан байна.

7.7. Өргөдөл, танилцуулга, баримт бичигт хуурамч мэдээлэл тусгахыг хориглоно. Хороонд ирүүлсэн өргөдөл, танилцуулга, бусад баримт бичгийн үнэн зөвийг үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтан хариуцна.

7.8. Хороо ирүүлсэн өргөдөл, танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хянан үзээд шаардлага хангасан гэж үзвэл үнэт цаасыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хороо үнэт цаас бүртгэхдээ үнэт цаас гаргагчийн холбогдох баримтыг шаардлагатай гэж үзвэл аудитын болон үнэлгээний байгууллагаар шалгуулж баталгаажуулахыг шаардах, тайлбар авах эрхтэй.

7.9. Хороо нь үнэт цаасыг бүртгэж, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар олгоно.

7.10. Хороо дараахь үндэслэлээр шинээр болон нэмж гаргасан үнэт цаасыг бүртгэхээс татгалзана:

7.10.1. Хороонд ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, тоон үзүүлэлт нь зөрүүтэй буюу дахин магадлах шаардлагатай;

7.10.2. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл хуурамч мэдээ, баримт тусгасан нь илэрсэн;

7.10.3. үнэт цаас гаргагч хөрөнгийн чадваргүй нь тогтоогдсон.

7.11. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл үнэт цаас гаргагч нь шүүхэд гомдол гаргах эрхтэй.

8 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх

8.1. Хороо нь үнэт цаас гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх тухай журам тогтооно.

8.2. Үнэт цаас гаргагч болон тухайн үнэт цаасыг зуучлан арилжих мэргэжлийн байгууллага нь үнэт цаасыг арилжихаас өмнө сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

9 дүгээр зүйл. Үнэт цаасыг худалдах, тайлагнах

9.1. Үнэт цаасны зах зээл дээр зөвхөн Хороонд бүртгүүлсэн үнэт цаасыг арилжаална.

9.2. Үнэт цаас гаргагч үнэт цаасаа анхдагч зах зээл дээр шууд, эсхүл андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компанид худалдаж болно.

9.3. Үнэт цаасыг зээлээр худалдахыг хориглоно.

9.4. Хөрөнгө оруулалтын нээлттэй сангаас бусад үнэт цаас гаргагч нөгөнт худалдсан үнэт цаасаа хуулиар тогтооснос бусад тохиолдолд эргүүлэн худалдан авах үүрэг хүлээхгүй.

9.5. Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг танилцуулгад заасан зориулалтаар зарцуулна.

9.6. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг арилжаалж дуусснаас хойш 30 хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний тайланг Хороонд ирүүлнэ. Тайланд дор дурдсан зүйлийг тусгасан байна:

9.6.1. үнэт цаасыг арилжаалж эхэлсэн болон дуусан огноо;

9.6.2. арилжсан үнэт цаасны тоо ширхэг, арилжааны ханш;

9.6.3. үнэт цаасны арилжааны нийт орлого /төгрөг, валют, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэр тус бүрээр/, төлбөр хийгдсэн байдал;

9.6.4. хэрвээ компанийн энгийн хувьцааг арилжаалсан бол хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг худалдан авч эзэмшсэн этгээдийн нэрс.

9.7. Хороо тайланг ажлын 10 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан гэж үзвэл бүртгэж авна.

9.8. Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгэснээс хойш 1 жилийн хугацаанд арилжаалаагүй бол бүртгэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

10 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг

10.1. Үнэт цаас гаргагч дараахь нийтлэг үүрэгтэй байна:

10.1.1. үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хуралаар хэлэлцэн гаргах;

10.1.2. үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх;

10.1.3. үнэт цаас гаргагч нь хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай[1] хуульд заасан хугацаанд гаргаж, Хороо болон Хөрөнгийн биржид хүргэх;

10.1.4. Хорооноос тогтоосон журмын дагуу тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх;

10.1.5. үнэт цаас нь бүртгэлтэй хувьцаат компани хувь нийлүүлэгчдийн эзэлжит хүрлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6 дугаар сарын 1-ний дотор, эзлэгт бус хүрлын материалыг хүрал гаралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд хүргэх.

10.2. Үнэт цаасны зах зээлийн үнэ, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээлэл, түүнийг олон нийтэд хүргэх журмыг Хороо тогтооно.

11 дүгээр зүйл. Тендер санал

11.1. Тендер саналыг энэ хууль болон түүнд нийцүүлэн Хорооноос тогтоосон журмын дагуу гаргана.

11.2. Хувьцаат компанийн энгийн хувьцааны хэналтын багц буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд бусад хувьцаа эзэмшигчээс худалдан авахыг хүсэж тендер санал гаргах бөгөөд энэ тухайгаа Хороонд мэдэгдэж, шийдвэр гаргуулна.

11.3. Тендер санал гаргагч нь компанийн хувьцааг худалдан авахыг хүсэж нийлүүлэгчид санал болгохдоо Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлана.

11.4. Тендер саналын талаар нийтэд хүргэх мэдээлэлд дор дурдсан зүйлийг тусгасан байна:

11.4.1. тендер санал гаргагчийн нэр;

11.4.2. тендер санал гаргагчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээ, хувь;

11.4.3. хувьцаа худалдан авах хөрөнгийн эх үүсвэр;

11.4.4. компанийг хөгжүүлэх төсөл, санал.

11.5. Тендер саналын хүчинтэй байх доод хугацаа ажлын 60 хоног, дээд хугацаа 6 сар байна.

11.6. Тендер санал гаргагчийн хувьцаа худалдан авахаар санал болгож буй үнийг тухайн хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, тендер санал гаргагч тухайн хувьцаагаа худалдан авсан дээд ханш хөрөнгө аль өндрөөс доошгүй байхаар тогтооно. Харин тендер саналын үнэ нь уг хувьцааны нэрлэсэн үнээс доогуур байж болохгүй.

11.7. Тендер санал гаргагч тендер саналтай холбогдсон мэдээллийг сонирхогч бүх этгээдэд нэгэн адил хүргэх үүрэгтэй.

11.8. Тендер санал гаргагч нь Хороонд тендер санал гаргахыг хүссэн өргөдөл ирүүлсэн үед тухайн компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа тендер санал зарлаагүй бусад этгээд болон компанийн удирдлагад энэ тухай мэдэгдэнэ.

12 дугаар зүйл. Үнэт цаас худалдан авагчийн үүрэг

12.1. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

12.2. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 12.1-д зааснаас гадна Компанийн тухай хуульд заасан шаардлагыг биелүүлнэ.

12.3. Энэ хуулийн 12.1-д заасан этгээдийн хувьцаа таван хувиар нэмэгдсэн тохиолдол бүрт энэ тухай Хороонд мэдэгдэнэ.

12.4. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувь болон хэналтын багцыг худалдан авснаа бүртүүлэх тухай журмыг Хороо тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах

13 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад үнэт цаасны зах зээл дээр тавигдах хязгаарлалт

13.1. Хөрөнгө оруулагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг мэдээлэх, өмчлөгчийн эвшээрелгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгохыг хориглоно.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасныг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ

[1] Нягтлан бодох бүртгэлийн тухай –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

ябуулдаг этгээд зөрчсөн нь үг этгээдийн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

14 дүгээр зүйл. Хөрөнгө оруулагчид үнэт цаасны гүйлгээтэй холбогдох мэдээлэл хүргэх

14.1. Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй.

14.2. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага хөрөнгө оруулагчийн шаардсанаар дараахь баримт бичиг болон мэдээллийг өгөх үүрэгтэй:

14.2.1. үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон баримт бичиг;

14.2.2. мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн өөрийн хөрөнгийн болон өр, зээл, санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;

14.2.3. ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн тухай мэдээлэл;

14.2.4. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан сүүлийн зургаан сарын үнэт цаасны арилжааны үнэ,ханш болон арилжааны тухай мэдээ.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасныг зөрчиж, хөрөнгө оруулагчид бүруу мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх нь хөрөнгө оруулагч болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн хооронд байгуулсан гэрээг хүчингүй болгох, эсхүл түүнд үндэслэн болно.

14.4. Хөрөнгө оруулагч нь үнэт цаасыг худалдан авах, худалдах явцад хууль тогтоомжид заасан мэдээллийг үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс шаардах эрхтэй.

15 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаарх Хорооны шийдвэр

15.1. Хорооноос хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийг үнэт цаасны зах зээлд оролцогч бүх этгээд биелүүлэх үүрэгтэй.

15.2. Хорооны шийдвэрийг биелүүлээгүй үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үүрэг биелүүлэх тухай мэдэгдэл өгөх, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

16 дугаар зүйл. Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад хориглох үйл ажиллагаа

16.1. Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

16.1.1. үнэт цаасны арилжаа болон үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох явцад нийтэд хуурамч мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх;

16.1.2. дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, нийтэд болон хөрөнгө оруулагчид хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, холбогдох этгээдэд өгөхөөс татгалзах;

16.1.3. үнэт цаасны зах зээлд ажиллаж байгаа брокер, дилер, андеррайтер үнэт цаасны ханшийг тодорхой төвшинд зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;

16.1.4. үнэт цаасны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд тухайн үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор хуурамч гүйлгээ хийх;

16.1.5. тодорхой үнэт цаасны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор брокер, дилерийн болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх;

16.1.6. хуулиар танилцуулгад тусгахаар заасан мэдээллийг орхигдуулах, бууруу мэдээлэх, тайлагнах;

16.1.7. үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны шийдвэр гарахаас өмнө үнэт цаасыг нийтэд санал болгох, сурталчлах.

16.2. Үнэт цаасны үнэ, ханш, арилжааны хэмжээ, явц болон үнэт цаас эзэмшигчийн талаар олон нийтийг төөрөгдүүлэхэд чиглэн хийгдсэн арилжаат үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Хорооноос хуурамч, эсхүл давхар гүйлгээ хийсэн гэж үзэж болно.

16.3. Үнэт цаас гаргагч, түүнтэй гэрээ байгуулсан андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх компанийн эрх бүхий албан тушаалтнаас авсан үнэт цаас гаргах, компанийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөний талаарх нийтэд тараагдаагүй мэдээллийг ашиглан ашиг олохыг хориглоно.

17 дугаар зүйл. Дотоод мэдээллийн нууцыг хадгалах

17.1. Энэ хуулийн 3.1.15-д заасан дотоод мэдээллийг эзэмшигчид үнэт цаас гаргаж байгаа компанийн удирдлага болон эрхэлж байгаа ажил, албан тушаалын дагуу үнэт цаас гаргагчийн талаар нийтэд тараагдаагүй мэдээлэл эзэмшиг, түүнчлэн Хорооноос дотоод мэдээллээ эзэмшигчээр тогтоосон этгээд хамаарна.

17.2. Дотоод мэдээлэл зээмшигч нь түүнийг ашиглан үнэт цаасны арилжааны оролцох, ашиг олох зорилгоор бусдад дамжуулах болон мэдээлэхийг хориглоно.

17.3. Хороо нь дотоод мэдээлэл болон дотоод мэдээлэл зээмшигчийн үйл ажиллагааны талаар журам тогтоон мөрдүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд

18 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд

18.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон хөрөнгө оруулагчид хамаарна.

19 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, тэдгээрийн нийтлэг чиг үүрэг

19.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах Хөрөнгийн бирж, Дилеруудийн арилжааны төв, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага, хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани байна.

19.2. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.1. үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу гаргаж тогтоосон хугацаанд Хороонд хүргэх;

19.2.2. бүртгэлийн, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны болон хадгаламжийн, гишүүний болон суудлын хураамж, бусад холбогдох үйлчилгээний хураамжийг тогтоож мөрдөх;

19.2.3. хууль тогтоомжийн хүрээнд Хорооны зөвшөөрснөөр өөрийн үйл ажиллагаанд баримтлах журам, заавар гарган мөрдөх;

19.2.4. өөрийн гишүүн болон үнэт цаас гаргагч, бусад оролцогч этгээд хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Хороонд хүргэх, тухай бүр олон нийтэд мэдээлэх;

19.2.5. хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль заасан хугацаанд гаргаж, Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргэх, жилийн эцсийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтэлж, хөрөнгө оруулагчид мэдээлэх;

19.2.6. дотоод мэдээлэл зээмшигчийн бүртгэл хөтлөх, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;

19.2.7. үнэт цаастай холбогдсон үнэн зөв мэдээллийг сонирхогч этгээдэд шуурхай өгөх;

19.2.8. үнэт цаасны арилжаа, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон гүйлгээг шударга, ил тод, шуурхай хийж гүйцэтгэх;

19.2.9 үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, Хороонд оруулах;

19.2.10. үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн нийтлэг эрх ашгийг хамгаалах;

19.2.11. болзошгүй эрсдлээс хамгаалах сангай байх. Сангийн эх үүсвэр нь хувь нийлүүлэгчийн хөрөнгө болон үйл ажиллагааны ашиг байна.

19.3. Энэ хуулийн 19.1-д заасан этгээд нь даатгуулах замаар эрсдлээс хамгаалах арга хэмжээ авч болно.

20 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох

20.1. Энэ хуулийн 19.1-д заасан этгээдэд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу Хороо олгоно.

20.2. Хорооноос Хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, Дилеруудийн арилжааны төвд тусгай зөвшөөрөл олгохдоо тус бүр нэг байгууллага байхаар, эсхүл хавсран гүйцэтгэхээр зохицуулж болно.

20.3. Арилжааны банкинд үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо Монголбанктай, даатгалын болон тэтгэврийн санд тусгай зөвшөөрөл олгохдоо Санхүүгийн болон Нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тев байгууллагатай тус тус зөвшилцөн шийдвэрлэнэ.

20.4. Энэ хуулийн 20.1-д заасан тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[1] хуульд зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргасан өргөдлийг Хороонд гаргана:

20.4.1. хуулиар тогтоосон хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг хангасан байдал;

20.4.2. компанийн дүрмийн

[1] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

баталгаажуулсан хуулбар;

20.4.3. эхний 3 жилийн төлөвлөгдөж буй ашгийг тусгасан бизнес төлөвлөгөө;

20.4.4. үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тухайд Хөрөнгийн биржээс эсхүл Дилерүүдийн арилжааны төвийн арилжааны сүлжээтэй үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулах талаархи дэлгэрэнгүй танилцуулга;

20.4.5. хувь нийлүүлэгчийн төлбөрийн чадвар, банк санхүүгийн байгууллагад хүгацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт;

20.4.6. эрсдлийн менежментийн төлөвлөгөө;

20.4.7. мэргэжил, мэргэшлийн дадлага туршлагатай боловсон хүчнээр хангагдсан байдал;

20.4.8. орон байр, техник, тоног төхөөрөмжийн хангалт, цахим тоолуурын сүлжээнд холбогдсон байдал.

21 дүгээр зүйл. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага

21.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг бүртгэх, арилжихтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлдэг компани бөгөөд Хөрөнгийн биржээ, Дилерүүдийн арилжааны төвийн хэлбэрээр зохион байгуулагдана.

21.2. Энэ хуулийн 20.4-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан этгээдэд үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

21.2.1. Хороонооос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 5-аас доошгүй гишүүнтэй байна. Нэг гишүүн нь Хөрөнгийн биржийн болон Дилерүүдийн арилжааны төвийн аль нэгний нь гишүүн байна;

21.2.2. үүсгэн байгуулагчийн баталсан дүрэмд дараахь зүйлийг тусгасан байна:

21.2.2.а. гишүүн элсүүлэх журам, гишүүдэд тавигдах хөрөнгийн доод хэмжээний шаардлага, элсэлтийн болон жилийн хураамжийн хэмжээ, мэргэжлийн ажилтанд тавигдах шаардлага;

21.2.2.б. гишүүнээс хасах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам;

21.2.2.в. хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээ;

21.2.2.г. хэрилцагч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ.

21.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүрэгтэй байна:

21.3.1. өөрийн гишүүн болон олон нийтэд арилжаа явагдах цаг хугацаа, бирж дээр арилжихаар зөвшөөрөгдсөн үнэт цаасны жагсаалт, код, арилжааны үр дүн, түүнчлэн энэ хуульд заасан бусад мэдээллийг хүргэх замаар үнэт цаасны арилжаа шударга, ил тод, шуурхай явуулах;

21.3.2. гишүүн нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн үйл ажиллагаа явуулсан, харилцагчийг хууран мэхэлсэн, төөрөгдүүлсэн, хуурамч гүйлгээ хийсэн нь тогтоогдвол тэдэнд хариуцлага ногдуулах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авч, энэ талаар Хороонд мэдэгдэх;

21.3.3. үнэт цаасны арилжааны болон үнэ, ханшийн тухай мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх.

21.4. Үнэт цаасны арилжаат зохион байгуулахад дараахь журмыг баримтална:

21.4.1. үнэт цаасыг худалдахад хамгийн бага үнээс, худалдан авахад хамгийн өндөр үнээс эхлэх;

21.4.2. үнэт цаасыг худалдах, худалдан авах захиалгыг хэрэгжүүлэх үед үнийн санал тэнцвэл захиалгын дараалларыг баримтлах.

21.5. Үнэт цаас худалдагч, худалдан авагч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч, эрх бүхий бусад этгээдээс гаргасан дүгнэлтийг үндэслэн үнэт цаасны арилжаат Хороо түр зогсоох шийдвэр гаргана.

21.6. Энэ хуулийн 21.5-д заасан шийдвэр гаргасны дараа ажлын нэг өдрөт багтаан, уг шийдвэрийн үндэслэл, тайлбарын хамт үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Энэ тухай үнэт цаас гаргагчид мэдэгдэнэ.

21.7. Хороонооос үнэт цаасны арилжаат түр зогсоох хугацаа нь нэг удаад 2 сараас илүүгүй байна. Зөрчил арилсан гэж үзвэл Хороо арилжаат сэргээх тухай шийдвэрийг тухай бүр гаргана.

22 дугаар зүйл. Хөрөнгийн биржийн

22.1. Хөрөнгийн биржийн нь үнэт цаасны арилжаа эрхлэн явуулах болон хүүлиар хориглоогүй бусад ажил, үйлчилгээ үзүүлдэг компани байна.

22.2. Хөрөнгийн биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,0 тэрбум төгрөгөөс доошгүй байна.

22.3. Хөрөнгийн биржийн нь энэ хуулийн 19, 21 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүрэгтэй байна:

22.3.1. гишүүн байгууллагад суудлын эрх олгох, тэдгээрийг төлөөлөн арилжаанд оролцох ажилтнуудыг бүртгэх;

22.3.2. Хөрөнгийн биржид суудалтай гишүүдийг арилжаа явуулах нөхцөлөөр хангасан

зориулалтын байр, тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээгээр хангах;

22.3.3. Хөрөнгийн биржээр арилжаалагдаж буй үнэт цаасны үнэ, хангийг зохиомлоор нэг хэмжээнд барих, өсгөх, бууруулахаас сэргийлэх;

22.3.4. Хөрөнгийн биржийн гишүүн болон бусад харилцагчийг мэдээллээр хангах;

22.3.5. гишүүний болон ажилтны ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх.

22.4. Хөрөнгийн биржийн арилжаанд зөвхөн суудлын эрхтэй гишүүн оролцох бөгөөд биржийн гишүүн бус этгээд зөвхөн биржийн гишүүнээр зуучлуулан арилжаанд оролцож болно.

22.5. Хөрөнгийн биржийн гишүүн зохих журмын дагуу суудлын эрхээ худалдаж, түрээслэж болно. Суудлын эрхийг худалдан авсан буюу түрээслэн авсан этгээд нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага байна.

22.6. Хөрөнгийн биржийн ажилтан нь үнэт цаасны арилжаанд оролцохыг хориглоно.

23 дугаар зүйл. Үнэт цаасны дилерүүдийн арилжааны төв

23.1. Үнэт цаасны дилерүүдийн арилжааны төв /цаашид "Дилерүүдийн арилжааны төв" гэх/ нь үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас бүрдсэн гишүүнчлэлтэй, үнэт цаасны арилжаа эрхлэх чиг үүрэг бүхий компани байна.

23.2. Дилерүүдийн арилжааны төвийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 500.0 сая төгрөгөөс доошгүй байна.

23.3. Дилерүүдийн арилжааны төвийн гишүүдийн тоо 5-аас доошгүй байна.

23.4. Дилерүүдийн арилжааны төвд бүртгэлтэй үнэт цаасны арилжаог байршил харгалзахгүйгээр гишүүн байгууллагын эрх бүхий ажилтнууд цахим сүлжээгээр дамжуулан явуулна.

23.5. Сүлжээний найдвартай байдал, сүлжээ дэх мэдээллийн нууцлалын асуудлыг Дилерүүдийн арилжааны төвийн удирдлага хариуцна.

23.6. Дилерүүдийн арилжааны төв нь арилжаанд хяналт тавих албатай байх бөгөөд уг төвийн байранд байрлах цахим тооцооллын хэрэгслийг ашиглан сүлжээгээр явагдах арилжааг тогтмол хянана.

23.7. Дилерүүдийн арилжааны төв нь үнэт цаасны бүртгэл, арилжаа, арилжаанд хяналт тавих, арилжааны мэдээг олон нийтэд хүргэх, гишүүн байгууллагын үйл ажиллагаагаа зохицуулахтай холбогдох журмыг Хорооны зөвшөөрснээр батална мөрдөнө.

23.8. Дилерүүдийн арилжааны төвд энэ хуулийн 22.3-д заасан чиг үүрэг нэгэн адил хамаарна.

24 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага

24.1. Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага /цаашид "Төлбөр тооцооны байгууллага" гэх/ нь үнэт цаасны арилжааны үр дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэдэг компани байна.

24.2. Төлбөр тооцооны байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг түүний гишүүн байгууллагууд бүрдүүлэх бөгөөд түүний хэмжээ 100.0 сая төгрөгөөс доошгүй байна.

24.3. Төлбөр тооцооны байгууллага нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.3.1. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны холбогдох компаниас ирүүлсэн мэдээ, баримтыг тулган хянаж, харилцагч хоорондын төлбөрийг үүргийг тодорхойлж, тооцоог хийж гүйцэтгэх, холбогдох баримтыг бүрдүүлэх;

24.3.2. үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдох баримтыг хадгаламжийн байгууллагад шилжүүлэх;

24.3.3. эрсдэлийн сан байгуулах замаар болзошгүй эрсдэлээс хамгаалах, харилцагчийн төлбөрийн үүргийн биелэлтийг шуурхай хангах;

24.3.4. үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх.

25 дугаар зүйл. Үнэт цаасны хадгаламжийн байгууллага

25.1. Үнэт цаасны хадгаламжийн байгууллага /цаашид "Хадгаламжийн байгууллага" гэх/ нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон үг эрх бусдад шилжсэнийг бүртгэх, үнэт цаас хадгалах үйлчилгээ үзүүлдэг компани байна.

25.2. Хадгаламжийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг түүний гишүүн байгууллагууд бүрдүүлэх бөгөөд түүний хэмжээ 100.0 сая төгрөгөөс доошгүй байна.

25.3. Хадгалагдаж буй хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаагүйгээс үүрсан хохирлыг хадгаламжийн байгууллага хариуцна.

25.4. Хадгаламжийн байгууллага энэ хуулийн 19 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.4.1. үнэт цаас шинээр гаргах болон үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхэд гарсан өөрчлөлтийг эрх бүхий этгээдээс ирүүлсэн хүсэлт, бусад баримтыг үндэслэн бүртгэх;

25.4.2. Төлбөр тооцооны байгууллага болон үйлчүүлэгчээс хүлээн авсан баримтыг үндэслэн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх;

25.4.3. Хороо, Хөрөнгийн биржийн бусад эрх бухий этгээд болон үнэт цаас гаргагчийн хүсэлтээр үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийн мэдээг үнэн зөв гаргаж өгөх;

25.5. Хадгаламжийн байгууллага нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр төлбөр тооцооны үйлчилгээг хавсран эрхлэхээс бусад үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

26 дугаар зүйл. Үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон хөрөнгө оруулалтын сан

26.1. Үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага /цаашид "Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага" гэх/ нь үнэт цаасны зах зээлд даатгалын болон тэтгэврийн сангаас тусгай зориулалтаар төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хэсгээр, хөрөнгө оруулалтын сан /цаашид "Сан" гэх/ нь хувь нийлүүлэгчээс төвлөрүүлсэн хөрөнгөөр Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Төлбөр тооцооны болон Хадгаламжийн байгууллагатай хийсэн гэрээний үндэсэн дээр үнэт цаас худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг компани байна.

26.2. Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сан нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахдаа Хөрөнгө оруулалтын менежментийн компаниар дамжуулан, эсхүл өөрөө шууд эрхлэн гүйцэтгэж болно.

26.3. Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 100.0 сая төгрөгөөс доошгүй байна.

26.4. Сан үнэт цаасаа бусдад худалдахаар байгаа санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг буюу нээлттэй, үүсэн байгууллагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр үнэт цаас гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэгүй буюу хаалттай гэсэн хэлбэртэй байна.

26.5. Сан зөвхөн Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр үнэт цаасаа нийтэд санал болгож худалдана.

26.6. Сан нь тогтоосон журмын дагуу нийтэд санал болгон гаргах үнэт цаасны тухай танилцуулгыг Хороонд ирүүлнэ. Танилцуулгад Сангийн хөрөнгө оруулалтын бодлого, шимтгэл тооцох аргачлал, Сангийн удирдлага, ажилтнууд, үнэт цаасны хязгаалтын багцыг зээмшигч болон гэрээт Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн талаарх мэдээллийг тусгасан байна.

26.7. Сангийн дүрэмд дараахь зүйлийг тусгасан байна:

26.7.1. нээлттэй сангийн цэвэр хөрөнгийн доод хэмжээ, өөрийн үнэт цаасыг буцааж худалдан авах үнийг тогтоох журам;

26.7.2. Сангийн хувьцаа эзэмшигчид хүргэх танилцуулгад заавал тусгагдах мэдээлэл;

26.7.3. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн хяналт шалгалт болон мэдээ, тайлан гаргахад тавих шаардлага;

26.7.4. нийтэд санал болгосон үнэт цаасаа арилжих, эргүүлэн худалдан авах журам.

26.8. Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сан нь сангийн цэвэр хөрөнгө, нэгж хувьцааны үнэлгээ, үйлчилгээний хураамжийн хэмжээ, төлбөр тооцооны журам, сангийн итгэмжлэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон сангийн гаргасан үнэт цаасны 5-аас дээш хувийг эзэмшигчийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар Хороонооос тогтоосон журмын дагуу сангийн хувьцаа эзэмшигчид хагас жил тутам мэдээлэл хүргэх үүрэгтэй байна.

26.9. Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Санд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

26.9.1. үнэт цаасны зах зээлд энэ хуулиар зөвшөөрснөөс бусад төрлийн ажил, үйлчилгээ эрхлэх;

26.9.2. өрийн бичиг болон давуу эрхийн хувьцаа гаргаж нийтэд санал болгох;

26.9.3. Сангийн хөрөнгө оруулагчид ашиг олох баталгаа гаргах, сурталчлах;

26.9.4. хувьцаагаа тодорхой үнэ, ханшаар эргүүлэн авах амлалт, баталгаа гаргах;

26.9.5. Сангаас баталгаа гарган зээл авах, гуравдагч этгээдэд зээлийн баталгаа гаргаж өгөх, бусдад зээл олгох;

26.9.6. Сангийн удирдлага нь хувийн ашиг сонирхлын үүднээс сангийн хөрөнгийг зарцуулах, удирдлагын зардлыг үндэслэлгүй хэтрүүлэх;

26.9.7. нэг компанийн үнэт цаасыг худалдан авах хэмжээ нь Сангийн өөрийн эрэлтийн хөрөнгийн 5 хувиас хэтрэх;

26.9.8. нэг компанийн гаргасан нийт хувьцааны 20 хувиас, өрийн бичгийн 25 хувиас илүүг худалдан авах.

26.10. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тухай танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэх, зардлыг тооцох, зар сурталчилгаа явуулах, Сангийн хувьцааны үнэлгээ, хадгаламж, бүртгэл, санхүүгийн хяналт болон тэдгээрийг тайлагнах журмыг Хороо тогтооно.

27 дугаар зүйл. Брокер, дилерийн компани

27.1. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх компани /цаашид "Брокер, дилерийн компани" гэх/-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50.0 сая төгрөгөөс доошгүй байна. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагаат хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагаат эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ.

27.2. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүн байна.

27.3. Брокер, дилерийн компани энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.3.1. харилцагчийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх;

27.3.2. харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг зөвхөн тэдний захиалга, зөвшөөрлөөр арилжаанд оруулах;

27.3.3. үнэт цаасыг худалдах, худалдан авахдаа харилцагчийн захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлэх;

27.3.4. захиалгыг биелүүлэх явцад харилцагч болон брокер, дилер, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай харилцагчид нэн даруй мэдэгдэх.

27.4. Хороо брокер, дилерүүдийн мэргэжил, мэргэшлийн түвшин тогтоох болон аттестатчилах журам батлан мөрдүүлнэ.

28 дугаар зүйл. Андеррайтерийн компани

28.1. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компани /цаашид "Андеррайтерийн компани" гэх/-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 200.0 сая төгрөг, үүнээс мөнгөн болон түргэн борлогдох эргэлтийн хөрөнгө нь 100.0 сая төгрөгөөс доошгүй байна.

28.2. Андеррайтерийн компани нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна үнэт цаас гаргаж нийтэд санал болгох тухай танилцуулгад тусгасан болон түүнд хавсаргасан баримт, мэдээллийн үнэн зөв эсэхийг хянаж, мэдээлэл буруу байсныг илрүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцах үүрэгтэй.

29 дүгээр зүйл. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын менежментийн компани

29.1. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид "Хөрөнгө оруулалтын менежментийн компани" гэх/ нь таваас дээшгүй Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сантай гэрээ байгуулан хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг компани байна.

29.2. Хамтын хөрөнгө оруулалтын байгуллага болон Сан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулсан гэрээнд заасны дагуу үйлчилгээний хураамж төлнө.

29.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үнэт цаасны зах зээлд энэ хуульд зааснаас өөр төрлийн ажил, үйлчилгээ эрхлэх, Сангийн хөрөнгийг ашиглан менежментийн гэрээнд заасан үйлчилгээний хураамж, шимтгэлээс бусад орлого олохыг хориглоно.

30 дугаар зүйл. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх компани

30.1. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани /цаашид "Хөрөнгө оруулалтын компани" гэх/ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас нийтийн хүртээл болгохоор заасан мэдээллийг цуглуулж, судалгаа, дүгнэлт хийх, хөрөнгө оруулагчид зөвлөлгөө өгөх үйл ажиллагаа эрхэлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага

31 дүгээр зүйл. Үнэт цаасны хороо

31.1. Хороо нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогчийн үйл ажиллагаог зохицуулах, хяналт тавих, үнэт цаасны зах зээлийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж, тэдгээрийг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

31.2. Хороо 5 гишүүнээс бүрдэнэ.

31.3. Хороо нь өөрийн гишүүдэд тусалцаа үзүүлэх, Хорооны үйл ажиллагаат хэвийн явудлах нөхцөлийг хангах, хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байна. Ажлын албаны үйл ажиллагаат Хорооны дүрмээр зохицуулна.

31.4. Хороо нь улсын төсвөөс санхүүжинэ.

31.5. Хорооны ажлын албаны удирдах бүтэц гүйцэтгэх албан тушаал төрийн захиргааны албан тушаалд хамаарна.

31.6. Хороо жил бүр Улсын Их Хуралд ажлаа тайлагнана.

31.7. Хороо нь өөрийн билэгдэлтэй байж болох бөгөөд тогтоосон жүрмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

31.8. Хороо нь үйл ажиллагаандаа үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, бусдын

нөлөөнд үл автах болон хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгоно.

32 дугаар зүйл. Хорооны гишүүн

32.1. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны ерөнхийлөгч тус бүр 1 хүнийг, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо үлдэх 2 хүнийг нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас 5 жилийн хугацаагаар томилно. Байнгын хороонооc санал болгох нэр дэвшиг нь үнэт цаас гаргагчдыг төлөөлсөн байна.

32.2. Хорооны гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн болон Үндэсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүгч, прокурорыг томилж болохгүй.

32.3. Хорооны гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилоогүй бол энэ хуулийн 32.1-д заасан эрх бүхий этгээд жилын 14 хоногийн дотор өөр хүний нэрийг дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

32.4. Хорооны гишүүнийг дараахь үндэслэлээр үүрэгт аажлаас чөлөөлнө:

32.4.1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

32.4.2. эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгааналр албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй болсон;

32.4.3. Хорооны гишүүнээс чөлөөлж өгөхийг өөрөө хүсэж өргөдөл гаргасан.

32.5. Энэ хуулийн 32.4-т заасан үндэслэлээр Хорооны гишүүнийг үүрэгт аажлаас чөлөөлүүлэх тухай саналыг түүнийг анх томилуулахаар санал болгосон этгээд Улсын Их Хуралд оруулна.

32.6. Хорооны гишүүн нь үүрэгт аажлаа зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл хууль тогтоомж зөрчсөн бол түүнийг томилуулахаар санал болгосон этгээдийн саналыг үндэслэн, гэмт хэрэг үйлдсэн бол шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг үндэслэн Улсын Их Хурал огцруулна.

32.7. Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол энэ хуулийн 32.1-д заасан эрх бүхий этгээд өөр хүнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

32.8. Хорооны гишүүнийг зөвхөн нэг удаа улируулан томилж болно.

32.9. Хорооны дарга орон тооны, гишүүд орон тооны бус байна.

32.10. Хорооны даргын цалинг Улсын Их Хурал тогтооно. Гишүүдэд урамшил олгох журмыг Хорооны дүрмээр зохицуулна.

33 дугаар зүйл. Хорооны гишүүнд тавигдах шалгуур, хориглох зүйл

33.1. Хорооны гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

33.1.1. эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл болон хууль зүйн салбарын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх;

33.1.2. мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх.

33.2. Хорооны гишүүнд энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад дараахь зүйлийг хориглоно:

33.2.1. дотоод мэдээллийг Хорооны зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээлэх, дамжуулах;

33.2.2. дотоод мэдээлэл ашиглан үнэт цаасны арилжаанд оролцох;

33.2.3. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгч болох, удирдлагад нь сонгогдох, томилогдох;

33.2.4. хэлэлцэж буй асуудалд хувийн сонирхлын үүдэнээс хандах.

34 дүгээр зүйл. Хорооны эрх хэмжээ

34.1. Хороо дараахь эрх хэмжээтэй байна:

34.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

34.1.2. үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

34.1.3. эрх хэмжээнийхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;

34.1.4. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

34.1.5. үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

34.1.6. хөрөнгө оруулагчийн эрх ашигт хохиролтой гэж үзсэн нөхцөлд үнэт цаасны арилжааг түр зогсоох;

34.1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх, бүртгэлгүй үнэт цаасны арилжааг зогсоох, хориглох;

34.1.8. хувьцаат компанийн хувьцааны хяналтын багц буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээд худалдан авахаар гаргасан тендер саналыг энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөх, бүртгэх, хянах;

34.1.9. үнэт цаас гаргагч, үнэт цаас эзэмшигч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журамд заасан мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа эсэхэд хяналт тавих;

34.1.10. үнэт цаас гаргагч, үнэт

цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан, мэдээ, түүний тайлбар тодруулгад зайлшгүй тусгагдах үзүүлэлт, тайлан, мэдээний маягт хэрэглэх талаар журам тогтоож мөрдүүлэх;

34.1.11. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс зөрчилтэй гэж үзсэн бүюу арилжаанд оролцогч аль нэг талын хүсэлтийг үндэстэй гэж үзвэл тухайн үнэт цаасны арилжаат түр зогсоох шийдвэрийг зөрчилтэй нь нотлогдол түүний арилжааны хэлцлийг хүчингүй болгох;

34.1.12. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж авааг үй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх;

34.1.13. үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, бусад бариmтыг аудитын болон үнэлгээний байгууллагаар шалгуулан баталгаажуулахыг шаардах;

34.1.14. Хорооны гишүүн, ажлын албаны болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, тэдэнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаасны талаар мэдээлэл гаргуулах;

34.1.15. үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх олгох, хүчингүй болгох;

34.1.16. олон нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, тогтоосон журмын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

35 дугаар зүйл. Хорооны хуралдаан

35.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

35.2. Хорооны гишүүдийн олонхи нь оролцоноор хуралдаан хүчин төгөлдөр болж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

35.3. Хуралдаанаар баримтлах дэгээ Хороо тогтооно.

35.4. Хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, тэмдэглэл гаргана. Тогтоол, тэмдэглэлд Хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

36 дугаар зүйл. Хорооны гишүүний эрх хэмжээ

36.1. Хорооны дарга нь Хорооны гишүүн, үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх хэмжээнээс гадна дараахь эрх хэмжээтэй байна:

36.1.1. Хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

36.1.2. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, удирдах;

36.1.3. Хорооны гишүүн, ажилтны ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

36.1.4. эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах.

36.2. Хорооны даргын эзгүйд түүнийг Хорооны шийдвэрээр аль нэг гишүүн орлон ажиллана.

36.3. Хорооны гишүүн нь үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх хэмжээнээс гадна Хорооны хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах, Хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох, хууль тогтоомжид заасан бусад эрх хэмжээтэй байна.

37 дугаар зүйл. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх баталгаа

37.1. Хорооны гишүүн болон Хорооноос эрх олгосон ажлын албаны ажилтан үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч / цаашид "улсын байцаагч" гэх/-ийн эрхтэй байна. Улсын байцаагч нь үнэмлэхтэй байх бөгөөд хувийн тэмдэг, торгуулийн хуудас хэрэглэнэ.

37.2. Улсын байцаагч дараахь эрх хэмжээтэй байна:

37.2.1. үнэт цаасны зах зээлийн талаархи хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шаардлагатай асуудлыг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах;

37.2.2. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад бариmт бичгийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

37.2.3. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн бүюу зөрчсөн нь тогтоогдсон бол үнэт цаасны арилжаат түр зогсоох, үнэт цаасыг тусгаарлах;

37.2.4. хяналт шалгалтын дүнг үндэслэн акт тогтоох, түүний гүйцэтгэлийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг өгч шаардлага тавих;

37.2.5. энэ хуулийн 37.2.4-д заасан шаардлагыг биелүүлээгүй үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх, үйл ажиллагаа нь түр зогсоох, шаардлагатай гэж үзвэл түсгай эвшээрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгох саналыг Хороонд оруулж шийдвэрлүүлэх;

37.2.6. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ямар нэгэн этгээд зөрчихөөр завдаж байгааг бариmтаар нотолсон, түүнчлэн зөрчлийг тогтоосон нөхцөл төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох.

37.3. Хороо дараахь тохиолдолд улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгоно:

37.3.1. хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон буюу гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон;

37.3.2. үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн.

37.4. Улсын байцаагч нь Төрийн албаны тухай[1] хуульд зааснаас гадна дараахь батлагаагаар хангагдана:

37.4.1. хяналт шалгалт хийх эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчин хувиас гаргасан зардлыг Хороонь төсөвөөс тогтоосон журмын дагуу нөхөн олгоно;

37.4.2. хяналт шалгалт хийх эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацаанд түрш тус тус авна;

37.4.3. хяналт шалгалт хийх эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний албан тушаалын гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн бүцалтгүй тусламжийг хохирогчийн ар гэрт олгоно;

37.4.4. энэ хуулийн 37.4.2, 37.4.3-т заасан тэтгэвэр, тэтгэмж болон албан тушаалын цалингийн зөрүү, бүцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

38 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

38.1. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

38.1.1. энэ хуулийн 7.2, 9.5, 9.6, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5, 11.7, 11.8, 14.1, 14.2, 15.1, 19.2.1, 19.2.4, 19.2.5, 19.2.6, 19.2.7, 19.2.8, 19.2.11, 21.3.1, 21.3.3, 21.4, 26.8, 27.3, 12 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол иргэнийг 20000-40000, албан тушаалтныг 30000-50000, хуулийн этгээдийг 100000-200000 төгрөгөөр торгох;

38.1.2. энэ хуулийн 5.6, 7.7, 9.3, 13.1, 17.2, 22.6, 25.5, 26.9, 29.3, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол албан тушаалтныг 40000-60000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгох.

39 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

39.1. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

39.2. Энэ хуулийн Хөрөнгө оруулалтын сан болон Брокер, дилерийн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заасан 26.3, 27.1 дэх хэсгийг 2003 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Үнэт цаасны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батална Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1-ийн "хөрөнгө оруулалтын сан" гэсний дараа "хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1-ийн "хөрөнгийн биржээс" гэсний "үнэт цаасны арилжаа эрхлэх" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

---

[1] Төрийн албаны тухай –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №48(285)
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр
Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд эвдэрсэн олгох, тэдгээхүүлэх хүчинтэй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж

2.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Компанийн тухай хууль[2], Банкны тухай хууль[3], Аж ахуйн үйл ажилллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль[4], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн 7.1.-д заасан үйл ажиллагаа Монголбанкнаас зөвшөөрөл авсан этгээд эрхлэхтэй холбогдсон харилцаг энэхүү хуулиар зохицуулна.

3.2. Банк, даатгал, үнэт цаасны компани, тэтгэврийн сан, хөрөнгө оруулах сангийн үйл ажиллагаа, барьцаалан зээлдүүлэх газар, төслийн нэгж, Засгийн газрын тусгай эрхтэй сангаас олгох зээлийн үйл ажиллагаанд холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "банк бус санхүүгийн үйл ажиллагаа" гэж Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг;

4.1.2. "факторингийн үйлчилгээ" гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс менгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагаа;

4.1.3. "санхүүгийн түрээсийн үйлчилгээ" гэж түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалсан буюу сонгосон эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх, эсхүл худалдаж буюу нийлүүлэгчээс өөрийн нэр дээр худалдан авах замаар түрээслэгчид тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгээр түрээслэх үйл ажиллагаа;

4.1.4 "төлбөрийн баталгаа гаргах" гэж Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасныг;

4.1.5 "цахим төлбөр тооцоо, менгөн гүйвүүлэгч үйлчилгээ" гэж бусдын менгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагаа;

4.1.6 "гадаад валютын гүйлгээ" гэж гадаад валютыг худалдах, худалдан авах, түүнээс зээл олгох, баталгаа гаргах үйл ажиллагаа;

4.1.7. "итгэлцлийн үйлчилгээ" гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн менгө, зээл, бусад актив-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндэсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаа;

4.1.8. "бөгино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх" гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрөвүүлэхийг;

4.1.9. "банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд" гэж энэ хуулийн 6.1.-д заасан этгээдийг;

4.1.10. "банк бус санхүүгийн байгуулагын актив, пассив, өөрийн хөрөнгө" гэж олон улсын жишигт нийцүүлэн Монголбанкнаас батална нягтлан бодох бүртгэлийн жүрамд тодорхойлсныг.

ХОЁРДҮГЭЭР БҮЛЭГ
Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх

[1] Иргэний хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн
[2] Компанийн тухай -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн
[3] Банкны тухай -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн
[4] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

5 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг үүсгэн байгуулах

5.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хууль заасны дагуу үүсгэн байгуулна.

6 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх

6.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын хуулийн этгээд, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр зөвшөөрөгдсөн гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно.

6.2. Улсын төсөвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон улс төрийн байгууллага, төрийн бус байгууллага, Иргэний хуулийн 36.2.-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

7 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа

7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно:

7.1.1. зээл;

7.1.2. факторингийн үйлчилгээ;

7.1.3. санхүүгийн түрээс;

7.1.4. төлбөрийн баталгаа гаргах;

7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;

7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ;

7.1.7. гадаад валютын арилжаа;

7.1.8. итгэлцлийн үйлчилгээ;

7.1.9. бөгино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;

7.1.10.хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.

8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг

8.1. Энэ хуулийн 7.1.-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.-д заасан болон дараахь баримт бичиг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ:

8.1.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэм, үүсгэн байгуулах баримт бичиг;

8.1.2. бизнес төлөвлөгөө;

8.1.3.Монголбанкнаас тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан эсэхийг нотлох баримт бичиг;

8.1.4. аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

8.1.5.боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаархи мэдээлэл;

8.1.6. хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

8.1.7. тухайн банк бус санхүүгийн байгууллагын нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг дангаар эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн орлогын мэдүүлэг, дүрмийн санд оруулсан хөрөнгийн гарал үүслийн талаархи шаардлагатай мэдээлэл;

8.1.8. тухайн банк бус санхүүгийн байгууллагын нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг дангаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт.

8.2. Энэ хуулийн 8.1.-д заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичгийг дутуу буюу тодорхой бус гэж үзвэл Монголбанк үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, банк бус санхүүгийн байгууллагын удирдлагатай холбоотой асуудлаар холбогдох байгууллагаас лавлагаа авч болно.

9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

9.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсч, ирүүлсэн баримт бичгийг Монголбанк хүлээн авч ажлын 30 хоногийн дотор хянаад, дараахь шаардлагыг хангасан тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

9.1.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрмийн сан нь Монголбанкнаас тогтоосон хэмжээнд хүрсэн;

9.1.2. бизнес төлөвлөгөөнд банк бус санхүүгийн үйл ажиллагааг амжилттай эрхлэх стратеги, нөхөөлөх хүчин зүйлийг оновчтой тусгаж чадсан;

9.1.3. тухайн банк бус санхүүгийн байгууллагын удирдлага нь энэ хуулийн 13.5,13.6-д заасан шалгуурыг хангасан;

9.1.4. банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, ажуулгүй ажиллагааны шаардлагыг зохих түвшинд хангасан.

9.2. Ирүүлсэн баримт бичгийг магадлан шинжлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд Монголбанк энэ хуулийн 9.1.-д заасан хугацааг 14 хоногоор сунгаж болно.

9.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл, эрхлэх хугацааг тодорхой заана.

9.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газар, нэгжийг Монголбанкны зөвшөөрөлтэйгээр нээнэ.

10 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэм

10.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2.-т заасан болон дараахь зүйлийг тусгана:

10.1.1. өөрийн хөрөнгө /дүрмийн сан/-ийн хэмжээ;

10.1.2. банк бус санхүүгийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

10.1.3. хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах журам;

10.1.4. дотоод хяналтын албаны ажиллах журам.

10.2. Банк бус санхүүгийн байгууллагын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Монголбанкинд бүртүүлнэ.

11 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын нэр

11.1. Банк бус санхүүгийн байгууллагын нэр нь түүний оносон нэр болон "Банк бус санхүүгийн байгууллага" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ББСБ" гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

11.2. Энэ хуулийн 7.1.-д заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс өөр этгээд өөрийн оносоон нэртэй хамт "Банк бус санхүүгийн байгууллага" болон "ББСБ" гэсэн тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

11.3. Банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг Монголбанкны зөвшөөрөлтэйгээр өөрчилнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл, тавих шаардлага

12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл

12.1. Банк бус санхүүгийн байгууллага дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

12.1.1. тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх;

12.1.2. өөрийн үйл ажиллагааны талаар бууруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;

12.1.3. иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх;

12.1.4. чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах;

12.1.5. банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах.

12.2.Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг зээл төлүүлэх зорилгоор зээлших, худалдаж борлуулах үйл ажиллагаа энэ хуулийн 12.1.1.-д хамаарахгүй.

12.3.Банк бус санхүүгийн байгууллага, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гаргаж өгөх, задлах, ашиглахыг банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд хориглоно.

13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага

13.1.Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй.

13.2.Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгааны нийт дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 70 хувиас илүүгүй байна.

13.3.Тухайн банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтэрч болохгүй бөгөөд иймхүү олгохдоо дараахь шаардлагыг баримтална:

13.3.1. банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн санд оруулсан хөрөнгийг барьцаалан зээл олгохгүй байх;

13.3.2. олгосон зээлийн төлөгдөх хугацаа нь зургаагаас дээш сараар хэтэрсэн бол тухайн этгээд банк бус санхүүгийн байгууллагын удирдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглох.

13.4. Нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрээлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу хангаж биелүүлнэ.

13.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, түйлэтгэх захирал дараахь шалгуурыг хангасан байна.

13.5.1. зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

13.5.2. ял шийтгэлгүй;

13.5.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх.

13.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Өөрийн хөрөнгө, санхүүгийн тайлан

14 дүгээр зүйл.Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө

14.1.Банк бус санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөтэй байна. Өөрийн хөрөнгийг Монголбанкнаас батлагдсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тодорхойлно.

14.2.Дүрмийн сан нь банк бус санхүүгийн байгууллагын хувь нийгүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханшийн өөрчлөлт, банк бус санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк тогтоно.

14.3. Банк бус санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгийн хэмжээг ашиг, алдагдлаараа буюу зээл төлөгдөхэд үчирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан илүү, дутуу байгуулсан хэсгээрээ нэмэгдүүлж, эсүүл хорогдуулж тодорхойлно.

14.4. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийгүүлэгч дүрмийн сан оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.

14.5. Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийгүүлэгчдийн бүрэндэхүүнд өөрчлөлт оруулах бүрд Монголбанкинд мэдэгдэж зөвшөөрөл авна.

14.6. Дүрмийн санг нэмэгдүүлэх, хорогдуулах шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журмыг Монголбанк тогтооно.

15 дугаар зүйл.Санхүүгийн тайлан, түүнийг нийтэд мэдээлэх

15.1. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого, зарлагын болон мөнгөн хөрөнгийн хөдлөлийн тайлан, тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

15.2. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байна.

15.3. Банк бус санхүүгийн байгууллага нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж Монголбанкинд хүргүүлнэ. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт нотлох баримтыг Монголбанк шаардах эрхтэй.

15.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

15.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс нийтэлсэн санхүүгийн тайлан, мэдээлэл нь зохих журмыг баримтлаагүй, буруу, ташаа, алдаатай бол Монголбанк залруулахыг шаардана.

16 дугаар зүйл. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах

16.1.Банк бус санхүүгийн байгууллага нь санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт, материалаа аудитын байгууллага /аудитор/-аар жилд нэгээс доошгүй удаа шалгуулж баталгаажуулна.

16.2. Аудитын байгууллага /аудитор/ нь баталгаажуулсан санхүүгийн тайлан, баримт материалынхаа талаархи дүгнэлтийг тухайн банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгагчдын зөвлөлд танилцуулна.

17 дугаар зүйл. Аудитын дүгнэлтийг Монголбанкинд гаргаж өгөх

17.1.Аудитын байгууллага /аудитор/ нь өөрийн баталгаажуулсан тайлангийн талаарх эцсийн дүгнэлтийг тухайн банк бус санхүүгийн байгууллага болон Монголбанкинд хүргүүлнэ.

17.2.Аудитын байгууллага /аудитор/ нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын баримт материалд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргавал энэ талаарх дүгнэлтээ Монголбанкинд даруй мэдээлнэ:

17.2.1. төлөөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсноос ойрын үед санхүүгийн онц хүндрэлтэй байдалд орж болзошгүй байгаа;

17.2.2. тухайн банк бус санхүүгийн байгууллагын ажилтнууд өөрийн банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлсөн шударга бус, хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон гэж үзсэн.

18 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийгүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл

18.1.Банк бус санхүүгийн байгууллагыг Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хүрлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

18.2.Банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай зөвшөөрөл авахад дор дурдсан баримт бичгийг Монголбанкинд гаргаж өгнө:

18.2.1.банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

18.2.2.банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацаа заасан баримт бичиг, тухайн банк бус санхүүгийн байгууллагаас үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хүрэх нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл;

18.2.3.банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараа байгуулагдах банк бус санхүүгийн байгууллагын эхлэлтийн тайлан тэнцэл.

18.3.Монголбанк баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ.

18.4.Банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Монголбанк зөвшөөрөл өгөхөөс татгалзана.

18.5.Банк бус санхүүгийн байгууллагыг татан буулгах тухай Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн хууль тогтоомжид заасан жүрмын дагуу банк бус санхүүгийн байгууллагыг татан буулгана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

19 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

19.1. Монголбанк энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрүүдэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

19.2. Банк бус санхүүгийн байгууллага нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг зөрчсөн нь хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөлд Монголбанк дор дурдсан арга хэмжээ авна:

19.2.1. албан бичгээр сануулах, зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

19.2.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

19.2.3. гүйцэтгэх захирлыг өөрчлөх, түүнд хариуцлага тооцох талаар банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлд санал оруулах;

19.2.4. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

19.3. Энэ хуулийн 19.2-т дурдсан арга хэмжээг авахдаа адил зөрчилд адил арга хэмжээ авах зарчмыг баримтлах бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Монголбанк батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

20.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм бурууташ этгээдэд Монголбанкны хянан шалгагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

20.1.1. банк бус санхүүгийн байгууллагын салбарыг зөвшөөрөлгүй нээсэн бол хууль бусаар олсон орлогыг хураах, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.2. банк бус санхүүгийн байгууллагаас бусад этгээд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлсэн бол олсон орлогыг хураах, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.3. банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Монголбанкнаас гаргасан шийдвэрийг биелүүлэхгүй ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.4. хяналт шалгалтад саад учруулсан иргэнийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.5. төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээ саатуулсан ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

торгох;

20.1.6. тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Монголбанкинд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 15 дугаар зүйлийн дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.7. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.8. нийтлүүлсэн тайлан мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол тухайн банк бус санхүүгийн байгууллага буюу уг тайлан мэдээллийг нийтлүүлэх үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

20.1.9. энэ хуулийн 12.1.2.-т заасныг зөрчин хуурамч, худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгаг тараасан бол тухайн банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дээ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, уг зар сурталчилгаг тараах үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

20.1.10.энэ хуулиар хориглосон болон тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн банк бус санхүүгийн байгууллагын олсон орлогыг хурааж, банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин таваас дээ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, зөвшөөрснээс бусад тохиолдолд банк бус санхүүгийн байгууллагын болон тухайн байгууллагын харилцагчдын нууцыг задруулсан эгтэздийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

20.2. Торгуулийн орлогыг улсын төсөвт оруулна.

20.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөнөөс үүрсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

20.4.Энэ хуулийн 20.1.-д заасан торгуулийг үндэслэлгүй ногдуулсан гэж үзвэл шүүхэд гомдол гаргаж болно.

21 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

21.1. Энэ хуулийг 2003 оны 2 дугаар сарын 1-ний өдөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "... энэ хуулийн 28, 28' дүгээр зүйл, ..."гээний дараа "...Банк бус санхүүгийн үйл ажиллагаа,..." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараахь заалт нэмсүгэй:

"15.2.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуульд дор дурдсан агуулгатай Зургаа[1]дугаар бүлэг, 26[1] дугаар зүйл, 3.5, 5.2, 8.3, 8.4, 16.7, 27.9 дэх хэсэг, 8.1.5, 14.1.11, 35.1.5, 49.1.3 дахь заалт нэмсүгэй:

1/ Зургаа[1]дугаар бүлэг

"ЗУРГАА[1]ДУГААР БҮЛЭГ

Хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа

48[1] дугаар зүйл. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа

48[1].1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо 20-иос доошгүй гишүүнтэй байна.

48[1].2. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь дараахь асуудлыг дүрэмдээ тусгана:

48[1].2.1. хадгаламж авах, зээл олгох журам;

48[1].2.2. хоршоо болон гишүүдийн харицан хүлээх эрх, үүрэг;

48[1].2.3. хоршооны зээлийн сан, зээлийн эрсдэлийн сан болон бусад санг байгуулах, зарцуулах журам;

48[1].2.4. зээлийн хоroo болон хоршооны бүтэц дэх бусад байгууллагаас хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд оролцох журам.

48[1].3. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн[1] 15.2.1-д заасан тусгай зөвшөөрөл хамаарахгүй.

48[2] дугаар зүйл. Хоршооны хадгаламжийн үйл ажиллагаа

48[2].1. Хоршоо нь өөрийн гишүүнээс мөнгөн хөрөнгийн хадгаламж авч болно.

48[2].2. Хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь Иргэний хуулийн[2] 454-456 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулсан гэрээний үндэсэн дээр мөнгөн хөрөнгө хадгална.

48[2].3. Хоршооны хадгаламжид авсан мөнгөн хөрөнгө нь тухайн хоршооны эд хөрөнгөд хамаарахгүй. Хадгаламж дахь хөрөнгийг эзэмшэн хоршооны зээлийн сангийн эх үүсвэр болгон ашиглаж болно.

48[2].4. Хоршоонд хадгалуулахаар өгсөн хөрөнгө нь хамтран эзэмшигчэй бол хадгаламж бүхий гишүүн нь энэ тухай хадгаламжийн гэрээ байгуулахаас өмнө хоршоонд мэдэгдэх үүрэгтэй.

48[2].5. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хадгаламж, зээлийн хүүг тодорхойлох журмыг бүх гишүүдийн хурлаас тогтооно.

48[2].6. Хоршооны гишүүн нь өөрийн насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр хоршоонд хадгаламж нээж болно. Энэ тохиолдолд гэрээг тухайн хүүхдийг насанд хүрэх хүртэлх хугацаагаар байгуулна.

48[3] дугаар зүйл. Хоршооны зээлийн үйл ажиллагаа

48[3].1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь гишүүндээ хоршооны зээлийн сангийн хөрөнгөөс дүрэмд заасан журмын дагуу зээл олгож болно.

48[3].2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь зээлийн сан, зээлийн эрсдэлийн сан байгуулна. Зээлийн сан нь хоршооны хөрөнгөөс хуваарилсан хөрөнгө болон хоршооны гишүүдээс авсан хадгаламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

Хоршооны зээлийн сан хоршооны өөрийн хөрөнгөөс хуваарилах хөрөнгийн хэмжээ болон зээлийн эрсдэлийн сангийн хөрөнгийн хэмжээг дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлаас тогтооно.

48[3].3. Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоо нь гишүүддээ Иргэний хуулийн 451-453 дугаар зүйлд заасны дагуу гэрээний үндэсэн дээр зээл олгоно.

48[3].4. Зээлийн бүцаан төлөлтийг гишүүний хоршоонд оруулсан хувь хөрөнгө болон хадгалуулсан хөрөнгөөр баталгаажуулж болно.

48[4] дугаар зүйл. Зээлийн хоroo, түүний бүрэн эрх, бүрэлдэхүүн

48[4].1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь зээлийн хороотой байна. Зээлийн хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байна. Зээлийн хорооны гишүүдийг бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. Зээлийн хорооны гишүүн нь тэргүүлэгч гишүүн, хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

48[4].2. Зээлийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48[4].2.1. зээл авахаар хүсэлт гаргасан хоршооны гишүүний өргөдлийг шалгах;

[1] Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт хэвлэгдсэн.

[2] Монгол Улсын Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаар хэвлэгдсэн.

48¹.2.2. зээл олгох эсэхийг шийдвэрлэх, зээл олгох;

48¹.2.3. олгосон зээлийг эргэн төлүүлэх;

48¹.2.4. шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг хуралдуулах;

48¹.2.5. хууль болон хоршооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

48¹.3. Зээлийн хорооны хурал гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно. Дүрмээр үүнээс дээгүүр хувь тогтоож болно.

48¹.4. Дүрэмд энэ хуулийн 48¹.3-т зааснаас өндөр хувь тогтоогоогүй бол зээлийн хорооны шийдвэрийг санал хураалтад оролцсон хорооны гишүүдийн олонхийн саналаар гаргана.

48¹.5. Зээлийн хорооны даргыг тухайн хоршооны Төрүүлэгчидийн хурал зээлийн хорооны гишүүдээс томилно."

2/ 26¹ дугаар зүйл:

"26¹ дугаар зүйл. Төлөөлөгчидийн хурал

26¹.1. 100-аас дээш тооны гишүүнтэй анхан шатны хоршоо шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлын оронд төлөөлөгчидийн хуралтай байж болно.

26¹.2. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчидийн хуралд энэ хуулийн 23.4.1, 23.4.5, 23.4.10, 23.10, 26¹.3-аас бусад бүх гишүүдийн хуралд хамаарахаар заасан заалт нэгэн адил хамаарна.

26¹.3. Төлөөлөгчидийн хурлын гишүүдийн тоо, түүний бүрэн эрхийн хугацаа, төлөөлөгч сонгох, дүнг гаргах болон нэг төлөөлөгч хоршооны саналын эрх бүхий хэдэн гишүүнийг төлөөлж байх журмыг бүх гишүүдийн хурал тогтоно.

Төлөөлөгчидийн хурлын гишүүдийн тоо нь нийт саналын эрх бүхий гишүүдийн 25 хүвиас багагүй хэмжээтэй байна.

26¹.4. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчийг бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. Төлөөлөгч нь бүрэн эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

26¹.5. Төлөөлөгч түс бүрийн саналын эрх нь түүний төлөөлж буй хоршооны гишүүдийн саналын эрхийн нийлбэрээр тодорхойлогдоно.

26¹.6. Төлөөлөгч нь тухайн хоршооны гишүүн байна."

3/ 3.5 дахь хэсэг:

"3.5. Хоршоо нь энэ хуулийн 3.4-т заасан хэд хэдэн үйл ажиллагаа нэгэн зэрэг эрхэлж болно.

4/ 5.3 дахь хэсэг:

"5.3. Хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг өөрийн хөрөнгөөр хүлээнэ."

5/ 8.3 дахь хэсэг:

"8.3. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны өөрийн хөрөнгө нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, нөөц сан, хуваарилагдаагүй орлого, хандив, нийгмийн хөгжлийн сан болон тухайн жилийн цэвэр ашгаас бүрдэнэ.

6/ 8.4 дэх хэсэг:

"8.4. Хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд мөрдөх зохистой үзүүлэлт, эрсдэлийн сангийн доод хэмжээг тодорхойлох журмыг Төв банк тогтооно."

7/ 16.7 дахь хэсэг:

"16.7. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хоршоо санхүүгийн жил дуусснаас хойш 4 сарын дотор орлого хуваарилах асуудлыг шийдвэрлэнэ."

8/ 27.8 дахь хэсэг:

"27.8. Тэргүүлэгчид нь гишүүдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтооно."

9/ 8.1.5 дахь заалт:

"8.1.5. хоршооны өмчлөл дэх бусад хөрөнгө. "

10/ 14.1.11 дэх заалт:

"14.1.11. хууль, дүрэмд өөрөөр заагаагүй бол өрсөлдөгч бус өөр хоршоонд гишүүн байх, хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч байх."

11/ 35.1.5 дахь заалт:

"35.1.5. зээлийн олголт, эргэн төлөлт, Зээлийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих."

12/ "49.1.3 дахь заалт:

"**49.1.3.** Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь өөрийн гишүүн бус этгээдээс хадгаламж авсан, өөрийн гишүүн бус этгээдэд зээл олгосон, хадгаламж авах, зээл олгохоор зар сурталчилгаа хийсэн бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хураож, гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөг, хоршоог 50000-250000 хүртэл төгрөгөөр торгоно."

2 дугаар зүйл. Хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн гарчгийн "түүний" гэсний дараа "үйл ажиллагааны" гэж, 3.1 дэх хэсгийн "ардчилсан" гэсний дараа "хамтын" гэж, 3.2 дахь хэсгийн "зорилгоор" гэсний дараа "бусад хоршоо болон хуулийн этгээдтэй хамтран" гэж; мөн хэсгийн "болно." гэсний дараа "Дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байна." гэж; 6.1 дэх хэсгийн "Хоршоог" гэсний өмнө "Анхан шатны" гэж; 8.1.3 дахь заалтын "хоршооны" гэсний дараа "болзошгүй алдагдлын" гэж; 15.1.4 дэх заалтын "өөрчилсөн" гэсний дараа "өөр

хоршоонд гишүүнээр элссэн" гэж; 29.2.4 дэх заалтын "гишүүнээс гарсан" гэсний өмнө "гишүүнээр элссэн," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хоршооны тухай хуулийн 3.4 дэх хэсгийн "Хоршоо нь үйл ажиллагааны чиглэлээр дараахь төрөлтэй байна:" гэснийг "Хоршоо нь дараахь төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно:" гэж; 3.2.8 дахь заалтыг дүрэмд заасан үйл ажиллагаа." гэж; 6.1 дэх хэсгийн "хөөрөөс доошгүй хоршоо" гэснийг "хөөрөөс доошгүй хуулийн этгээд" гэж; 7.1. дэх заалтыг "Хоршоо нь оноосон нэртэй байна. Хоршооны оноосон нэрний ард "Хоршоо" гэсэн ялгах тэмдгийг хэрэглэнэ." гэж; 9.3.5 дахь заалтын "гишүүдээс хоршоонд заавал оруулах хөрөнгийн хэмжээ" гэснийг "гишүүнээс хоршоонд оруулах хөрөнгийн доод хэмжээ" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 3.1 дэх хэсгийн "хамтран өмчлөх", 9.3.2 дахь заалтын "үүсгэн байгуулагч", 15.1.1, 17.1.2 дахь заалтын "биечлэн" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Хоршооны тухай хуулийн 3.4 дэх хэсгийн 3.2.1 дугаарыг 3.4.1 гэж; 3.2.2 дугаарыг 3.4.2 гэж; 3.2.3 дугаарыг 3.4.3 гэж; 3.2.4 дугаарыг 3.4.4 гэж; 3.2.5 дугаарыг 3.4.5 гэж; 3.2.6 дугаарыг 3.4.6 гэж; 3.2.7 дугаарыг 3.4.7 гэж; 3.2.8 дугаарыг 3.4.8 гэж; 11.2 дугаарыг 11.3 гэж; 11.3 дугаарыг 11.4 гэж; 11.4 дугаарыг 11.5 гэж; 11.5 дугаарыг 11.6 гэж; 27.5 дугаарыг 27.7 гэж; 35.1.5 дугаарыг 35.1.6 гэж; 38.2 дугаарыг 38.3 гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 94** **Улаанбаатар хот**

Үндэсний статистикийн газрын дэргэ төлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн газрын дарга Чүлтэмжамцын Даваасүрэнг өөрийнх нь хүсэлт, Улсын Их Хурлын даргын 2002 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 138 тоот захирамжийг үндэслэн албан тушаалаас нь чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Пандийн Бямбацэрэнг Үндэсний статистикийн газрын дарга томилсугай.

3.Энэ тогтоолыг 2002 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 95** **Улаанбаатар хот**

Д.Батбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан Д.Батбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2002 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 96** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Намсрайжавын Лувсанжавыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2002 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 185** **Улаанбаатар хот**

Борис Иосифович Писарскийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын эрдэмтдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, гидрогеологийн үндэсний мэргэжилтнүүдийг сургах, эрдэмтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Сибирийн салбарын Эрхүү хот дахь Газрын цаг судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Борис Иосифович Писарскийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 186** **Улаанбаатар хот**

Владимир Павлович Тихомиров, Виктор Алексеевич Благодатских нарыг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын статистикийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, манай улсын статистикийн салбарын мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Москвагийн эдийн засаг, статистик, мэдээлэл зүйн улсын их сургуулийн захирал Владимир Павлович Тихомировыг "Алтан гадас" одонгоор, мөн сургуулийн гадаад оюутны асуудал эрхэлсэн декан Виктор Алексеевич Благодатскихыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 187** **Улаанбаатар хот**

ОХУ-ын зарим иргэнийг "Шудрага журам" медалиар шагнах тухай

Голын усанд машинтайгаа живсэн, Монгол улсын иргэн, долоон хүний амийг хүнлэг ариун сэтгэл, эр зориг, авхаалж самбаа гаргаж аварсан ОХУ-ын дор дурдсан иргэдийг "Шударга журам" медалиар тус тус шагнасугай.

1. Валентин Викторович Паушок
-ОХУ-ын хөрөнгө оруулалттай "Алтан Дорнод Монгол" ХХК-ийн ахлах байцаагч

2. Сергей Викторович Поликанин
-мөн компанийн баазын дарга

3. Александр Васильевич Сафонов
- мөн компанийн хэсгийн дарга

4. Юрий Анатольевич Семилетов
-мөн компанийн жолооч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 188** **Улаанбаатар хот**

Долгорсүрэнгийн Дагвадоржид Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Сумо бөхийн барилдааны ур чадварыг богино хугацаанд чадамгай эзэмшин спортын амжилтаа байнга ахиулан өндөр цол хүртэж, дээд зиндаанд түрүүлэн эх орныхоо нэр хүндийг дуурсгаж буй мэргэжлийн сумо бөхийн тамирчин Долгорсүрэнгийн Дагвадоржид Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 189** **Улаанбаатар хот**

Ким Үү Согиг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын нийслэлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, Улаанбаатар хотын тохижилт, соёлжилтыг дээшүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын Сеүл хотын нэгдүгээр орлогч дарга Ким Үү Согиг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 190** **Улаанбаатар хот**

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг оюун ухаан, ёс суртахууны хүрээнд төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж, мөрдөх тухай

Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхлын цогц илэрхийлэл болсон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын баталгаажилт нь эх байгаль, үгсаатны болон үндэсний соёлын экологид суурилсан эх оронч үзэл билээ.

Улс үндэстнийхээ аюулгүй байдлын үндсэн баталгаа нь ямагт байх ёстой иргэддээ эх оронч соёл, үндсэн бадраах үзэл хүмүүжил төлөвшүүлэх нь улам бүр даяаршиж буй дэлхий ертөнцөд Монголын ард түмэн өөрийнхөө эрхэм дээд үнэт зүйлс болох улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататтан хөгжүүлэх үндэсний хэрэгцээ, язгуур ашиг сонирхолд нийцэж, үндэсний түүх, соёл, ухамсрыг өв тэгш хадгалах, хамгаалах цаашид хөгжүүлэх, дархлаажуулалтыг нь улам бөхлөн бататтах нийгмийн захиалгаар нөхцөлдэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ерөнхийлөгчийн "Зууны илгээлт", "Шинэ зуун: Төрийн хэрэг иргэдээсээ, иргэний амьдрал төрөөсөө" мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хэсэгчлэн тусгагдсан үндэсний ухамсар, эх оронч үзлийг иргэд, ялангуяа залуу үед төлөвшүүлэх зорилго, зорилтыг цогцолбор түвшинд хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол улсын иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх иж бүрэн хөтөлбөрийг иргэд, олон нийт, эрдэмтэн, судлаачид, улс төрчдийн төлөөлөл, холбогдох яамдын санал санаачлагад тулгуурлаж боловсруулан мөрдөж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 191** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйлийн 4 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1"Шүүхийн сахилгын хорооны дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Монгол Улсын Шүүхийн шүүгчийн сахилгын хорооны дүрэм" батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 191 дүгээр зарлигийн хавсралт

ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын шүүхийн сахилгын хороо /цаашид "сахилгын хороо" гэх/ нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Сахилгын хороо Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, холбогдох бусад хууль, энэхүү дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа улсын хэмжээнд нэгдмэл байдлаар явуулна.

1.3. Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 3-т заасан албан тушаалтан, байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ. Иймхүү нэр дэвшүүлсэн саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл нэгтгэн, нэр дэвшигчийн биеийн байдлаалт, танилцуулгын хамт Ерөнхийлөгчид иргүүлнэ.

1.4. Ерөнхийлөгч Сахилгын хорооны гишүүдийг томилсноос хойш 14 хоногийн дотор Сахилгын хорооны даргад хорооны гишүүд дотроосоо нэр дэвшүүлж хуралдаанаараа хэлэлцэн нууцаар санал хураауж, олонхийн санал авсан хүнийг томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Уг хуралдааныг Сахилгын хорооны хамгийн ахмад гишүүн удирдаж явуулна.

1.5. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

1.6. Сахилгын хорооны гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал Шүүхийн тухай хууль, энэ дүрэмд заасан журмын дагуу нөхөн томилно.

1.7. Сахилгын хорооны гишүүн дараах эрх эдэлнэ:

1/ Гомдол, хүсэлтийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах;

2/ Шаардлагатай гэж үзвэл гомдол, хүсэлтийг биечлэн шалгах;

3/ Сахилгын хорооны даргын томилсноор сахилгын хэргийг хянан хэлэлцэх хуралдааныг даргалах;

4/ Сахилгын хэргийг хянан хэлэлцэх хуралдаанд таслах эрхтэй оролцох.

1.8. Сахилгын хорооны дарга гишүүний эрхээс гадна Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 2-т заасан дараах эрх эдэлнэ.

1/ Сахилгын хорооны хуралдааныг даргалах;

2/ Хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнийг томилох;

3/ Сахилгын хорооны ажлын албыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;

4/ Хуульд заасан бусад эрх.

1.9. Сахилгын хороо нь орон тооны ажлын албатай байна. Сахилгын хорооны Ажлын алба нь /цаашид "ажлын алба" гэх/ түүний өдөр тутмын тасралтгүй ажиллагааг хангаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдан ажиллана.

1.10. Ажлын алба дараах эрх, үүрэгтэй:

1/ Гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, харьяаллын бус гомдол, хүсэлтийг Сахилгын хорооны дарга, гишүүнд танилцуулсны үндсэн дээр буцаах;

2/ Сахилгын хорооны дарга, гишүүний даалгаснаар гомдол, хүсэлтийг шалгах ажиллагааг явуулах;

3/ Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

4/ Сахилгын хорооны хэвийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангах, шийдвэрийг баримтжуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

1.11. Ажлын албаны ажилтныг Сахилгын хорооны даргатай зөвшилцөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга томилно.

1.12. Ажлын албаны ажилтнуудын ажил үүргийн хуваарийг Сахилгын хорооны даргатай зөвшилцөн Ажлын албаны дарга тогтооно.

1.13. Сахилгын хороо тэмдэг, тогтоосон загвараар үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Сахилгын хэрэг үүсгүүлэх гомдол, хүсэлтийг хүлээн авах, шалгах, сахилгын хэрэг үүсгэх

2.1. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэх үзсэн дараах гомдол, хүсэлт нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болно.

1/ иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага гомдол гаргасан;

2/ бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч хүсэлт гаргасан.

2.2. Ажлын алба нь энэ дүрмийн 2 дахь хэсгийн 1-д заасан гомдол, хүсэлт нэг бүрийг хүлээн авч бүртгэнэ.

2.3. Ажлын алба хүлээн авсан гомдол, хүсэлтийг хянан үзээд Сахилгын хорооны дарга /гишүүн/-д танилцуулсны үндсэн дээр шалгах журмыг тогтоно.

2.4. Сахилгын хорооны дарга шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр ирүүлсэн гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд харшлах дараахь шалтгаан байгаа эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр Сахилгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар хуваарилна:

1/ сахилгын хэрэгт холбогдсон шүүгчийн болон гомдол, хүсэлт гаргасан этгээдийн төрөл садан бол, эсхүл бүрэлдэхүүн хоорондоо төрөл садангийн холбоотой хүмүүс байвал;

2/ сахилгын хэрэгт холбогдсон шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээдтэй хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

2.5. Сахилгын хорооны гишүүн нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэлтэй эсэхийг тогтоохоо шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт материалыг холбогдох этгээдээс гаргуулан авч судлах бөгөөд 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2.6. Сахилгын хорооны гишүүн шүүгчид сахилгын хэрэг үүсэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана. Хэрэв сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг эс зөвшөөрч гомдол гаргавал 3 гишүүний бүрэлдэхүнтэй хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

2.7. Сахилгын хэрэг үүсгэсэн захирамжид шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг тогтоохоо шаардлагатай ажиллагаа, түүнийг явуулах хугацааг тодорхой зааж, Ажлын албанд уг шалгалтыг хийлгүүлэхээр шилжүүлнэ.

2.8. Ажлын алба Сахилгын хорооны гишүүнээс даалгасны дагуу сахилгын хэргийг шалгах ажиллагааг 30 хоногт багтаан дуусгаж, Сахилгын хорооны даргад танилцуулна.

2.9. Сахилгын хорооны дарга шалгалтын материалтай танилцан хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай бүрдсэн байна гэж үзвэл уг хэргийг Сахилгын хорооны анхан шатны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гарган, хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнийг томилж, хуралдаан болох газар, хугацаог товлон зарлана.

Гурав. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх

3.1. Сахилгын хэргийг анхан шатны журмаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ. Сахилгын хорооны гишүүнийг татгалзах үндэслэл гаргавал Сахилгын хорооны дарга хянан үзэж өөр бүрэлдэхүүн томилох эсэхийг шийдвэрлэнэ.

3.2. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн болон сахилгын хэрэгт холбогдож буй шүүгч, түүнчлэн гомдол, хүсэлт гаргасан этгээдэд Сахилгын хорооны даргын захирамжийг хүргүүлнэ.

3.3. Сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгч хэргийн баримттай танилцах, сахилгын хорооны хуралдаанд оролцох, тайлбар гаргах эрхтэй.

3.4. Сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгч өвчтэй, чөлөөтэй, эзэлжийн амралттай байсан, гадаадад албан томилолтоор явсан зэрэг үндэслэн үзэх шалтгаантай боловч Сахилгын хорооны хуралдаанд оролцох хүсэлтээ бичгээр гаргаагүй бол энэ тухай албан ёсны баримтыг хэрэгт хавсарган сахилгын хэргийг уг шүүгчийн эзгүйд хэлэлцэн шийдвэрлэж болно.

3.5. Шүүгч Сахилгын хорооны хуралдаанд оролцох хүсэлтээ бичгээр гаргасан боловч энэ дүрмийн 3.4-т заасан үндэслэн үзэх шалтгаантай байвал уг шалтгааныг арилах хүртэл хугацаагаар хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.

3.6. Сахилгын хэрэг үүсгүүлэхээр гомдол, хүсэлт гаргасан этгээд хүсвэл сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хуралдаанд оролцож болно.

3.7.Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэж байгаа бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл гомдол, хүсэлт гаргасан этгээд болон холбогдох гэрчийг хуралдаанд оролцуулж болно.

3.8. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэх хуралдаан сахилгын хэрэг үүсгэсэн гишүүний хэрэг үүсгэсэн үндэслэл, түүнийг шалгаж тогтоосон нотлох баримтын тухай илтгэснээр эхэлж, дараахь дараалалаар явагдана:

1/ Сахилгын хорооны гишүүд сахилгын хэргийн нотлох баримтыг шинжлэн судлах;

2/ Сахилгын хэрэг үүсгүүлсэн

шүүгчийн тайлбарыг сонсох, нэмэлт тайлбар, бусад баримт байгаа эсэхийг лавлах;

3/ Гомдол, хүсэлт гаргасан этгээдийн гомдол, хүсэлтийг шалгах, нэмэлт тайлбар байгаа эсэхийг лавлах.

3.9. Сахилгын хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд олонхийн саналаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/ Сахилгын шийтгэл оногдуулах;

2/ Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

3/ Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

3.10. Сахилгын хороо сахилгын хэргийг хэлэлцэхэд тогтоол гаргана. Тогтоол нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсэгтэй байх бөгөөд түүнд хуралдаан хийсэн он, сан, өдөр, газар, сахилгын хэргийг хэлэлцэх шийдвэрлэсэн бүрэлдэхүүн, оролцогчид, сахилгын хэрэг үүсгүүлсэн шүүгчийн овог, эцгийн нэр, нэр, албан тушаал, сахилгын хэрэг үүсгэсэн шийдвэр, түүний үндэслэл, хэргийг шалгасан байдал, сахилгын хорооны дүгнэлт, шийдвэр, түүнд гомдол гаргах журмыг тодорхой тусгана. Тогтоолд сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

3.11. Сахилгын хорооны тогтоолыг сахилгын хэрэг үүсгүүлсэн тухайн шүүгчид уншин сонсгож давж заалдах гомдол гаргах эрхийг оролцогчдод танилцуулна.

3.12. Сахилгын хорооны тогтоолыг гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Ажлын албаны Шүүхийн ерөнхий зөвлөл, сахилгын хэрэг үүсгүүлсэн шүүгч, сахилгын хэрэг үүсгүүлэхээр гомдол, хүсэлт гаргасан иргэн, байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.13. Хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна.

3.14. Сахилгын хороо сахилгын хэрэг бүрийг тусад нь хэлэлцэнэ. Харин хэд хэдэн шүүгч хамтран зөрчил гаргасан тухай гомдол байгаа бол хэргийг хамтатган хянан хэлэлцэж болно.

3.15. Сахилгын хорооны шийдвэр нь:

1/ Шүүгч сахилгын шийтгэл ногдуулсан сахилгын хорооны шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гомдол гаргаагүй бол гомдол гаргах хугацаа дууссан өдрийн дараагийн өдрөөс;

2/ Хэрэв гомдол гаргасан бол Сахилгын хорооны шийдвэрийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн тухай Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдааны магадлал гарсан өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр болно.

3.16. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцсэн хуралдааны тэмдэглэлийг Ажлын албаны тухайн хэргийг шалгасан мэргэжилтэн хөтөлж, Сахилгын хорооны хуралдаан даргалагч болон тэмдэглэл хөтөлсөн мэргэжилтэн гарын үсэг зурна.

Дөрөв. Сахилгын хорооны шийдвэрт гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

4..1. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэн гаргасан тогтоолыг гомдол, хүсэлт гаргасан этгээд, эсхүл сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч эс зөвшөөрвөл Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гомдлоо Сахилгын хороонд гаргах эрхтэй.

4.2. Ажлын албан давж заалдах гомдлыг хүлээн авч бүртэн Сахилгын хорооны даргад танилцуулна.

4.3. Сахилгын хорооны дарга давж заалдах гомдлыг хүлээн авмагц сахилгын хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх Сахилгын хорооны хуралдааны товыг зарлана. Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдааныг Сахилгын хорооны дарга даргална. Сахилгын хорооны даргын эзгүйд түүний томилсон гишүүн хуралдааныг даргална.

4.4. Ажлын алба хуралдаан болохоос 7 хоногийн өмнө зарыг нийт гишүүд, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч, шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр гомдол, хүсэлт гаргасан этгээдэд хүргэх үүрэгтэй.

4.5. Сахилгын хороо давж заалдах гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж магадлал гаргана.

4.6.Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч сахилгын хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх Сахилгын хорооны хуралдаанд биечлэн оролцох эрхтэй.

4.7. Сахилгын хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх хуралдаанд гомдол, хүсэлт гаргасан этгээдийг шаардлагатай гэж

үзвэл оролцуулж болно.

4.8. Сахилгын хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх хуралдаан Сахилгын хорооны бүрэлдэхүүнийг болон ямар хэргийг хэний гомдлоор хянан хэлэлцэж байгаа тухай хуралдаан даргалагчийн зарласнаар эхэлж, илтгэгч гишүүний илтгэлийг сонсон дараахь дараалаар явагдана:

1/ Шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр гаргасан гомдол, хүсэлтийн агуулга, түүнийг шалгасан баримтыг судлан шинжлэх;

2/ Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцсэн Сахилгын хорооны тогтоолын агуулга, үндэслэл, шийдвэрлэсэн байдалтай танилцах;

3/ Сахилгын хорооны хуралдаанд оролцож байгаа шүүгч, бусад оролцогчийн тайлбарыг сонсох.

4.9. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэх хуралдаанд хэргийг илтгэсэн гишүүн давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэж байгаа Сахилгын хорооны хуралдаанд дахин илтгэхгүй.

4.10. Сахилгын хэргийг дахин шалгуулахаар шийдвэрлэсэн бол сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцсэн бүрэлдэхүүн дахин нэг удаа хэлэлцэж болно.

4.11. Сахилгын хороо давж заалдах гомдлыг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/ Давж заалдах гомдлыг хангахгүйгээр Сахилгын хорооны тогтоолыг хэвээр үлдээх;

2/ Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3/ Анханы шатны журмаар хянаң шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолың зарим хэсгийг хүчингүй болгох;

4/ Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, сахилгын хэргийг дахиң шалгуулж шийдвэрлүүлэх;

5/ Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоң шүүгчийг цагаатгах.

4.12. Сахилгын хэргийг давж заалдах шатны журмаар хянан хэлэлцсэн хуралдааны тэмдэглэлийг Ажлын албаны мэргэжилтэн хөтөлж, хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтөлсөн мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.13. Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлал эцсийнх байна.

4.14. Шүүгч сахилгын шийтгэл хүлээснээс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахиң хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

4.15. Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахиң хүлээсэн бол Сахилгын хороо түүнийг огцруулах саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд гаргана.

4.16. Шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гарсnаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй.

4.17. Сахилгын хороо шүүгчид Шүүхийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулах бөгөөд шийтгэлийг давхардуулан оногдуулж болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 192** **Улаанбаатар хот**

Шүүхийн сахилгын хорооны даргыг томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйлийн 7 дахь заалтыг баримтлан, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Мөнхнасангийн Дамирансүрэнг Шүүхийн сахилгын хорооны даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №48(285)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 193 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор батalсан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн гурвын 9 дэх хэсгийн "б"-д заасныг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөлийн ажиллах журмыг хавсралтын ёсоор батална.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 193 дугаар зарлигийн хавсралт

АВИЛГАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ нь Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий төрийн орон тооны бус байгууллага мөн.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндэсэн хууль, бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгатай, банкинд данстай байна.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Зөвлөлийг Үндэсний зөвлөлийн дарга толгойлно.

2.2 Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хуралдаанаар Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, Үндэсний зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилсан сэргийлэх талаар бусад шатны төрийн байгууллагаас зохиож байгаа ажил, зөвлөлөөс зарим тодорхой асуудлаар хийсэн хяналт шалгалтын ажлын дүн болон бусад холбогдох асуудлыг хэлэлцэх бөгөөд хэлэлцэж байгаа асуудлыг хуралдаанд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө.

2.3 Хуралдааны шийдвэрийн үндсэн хэлбэр нь тогтоол байна. Тогтоолыг хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар гаргана. Мөн шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн албан даалгавар, зөвлөмж гаргаж болно. Албан даалгаврыг Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажиллаж буй яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөлд, зөвлөмжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид тус тус өгнө. Эдгээр шийдвэрт Үндэсний зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн тогтоол, албан даалгавар, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд хариу мэдэгдэх үүрэгтэй.

2.4 Хуралдааны дэгийг Зөвлөлийн хуралдаанаар батална. Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, түүнийг эзгүйд дэд дарга эсхүл Зөвлөлийн даргын томилсон гишүүн удирдана.

2.5 Зөвлөлийн дарга бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар захирамж гаргана.

2.6 Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, эрдэмтэд, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөгчийг оролцуулсан байнгын буюу түр ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.7. Зөвлөл нь яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэй байна.

2.8. Зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь УИХ-ын даргын гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байна.

Гурав. Зөвлөлийн эрх хэмжээ

3.1. Зөвлөлийн чиг үүрэг

3.1.1 Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион хэмжээнд зохион байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар яам, агентлаг, салбар зөвлөлөөс зохиож буй ажлыг уялдуулж, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2 Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлж,

боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

3.1.3 Авилгалтай тэмцэх ажилд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэх, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.1.4 Авилгалыг үл тэсвэрлэх нийгмийн уур амьсгал бий болгох зорилгоор авилгалын хор уршиг, авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааг бодлого чиглэлтэй хийх.

3.2. Зөвлөлийн бүрэн эрх

3.2.1. Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, аймаг, нийслэлийн салбар зөвлөл, шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын төв байгуулагаас авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайлан, мэдээ гаргуулан авах;

3.2.2. Авилгалтай тэмцэхтэй холбогдсон хууль тогтоомж, Зөвлөлийн тогтоол, албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийг яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр шалгаж танилцах, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж үүрэг чиглэл өгөх;

3.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой ажилд эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчийг харьяа байгуулагатай нь тохиролцсоны үндэсэн дээр татан оролцуулах;

3.2.4. Эрх хэмжээний асуудлаар улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөлгөөн, семинар зохион байгуулах;

3.2.5. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй оролцон иргэн, аж ахуйн нэгж, байгуллагыг шагнаж урамшуулах;

3.2.6. Зөвлөлийн тогтоол, албан даалгавар, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтны асуудлыг холбогдох дээд шатны байгуулагад нь албан ёсоор тавьж, хариу авах;

3.2.7 Авилгалын асуудалтай холбоотой иргэд, байгуулагаас ирүүлсэн мэдээллийг холбогдох байгуулагад нь шилжүүлж, түүний шийдвэрлэлтэд хяналт тавих;

3.2.8. Хөтөлбөрийн биелэлтийг хагас жил тутам нэгтгэж, дүгнэлт хийх;

3.2.9. Авилгалтай тэмцэх талаар иргэн, байгуулага, аж ахуйн нэгжээс гаргасан санал, хүсэлтийг тогтоосон жүрмын дагуу холбогдох байгуулагад тавьж шийдвэрлүүлэх, судлах үзэх;

3.2.10. Авилгалаас урьдчилан сэргийлэх талаар хандивлагч орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгуулагатай хамтран улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээнд төсөл хэрэгжүүлэх, иргэд, төрийн бус байгуллагын үүсгэл санаачилгыг дэмжин тэдгийг эжил өргөнөөр татан оролцуулах, туслалцаа үзүүлэх.

3.2.11. Авилгалын асуудлаар олон нийтийн санал, хандлагыг хоёр жил тутам судлан дүгнэлт хийж байх;

3.2.12. Авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгуулага, гадаад орнуудтай хамтран ажиллах асуудлыг зохицуулах;

3.2.13. Зөвлөлд Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас даалгаж хариуцуулсан бусад ажил.

3.3. Зөвлөлийн гишүүний бүрэн эрх

3.3.1. Зөвлөлийн хуралдаанд санал оруулж хэлэлцүүлэх;

3.3.2. Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариулан ажилласх, гүйцэтгэл, үр дүнгийн талаар Зөвлөлийн хуралдаанд мэдээлэх;

3.3.3. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг яам, агентлаг, нутгийн захиргааны байгуулага, аж ахуйн нэгжид Зөвлөлийн шийдвэрийн дагуу шалган танилцах;

3.3.4. Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулж, хяналт тавихтай холбогдсон асуудлаар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр байгуллага, аж ахуйн нэгжид саадгүй нэвтэрч холбогдох мэдээ, баримт, материал гаргуулан авах.

3.4. Зөвлөлийн даргын бүрэн эрх

Зөвлөлийн дарга нь Зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.4.1. Зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг товлох, даргалах;

3.4.2. Өөрийн болон дэд даргын эзгүйд хуралдаан даргалах гишүүнийг томилох;

3.4.3. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих;

3.4.4. Хууль тогтоомжоор олгосон бусад бүрэн эрх.

3.5. Зөвлөлийн ажлын алба

3.5.1. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцаж гүйцэтгэх бөгөөд энэ ажлыг дагнаж хариуцсан ажилтнуудтай байна. УИХ-ын Тамгын газар нь Үндэсний зөвлөлийн ажилтай бүх талын нөхцөлийг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

3.5.2. Зөвлөлийн Ажлын алба / цаашид "Алба" гэнэ/-ны үүрэг нь Үндэсний зөвлөлөөс Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулахад туслах, Зөвлөлийн едер тутмын үйл ажиллагаат зохион байгуулах, авилгалтай тэмцэхтэй холбогдолтой хууль тогтоомж, түүнийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулахад оршино.

3.5.3. Алба нь дараахь эрх үүрэгтэй байна:

3.5.3.1. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүдээс шаардлагатай дэмжлэг, туслалцаа авна;

3.5.3.2. Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, аймаг, нийслэлийн салбар зөвлөл шүүх эрх мэдлийн болон хууль, хяналтын төв байгууллагаас авилгалтай тэмцэх талаар зохиосон ажлын тайлан гаргуулан авна;

3.5.3.3. УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, Засгийн газрын агентлаг, хууль хяналтын байгууллагуудаас холбогдох асуудлаар туслалцаа авна;

3.5.3.4. Авилгалтай тэмцэхтэй холбогдсон хууль тогтоомж, Зөвлөлийн тогтоол, албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийг Зөвлөлийн даалгасны дагуу яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн төрөл , хэлбэр харьяалал харгалзахгүйгээр шалгана;

3.5.3.5. Хяналт, шалгалтын ажилд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгаа, тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авч, хяналт шалгалттай холбогдуулан ажилласн нөхцөлөөр хангуулна;

3.5.3.6. Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулна;

3.5.3.7. Зөвлөлийн дарга, гишүүдийг тухай бүр шаардлагатай мэдээллээр шуурхай хангаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ;

3.5.3.8. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Зөвлөлийн жил, улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна;

3.5.3.9. Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна;

3.5.3.10. Зөвлөл болон Үндэсний зөвлөлийн даргаас даалгаж хариуцуулсан бусад ажил.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт нь улсын нэгдсэн төсвөөс олгосон хөрөнгө болон дотоод, гадаадын байгууллага, иргэдийн өгсөн хандив, тэслийн хөрөнгөнөөс бүрдэнэ.

4.2. Зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардлыг жил бүрийн төсөвтөө тусгах үндэсэн дээр УИХ-ын Тамгын газраас санхүүжүүлнэ.

4.3. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгийг Зөвлөлийн шийдвэрээр захиран зарцуулна.

4.4. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгийг дараахь чиглэлээр зарцуулна:

4.4.1. Авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар семинар, сургалт, сурталчилгаа;

4.4.2. Авилгалыг үл тэвчих нийгмийн уур амьсгал бүрдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажил;

4.4.3. Үндэсний хөтөлбөрт заасан бусад тодорхой арга хэмжээ.

4.5. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хоригломо.

Тав. Салбар зөвлөлийн үүрэг

5.1. Үндэсний хөтөлбөрт зааснаар яам, Засгийн газрын агентлаг бүрт авилгал, хээл хахуультай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал зөрхэлсэн салбар зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Сайд, агентлагийн дарга батална.

5.2. Орон нутагт салбар зөвлөлийн үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гүйцэтгэнэ.

5.3. Салбар зөвлөл нь тухайн яам, агентлагийн хүрээнд болон харьяа нутаг дэвсгэртээ Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний үндэсэн дээр зохион байгуулна.

5.4. Салбар зөвлөл нь авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайлан, мэдээг улирал бүр Үндэсний зөвлөлд ирүүлнэ.

5.5. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн зардал, бусад үйлчилгээг тухайн яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчийн ажлын алба хариуцах бөгөөд зардлыг яам, Засгийн газрын агентлаг болон орон нутгийн төсөвөөс санхүүжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Улаанбаатар- 12 Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003
☎ 329487 Хэвлэлийн хуудас 4